



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ХӨХ НОМ





МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД БОДЛОГЫН ХӨХ НОМ

2018



МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ХӨХ НОМ 2018

Хэвлэлийн хуудас: 13

Цаасны хэмжээ: 70x100/16

Хэвлэсэн тоо: 500

Хэвлэсэн он: 2019

Зохиогчийн эрх ©МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ


Улаанбаатар хот 2019 он

Энэхүү бүтээл зохиогчийн эрхийн хуулийн дагуу хамгаалагдсан болно. Бүтээлийг бүтнээр буюу хэсэгчлэн хувилах, нийтлэх, микрофильм хийх, электрон системд оруулах болон бусад ямар нэг хэлбэрээр олшруулахыг хориглоно.


Гадаад харилцааны яам, Энх тайвны гудамж-7А


Улаанбаатар-14210, Монгол Улс

 info@mfa.gov.mn

 976-11-322127

 www.mfa.gov.mn

 @MongolDiplomacy

 [mfamongoliaMN](https://www.facebook.com/mfamongoliaMN)

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	4
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	6
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ	8
БҮЛЭГ 1. ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ БАЙДАЛ БА МОНГОЛ УЛСЫН ГАДААД ОРЧИН	9
БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:ХОЁР ТАЛЫН ХАРИЛЦАА.....	13
МОНГОЛ УЛС БА ХӨРШ ОРНУУД,ГУРВАН ТАЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА.....	13
МОНГОЛ УЛС БА АЗИ, НОМХОН ДАЛАЙН ОРНУУД.....	26
МОНГОЛ УЛС БА ЕВРОПЫН ХОЛБОО.....	42
МОНГОЛ УЛС БА ЕВРОПЫН ОРНУУД.....	45
МОНГОЛ УЛС БА АМЕРИК, ОЙРХ ДОРНОД, АФРИКИЙН ОРНУУД.....	67
БҮЛЭГ 3. ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА	81
МОНГОЛ УЛС БА НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА.....	81
ДАЛАЙД ГАРЦГҮЙ ХӨГЖИЖ БУЙ ОРНУУДЫН ОЛОН УЛСЫН СУДАЛГААНЫ ТӨВ	89
МОНГОЛ УЛС БА ЭВСЭЛД ҮЛ НЭГДЭХ ХӨДӨЛГӨӨН	91
МОНГОЛ УЛС БА АЗИ-ЕВРОПЫН УУЗАЛТ/АСЕМ/.....	92
МОНГОЛ УЛС БА ЕВРОПЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА/ЕАБХАБ.....	93
МОНГОЛ УЛС БА ЗҮҮН ХОЙД АЗИ	94
БҮЛЭГ 4. МОНГОЛ УЛСЫН ХУДАЛДАА,ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ХАРИЛЦАА.....	97
ГАДААД ХУДАЛДАА	97
ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	100
ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	101
ОЛОН УЛС, БҮС НУТГИЙН ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА	102
БҮЛЭГ 5. ГАДААД СУРТАЛЧИЛГАА, СОЁЛЫН ХАРИЛЦАА	105
ГАДААД СУРТАЛЧИЛГААНЫ БОДЛОГО, СТРАТЕГИ	105
ТҮҮХ, СОЁЛЫН ӨВ	107
МОНГОЛ СУДЛАЛ.....	108
ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА	109
СУРТАЛЧИЛГАА БА ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ МОНГОЛ ИРГЭД	110
БҮЛЭГ 6. ЭРХ ЗҮЙ БА КОНСУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	113
ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	113
КОНСУЛЫН ХАРИЛЦАА.....	133
КОНСУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	134
ИРГЭДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	136
БҮЛЭГ 7. ХАВСРАЛТУУД.....	139
I. МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ.....	139
II. ӨРГӨТГӨСӨН ИЖ БҮРЭН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛС, АНУ-ЫН ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ.....	148
III. МОНГОЛ УЛС, АНУ ХООРОНДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨРГӨТГӨСӨН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ЗАМЫН ЗУРАГЛАЛ	155
IV. МОНГОЛ,ЯПОНЫ ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ.....	163
V. ХЭЛСЭН ҮГҮҮД.....	170
VI. МОНГОЛ УЛСЫН ДИПЛОМАТ ХАРИЛЦААТАЙ ОРНУУД.....	189
VII. МОНГОЛ УЛСААС ХИЛИЙН ЧАНАДАД СУУГАА ДТГ-УУД.....	194
VIII. МОНГОЛ УЛСАД СУУГАА ГАДААДЫН ДТГ-УУД.....	201
IX. ВИЗГҮЙ ЗОРЧИХ НӨХЦӨЛИЙН ТУХАЙ ЛАВЛАХ.....	205



ӨМНӨХ ҮГ

Эрхэм хүндэт уншигчид аа,

Гадаад харилцааны Яамны хамт олон 2018 онд үйл ажиллагаагаа Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг удирдлага болгон ажиллаж гадаад харилцааг бүхий л чиглэлээр өргөжүүлэн хөгжүүлэх үйлсэд хүчин чармайлт гаргаж, улсынхаа хөгжлийн гадаад таатай орчинг бүрдүүлэх чиглэлээр идэвхитэй ажиллалаа.

Тус Яам нь 2018 онд Монгол Улсын төр, засгийн тэргүүн, Гадаад харилцааны сайд, төрийн өндөр албан тушаалтнуудын гадаад улсад хийсэн 20 гаруй айлчлал, гадаад улсын төр, засгийн тэргүүн, өндөр түвшний төлөөлөгчдийн манай улсад хийсэн 12 айлчлалыг зохион байгуулахын сацуу Засгийн газар болон ГХЯ-наас шууд болон хамтран зохион байгуулсан олон улс, бүс нутгийн хэмжээний 6 олон улсын хурал, зөвлөгөөн, ЗГХК-ын 15 хуралдааныг тус тус зохион байгууллаа. 2018 онд манай улс олон талт 6 гэрээнд нэгдэж, Засгийн газар хоорондын 22 гэрээ байгуулж, өмнө нь байгуулсан 9 гэрээг

хүчин төгөлдөр болгож, байгууллага хоорондын 65 гэрээ байгуулан бүртгэж, байгууллага хоорондын 128 гэрээ байгуулах асуудалтай холбоотой үйл явцад оролцсон нь 2017 онтой харьцуулахад энэхүү үзүүлэлт даруй 60 орчим хувиар нэмэгдлээ.

Хөрш орнууд болон голлох түнш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, Монголын экспортын бараа бүтээгдэхүүний гадаад зах зээлийг өргөтгөх, худалдааг хөнгөвчлөх асуудал бидний анхаарлын төвд байлаа. Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2017 оныхтой харьцуулахад 18,2 хувиар өсөж, 13 тэрбум орчим ам.долларт хүрсэн нь түүхэнд урьд өмнө байгаагүй өндөр үзүүлэлт болов. Манай экспорт 2018 онд 23%-иар өсч, 2018 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт 2,47 тэрбум ам.долларт хүрч 2017 оныхтой харьцуулахад 382,9 сая ам.доллар буюу 18%-иар өсөв. Ийнхүү гадаад худалдаа өсч, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр манай гадаад валютын нөөц эрс нэмэгдэж гурван тэрбум

ам.долларын босго давав. Цаашид энэхүү ололт амжилтаа бататгах, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах үүднээс эхний ээлжинд Бээжин, Токио, Владивосток зэрэг хотуудад Монгол Улсын Худалдааны төлөөлөгчийн газрыг шинээр нээж ажиллуулахаар шийдвэрлүүлээд байна.

Тус Яам нь “Best of Mongolia” цахим хуудсаар дамжуулан явуулсан хэрэглэгч, олон нийтийн санал асуулгаар 2018 оны шилдэг төрийн байгууллагаар шалгарсан нь Яамны хамт олны ажилд тавьсан өргөн олон нийтийн үнэлгээ хэмээн үзэж байгаагаа энэ дашрамд дурдахад таатай байна.

Бид “Монгол Улсын гадаад бодлогын хөх ном”-ыг жил бүр хэвлүүлж уншигч оныхоо хүртээл болгож ирсэн уламжлалынхаа дагуу “Монгол Улсын гадаад бодлогын хөх ном-2018”-ыг уншигч авхай та бүхэнд үүгээр толилуулж байна.

Тус ном нь Монгол Улсын гадаад харилцааны 2018 оны гол гол үйл явдлууд, хийж гүйцэтгэсэн ажлуудын талаар товч танилцуулахыг зорьж, номын нэгдүгээр бүлэгт, олон улсын харилцааны 2018 оны ерөнхий байдал, Монгол Улсын гадаад орчин, хоёрдугаар бүлэгт, дэлхийн улс орнуудтай тогтоосон

Монгол Улсын хоёр талын харилцааны хөгжил, ололт амжилт, шийдвэрлэсэн гол асуудлууд, гуравдугаар бүлэгт, Монгол Улсын олон талт дипломат үйл ажиллагаа, дөрөвдүгээр бүлэгт, Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцаа, тавдугаар бүлэгт, гадаад сурталчилгаа, соёлын харилцаа, зургадугаар бүлэгт, олон улсын эрх зүйн зохицуулалт, консулын болон иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр хийж гүйцэтгэсэн гол ажлуудыг тусгасан болно. Чингэхдээ гол бодлогын баримт бичиг, гадаад бодлогын чиглэлээр олон улсын гол гол арга хэмжээний үеэр удирдагчдын хэлсэн үгүүд, гэрэл зураг, статистик мэдээ, график, инфографик зэргийг мөн оруулсан болно.

Монгол Улсын гадаад харилцааны 2018 оны гол гол үйл явдлуудын талаарх уншигч таны мэдлэгийн санд энэхүү бүтээл зохих хувь нэмрээ оруулна хэмээн гүнээ найдаж байна.

Эрхэм уншигч та цаашид Монгол Улсын гадаад бодлогын Хөх номыг баяжуулж, сайжруулахад санал бодлоо тус Яамны хаягаар болон цахим шуудангаар ирүүлж байх аваас бид энэхүү номын дараа дараагийн дугаартаа харгалзаж байх болно.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**



ДАМДИНЫ ЦОГТБААТАР

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Гадаад харилцааны Яам нь анх Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч Яам нэртэйгээр 1911 онд байгуулагдсан Монгол Улсын ууган яамдын нэг бөгөөд улмаар Гадаад явдлын Яам, Гадаад хэргийн Яам нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн түүхтэй.

“Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 3 дугаар тогтоолоор Гадаад харилцааны Яамыг 13 газар, газрын харьяаны 4 хэлтэс, Гадаад харилцааны төв архивын бүтэцтэй ажиллуулахаар тогтоож баталсан юм.

2018 оны байдлаар хилийн чанадад Монгол Улсын 42 Дипломат төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байгаагаас Элчин сайдын яам 29, Олон улсын байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газар 2, Ерөнхий консулын газар 9, Консулын газар 2 тус тус байна. 2018 оны хувьд

Монгол Улс Бүгд Найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс, Арабын Нэгдсэн Эмират Улсад Элчин сайдын Яам, Бээжин, Токио, Владивосток хотноо Худалдааны төлөөлөгчийн газар, БНХАУ-ын Шанхай, Хайлаар хотноо консулын газар тус тус нээж ажиллуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Мөн оны байдлаар Монгол Улсын 60 Өргөмжит консул гадаадын 42 оронд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн 8 нь Өргөмжит ерөнхий консулын зэрэгтэй, 16 нь виз олгох эрхтэй ажиллаж байна.

Монгол Улсад байнга суугаа гадаадын 25 орны ЭСЯ, 3 орны ЕКГ, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудын 10 төлөөлөгчийн газар, 34 орны Өргөмжит консул үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Монгол Улсын Соёлын элчээр 13 монгол, 30 гадаадын иргэн тус тус ажиллаж байна.

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД



Вэб сайт

- mfa.gov.mn
Монгол, англи хувилбартай
- 27 ДТГ вэб сайттай



Фейсбүүк

- mfamongoliaMN
- 35 ДТГ Фейсбүүк хөтөлдөг




Твиттер

- @MongolDiplomacy
- 21 ДТГ болон элчин сайд нар
Твиттер хөтөлдөг
- Консулын газрын Твиттер хаяг:
@Consulsmn

Бусад нийгмийн сүлжээний сувгууд:

- Youtube – MFA Mongolia
- Instagram – MFA Mongolia

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ БҮТЭЦ:



ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛААГАНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Тус яамны эрхэм зорилго нь Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд таатай гадаад орчныг бүрдүүлэхэд оршино. Энэхүү зорилгын хүрээнд ГХЯ нь гадаад улс орнууд, олон улсын байгууллагатай хоёр болон олон талт харилцаа, хамтын ажиллагааг улс төр, эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалт, соёл, боловсрол, шинжлэх ухаан, спорт, хүмүүнлэг зэрэг бүхий л салбарт хөгжүүлэхийг зорин ажиллаж байна.

Үүний зэрэгцээ 2016-2020 оны үйл ажиллагаандаа дор дурдсан тэргүүлэх чиглэлд онцгой анхаарал хандуулна. Үүнд:

1. Гадаад эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар Монгол Улсын хөгжлийн таатай гадаад орчныг бүрдүүлэх;

- Худалдааны гол түнш болон бусад улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах замаар худалдааг хөнгөвчлөх, худалдааны тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулах,
- Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн тогтвортой, тааламжтай орчин бүрдүүлэх, олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын болон бусад бүх салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах,
- Хил орчмын худалдааг хөнгөвчлөх зорилгоор хилийн боомт, хил

орчмын дэд бүтэц, иргэд зорчих нөхцөлийг сайжруулах, олон улс, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграци болон дэд бүтцийн сүлжээнд хамрагдах үйл явцыг эрчимжүүлэх,

- Гадаадын зах зээлд экспортлох боломжтой тэргүүлэх ач холбогдол бүхий бараа бүтээгдэхүүний судалгаа, маркетингийг төрөөс дэмжих “Монгол экспорт” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монгол-Экспо үзэсгэлэн яармаг арга хэмжээг гадаад орнуудад зохион байгуулах.
2. Гадаад сурталчилгаа, соёлын харилцааг хөгжүүлэх, хилийн чанад дахь монгол иргэд, сургууль, цэцэрлэг, холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлэх;
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангах ажлыг зохион байгуулах,
 - “Дэлхийн Монголчууд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангах ажлыг зохион байгуулах.
3. Монгол Улсын иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хилийн чанадад хамгаалах.
-

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ БАЙДАЛ БА МОНГОЛ УЛСЫН ГАДААД ОРЧИН

Олон улсын харилцаа 2018 оны хувьд улс төр, эдийн засгийн тогтворгүй орчинд үргэлжилж, геополитикийн сөргөлдөөн нэмэгдэж, шинэ сорилт бэрхшээлүүд гарсаар байлаа. Өнөөгийн дэлхий ертөнцөд “шинэ хүйтэн дайны”-ы нөхцөл рүү хальтран орох эрсдэл ч оршиж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

ОХУ болон АНУ-ын геополитикийн сөргөлдөөн үргэлжилж, улмаар АНУ болон Европын орнуудын зүгээс ОХУ-ын эсрэг тавьсан эдийн засгийн хориг арга хэмжээ үргэлжилж, АНУ болон ОХУ-ын зэвсэглэлийн салбарын сөргөлдөөн нэмэгдэв. АНУ нь Үндэсний батлан хамгаалах стратегиа 2018 онд шинэчлэн гаргаж “терроризм бус харин их гүрнүүдийн өрсөлдөөн нь АНУ-ын үндэсний аюулгүй байдлын бодлогын гол төвлөрөх асуудал” хэмээн тунхаглав. Түүнчилэн Дунд болон ойрын зайн тусгалтай пуужинг устгах тухай ОХУ, АНУ-ын 1987 оны гэрээнээс АНУ дангаараа гарч байгаагаа зарлав.

Дэлхий дахинд ялангуяа, Ойрх Дорнод, Латин Америкийн зарим орнууд, Украины улс төр, эдийн засгийн болон хүмүүнлэгийн хямрал гүнзгийрч, зарим орнуудад байдал улам дордов. Ираны

цөмийн тохиролцоог АНУ хэт нэг талыг баримталсан тохиролцоо хэмээн үзэж түүнээс албан ёсоор гарч байгаагаа мэдэгдсэн нь энэ бүс нутаг, түүний дотор Ойрх Дорнодод ээдрээтэй нөхцөл байдлыг буй болгож, улмаар дэлхийн нефтийн зах зээлд тодорхойгүй байдал үүсгэв.

Дэлхийн эдийн засаг 2018 оны эхээр сэргэлтийн мөчлөгтөө орж 3.2-3.5 хувиар өсөх эерэг таамаглалтай байсан боловч геополитикийн эрсдэлүүд нүүрлэж, олон улсын эдийн засгийн харилцаанд протекционизм давамгайлж, даяаршлаас дангааршил руу чиглэх хандлага нэмэгдэж дэлхийн эдийн засагт шинэ шинэ эрсдэл тулгарч эхлэв. Эдийн засгийн өсөлт удаашрах үзэгдэл АНУ, Евро бүсийн улсууд, Япон зэрэг оронд ажиглагдаж, эдгээр орнууд дотоодын эдийн засгаа дэмжих үүднээс импортоо хумих бодлого баримталж эхлээд байна. Их Британи Европын Холбооноос гарах үйл явц ээдрээтэй байдлаар өрнөсөөр байна.

Дэлхийн эдийн засагт шинээр нүүрлээд буй томоохон эрсдлүүдийн нэг нь АНУ, БНХАУ-ын худалдааны маргаан юм. АНУ, Хятадын худалдаа нь дэлхийн худалдааны 20 хувь, ДНБ-ий 40 хувьтай

тэнцдэг тул тус хоёр улсын эдийн засгийн гадаад харилцаанд гарч байгаа өөрчлөлт нь дэлхийн эдийн засагт хүчтэй нөлөө үзүүлэх нь дамжиггүй юм. Дэлхийн хамгийн том эдийн засагтай хоёр орны худалдааны маргаан 2018 онд дэлхийн худалдааг 2.5 хувиар буурахад нөлөөлсөн байна. АНУ болон БНХАУ-ын хооронд “худалдааны дайн” эхлэж, талууд асуудлаа зохицуулах чиглэлээр 2018 онд багагүй хүчин чармайлт тавьсан боловч тодорхой шийдэлд хүрч чадахгүй, маргаан үргэлжилж, тарифын “дайн”-аас технологийн “дайн” руу шилжих эрсдэл ч нэмэгдэж, улмаар асуудал олон улсын эдийн засгийн харилцаанд бүхэлд нь сөргөөр нөлөөлөх магадлалтай байна. Хэрэв талууд тодорхой тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд дэлхийн эдийн засаг цаашид 5 хүртэл хувиар буурах магадлал байгааг зарим судлаачид таамаглаж байна.

Олон улсын терроризм, хүрээлэн буй орчны доройтол, экологийн тэнцвэргүй байдал, байгаль, цаг уурын өөрчлөлт, шашин, угсаатны улбаатай үндэстэн хоорондын зөрчил, мөргөлдөөн, мөн хил дамнасан гэмт хэрэг, хүний болон хар тамхины наймаа, хүн, амьтны халдварт өвчний тархалт, цахим халдлага зэрэг уламжлалт бус аюулын эрсдэл оршсоор байна. Дэлхийн олон оронд дотоодын шашин, улс төрийн зөрчил, тэмцэл ч үргэлжилж байна.

Зүүн Хойд болон Зүүн Өмнөд Азийн аюулгүй байдал, энэ бүс нутгийн зарим орнуудын хоорондын газар нутгийн маргаан, бүс нутагт зэвсэглэлээр хөөцөлдөх үйл явцыг зогсоох, түгшүүртэй байдлыг намжаах зэрэг асуудлаар хоёр талын болон олон талт

яриа хэлэлцээг сэргээх чиглэлээр тодорхой ахиц гарав. Солонгосын хойгийн түгшүүртэй байдал урьд өмнө байгаагүй хэмжээгээр хурцдаж, Умард Солонгосын цөмийн хөтөлбөрийн асуудлаар АНУ болон Умард Солонгосын анхны дээд хэмжээний уулзалтыг талууд Сингапур Улсад зохион байгуулснаар Хойгийн түгшүүртэй байдлыг намжааж, асуудлыг яриа хэлэлцээний замаар шийдвэрлэх эхлэлийг тавив.

БНХАУ “Бүс ба зам” санаачилгынхаа хүрээнд олон улсын хамтын ажиллагааны шинэ шинэ боломжуудыг нээж хөгжүүлэхэд анхаарч байгаа нь дэлхийн эдийн засгийн сэргэлтэд нааштай нөлөө үзүүлнэ гэж ажиглагчид үзэж байна. Торгоны зам болон “Бүс ба зам” хэмээх дэлхийн худалдаа, эдийн засгийн харилцааг тэлэх үзэл санаа нь улс орнуудын анхаарлыг татаж, торгоны замын эдийн засгийн бүсэд холбогчийн үүрэг гүйцэтгэхийн төлөө улс орнуудын хооронд яриа хэлэлцээ эрчимжиж, ахиц дэвшил гарсаар байна. Цаашид “Бүс ба зам” санаачилга, түүний хүрээнд өрнөж буй хамтын ажиллагаа улс орнуудын худалдааны эргэлт, хөрөнгө оруулалтад зохих хэмжээний эерэг нөлөө үзүүлэх төлөвтэй байна.

Евразийн бүс нутаг дахь интеграцчилалын үйл явц Евразийн эдийн засгийн холбооны хүрээнд өрнөхийн сацуу ШХАБ-ын оролцогч талууд энэхүү байгууллагын хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Монгол Улсын ойрын хөрш-БНХАУ-ОХУ-тай тогтоосон харилцаа, хамтын ажиллагаа гүнзгийрэн хөгжиж, дэлхийн нефть болон гол түүхий эдийн үнэ, түүний дотор Монгол Улсын

экспортын гол гол бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ 2018 онд харьцангуй тогтвортой байсан нь манай гадаад орчинд бүхэлдээ таатай нөлөө үзүүлэв. Түүнчилэн Монгол, БНХАУ, ОХУ-ын гурван талын хамтын ажиллагаа хэвийн хөгжиж Монгол Улс зам, тээвэр, эрчим хүч, уул уурхай, үйлдвэрлэлийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, хөрш орнуудтай дэд бүтцээр холбогдох, худалдааг хөнгөвчлөх, тээврийн зардлыг бууруулах зорилгоор Хөгжлийн зам хөтөлбөрөө хэрэгжүүлэх, түүнийг бүс нутгийн дэд бүтцийн томоохон санаачилгуудтай уялдуулах, Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улс, БНХАУ болон ОХУ нь бүх талаар харилцан ойлголцож, хамтран ажиллаж байна.

Манай гадаад орчинг тодорхойлоход хоёр хөршөөс гадна Монгол Улсын “гуравдагч хөрш”-үүд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна. Монгол Улсын “гуравдагч хөрш”-АНУ, Европын Холбоо, Япон, БНСУ, Энэтхэг зэрэг орнуудтай хөгжүүлж байгаа найрсаг харилцаа, хамтын ажиллагаа манай улсын ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засгийн хөгжлийн баталгаа болж байна. Түүнчилэн Зүүн хойд Ази болон Төв Азийн бүс нутгийн байдал, эдгээр бүс нутгийн орнуудын өөр хоорондын харилцаа, тэдгээрийн гадаад худалдаа, зам тээврийн нөхцөл, манай экспортын гол нэрийн бараа болох алт, зэс, нүүрс, ноолуур зэргийн дэлхийн зах зээлийн үнэ ханш зэрэг нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна.

Монгол Улс бүс нутгийн орнуудтай эдийн засгийн гадаад харилцааны

таатай нөхцөл бүрдүүлэх үүднээс Япон Улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан бөгөөд цаашид ШХАБ-ын хүрээний эдийн засгийн томоохон хөтөлбөр, төслүүдэд оролцох, Евразийн эдийн засгийн Холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах нөхцөл боломжийн талаар судалгаа хийж, идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна.

Зүүн хойд Азийн бүс нутгийн улс орнуудтай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, бүс нутгийн олон талт үйл явц, яриа хэлэлцээ, интеграцийн үйл явцад оролцох, ялангуяа Солонгосын хойгийн тогтвортой байдлыг сахин хамгаалахад өөрийн хувь нэмрээ оруулах явдал Монгол Улсын гадаад бодлогын чухал зорилтууд нэг хэвээр байна. Энэ чиглэлээр Монгол Улс Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх Улаанбаатарын яриа хэлэлцээг (Ulaanbaatar Dialogue Initiative on Northeast Asian Security) үргэлжлүүлж байна.

2

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА: ХОЁР ТАЛЫН ХАРИЛЦАА

МОНГОЛ УЛС БА ХӨРШ ОРНУУД, ГУРВАН ТАЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

МОНГОЛ УЛС-ОХУ

Монгол Улс, ОХУ-ын уламжлалт найрсаг, сайн хөршийн, стратегийн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, дээд, өндөр түвшний яриа хэлэлцээ, уулзалтын давтамжийг хадгалах, хоёр орны худалдаа, эдийн засгийн болон бусад салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, үр өгөөжийг нь нэмэгдүүлэх, агуулгыг нь баяжуулахад гол анхаарлаа хандуулав.

Монгол, Оросын дээд, өндөр хэмжээний улс төрийн яриа хэлэлцээ идэвхтэй өрнөв. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинтэй 6 дугаар сард БНХАУ-ын Чиндао хотноо, 9 дүгээр сард ОХУ-ын Владивосток хотноо, мөн Азербайжан Улсын Баку хотноо тус тус уулзаж, харилцаа, хамтын ажиллагааны асуудлуудаар тодорхой тохиролцоонд хүрэв.



Дорнын эдийн засгийн чуулга уулзалтын үеэр

Ерөнхийлөгч Х.Баттулга 9 дүгээр сарын 11-13-нд ОХУ-ын Владивосток хотноо зохион байгуулсан “Дорнын эдийн засгийн чуулга уулзалт”-д оролцож,

өргөтгөсөн хуралдаанд үг хэлэв. Чуулга уулзалтын хүрээнд Ерөнхийлөгч Х.Баттулга ОХУ, БНХАУ-ын Төрийн тэргүүн нартай албан ёсны уулзалт

хийсэн бөгөөд Япон, БНСУ-ын Ерөнхий сайд нар Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхаж харилцааны асуудлаар санал солилцов. Мөн энэ үеэр “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридорыг хамтран урагшлуулах механизмыг байгуулах тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам, ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яам, БНХАУ-ын Хөгжил, шинэчлэлийн хороо хоорондын Санамж бичиг”-т талууд гарын үсэг зурав.


Гадаад харилцааны сайд ОХУ-д айлчлав.

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Швейцарийн Холбооны Улс /ШХУ/-ын Давос хотноо 1 дүгээр сард зохион байгуулсан Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын үеэр ОХУ-ын Засгийн



Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.В.Лавров нар

газрын орлогч дарга А.В.Дворкович, Олон нийтийн харилцаа, холбооны сайд Н.А.Никифоров нартай харилцааны асуудлаар санал солилцоноос гадна 5 дугаар сард ОХУ-ын Гадаад хэргийн сайд С. Лавровын урилгаар ОХУ-д айлчилж, хоёр талын харилцааны тулгамдсан асуудлаар санал солилцов. Мөн сайд Д.Цогтбаатар 9 дүгээр сарын 9-10-ны өдрүүдэд Оросын Холбооны Улсын Алс Дорнодын бүс нутагт ажлын айлчлал хийв. Айлчлалын хүрээнд Гадаад харилцааны сайд ОХУ-ын Хабаровск, Приморын хязгаарын Амбан захирагч нар болон Ванино далайн боомтын удирдлага, уг боомтод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн удирдлагатай уулзаж, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.



Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар ОХУ-ын Хабаровскийн хязгаарын Амбан захирагч В.И.Шпорт-той уулзав.

Монгол Улс Валдайн клубын үйл ажиллагаанд идэвхтэй оролцов.

Сайд Д.Цогтбаатар ОХУ-ын Владивосток хотноо 9 дүгээр сард Дорнын эдийн засгийн IV чуулга уулзалтын үеэр болсон Олон улсын хэлэлцүүлгийн “Валдай” клубын “Азийн шинэ геополитик ба улс төрийн эдийн засаг: Оросын

боломжууд” сэдэвт тусгай хуралдаанд үг хэлж, 10 дугаар сард ОХУ-ын Сочи хотноо зохион байгуулсан уг клубын XV бага хуралд оролцож, “Ирээдүй рүү хөтлөх зам дахь Еврази” сэдвээр илтгэл тавьж, 10 дугаар сард Москва хотноо зохион байгуулсан Оросын ШУА-ийн Дорнын судлалын хүрээлэнгийн 200 жилийн ойн арга хэмжээнд оролцов.




Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Олон улсын хэлэлцүүлгийн Валдай клубын XV бага хуралд оролцов.

“Монгол, Оросын санаачилга-2018” цуврал арга хэмжээг Улаанбаатар хотноо 6 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд зохион байгуулав. Энэхүү арга хэмжээний хүрээнд ОХУ-ын Аж үйлдвэрийн сайд Д.В.Мантуров, Тээврийн сайд Е.И.Дитрих, ОХУ-ын Ерөнхийлөгчийн туслах И.Е.Левитин, Эрхүү мужийн Амбан захирагч С.Г.Левченко тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Шадар сайд Ө.Энхтүвшин нарт бараалхаж

хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов. Цуврал арга хэмжээний хүрээнд эдийн засгийн чуулга уулзалт, Оросын дэвшилтэт техник, тоног төхөөрөмж болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үзэсгэлэн, И.Моисеевын нэрэмжит академик чуулгын тоглолт, гэрэл зургийн үзэсгэлэн, Монгол, Оросын залуу жудочдын нөхөрсөг тэмцээн зэрэг арга хэмжээ зохион байгуулав. Үзэсгэлэн яармагт ОХУ-ын 53 компаний төлөөлөл оролцсон болно. Түүнчлэн талууд “Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”, “Монгол Улсын Хөгжлийн банк, Ди Би Эм лизинг ХХК болон Внешэкономбанк хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”, Монгол Улсын “Ди Би Эм Лизинг” ХХК болон ОХУ-ын “Veles” үйлдвэрийн хооронд бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ тус тус байгуулав.



“Монгол, Оросын санаачилга 2018” арга хэмжээг Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга нээж үг хэлэв.



Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцлийн тухай хэлэлцээр байгуулав.

Батлан хамгаалахын сайд Н.Энхболд ОХУ-ын Батлан хамгаалахын сайд С.К.Шойгу-гийн урилгаар 2 дугаар сард Москва хотноо зохион байгуулсан Улаан арми байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээ, 4 дүгээр сард Олон

улсын аюулгүй байдлын асуудлаарх VII бага хурал, 6 дугаар сард ОХУ-ын Кызыл хотноо зохион байгуулсан Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудын Батлан хамгаалахын сайд нарын зөвлөлийн хуралдаанд тус тус

оролцсон нь тус салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэхэд түлхэц үзүүлэв.

Хоёр орны хууль тогтоох байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж тэргүүтэй төлөөлөгчид ОХУ-ын Хууль зүйн сайд А.В.Коноваловын урилгаар 5 дугаар сард ОХУ-ын Санкт-Петербург хотноо зохион байгуулсан Петербургийн олон улсын эрх зүйн VIII чуулга уулзалтад оролцов.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, ОХУ-ын Хөдөө аж ахуйн сайд А.Н.Ткачев нар Москва хотноо 2 дугаар сард зохион байгуулсан хоёр орны ЗГХК-ын хуралдааны хүрээнд уулзаж хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар 9 дүгээр сард ОХУ-д ажлын айлчлал хийв. Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн Москва хотноо 10 дугаар сард зохион байгуулсан “Эрчим хүчний долоо хоног” олон улсын чуулга уулзалтад оролцов. Тэрээр энэ үеэр ОХУ-ын Эрчим хүчний сайд А.В.Новактай уулзаж хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.


Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа 10 дугаар сард ОХУ-ын Эрхүүгийн Улсын их сургуулийн 100 жилийн ойн арга хэмжээнд оролцсон бөгөөд улмаар 11 дүгээр сард ОХУ-д ажлын айлчлал хийсэн бөгөөд энэ үеэр талууд “Боловсрол, шинжлэх ухааны салбарт 2018-2020 онуудад хамтран ажиллах тухай Монгол Улсын БСШУСЯ, ОХУ-ын Шинжлэх ухаан, дээд боловсролын яам хоорондын хөтөлбөр”, “Монгол Улсын БСШУСЯ, ОХУ-ын Соёлын яам

хоорондын 2018-2020 оны Хамтын ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын БСШУСЯ, ОХУ-ын Спортын яам хоорондын Биеийн тамир, спортын салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичиг”-т тус тус гарын үсэг зурав.

Зам, тээврийн хөгжлийн сайд Я.Содбаатар 11 дүгээр сард Москва хотноо зохион байгуулсан “Тээврийн долоо хоног” олон улсын чуулга уулзалтад оролцохын сацуу ОХУ-ын Тээврийн сайд И.Е.Дитрихтэй уулзаж хоёр улсын энэ салбарын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга А.Гансүх тэргүүтэй төлөөлөгчид ОХУ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Н.П.Патрушевын урилгаар 4 дүгээр сард ОХУ-д ажлын айлчлал хийхийн сацуу аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагуудын өндөр, дээд албан тушаалтны олон улсын IX чуулга уулзалтад оролцов.

*ОХУ-ын Батлан хамгаалахын сайд
Монгол Улсад албан ёсны айлчлал
хийв.*



Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, ОХУ-ын Батлан хамгаалахын сайд С.К.Шойгу нар.

ОХУ-ын Батлан хамгаалахын сайд С.К.Шойгу 10 дугаар сард Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Энэхүү айлчлал нь ОХУ-ын Батлан хамгаалахын сайдын төвшинд манай улсад 10 жилийн дараа хийсэн айлчлал байлаа. Дээрх айлчлалын үеэр талууд Цэргийн хамтын ажиллагааг хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөрт үсэг зурав.

Жил бүр зохион байгуулдаг Монгол, Оросын хамтарсан “Сэлэнгэ-2018” хээрийн сургууль болон “Восток-2018” хээрийн сургууль, Хабаровск хотноо зохион байгуулсан “Амурские волны” цэргийн хөгжмийн наадам, “Армейские международные игры-2018” олон улсын цэргийн тэмцээн зэрэг арга хэмжээнд Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн оролцов.

Хоёр орны хууль тогтоох байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагаа, түүний дотор парламентын байнгын хороодын удирдлагууд болон орон нутгийн хууль тогтоох байгууллагуудын хамтын ажиллагаа өмнөх жилүүдтэй харьцуулахад идэвхжив.

УИХ-ын дарга М.Энхболд 1 дүгээр сард Ази, Номхон далайн орнуудын парламентын XXVI чуулганы үеэр / Вьетнам, Ханой/ ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын орлогч дарга О.Н.Епифанова-тай уулзаж, хоёр талын харилцаа, парламент хоорондын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон бөгөөд улмаар 6 дугаар сард ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын дарга В.В.Володины урилгаар ОХУ-д ажлын айлчлал хийж хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны өргөн хүрээтэй асуудлаар санал солилцсон. Мөн Москва хотноо

зохион байгуулсан “Парламентаризмын хөгжил” сэдэвт олон улсын чуулга уулзалтад тэрээр оролцсон. Түүнээс гадна УИХ-ын дэд дарга Л.Энх-Амгалан Олон улсын Парламентын Холбооны Ассамблейн 138 дугаар чуулганы үеэр /ШХУ, Женев/ ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын орлогч дарга П.О.Толстой-той, Евразийн орнуудын парламентын спикерүүдийн III чуулга уулзалтын үеэр/Турк, Анаталья/ ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын дарга В.В.Володинтой, Олон улсын Парламентын Холбооны Ассамблейн 139 дугаар чуулганы үеэр/ШХУ, Женев/ ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн орлогч дарга И.М.С.Умаханов, ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын орлогч дарга П.О.Толстой нартай тус тус уулзаж, хоёр орны парламент хоорондын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон.

ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2018 оны ээлжит сонгуульд УИХ-ын гишүүн, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Д.Лүндээжанцан, УИХ-ын гишүүн Л.Болд, Б.Энх-Амгалан зэрэг гишүүд ажиглагчаар оролцов. Мөн УИХ-ын гишүүн, Монгол, Буриадын парламентын бүлгийн дарга Н.Оюундарь тэргүүтэй төлөөлөгчид ОХУ-ын Улаан-Үд хотноо 5 дугаар сард зохион байгуулсан Монгол, Буриадын бизнес чуулга уулзалт, 8 дугаар сард зохион байгуулсан Байгалийн боловсролын чуулга уулзалтад тус тус оролцов.

ОХУ-ын Холбооны Зөвлөлийн Үндсэн хуулийн эрх зүй, Төрийн байгуулалтын хорооны дарга А.А.Клишас тэргүүтэй төлөөлөгчид 11 дүгээр сард Монгол Улсад айлчлав.

*Монгол –ОХУ-ын худалдааны эргэлт
1,796 сая ам.долларт хүрэв.*

Монгол, Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжиж, худалдааны эргэлт сүүлийн гурван жил дараалан өсөв. Тухайлбал, 2018 онд Монгол Улс 85,9 сая ам.долларын бараа ОХУ-д экспортлосон нь 2017 оныхтой харьцуулахад 27 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин манай улс ОХУ-аас 1,710,3 сая ам.долларын бараа импортлосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40 хувиар өсч, худалдааны нийт эргэлт 1,796 сая ам.долларт хүрэв. Энэ нь 2017 оны мөн үетэй харьцуулахад хоёр орны нийт худалдааны эргэлт 39,8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хоёр орны худалдааны нийт эргэлт ийнхүү өсөлттэй байгаа хэдий ч манай улсын хувьд хоёр талын худалдаа алдагдалтай хэвээр байна.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын XXI хуралдааныг 2 дугаар сард Москва хотноо хуралдуулж түүний хүрээнд Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд комиссын 13 дугаар хуралдаан, Боловсрол, шинжлэх ухааны хамтын ажиллагааны Дэд комиссын 12 дугаар хуралдаан, Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн асуудлаарх хоёр талын Ажлын хэсгийн зөвлөлдөх уулзалт, Эрчим хүчний яам хоорондын Ажлын хэсгийн анхдугаар уулзалт, Барилга, хот байгуулалтын яамд хоорондын Ажлын хэсгийн 2 дугаар хуралдаан зэргийг тус тус зохион байгуулав.Түүнчилэн Монгол Улсын Шадар сайд, ЗГХК-ын монголын хэсгийн дарга Ө.Энхтүвшин 9 дүгээр сард ОХУ-д ажлын айлчлал хийв.

Орон нутгийн ажил хэргийн түвшний харилцан айлчлал, уулзалт идэвхжсэн нь бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагаанд ихээхэн түлхэц үзүүлэв. Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын урилгаар ОХУ-ын Засгийн газрын орлогч дарга бөгөөд Алс Дорнодын Холбооны тойрог дахь ОХУ-ын Ерөнхийлөгчийн бие төлөөлөгч Ю.П.Трутнев 4 дүгээр сард Монгол Улсад айлчлав. Айлчлалын үеэр талууд тохиролцсоны дагуу Монгол Улс, ОХУ-ын Алс Дорнодын Холбооны тойрог хоорондын харилцааг хөгжүүлэх, төмөр замын болон далайн тээврийн хамтын ажиллагааг эхлүүлэх боломжийг судлах ажлын хэсгийн төлөөлөгчид 5 дугаар сард ОХУ-ын Алс Дорнодод ажиллав. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хоёр хөршийн далайн боомтыг ашиглах, тэдгээрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар 9 дүгээр сард ОХУ-ын Алс Дорнодын бүс нутагт ажиллаж, тус бүс нутгийн болон далайн боомтуудын удирдлага, тээврийн компаниудын төлөөлөлтэй уулзалт хийв.


ОХУ-ын Буриад Улсын тэргүүн А.С.Цыденов 1 дүгээр сард Монгол Улсад айлчилсан бөгөөд энэ үеэр зохион байгуулсан ОХУ-ын БН Буриад Улсын “Хөрөнгө оруулалтын боломжууд” сэдэвт бизнес чуулга уулзалтад монголын талаас 100 орчим, буриадын талаас 40 орчим аж ахуй нэгж оролцов. Мөн Буриад Улсын Ардын Хурлын дарга Ц.-Д.Э.Доржиев тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад 4 дүгээр сард айлчлав. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатарын урилгаар ОХУ-

ын Тува Улсын тэргүүн Ш.В.Кара-оол 5 дугаар сард Монгол Улсад ажлын айлчлал хийж, хоёр талын харилцаа, зам, тээвэр, эрчим хүч, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааны асуудлуудаар санал солилцов. “Монгол, Оросын санаачилга-2018” цуврал арга хэмжээний хүрээнд ОХУ-ын Эрхүү мужийн Амбан захирагч С.Г.Левченко, ОХУ-ын Буриад Улсын Засгийн газрын эдийн засгийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч дарга И.И.Зураев нар тус тус оролцов. ОХУ-ын Эрхүү хотын дарга Д.В.Бердников 11 дүгээр сард Монгол Улсад айлчилж, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын дарга С.Батболдтой хэлэлцээ хийж, Улаанбаатар, Эрхүү хотуудын хоорондын 1998 онд байгуулсан хамтын ажиллагааны Хэлэлцээрийг хэрэгжүүлэх Нэмэлт хэлэлцээрт гарын үсэг зурж, холбогдох албаны хүмүүстэй уулзалт хийв.

*Монгол Улс Владивосток хотноо
Худалдааны төлөөлөгчийн газар
нээхээр шийдвэрлэв.*

Монгол Улс ОХУ-ын Владивосток хотноо Худалдааны төлөөлөгчийн газар нээж ажиллуулахаар Оросын талтай тохиролцож, холбогдох бэлтгэл ажлыг хангав.

МОНГОЛ УЛС-БНХАУ



Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, БНХАУ-ын дарга Ши Жиньпин нар Дорнын эдийн засгийн чуулга уулзалтын үеэр

Монгол Улс, БНХАУ-ын харилцаа нь өнгөрсөн 70 жилийн хугацаанд улс хоорондын харилцааны шалгуур, бэрхшээл, сорилтыг давж, өдгөө хамгийн таатай үедээ хөгжиж байна. 1994 онд “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ” байгуулсан нь хоёр орны харилцааны эрхзүйн үндэс болж байна. Тус гэрээг байгуулснаас хойшх 25 жилийн хугацаанд хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарт өргөжин гүнзгийрч ирсэн бөгөөд 2003 онд Сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн, 2011 онд Стратегийн түншлэлийн, 2014 онд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг тус тус тогтоон болж хөгжүүлж байна. Цаашид урт хугацаанд тогтвортой, идэвхтэй хамтын ажиллагааг бэхжүүлж бүс нутагт төдийгүй хөрш зэргэлдээ улс орнуудын харилцааны үлгэр жишээ болгон хөгжүүлэхээр санал нэгдсэн.


Монгол, Хятадын дээд, өндөр түвшний яриа хэлэлцээ, харилцан

айлчлалын давтамжийг хадгалах зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ахиц гарч, харилцан айлчлал, уулзалт тогтмолжиж, улс төрийн намууд, төр, хувийн хэвшил, иргэд хоорондын солилцоо улам бүр өргөжиж, харилцан итгэлцэл нэмэгдсэн.

БНХАУ-ын дарга Ши Жиньпиний урилгаар Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 6 дугаар сарын 10-12-нд БНХАУ-ын Чиндао хотноо зохион байгуулсан ШХАБ-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн хуралдаанд оролцож, энэ үеэр БНХАУ-ын дарга Ши Жиньпинтэй хоёр талын уулзалт хийв. ШХАБ-ын дээд түвшний уулзалтын үеэр Монгол, Хятад, Орос гурван улсын төрийн тэргүүн нарын 4 дэх удаагийн уулзалтыг талууд зохион байгуулж, гурван талын хамтын ажиллагааг бэхжүүлэх, эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг түргэтгэх асуудлаар санал солилцов.

Ерөнхийлөгч Х.Баттулга ОХУ-ын Владивосток хотноо 9 дүгээр сард зохион байгуулагдсан “Дорнын чуулга уулзалт”-д оролцох үеэрээ БНХАУ-ын дарга Ши Жиньпинтэй мөн уулзаж, хоёр талын улс төрийн харилцан итгэлцэл, уламжлалт найрсаг харилцааг бэхжүүлэх, Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх талаар ярилцаж, нэгдмэл ойлголтод хүрсэн.

*Монгол Улсын Ерөнхий сайд
БНХАУ-д албан ёсны айлчлал хийв.*



Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Кечянь нар


Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 4 дүгээр сард БНХАУ-д албан ёсны айлчлал хийж, Хайнань мужийн Боа хотноо зохион байгуулсан Азийн төлөөх Боаогийн чуулга уулзалтад оролцов. Ерөнхий сайд У.Хүрэлсүх БНХАУ-ын дарга Ши Жиньпин, БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Ли Жаньшунарт бараалхаж, Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Көчянтай албан ёсны хэлэлцээ хийв. Айлчлалын үеэр талууд хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны явцыг дүгнэж, хэтийн төлвийн талаар санал солилцож, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тодорхой асуудлуудыг урагшлуулах, ялангуяа БНХАУ-ын Засгийн газраас олгосон хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх томоохон төслүүдийг эрчимжүүлэхээр тохиролцов. Айлчлалын хүрээнд Монгол, Хятадын бизнес форум зохион байгуулсан бөгөөд энэ үеэр хоёр орны аж ахуйн нэгжүүдийн хооронд нийт 4,6 тэрбум ам.долларын гэрээ, хэлэлцээр байгуулав.

Хоёр улсын хууль тогтоох, хууль сахиулах байгууллага хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Монгол, Хятадын парламент хоорондын байнгын уулзалтын механизмын хоёр

дахь удаагийн уулзалтыг 2 дугаар сард Бээжин хотноо талууд зохион байгуулсан бөгөөд түүнд манай төлөөлөгчдийг УИХ-ын дэд дарга Л.Энх-Амгалан тэргүүлж оролцов. УИХ-ын дэд дарга Л.Энх-Амгалан тэргүүтэй манай төлөөлөгчид БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Жан Дөжянтай уулзаж, хоёр улсын харилцаа, парламент хоорондын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

Монгол Улс, БНХАУ-ын ГХЯ-дын харилцаа идэвхтэй өрнөж, хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд амжилттай хэрэгжиж, газар, нэгж хоорондын харилцан айлчлал, зөвлөлдөх уулзалт, ажил хэргийн холбоо үр дүнтэй хэрэгжиж байна.

*БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн гишүүн,
Гадаад хэргийн сайд Монгол Улсад
албан ёсоор айлчлав.*



Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатарын урилгаар БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн бөгөөд Гадаад хэргийн сайд Ван И 8 дугаар сард Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр хоёр орны Гадаад харилцааны сайд нар албан ёсны хэлэлцээ хийснээс гадна сайд Ван И Ерөнхийлөгч Х.Баттулга, УИХ-

ын дарга М.Энхболд болон Ерөнхий сайд У.Хүрэлсүх нарт бараалхав. Яриа хэлэлцээний үеэр талууд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаагаа бэхжүүлэх хүрээнд улс төр, худалдаа, эдийн засаг, хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх асуудал болон бүс нутаг, олон улсын байдлын талаар санал солилцож, хоёр орны харилцааг бие биеийн хөгжлийг дэмжсэн, бүс нутагт үлгэр дууриалал болсон хамтын ажиллагаа болгохоор тохиролцов. Хятадын тал хоёр орны харилцааг "...байгалиас заяасан хамтрагч түнш, харилцаа, хамтын ажиллагааг тод, хэлбэрэлтгүй хөгжүүлэх"-ийн төлөө байгаагаа нотлосон бөгөөд манай тал "...хөгжлийн төлөөх харилцан ашигтай, түншлэлийн харилцаа"-г хэлбэрэлтгүй хөгжүүлэхийн төлөө байгаагаа илэрхийлэв. Мөн талууд хоёр улсын ГХЯ-д хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэхээр тохиролцож, 2019 онд тохиох Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойг хамтран тэмдэглэх тухай Санамж бичиг, 2019-2020 онд Монгол Улсын ГХЯ, БНХАУ-ын ГХЯ хоорондын хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тус тус үсэг зурав.

Монгол Улсын Гадаад харилцааны яам, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын засгийн газар хоорондын байнгын зөвлөлдөх ажлын хэсгийн IV уулзалтыг 8 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулав. Зөвлөлдөх ажлын хэсгийн хуралдааны хүрээнд Худалдаа, боомт, зам тээврийн салбар хуралдаан, соёл, хүмүүнлэг, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбар хуралдаануудыг зохион байгуулав.

Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Г.Занданшатарын урилгаар ХКН-ын Төв хорооны Улс төрийн товчооны гишүүн, Тяньжин хотын Намын хорооны нарийн бичгийн дарга Ли Хунжун 10 дугаар сард, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Намын хорооны нарийн бичгийн дарга, АТИХ-ын Байнгын хорооны дарга Ли Жихөн тэргүүтэй төлөөлөгчид 7 дугаар сард Монгол Улсад айлчлав. Г.Занданшатар 9 дүгээр сард ӨМӨЗО-ны Намын хорооны нарийн бичгийн дарга, Ардын төлөөлөгчдийн хурлын дарга Ли Жихөний урилгаар БНХАУ-ын ӨМӨЗО-нд хариу айлчлал хийв.

Монгол Улсын Батлан хамгаалахын сайд БНХАУ-д албан ёсоор айлчлав.



Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, БНХАУ-ын Цэргийн Төв Зөвлөлийн орлогч дарга хурандаа генерал Сюй Цилян нар

Батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах салбарын хамтын ажиллагаанд ахиц гарав. Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Н.Энхболд 5 дугаар сард БНХАУ-д албан ёсны айлчлал хийв.

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын Засгийн газар хоорондын комиссын

XV хуралдааныг хоёр тал 9 дүгээр сард Бээжин хотноо зохион байгуулж хоёр орны хамтын ажиллагааны өнөөгийн байдлыг дүгнэж, хэтийн чиг хандлагыг тодорхойлж, “Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны дунд хугацааны хөтөлбөр”-ийг шинэчлэн, хэрэгжүүлэх хамтарсан төлөвлөгөө, “Хөгжлийн зам” хөтөлбөр болон “Бүс ба Зам” санаачилгыг уялдуулах тухай санамж бичгийг хэрэгжүүлэх хамтарсан төлөвлөгөө, БНХАУ-ын Засгийн газраас 2018-2020 онд Монгол Улсад үзүүлэх буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх төслүүдийн төлөвлөгөө зэргийг тус тус гаргаж хамтарч ажиллахаар тохиролцов.

Монгол Улс, БНХАУ-ын эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд томоохон төслүүдийн хэрэгжилтэд бодит ахиц гарав. Энэ хүрээнд Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх төслийн ажлыг эхлүүлж, Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах ажлыг бүрэн гүйцэтгэж, Замын цагдаагийн газрын дэргэдэх гүүрэн гарцын инженерийн ажлыг үргэлжлүүлж 2019 оны сүүлээр ашиглалтад оруулахаар ажиллаж байна. БНХАУ-ын Засгийн газраас 2014 онд олгосон 300 сая юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр ерөнхий боловсролын 7 сургууль, 1 цэцэрлэг барихаар хоёр тал тохиролцож, холбогдох төслүүдийг хэрэгжүүлсэн бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй Хүүхдийн ордон барьж ашиглалтад оруулав.

*Монгол, Хятадын худалдаа
21 хувиар өсөв.*

Шанхай хотноо 11 дүгээр сард зохион байгуулсан “Хятадын олон улсын импортын ЭКСПО”-д Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар тэргүүтэй манай төлөөлөгчид оролцсон нь хоёр орны бизнесийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болов. Монгол Улс, БНХАУ-ын худалдааны нийт эргэлт 2018 оны эцсийн байдлаар 8,4 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд манай экспорт 6,5 тэрбум ам.доллар, импорт 1,9 тэрбум ам.долларт хүрсэн нь нийт худалдааны хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,8 тэрбум ам.доллар буюу 21 хувиар өсөв. БНХАУ-тай хийсэн худалдаа манай улсын нийт гадаад худалдааны 65,2 %-ийг эзлэж байна.

*Монгол, Хятадын хүмүүнлэгийн
солилцооны хамтарсан зөвлөл
байгуулж үйл ажиллагаагаа эхлүүлэв.*

Бусад салбарын хамтын ажиллагаа. Монгол, Хятадын хүмүүнлэгийн солилцооны хамтарсан зөвлөл байгуулж, анхдугаар хуралдааныг 1 дүгээр сард Бээжин хотноо зохион байгуулав. Хамтын ажиллагааны энэхүү шинэ механизм нь хоёр орны хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байгаа бөгөөд уг Зөвлөлийг монголын талаас ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, хятадын талаас БНХАУ-ын Гадаад хэргийн дэд сайд тэргүүлж байхаар хоёр тал тохирсны дагуу энэ оны хуралдааныг манай талаас ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, хятадын талаас Гадаад хэргийн дэд сайд

Кун Шюаньёу нар тэргүүлэв. Энэхүү хуралдаанд хоёр талын боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт, хэвлэл мэдээлэл, хүмүүнлэг, аялал жуулчлал зэрэг салбар хариуцсан яам, агентлаг болон төрийн байгууллагуудын төлөөлөл оролцов. Талууд боловсрол, соёл, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, кино, телевиз, биеийн тамир, спорт, аялал жуулчлал, найрсаг солилцоо, хүүхэд залуучууд, орон нутгийн солилцоо зэрэг хүмүүнлэгийн 9 салбарын хамтын ажиллагааны өргөн хүрээтэй асуудлаар санал солилцож, нийт 44 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр тохиролцож ажил хэрэг болгов. Хоёр орны хүүхэд, залуучуудын солилцооны төлөвлөгөөний дагуу манай 100 залуу БНХАУ-д, Хятадын 50 залуу Монгол Улсад танилцах аялал хийв.

ГУРВАН ТАЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



БНХАУ-ын Чиндао хотноо 6 дугаар сард зохион байгуулсан ШХАБ-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн 18 дугаар хуралдааны үеэр Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын 4 дэх удаагийн гурван талын уулзалтыг зохион байгуулж “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг идэвхжүүлэхээр тохиролцов. Энэ хүрээнд талууд Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридорыг хамтран урагшлуулах механизм байгуулах тухай Монгол Улсын ГХЯ, ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яам, БНХАУ-ын Хөгжил, шинэчлэлийн хорооны хооронд Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, түүний дагуу дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх гурван талын ажлын хэсгийн шинжээчдийн түвшний зөвлөлдөх уулзалтыг 12 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулж, гурван талын нэн тэргүүнд хэрэгжүүлэх төслүүдийн талаар хэлэлцэв. Уулзалтаар “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны өнөөгийн байдлыг дүгнэж, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцов.

Монгол Улс, ОХУ, БНХАУ Эдийн засгийн коридорыг хамтран урагшлуулах механизм байгуулахаар тохиров.


Гурван талын хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Аялал жуулчлалын сайд нарын III хуралдааныг 7 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан бөгөөд түүнд БНХАУ-ын Соёл, аялал жуулчлалын дэд сайд Ду Жян, ОХУ-ын Холбооны Аялал жуулчлалын агентлагийн орлогч дарга Н.В.Королев тэргүүтэй төлөөлөгчид оролцож, хуралдааны дүнгээр Протокол байгуулав. Мөн гурван улсын найрсаг харилцааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үүднээс 11 дүгээр сард Улаанбаатар хотноо “Улаанбаатар–Улаанцав–Улаан-Үд хотуудын Хамтын Ажиллагаа 2018” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд түүнд манай нийслэлийн засаг даргын тамгын газар, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын Засгийн газар, ОХУ-ын Буриад Улсын Улаан-Үд хотын захиргаа, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Олон улсын худалдааг дэмжих хороо, ОХУ-ын Буриад Улсын Ардын хурал, ОХУ-ын Буриад Улсын Бүс нутгийн хөгжлийн сан, Монгол Улс дахь ОХУ-ын Худалдааны төлөөлөгчийн газар тус тус оролцов.

Азийн автозамын сүлжээгээр олон улсын авто тээвэр гүйцэтгэх тухай гурван талт хэлэлцээр хүчин төгөлдөр болов.

Монгол Улсын төмөр замаар дамжин өнгөрөх тээврийн хэмжээ 2018 онд нэмэгдсэн бөгөөд “Азийн автозамын сүлжээгээр олон улсын авто тээвэр гүйцэтгэх тухай” Монгол, Орос, Хятадын гурван талт хэлэлцээр хүчин төгөлдөр болсон нь цаашид худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэнэ гэж үзнэ.

МОНГОЛ УЛС БА АЗИ, НОМХОН ДАЛАЙН ОРНУУД

МОНГОЛ УЛС-ЯПОН



Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, Япон Улсын Ерөнхий сайд Ш.Абэ нар

Монгол-Японы Стратегийн түншлэлийн харилцаа бэхжиж, дээд, өндөр түвшинд харилцан айлчлал хэрэгжиж, бүс нутгийн хамтын ажиллагаа өргөжив.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 9 дүгээр сард ОХУ-ын Владивосток хотноо “Дорнын эдийн засгийн IV чуулга уулзалт”-ын үеэр Япон Улсын Ерөнхий сайд Ш.Абэтэй уулзаж хоёр улсын Стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, эдийн засгийн болон бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх асуудлуудаар санал солилцов.



Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Япон Улсын Ерөнхий сайд Ш.Абэ нар

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 12 дугаар сард Япон Улсад албан ёсоор айлчлав. Айлчлалын үеэр талууд хоёр улсын улс төрийн итгэмжилсэн харилцааг гүнзгийрүүлэх, эдийн засгийн харилцааг идэвхжүүлж, худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, олон улс, бүс нутгийн түвшинд үйл ажиллагаагаа уялдуулахад чухал ач холбогдолтой болов.

Ерөнхий сайд Япон Улсад албан ёсоор айлчлав.

Парламент хоорондын хамтын ажиллагаа идэвхтэй өрнөж хоёр улсын хууль тогтоох дээд байгууллагын дэд дарга нар харилцан айлчлав.

Гадаад харилцааны сайд Япон Улсад албан ёсоор айлчлав.



Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Япон Улсын
Гадаад харилцааны сайд Коно Таро нар

Монгол Улсын Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар 2 дугаар сард Япон Улсад албан ёсоор айлчилснаас гадна 4 дүгээр сард Монгол, Японы Гадаад харилцааны яам хоорондын стратегийн III зөвлөлдөх уулзалтыг Токио хотноо зохион байгуулав. Түүнчлэн Япон Улсын Ерөнхий сайдын Үндэсний аюулгүй байдлын асуудал эрхэлсэн зөвлөх К.Соноура 8 дугаар сард Монгол Улсад айлчлав.

Япон Улсад цэргийн атташе суулгав.

Хоёр улсын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд Монголын Улс Токио дахь ЭСЯ-ндаа цэргийн атташе суулгахаар шийдвэрлэж ажил хэрэг болгов. Японы тал Монгол Улсын Зэвсэгт хүчний чадавхийг нэмэгдүүлэх чиглэлд дэмжлэг үзүүлж байна.

32 тэрбум иенийн санхүүжилт амжилттай хэрэгжив.

Япон Улсын Засгийн газраас ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад олгож буй "Төсөв, нийгэм болон эдийн засгийн шинэчлэлийн хөгжлийн бодлогын зээл"-ийн I шатны 32 тэрбум иенийн санхүүжилт амжилттай

хэрэгжиж, манай улсын төсвийн нөхцөл байдлыг сайжруулах, макро эдийн засгийг тогтворжуулахад үнэтэй хувь нэмэр оруулав.

Япон Улсын баруун нутгаар хүчтэй бороо орж, үер болсны улмаас олон хүний амь үрэгдэж, эд материалын их хэмжээний хохирол учирсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас хүмүүнлэгийн тусламж үзүүлэв.

Худалдаа 55 хувиар өсөв.

Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлд ахиц гарч, худалдаа, хөрөнгө оруулалт нэмэгдэв. Хоёр орны худалдааны нийт эргэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 588 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 55% өссөн бөгөөд манай улсын нийт худалдааны 4.6 хувийг эзлэв. Үүнээс экспорт 26,5 сая (79%-иар өссөн), импорт 561 сая ам.долларт (55%-иар өссөн) хүрэв.

Монгол, Японы худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаарх төр, хувийн хэвшлийн IX зөвлөлдөх уулзалт, Монгол, Японы бизнес форум Токио хотноо, Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хамтын ажиллагааны асуудлаарх хамтарсан Дэд хорооны анхдугаар хуралдаан, Монгол-Хоккайдогийн бизнес форумыг Улаанбаатар хотноо тус тус зохион байгуулсан болно. Монгол Улсын Засгийн газар хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхижүүлэх үүднээс Токио хотноо Худалдааны төлөөлөгчийн газар нээж ажиллуулахаар шийдвэрлэв.

*Монгол Улсын Худалдааны
төлөөлөгчийн газар Токио хотноо
нээхээр шийдвэрлэв.*

Япон Улсын Засгийн газраас Монгол Улсад үзүүлэх Хөгжлийн албан ёсны тусламжийн хөтөлбөрийг манай улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичигтэй уялдуулан макро эдийн засгийн менежментийг сайжруулж, засаглалыг бэхжүүлэх, хүрээлэн буй орчинд ээлтэй эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, нийтэд тэгш хүртээмжтэй нийгмийг цогцлоон бүтээх чиглэлд тэргүүлэх ач холбогдол өгч шинэчлэв.

Япон Улсын Засгийн газрын ХАЁТ-ийн шугамаар хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал” төслийн менежментийн концессын гэрээг байгуулах яриа хэлэлцээ үргэлжилж, “Монгол, Японы хамтарсан АШУУИС-ийн харьяа их сургуулийн эмнэлэг байгуулах төсөл”, “Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр”, “Инженер, технологийн дээд боловсрол” зэрэг төслүүд амжилттай хэрэгжиж байна. Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын шугамаар “Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл”, “Хөдөө аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэх замаар нэмүү өртгийн сүлжээг бий болгох мастер төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийг тус тус хэрэгжүүлэх, “Мал эмнэлэг, мал, аж ахуйн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийг үргэлжлүүлэхээр талууд тохирлцсон.

Соёл, боловсрол, урлаг, спорт, олон нийтийн харилцааг идэвхижүүлэх хүрээнд Монгол, Японы найрамдал, олон нийтийн байгууллагуудын “Хурилдай II” арга хэмжээ 9 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулснаас гадна Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Япон Улсын Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, Япон Улсын “Гадаадын иргэн харьяатын багц хууль”-ийн нэмэлт өөрчлөлтийн тухай хуулинд нь мэргэжлийн ажилтан хүлээн авах орнуудын жагсаалтад Монгол Улсыг оруулав.

Бүс нутаг, олон улсын тавцан дахь хоёр орны хамтын ажиллагааны хүрээнд Монгол, Япон, АНУ-ын гурван талт III уулзалт 4 дүгээр сард Токио хотноо зохион байгуулсан бөгөөд Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлцээ” олон улсын V бага хуралд Япон Улсын ГХЯ-ны төлөөлөгчид оролцов. Монгол Улсын Зүүн Азийн дээд түвшний уулзалтад оролцох эрмэлзлийг японы тал дэмжихээ дээд түвшинд нотлов. Түүнчлэн хоёр улс бүс нутгийн нээлттэй хөгжил, хамтын ажиллагааг дэмжих хүрээнд “Чөлөөт, нээлттэй Энэтхэг, Номхон далай”-г цогцлоох чиглэлд хамтран ажиллахаар санал нэгдэв.

МОНГОЛ УЛС-БНСУ




Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, БНСУ-ын Ерөнхий сайд Ли Хаг Ён нар

Монгол Улс, БНСУ-ын “иж бүрэн

түншлэл”-ийн харилцаа улс төр, эдийн засаг, соёл, боловсрол зэрэг нийгмийн бүхий л салбарыг хамран өргөжин хөгжиж байна.

Ерөнхий сайд БНСУ-д албан ёсоор айлчлав.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 2018 оны 1 дүгээр сард БНСУ-д албан ёсоор айлчилж Ерөнхий сайд Ли Хаг Ён-тэй хэлэлцээ хийж, хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, иргэд зорчих нөхцлийг хөнгөвчлөх болон олон улс, бүс нутгийн асуудлаар санал солилцов.



Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, БНСУ-ын Ерөнхийлөгч Мүн Жэ Ин-д бараалхав.

Монгол Улсын Ерөнхий сайд У. Хүрэлсүхийг БНСУ-ын Ерөнхийлөгч Мүн Жэ Ин хүлээн авч уулзаж, хоёр орны харилцааг шат ахиулан “стратегийн түншлэл”-ийн түвшинд хүргэх санал дэвшүүлэв. Айлчлалын үеэр БНСУ-ын Засгийн газраас ОУВС-

ийн хөтөлбөрийн хүрээнд олгож буй 500 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн Ерөнхий хэлэлцээрт талууд гарын үсэг зурж, зээлийн хөрөнгийг Улаанбаатар хотын агаарын бохирдол, орчны асуудлыг шийдвэрлэхэд зарцуулахаар тохиролцов. Айлчлалын хүрээнд

Монгол-Солонгосын Бизнес форум зохион байгуулж, хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, хамтын ажиллагааны боломжуудын талаар бизнес эрхлэгчид санал солилцов.



БНСУ-ын Ерөнхий сайд Ли Хаг Ён, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхав.


Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2018 оны 9 дүгээр сард Владивосток хотноо болсон “Дорнын эдийн засгийн

IV чуулга уулзалт”-ын үеэр БНСУ-ын Ерөнхий сайд Ли Хаг Ён-тэй уулзаж Монгол Улс, БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойг 2020 онд тэмдэглэх, хоёр улсын харилцааг шат ахиулах, Монгол Улс, БНСУ-ын Бизнес Зөвлөл байгуулж хамтран ажиллах зэрэг санал тавьж, бүс нутгийн хүрээнд хамтран ажиллах боломжийн талаар санал солилцов.

БНСУ манай гадаад худалдааны 4 дэх түнш

Хоёр орны худалдааны нийт эргэлт 2018 оны 12 дугаар сард 283,5 сая ам.доллар, үүнээс экспорт 21,2 сая ам.доллар, импорт 262,3 сая ам.доллар тус тус эзэлж байна. Хоёр орны 2018 оны худалдааны эргэлтийг 2017 оны мөн үетэй харьцуулахад 35.4 хувиар өссөн байна. БНСУ нь Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтийн 2,2 хувийг эзлэж манай худалдааны түншүүдийн 4 дүгээрт багтаж байна.

МОНГОЛ УЛС-БНАСАУ



Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, БНАСАУ-ын Гадаад хэргийн сайд Ри Ён Хо нар.


Гадаад харилцааны сайд нар харилцан айлчлав.

Монгол Улс, БНАСАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойг талууд өргөнөөр тэмдэглэв. Ойн хүрээнд Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар 2 дугаар сард БНАСАУ-д, БНАСАУ-ын Гадаад хэргийн сайд Ри Ён Хо 12 дугаар сард Монгол Улсад айлчлав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд тэргүүтэй төлөөлөгчид БНАСАУ-д айлчлав. УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол, БНАСАУ-ын Парламентын бүлгийн дарга

О.Баасанхүү 9 дүгээр сарын 9-ний өдөр Пёньян хотноо зохион байгуулсан

БНАСАУ байгуулагдсаны 70 жилийн ойн арга хэмжээнд оролцсон.



БНАСАУ-ын Ардын Дээд Хурлын гишүүн, Солонгос-Монголын найрамдлын бүлгийн дарга, Дээд боловсролын сайд Тэ Хён Чөл Монгол Улсад айлчлав.

форум”-д БНАСАУ-ын Пёньян хотын Ардын хорооны Гадаад харилцааны газрын дарга Пак Сан Вон тэргүүтэй төлөөлөгчид тус тус оролцсон.

“Улаанбаатарын яриа хэлэлцээ” олон улсын V бага хуралд БНАСАУ-ын ГХЯ-ны Зэвсэг хорогдуулах Энх тайвны хүрээлэнгийн захирал Ким Ён Гүк тэргүүтэй төлөөлөгчид, Улаанбаатар хотноо зохион байгуулсан “Зүүн хойд Азийн хотын дарга нарын

Пёньяны Гадаад хэлний дээд сургуульд монгол хэл, соёлын танхим байгуулж, Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Дэлхийн монгол судлаач” зуны сургалтанд Пёньяны Гадаад хэлний дээд сургуулийн 2 оюутан оролцов.

МОНГОЛ УЛС-БНЭУ



Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, БНЭУ-ын Гадаад хэргийн сайд Сушма Свараж нар.

түншлэлийн харилцаа гүнзгийрч, яриа хэлэлцээний давтамж хадгалагдаж, хоёр орны эдийн засгийн харилцаанд бодитой ахиц гарсан он байлаа.

Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Энэтхэг Улсад, Энэтхэгийн Гадаад хэргийн сайд, Дотоод хэргийн сайд нар манай улсад тус тус айлчлав. БНЭУ-ын Гадаад хэргийн сайд Сушма Свараж Кушок Бакула ринбүчигийн мэлмий гийсний 100 жилийн ойн хуралд оролцов.

Монгол, Энэтхэгийн Стратегийн

Монгол, Энэтхэгийн Гадаад харилцааны яам хоорондын ээлжит зөвлөлдөх уулзалтыг 11 дүгээр сард Шинэ Дели хотноо зохион байгуулсан бөгөөд манай талын төлөөлөгчдийг ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн тэргүүлж оролцов. Зөвлөлдөх уулзалтаар талууд Монгол, Энэтхэгийн харилцаа, хамтын ажиллагааг улс төр, аюулгүй байдал, батлан хамгаалах,

худалдаа, хөрөнгө оруулалт, мэдээллийн технологи, харилцаа холбоо, хөдөө аж ахуй, боловсрол, соёл, хүмүүнлэгийн зэрэг өргөн хүрээтэй салбарт хөгжүүлэх, мөн олон улс, бүс нутгийн талбарт бие биеэ дэмжсэн нягт хамтын ажиллагааг цаашид ч үргэлжлүүлэхээр тохиролцов.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн шав тавив.



Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, БНЭУ-ын Дотоод хэргийн сайд Ражнат Сингх нар газрын тос боловсруулах үйлдвэрийн шав тавив.

Монгол, Энэтхэгийн Хамтын ажиллагааны хамтарсан хорооны VI хуралдааныг Улаанбаатар хотноо зохион байгуулав. Энэтхэг Улсын Засгийн газрын 1 тэрбум ам.долларын зээлээр Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр барих ажилд бодит ахиц гарч холбогдох үйлдвэрийг Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт барихаар тохирч үйлдвэрийн шавыг тавив. Шав тавих ёслолын ажилд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Энэтхэгийн талаас Дотоод хэргийн сайд Ражнат Сингх нар оролцов. Газрын тос боловсруулах үйлдвэрийг барих ажлыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар

тэргүүтэй төлөөлөгчид БНЭУ-д, Энэтхэгийн ГХЯ, “Инженерс Индиа Лимитед” компанийн төлөөлөгчид манай улсад тус тус ажиллаж холбогдох яриа хэлэлцээг хийв.

Монгол, Энэтхэгийн зэвсэгт хүчний албан хаагчдын багууд Монгол Улсад зохиосон “Хааны эрэлд”, “Нүүдэлчин заан” хээрийн сургуулиудад уламжлал ёсоор оролцов.

Хоёр орны худалдааны эргэлт 52,6 сая ам.доллар, үүнээс экспорт 990 мянган ам.доллар, импорт 51,7 сая ам.доллар байна.

МОНГОЛ УЛС- ӨМНӨД АЗИЙН ОРНУУД




Балба Улсын Гадаад хэргийн сайд Ерөхийлөгч Х.Баттулгад бараалхав.

Балба Улсын Гадаад хэргийн сайд Прадип Кумар Гявали 6 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан Далайд гарцгүй орнуудын Олон улсын судалгааны төвийн нээлтийн бага хуралд оролцов. Энэ үеэр сайд Прадип Кумар Гявали Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхаж, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатартай уулзаж хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

Хоёр орны Гадаад харилцааны яамдын анхдугаар зөвлөлдөх уулзалтыг талууд 10 дугаар сард Катманду хотноо зохион байгуулсан бөгөөд манай төлөөлөгчдийг ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн тэргүүлэв. Монгол Улс болон Балба Улс нь шашин шүтлэг, өв соёлын хувьд ойр, нийтлэг үнэт зүйлсээр холбогддог зэрэг нь найрсаг харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх хөрс суурь болж байгаа бөгөөд хөгжиж буй, далайд гарцгүй орнуудын хувьд хоёр талын болон олон улс, бүс нутгийн түвшинд хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх хүсэлтэй байгаагаа хоёр тал нотлов.

Монгол, Балбын худалдааны эргэлт 54,200 ам.доллар, үүнээс экспорт 23,000 ам.доллар, импорт 31,200 ам.доллар байна.

Бутан Улс Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төвийг үүсгэн байгуулах тухай Олон талт хэлэлцээрт 2018 оны 4 дүгээр сарын 3-нд нэгдэж, тус төвд нэгдсэн 11 дэх улс болов. Улаанбаатар хотноо 6 дугаар сард зохион байгуулагдсан Далайд гарцгүй орнуудын Олон улсын судалгааны төвийн нээлтийн бага хуралд Бутаны Гадаад хэргийн сайд Дамчо Доржи оролцов. Энэ үеэр Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Гадаад хэргийн сайд Дамчо Доржи-той уулзаж, хоёр орны хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.



Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Бутаны Гадаад хэргийн сайд Дамчо Доржи нар.

Манай улсын зохион байгуулж ирсэн энхийг дэмжих ажиллагааны “Хааны эрэлд” олон улсын хээрийн сургуульд бутаны тал анх удаа ажиглагчийн түвшинд оролцов.


Монгол, **Пакистаны** Гадаад хэргийн яамдын анхдугаар зөвлөлдөх уулзалтыг 11 дүгээр сард Исламабад

хотноо зохион байгуулсан бөгөөд манай төлөөлөгчдийг ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн тэргүүлэв. Зөвлөлдөх уулзалтын үеэр талууд хоёр орны улс төрийн яриа хэлэлцээг бэхжүүлэх, харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн болон

бусад салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийн талаар санал солилцов.

2018 оны байдлаар Монгол Улс Пакистан Улсаас 1,5 сая ам.долларын бараа бүтээгдэхүүн импортлосон бөгөөд экспорт хийгээгүй.

МОНГОЛ УЛС-ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН ОРНУУД



УИХ-ын дарга М.Энхболд, БНСВУ-ын Үндэсний Ассамблейн дарга Нгуен Тхи Ким Нган нар

БНСВУ-ын Үндэсний Ассамблейн дарга Нгуен Тхи Ким Нганы урилгаар УИХ-ын дарга М.Энхболд 2018 оны 1 дүгээр сард Ханой хотноо болсон Ази, Номхон далайн парламентын чуулганы 26 дугаар форумд оролцож, мөн албан ёсоор айлчилж хоёр улсын уламжлалт найрсаг харилцааг өргөжүүлэх, парламент хоорондын хэлхээ холбоог гүнзгийрүүлэх талаар санал солилцов. Айлчлалын хүрээнд Монгол Улсын Их Хурал, Вьетнам Улсын Үндэсний Ассамблейн хооронд 2018-2022 онд хамтран ажиллах тухай санамж бичиг, Монгол Улсын Төв аймаг, Вьетнам Улсын Хоа Бинь муж хооронд хамтран ажиллах санамж бичигт талууд гарын үсэг зурав.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Брюссель хотноо болсон АСЕМ-ын 12 дугаар бага хуралд оролцох үеэр Вьетнам Улсын Ерөнхий сайд Нгуен Суан Фук бараалхсан бөгөөд Евразийн орнуудын Парламентын спикерүүдийн III чуулганы үеэр УИХ-ын дэд дарга Л.Энх-Амгалан Үндэсний Ассамблейн дарга Нгуен Тхи Ким Нгантай уулзаж хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар тус тус санал солилцсон. ҮАБЗ-ийн Нарийн бичгийн дарга А.Гансүх болон Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нар Вьетнам Улсад айлчилсан. ХЗДХ-ийн сайдын айлчлалын үеэр талууд "Ялтан шилжүүлэх тухай гэрээ"-нд гарын үсэг зурж, "Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон БНСВУ хоорондын гэрээ"-г үзэглэв.

ГХЯ-ны ТНБД Д.Даваасүрэн тэргүүтэй төлөөлөгчид Вьетнам Улсад ажиллаж Вьетнам-Евразийн орнуудын хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан туршлага судлахын сацуу Вьетнамын холбогдох албаны хүмүүстэй уулзаж хамтын ажиллагааны асуудлуудаар санал солилцсон. Вьетнам Улсын Гадаад хэргийн дэд сайд Ле Хоай Чунг Монгол Улсад айлчилж, мөн хоёр улсын ГХЯ-дын зөвлөлдөх уулзалт хийв.

Хоёр орны худалдааны эргэлт 58,5 сая ам.доллар, үүнээс экспорт 9 сая 648.3 мянган ам.доллар, импорт 48 сая 951.0 мянган ам.доллар байна.

Монгол, **БНАЛАУ**-ын харилцаа, хамтын ажиллагааны хувьд УИХ-ын дарга М.Энхболд 1 дүгээр сард Ханой хотноо зохион байгуулсан Ази, номхон далайн орнуудын Парламентын чуулга уулзалтад оролцох үеэрээ, УИХ-ын дэд дарга Л.Энх-Амгалан 10 дугаар сард Женев хотноо зохион байгуулсан ОУПХ-ны чуулганы үеэр Лаосын Үндэсний Ассамблейн дэд дарга Сенгнүан Саяалаттай уулзаж хоёр орны хоёр орны парламентын хоорондын хамтын ажиллагаа болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон.

Лаосын Үндэсний Ассамблейн гишүүн, Лаос-Монголын парламентын бүлгийн дэд дарга Хөдөө аж ахуй, ойн дэд сайд Бунгкуанг Камбүнхөөн, Лаосын Дотоод хэргийн сайд Камман Соунвилет нар Монгол Улсад тус тус айлчлав.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол, Лаосын Засгийн газар хоорондын Комиссын 11 дүгээр хуралдааныг 12 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулав. Хуралдааны үеэр талууд хоёр орны Эрүүл мэндийн Яамдын хооронд Эрүүл мэнд, анагаах ухааны салбарт 2018-2020 онд хамтран ажиллах протокол, ЗГХК-ын 11 дүгээр хуралдааны Протоколд гарын үсэг зурав. Хуралдааны үеэр ГХЯ-дын Ази, Номхон далайн орнуудын газрын захирал нар уулзаж хамтын ажиллагааны асуудлуудаар мөн санал солилцов.

Хоёр орны худалдааны эргэлт 149.2 мянган ам.доллар (2017 онд 36,6 мянга, 2016 онд 25,5 мянга), үүнээс экспорт 40.7 мянган ам.доллар, импорт 108.50 мянган ам.доллар байна.

Монгол Улсын Засгийн газар 1050 толгой үржлийн хонь БНАЛАУ-д хүмүүнлэгийн тусламжаар олгож тээвэрлэлтийг лаосын талын зардлаар хүргүүлэв. Манай Засгийн газрын энэхүү тусламж нь хоёр орны уламжлалт найрсаг харилцааны илэрхийлэл болохын сацуу хоёр орны ард түмний харилцан ойлголцлыг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулав.

Монгол, **Камбожийн** харилцааны хувьд хоёр улсын үндэсний баяр болон бусад арга хэмжээ, үйл явдлыг тохиолдуулан төр засгийн удирдлагын түвшинд харилцан илгээлт солилцож ирэв. Монгол Улсаас Камбожийн Вант Улсад хавсран суугаа Элчин сайд Л.Галбадрах Камбожийн Гадаад хэрэг, олон улсын хамтын ажиллагааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Ийт Софитай уулзаж хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

Хоёр орны худалдааны эргэлт 2,261.7 мянган ам.доллар (2017 онд 1,592.1 мянга), үүнээс экспорт 929.3 мянган ам.доллар, импорт 1 сая 311.7 мянган ам.доллар байна.

Монгол, **Мьянмарын** харилцааны хувьд хоёр улсын үндэсний баяр болон бусад арга хэмжээ, үйл явдлыг тохиолдуулан төр засгийн удирдлагын түвшинд харилцан илгээлт солилцож ирэв. Улаанбаатар хотноо 4 дүгээр сард Олон улсын хамтын ажиллагааны сан (ОУХАС)-гийн шугамаар зохион байгуулсан "Гадаад бодлогын шийдвэр

гаргах механизмыг боловсронгуй болгох асуудал: Монгол Улсын жишээ” сэдэвт олон улсын хуралд Мьянмарын Гадаад хэргийн яамны Стратеги судлал, сургалтын газрын дарга Чай Ти Сое тэргүүтэй төлөөлөгчид оролцож, “Improving the foreign Policy decision making process (the case of Myanmar)” сэдвээр илтгэл тавив.

Хоёр орны худалдааны эргэлт 571.9 мянган ам.доллар (2017 онд 559.6 мянга), үүнээс, импорт 571.9 мянган ам.доллар, экспорт хийгээгүй болно.

Монгол, **Тайланд**ын харилцааны хувьд Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны зөвлөлийн анхдугаар хуралдааныг 9 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулав. Хуралдааны үеэр талууд хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны ойрын болон хэтийн төлөв, чиглэл, цар хүрээний талаар санал солилцож, ойрын 2 жилд хууль сахиулах, эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарын хүрээнд хамтарч ажиллахаар тохиролцов.



Монгол, Тайландын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны зөвлөлийн анхдугаар хуралдаан.
Улаанбаатар хот

Хоёр орны техникийн хамтын ажиллагаа хэвийн үргэлжилж ТАЙКА-гийн шугамаар хэрэгжүүлж ирсэн боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх 2017-2018 оны хөтөлбөрийн хүрээнд

манай 60 гаруй төрийн албан хаагчид эрүүл мэнд, хөдөө аж ахуй, санхүүгийн чиглэлээр богино хугацааны сургалтуудад хамрагдав.

Монгол Улсын Үндэсний хөгжлийн газар, ТАЙКА болон Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/-тэй хамтран “Монгол Улс дахь тогтвортой аялал жуулчлал” хөтөлбөрийн хүрээнд Увс, Баянхонгор, Сэлэнгэ аймагт “Монгол Улс дахь тогтвортой аялал жуулчлал” төслийг ТАЙКА, GIZ-ийн хамтарсан санхүүжилтээр 5 дугаар сарын 16-ны өдрөөс хэрэгжүүлж эхлэв.

Тайландын Хаан Пумипон Адульятет агсны санаачилсан “Хааны бороо” төслийг Монгол Улсад хэрэгжүүлэхээр талууд тохирч “Цаг агаарт зориудаар нөлөөлөх техникийн хамтын ажиллагааны хамтарсан хөтөлбөр”-ийг ТАЙКА-ын санхүүжилтээр хэрэгжүүлэхээр тохиров. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт эрчимтэй явагдаж, манай улсын цаг агаар сүүлийн 60 жилд дунджаар цельсийн 2 хэмээр дулаарч, хур тунадас багасаж цөлжилт нэмэгдэж буй үед энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой гэж үзнэ.

Монгол, Тайландын худалдааны эргэлт 35,1 ам.доллар болж өмнөх оноос 4,6 сая ам.доллараар нэмэгдсэн бөгөөд импорт 34,4 сая ам.доллар, экспорт 708.1 мянган ам.долларт хүрсэн байна.

Улаанбаатар–Бангкокийн чиглэлд шууд нислэг хийх хугацаанд (2017 оны 10 дугаар сараас 2018 оны 3 дугаар сар хүртэл) давхардсан тоогоор манай 10,000 гаруй иргэн Тайландад, Тайландын 3,500 орчим иргэн Монгол Улсад тус тус зорчив.

Монгол, **Сингапурын** Гадаад харилцааны яамдын анхдугаар бодлогын зөвлөлдөх уулзалтыг Улаанбаатар хотноо 9 дүгээр сарын 28-нд зохион байгуулсан бөгөөд уулзалтыг монголын талаас Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, сингапурын талаас Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын орлогч Нг Тек Хеэн нар тус тус тэргүүлж оролцов. Энэхүү бодлогын уулзалт нь хоёр талын харилцан ойлголцлыг гүнзгийрүүлж хамтын ажиллагааны цаашдын чиглэлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой болов. Талууд цаашид хөрөнгө оруулалт, худалдааг нэмэгдүүлэх, бизнес эрхчлэгчдийн хооронд харилцаа холбоо тогтооход дэмжлэг үзүүлэх, бизнес форум зэрэг хамтарсан арга хэмжээ зохион байгуулах, ялангуяа хоёр талын бизнесийн орчин, зах зээл, боломж, эрхзүйн орчны талаар бизнес эрхлэгчдийг мэдээллээр хангаж байх асуудалд анхаарч ажиллахаар талууд тохиров.

Монгол, Сингапурын худалдааны эргэлт 57,6 сая ам.долларт хүрсэн бөгөөд үүнээс экспорт 30 сая ам.доллар, импорт 27,6 сая ам.доллар байна.

Монгол, **Филиппиний** бодлогын III зөвлөлдөх уулзалт 10 дугаар сарын 11-нд Филиппиний Макати хотноо зохион байгуулсан бөгөөд манай төлөөлөгчдийг Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг тэргүүлж оролцов. Зөвлөлдөх уулзалтыг хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгаас Филиппиний

Ерөнхийлөгч Р.Дутертед илгээсэн баярын илгээлтийг дэд сайд Б.Батцэцэг Филиппиний Гадаад хэргийн дэд сайд Э.Маналод гардуулснаас гадна талууд Гадаад харилцааны яамд хоорондын хамтын ажиллагааны механизмыг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Филиппин Улсын Гадаад хэргийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан болно. Хоёр улсын харилцаа хөгжиж, зорчих иргэдийн тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан харилцаа, хамтын ажиллагааны эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох чиглэлээр анхаарч ажиллахаар талууд тохиролцов. Филиппиний тал жимс, далайн бүтээгдэхүүнээ экспортолж, манайхаас уул уурхай, эрдэс баялаг, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн худалдан авах сонирхолтой байгаагаа илэрхийлэв.



Дэд сайд Б.Батцэцэг Филиппиний Гадаад хэргийн дэд сайд Э.Манало нар

Хоёр орны худалдааны эргэлт 10,9 сая ам.долларт хүрсэн бөгөөд үүнээс экспорт 2,2 сая ам.доллар, импорт 8,7 сая ам.доллар байна.

Бүгд Найрамдах Индонез Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин сайд Жаухари Оратмангун Монгол Улсын Ерөнхийлөгчид ИЖБ-ээ 9 дүгээр сарын

17-ны өдөр барив. Талууд хоёр улсын эдийн засгийн харилцаа хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах боломжийг судлах, Монгол, Индонезийн Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны Комиссын хоёрдугаар хуралдааныг 2019 онд багтаан зохион байгуулахаар тохирсон.

Хоёр талын худалдааны эргэлт 18 сая ам.доллар, үүнээс экспорт 168.2 мянган ам.доллар, импорт 8,7 сая ам.долларт хүрч өмнөх онтой харьцуулахад бага зэрэг өсөв.

Малайз Улсад болсон сонгуулийн дүнд Др.Махадир Мохаммад Ерөнхий сайдаар томилогдсонтой нь холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нараас

баярын илгээлт хүргүүлэв. Малайз Улсын Шадар сайд Дато Сери Ван Азизах Ван Исмаил Улаанбаатар хотноо 7 дугаар сард зохион байгуулсан Гамшгийн эрсдлийг бууруулах Азийн сайд нарын бага хуралд оролцов. Шадар сайд Дато Сери Ван Азизах Ван Исмаил Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхаж харилцааны асуудлаар санал солилцов.

Монгол, **Бруней Даруссаламын** хооронд дипломат харилцаа тогтоосны 25 жилийн ойг тэмдэглэв. Ойн хүрээнд Бруней Даруссалам Улсын төв зурагтаар “Богд Хаан” монголын уран сайхны кино, МҮОНРТ-ийн сувгаар “Рина” хэмээх Брунейн уран сайхны киног тус тус үзэгч олны хүртээл болгов.

МОНГОЛ УЛС-АВСТРАЛИ, ШИНЭ ЗЕЛАНД

Монгол, Австралийн ГХЯ-дын зөвлөлдөх уулзалт, БХЯ-дын бодлогын яриа хэлэлцээг Улаанбаатар хотноо зохион байгуулав.

Австралийн шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хоёр орны уул уурхайн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх бодлогын хүрээнд Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар тэргүүтэй төлөөлөгчид Австралийн Викториа мужийн Эрдэс баялгийн сайд Тим Палласын урилгаар айлчлахын сацуу Олон улсын уул уурхай, эрдэс баялгийн 5 дахь чуулга уулзалт (IMARC)-д оролцов. Түүнчлэн талууд “Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр”-ийг 2019-2020 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тохиролцсон болно.

Австралийн ГХХЯ-ны Олон улсын хөгжил, Номхон далайн асуудал эрхэлсэн сайд К.Фиэрраванти-Уэлс тэргүүтэй төлөөлөгчид Улаанбаатар хотноо 7 дугаар сард зохион байгуулсан Гамшгийн эрсдлийг бууруулах Азийн сайд нарын бага хуралд оролцож, энэ үеэр Австралийн Засгийн газар Монгол Улсад 2019 оны санхүүгийн жилд 9,6 сая австрали долларын тусламж үзүүлэхээр шийдвэрлэв.

Онцгой байдлын ерөнхий газар Сэлэнгэ, Хэнтий аймгийн зарим суманд ой, хээрийн түймэртэй тэмцэх орон нутгийн иргэдийн сайн дурын бүлгүүдийг байгуулж, шаардлагатай хувцас, багаж төхөөрөмжөөр хангах, сургалтанд хамруулах, бодлого, журам боловсруулах цогц үйл ажиллагаа бүхий төсөл Австрали Улсын “Бичил

төслийн хөтөлбөр"-ийн хүрээнд 2018-2019 онд хэрэгжүүлэхээр тохирсон.

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд НҮБ-аас 2018-2021 онд хэрэгжүүлж буй Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих нэгдсэн хөтөлбөрт Австрали Улсын Засгийн газар болон Оюу Толгой ХХК хамтран оролцож байгаа бөгөөд Австралийн Засгийн газар дангаараа тус хөтөлбөрт 500000 австрали доллар зарцуулж байна. Мөн Австралийн ЭСЯ-наас тогтмол зарладаг "Бичил төслийн хөтөлбөр"-ийн хүрээнд 2018-2019 онд хэрэгжүүлэхээр шалгарсан 8 төслийн 4 нь орон нутгийн эрүүл мэндийн салбарт чиглэсэн төслүүд байлаа.

Хоёр орны худалдааны нийт эргэлт 51 сая ам. доллар бөгөөд үүнээс экспорт 1,27 сая ам.доллар, импорт 49,9 сая ам.доллар байна.

Монгол, Шинэ Зеландын найрсаг харилцаа хэвийн үргэлжилж байна. УИХ-ын дэд дарга Л.Энх-Амгалан Женев хотноо 3 дугаар сард зохион байгуулсан Олон улсын Парламентын холбооны ээлжит чуулганы үеэр Шинэ Зеланд Улсын Парламентын дэд спикер Анн Толлитоу уулзаж хоёр орны харилцааны асуудлаар санал солилцов.

Монгол, Шинэ Зеландын худалдааны нийт эргэлт 7,42 сая ам. доллар бөгөөд үүнээс экспорт 24500 ам.доллар, импорт 7,4 сая ам.доллар байна.

МОНГОЛ УЛС-ТӨВ АЗИ, БАРУУН АЗИЙН ОРНУУД

Монгол, Төв Азийн орнуудтай хөгжүүлж буй найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хэвийн үргэлжлэв. ШХАБ-ын хүрээнд болсон уулзалтуудад манай тал төрийн тэргүүн, шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын түвшинд оролцож, казахстан, киргиз, ираны талтай хоёр талын уулзалт хийж, харилцааг ялангуяа худалдааны хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийн талаар санал солилцов. Мөн Улаанбаатар хотноо зохион байгуулсан ДГХБО-ын ОУСТ-ийн удирдах зөвлөлийн хуралд Казахстан, Киргиз, Тажикистаны төлөөлөгчид оролцов.

Ашхабад хотноо 4 дүгээр сард болсон Туркмен морь, морь арчилгааны тухай Олон улсын шинжлэх ухааны бага

хуралд уяач, хурдан морь тайлбарлагч, сэтгүүлч, ETV телевизийн зураглаач бүхий баг бүрдүүлж оролцов.

Казахстан Улстай 2014 оноос хойш завсарласан Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын хамтын ажиллагааны Монгол, Казахстаны Засгийн газар хоорондын комиссын 7 дугаар хуралдааныг Астана хотноо зохион байгуулав. Хуралдааны үеэр Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбооны хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг судлах хамтарсан судалгааны ажлыг эхлүүлэхэд казахстаны тал дэмжлэг үзүүлж хамтарч ажиллахаар тохиров. Мөн Астана-Улаанбаатарын чиглэлийн шууд нислэг нээхээр хоёр тал тохиролцов.

Хоёр орны батлан хамгаалах, гамшгаас урьдчилан сэргийлэх чиг үүргийн байгууллагуудын харилцааны хувьд Казахстан Улсын Батлан хамгаалахын орлогч сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, дэслэгч генерал М.Маикеев Монгол Улсад айлчилж, Монгол, Казахстан Улсад болсон Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлаарх Азийн сайд нарын II бага хурал, "KADEX-2018" цэргийн зэвсэг техникийн олон улсын үзэсгэлэн, "Гал түймэр унтраах, аврах спортын цомын төлөө" олон улсын тэмцээн зэрэг арга хэмжээнд талууд төлөөлөгчдөө харилцан оролцуулав. Баян-Өлгий аймагт орсон бороо, үерийн улмаас их хэмжээний хохирол учирсантай холбогдуулан Казахстаны Засгийн газар 500,000 ам.долларын тусламж үзүүлсэн.

Монгол, Казахстаны найрамдал, хамтын ажиллагааны гэрээ байгуулагдсаны 25 жилийн ойг талууд тэмдэглэж, уг ойн хүрээнд Монгол Улсын Удирдлагын академи Казахстан Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ-тай хамтран хоёр орны харилцааны асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Монгол, Казахстаны нийт худалдааны эргэлт 35,7 сая ам.доллар бөгөөд үүнээс экспорт 3,5 сая ам.доллар, импорт 32,18 сая ам.доллар байна.

Монгол, **Киргизийн** харилцааны тухайд Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, Киргиз Улсын Онцгой байдлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд ОБЕГ-ын дарга Т.Бадрал Бишкек хотноо 3 дугаар сард Киргизийн Онцгой байдлын сайд К.А.Бороновтой уулзаж санал солилцсон бөгөөд Нийслэлийн

ОБГ-ын дарга Ж.Чүлтэмсүрэн тэргүүтэй төлөөлөгчид Киргизийн Онцгой байдлын үйл ажиллагаа, түүний дотор Киргизийн уул болон уснаас аврах үйл ажиллагаатай танилцаж эдгээр чиглэлээр киргизийн багш, мэргэжилтэн нараар Монгол Улсад сургалт зохион байгуулахаар тохирсон. Улаанбаатар хотноо зохион байгуулсан Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлаарх Азийн сайд нарын II бага хуралд Киргиз Улсын Онцгой байдлын яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Мамбетов тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Энэ үеэр хоёр орны ОБЕГ-уудын хооронд 2018-2022 онд хэрэгжүүлэх "Хамтын ажиллагааны төлөвлөгөө" байгуулав.

Хоёр орны худалдааны эргэлт 705 мянган ам.доллар бөгөөд экспорт 173.2 мянган ам.доллар, импорт 531.9 мянган ам.доллар байна.

Монгол, **Ираны** харилцааны хувьд хоёр орны төрийн тэргүүн нар БНХАУ-ын Чиндао хотноо 6 дугаар сард зохион байгуулсан ШХАБ-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн 18 дугаар хурлын үеэр уулзаж хоёр орны харилцааны асуудлаар санал солилцов.



Ерөнхийлөгч Х.Баттулга Иран Улсын Ерөнхийлөгч Хасан Роухани нар. Чиндао хот

Хоёр орны Гадаад харилцааны яамдын зөвлөлдөх уулзалт 7 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан бөгөөд 9 дүгээр сард Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг тэргүүтэй төлөөлөгчид Иран Улсад айлчлав.



Дэд сайд Б.Батцэцэг Ираны Гадаад хэргийн сайд Мохаммад Жавад Зариф нар. Тегеран хот

Хоёр тал хөдөө аж ахуй, түүхийн салбарт хамтран ажиллах боломжийг эрэлхийлэн ажиллаж байна. Ил Хаант

Улсын үеийн түүхийг хамтран судлах ажлын хүрээнд Иран Улсад зохион байгуулсан Монгол судлалын салбарын Монгол, Ираны хамтарсан судалгааны Хорооны ээлжит хуралдаан, Ил хаант улсын судалгааны чиглэлээрх Олон улсын Бага хуралд манай ШУА-ийн төлөөлөгчид тус тус оролцов.

Олон улсын хамтын ажиллагааны сан, Дипломат академитай хамтран 4 дүгээр сард зохион байгуулсан “Гадаад бодлогын шийдвэр гаргах механизмыг боловсронгуй болгох асуудал: Монгол Улсын жишээ” сэдэвт олон улсын бага хуралд **Афганистаны** төлөөлөгчид оролцсон бөгөөд мөн Улаанбаатар хотноо 5 дугаар сард зохион байгуулсан ДГХБО-ын ОУСТ-ийн Захирагчдын зөвлөлийн анхдугаар хурал болон 6 дугаар сард зохион байгуулсан Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Олон улсын судалгааны төвийн нээлтийн бага хуралд Афганистаны ГХЯ-ны төлөөлөгчид оролцсон.

МОНГОЛ УЛС БА ЕВРОПЫН ХОЛБОО

Монгол Улсын Их Хурал, Европын Холбооны Парламент хоорондын 12 дахь удаагийн уулзалтыг Улаанбаатар хотноо 9 дүгээр сард зохион байгуулж, хоёр талын улс төр, эдийн засгийн нөхцөл байдал, парламент хоорондын хамтын ажиллагааны явц, цаашдын чиглэл, аюулгүй байдал, бүс нутгийн асуудлуудаар санал солилцов. Уулзалтыг Монголын талаас УИХ дахь Монгол, Европын Парламентын бүлгийн дарга, УИХ-ын гишүүн Н.Оюундарь, Европын Холбооны талаас Европын Парламентын Төв Ази, Монгол Улстай харилцах бүлгийн дарга Ивета Григуле нар тэргүүлэв.

Монгол Улс, Европын Холбооны хамтын ажиллагааны хамтарсан хорооны 18 дугаар хуралдааныг 4 дүгээр сард Брюссель хотноо зохион байгуулав. Хамтарсан хороог Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Европын Гадаад харилцааны албаны Ази, Номхон далайн орнуудын Гүйцэтгэх захирал Гуннар Виганд нар тэргүүлж, хоёр

талын улс төр, эдийн засгийн харилцааг бэхжүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов. Хуралдааны хүрээнд Монгол Улс, Европын Холбооны хоорондын Хүний эрхийн асуудлаарх яриа хэлэлцээ, Худалдаа, хөрөнгө оруулалтын дэд хорооны хуралдааныг мөн зохион байгуулсан.




Монгол Улс, Европын Холбооны хамтын ажиллагааны хамтарсан хорооны 18 дугаар хуралдаан. Брюссель хот. 2018 оны 4 дүгээр сарын 23. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Европын Гадаад харилцааны албаны Ази, Номхон далайн орнуудын Гүйцэтгэх захирал Гуннар Виганд нар.



Монгол Улс, Европын Холбооны хамтын ажиллагааны хамтарсан хорооны 18 дугаар хуралдаан. 2018 оны 4 дүгээр сарын 23. Брюссель хот

Европын Комиссын Олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн асуудал эрхэлсэн комиссар Монгол Улсад айлчлав.




Европын Комиссын Олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн асуудал эрхэлсэн комиссар (сайд) Нэвэн Мимица Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхав. Улаанбаатар хот. 2018 оны 11 дүгээр сарын 13.



Европын Комиссын Олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн асуудал эрхэлсэн комиссар (сайд) Нэвэн Мимица, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар нар. Төрийн ордон, Улаанбаатар хот. 2018 оны 11 дүгээр сарын 13.

Европын Холбооны Төлөөлөгчийн газар Улаанбаатар хотноо нээгдэж, анхны суурин Элчин сайд үүрэгт ажилдаа оров.

Комиссар Н.Мимица айлчлалынхаа хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс дахь Европын Холбооны Төлөөлөгчийн газрын албан ёсны нээлтийн арга хэмжээнд оролцов.



Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газрын албан ёсны нээлт, тууз хайчлах ёслол. Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газар, Улаанбаатар хот. 2018 оны 11 дүгээр сарын 13.

Зүүн гар талаас: УИХ дахь Монгол Улс, Европын Холбооны бүлгийн дарга, УИХ-ын гишүүн Н.Оюундарь, Монгол Улсаас Европын Холбоонд суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд О.Оч, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, Европын Комиссын Олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн асуудал эрхэлсэн комиссар (сайд) Нэвэн Мимица нар.

Европын Холбоо ийнхүү Монгол Улсад суурин Төлөөлөгчийн газраа нээсэн нь хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэхэд чухал ач холбогдолтой болов.

Европын Холбооноос Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Траян Лауренцю Христееа 5 дугаар сарын 29-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад Итгэмжлэх жуух бичгээ барьж үүрэгт ажилдаа оров. Тэрээр Европын Холбооноос Монгол Улсад суурин суух анхны Элчин сайд бөгөөд үүнээс өмнө Европын Холбоо Монгол Улсыг БНХАУ-аас хавсран суудаг байсан юм.



Европын Холбооноос Монгол Улсад суугаа Элчин сайд Итгэмжлэх жуух бичгээ барих үеэр. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, Европын Холбооноос Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Траян Лауренцю Христеа Төрийн ордон, Улаанбаатар хот. 2018 оны 5 дугаар сарын 29.

Европын Холбоо болон түүний гишүүн орнуудаас Монгол Улсад суугаа болон хавсран суугаа Элчин сайд нарын 10 дугаар уулзалтыг Улаанбаатар хотноо 11 дүгээр сард зохион байгуулав. Уулзалтын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн нар Европын Холбооны гишүүн 21 улсын Элчин сайд, 5 улсын Элчин сайдын яамны төлөөллийг хүлээн авч уулзаж, Монгол Улс ба Европын Холбооны харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиглэлийн талаар санал солилцов.

Энэхүү уулзалтыг талууд сүүлийн 10

жил тасралтгүй зохион байгуулж ирсэн бөгөөд уулзалтын ач холбогдол жил ирэх тусам нэмэгдэж, яриа хэлэлцээний нэг төрлийн механизм болон хөгжиж байна. Элчин сайд нар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Зам, тээврийн хөгжлийн сайд Я.Содбаатар, Сангийн дэд сайд Х.Булгантуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд Ж.Сауле, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга С.Амарсайхан, Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч О.Эрдэмбилэг нартай уулзаж, салбарын бодлого, хамтын ажиллагааны талаар мэдээлэл авч, санал солилцов.

Европын Холбоо нь Монгол Улсад 1993 оноос эхлэн хөгжлийн албан ёсны тусламж үзүүлж ирсэн бөгөөд 2014-2020 онд 65 сая еврогийн тусламж үзүүлэх олон жилийн баримжаат хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Европын Холбооны шууд хөрөнгө оруулалт 6,9 тэрбум ам.долларт хүрэв.

Европын Холбоо нь Монгол Улсад 1990 оноос хойш 6,9 тэрбум ам.долларын шууд хөрөнгө оруулалт хийсэн нь манай улс дахь нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 30 орчим хувийг эзэлж байна. Хөрөнгө оруулалтын дийлэнх хувь буюу 6,1 тэрбум ам.долларыг ашигт малтмалын хайгуул, олборлолтын салбарт оруулсан байна. Европын Холбооны гишүүн орнуудын нийт 719 аж ахуйн нэгж Монгол Улсад бүртгэлтэй ажиллаж байна.

Монгол Улс, Европын Холбооны гишүүн орнуудтай хийсэн худалдааны нийт эргэлт 828,1 сая ам.доллар, үүнээс экспорт 252,9 сая ам.доллар, импорт 575,2 сая ам.доллар байна.

МОНГОЛ УЛС БА ЕВРОПЫН ОРНУУД

МОНГОЛ УЛС-ГЕРМАН

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Брюссель хотноо зохион байгуулагдсан АСЕМ-ын 12 дугаар уулзалтад оролцох үеэрээ ХБНГУ-ын Холбооны канцлер А.Меркелтэй уулзаж хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааг харилцан ашигтай өргөжүүлэн хөгжүүлэх, ялангуяа уул уурхай, шинэ хот байгуулах, малын гаралтай түүхий эдийг нано болон биотехнологиор боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд хамтран ажиллах талаар санал солилцов.



Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, ХБНГУ-ын Холбооны канцлер А.Меркел нарын уулзалт, Брюссель хот, 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдөр

Монгол Улс, ХБНГУ-ын ГХЯ-дын ээлжит улс төрийн зөвлөлдөх уулзалтыг Берлин хотноо 10 дугаар сард зохион байгуулсан бөгөөд уулзалтыг монголын талаас ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, германы талаас Холбооны ГХЯ-ны Ази, Номхон далайн газрын орлогч дарга, Азийн асуудал эрхэлсэн бүрэн эрхт төлөөлөгч, Элчин сайд Петра Зигмунд нар тэргүүлэв. Зөвлөлдөх уулзалтаар хоёр орны хооронд тогтоосон иж бүрэн түншлэлийн

харилцаа, хамтын ажиллагаа, түүний дотор дээд, өндөр түвшний уулзалт, харилцан айлчлал, батлан хамгаалах, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг урагшлуулах, соёл, боловсрол, технологи, олон талт хамтын ажиллагаа, консул болон олон улсын байгууллагуудын хүрээнд хамтран ажиллах зэрэг асуудлуудаар талууд санал солилцов.



ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, Холбооны ГХЯ-ны Ази, Номхон далайн газрын орлогч дарга, Азийн асуудал эрхэлсэн бүрэн эрхт төлөөлөгч, Элчин сайд Петра Зигмунд, Элчин сайд Д.Ганбат, Ази Номхон Далайн АР-02 хэлтсийн дарга Х.Зимон нар, Холбооны ГХЯ, Берлин хот, 2018 оын 10 дугаар сарын 29-ний өдөр

Монгол Улс, ХБНГУ-ын Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны ээлжит уулзалтыг Улаанбаатар хотноо 10 дугаар сард зохион байгуулав. Уулзалтыг монголын талаас Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Монгол-Германы Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хэлэлцээний монголын хэсгийн дарга С.Наранцогт, германы талаас Холбооны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны (ХЭЗХАХЯ) Хятад, Төв Ази, Зүүн

Ази, Лаос, Камбож хариуцсан хэлтсийн дарга, германы талын төлөөлөгчдийн

тэргүүн Катрин Оллерс нар удирдан явуулав.



Монгол, Германы Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хэлэлцээ, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Холбооны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны (ХЭЗХАХЯ) хэлтсийн дарга К.Оллерс нар. ГХЯ, Улаанбаатар хот, 2018 оны 10 дугаар сарын 8-ны өдөр

Энэ удаагийн уулзалтаар Германы тал “Ашигт малтмалын тогтвортой менежмент”, “Эрчим хүчний үр ашиг”, “Биологийн олон янз байдал” гэсэн тэргүүлэх 3 чиглэлийн нийт 16 төсөлд 55,4 сая еврогийн санхүүжилт олгох, үүнээс 22 сая еврог хөнгөлөлттэй зээл, 33,4 сая еврог буцалтгүй тусламжаар тус тус олгохоор шийдвэрлэв.



Төлөөлөгчдийн тэргүүн нар Хэлэлцээний протоколд гарын үсэг зурах ёслол, ГХЯ, Улаанбаатар, 2018 оны 10 дугаар 9-ний өдөр

“Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын

хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Монгол, Германы Засгийн газар хоорондын Ажлын хэсгийн 6 дугаар хуралдааныг 5 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулав. Хуралдааныг монголын талаас Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, германы талаас Холбооны Эдийн засаг, эрчим хүчний яамны Парламентын Төрийн нарийн бичгийн дарга Оливер Виттке нар тэргүүлэв. Хуралдаанаар талууд Ажлын хэсгийн дэргэдэх Эдийн засгийн хамтарсан хорооны хуралдааны дүнг хэлэлцэхийн сацуу Эдийн засгийн хорооны дэргэдэх Санхүүжилтийн ажлын хэсгээс хоёр тал хамтран хэрэгжүүлэх боломжтой төслүүдийг санхүүжүүлэх арга зам, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гарцын талаар санал солилцов.

Монгол, Германы Засгийн газар хоорондын Ажлын хэсгийн монголын талын тэргүүн Д.Сумъяабазар Монгол, Германы харилцаа, хамтын

ажиллагааны “Иж бүрэн түншлэл”-ийн харилцааны хүрээнд Монголын эрдэс баялаг, түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр хамтарч ажиллах, эрчим

хүч, уул уурхайн салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, мөн эдийн засгийн харилцан сонирхсон бусад салбарт хамтран ажиллах боломжийн талаар мэдээлэл хийж, санал солилцов.



Монгол, Германы Засгийн газар хоорондын Ашигт малтмалын хэлэлцээрийн Ажлын хэсгийн 6 дугаар хуралдаан, ГХЯ, Улаанбаатар хот, 2018 оны 5 дугаар сарын 29-ний өдөр

Монгол, Германы батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд УИХ-ын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд 9 дүгээр сард ХБНГУ-д айлчлав. Айлчлалын үеэр сайд Н.Энхболд ХБНГУ-ын Бундестагийн гишүүн, Герман-Төв Азийн парламентын бүлгийн дарга Манфред Грундтэй уулзаж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Мөн ХБНГУ-ны Холбооны Батлан хамгаалахын сайд Урзула фон дер Лайн 10 дугаар сард Монгол Улсад албан ёсоор айлчлав.



Холбооны Батлан хамгаалахын сайд Урсула фон дер Лайн Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Н.Энхболд нар Бундесверийн хүндэт харуулын өмнө. Берлин хот, 2018 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр




Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, ХБНГУ-ын Холбооны Батлан хамгаалахын сайд У.фан дер Лайн нар Төрийн хүндэт харуулын өмнө. БХЯ, Улаанбаатар хот, 2018 оны 10 дугаар сарын 20-ны өдөр

Айлчлалын үеэр талууд “Техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-т

гарын үсэг зурсан бөгөөд сайд Урзула Фон Дер Лайеныг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин хүлээн авч уулзаж, энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэрэг дайчдыг чадавхжуулах, техник, тоног төхөөрөмжөөр хангах асуудлаар санал солилцов.

Хоёр орны худалдааны нийт эргэлт 181 сая орчим ам. доллар, үүнээс экспорт 12,3 сая ам. доллар, импорт 168,7 сая ам.долларт хүрч худалдааны хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 40 орчим сая. ам.доллараар өсөв.



Шадар сайд Ө.Энхтүвшин, Холбооны Батлан хамгаалахын сайд У.Фон Дер Лайен нарын уулзалт, Төрийн ордон, Улаанбаатар хот, 2018 оны 10 дугаар сарын 20-ны өдөр

МОНГОЛ УЛС-ФРАНЦ



Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, БНФУ-ын Европ, гадаад хэргийн сайд Жан-Ив Лё Дриан нар (Парис хот, 2018.10.08-ны өдөр)

Монгол Улсын Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Франц Улсад 10 дугаар сард айлчлав. Айлчлалын үеэр талууд хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг иж бүрэн түншлэлийн

түвшинд хүргэж түншлэлийн тухай замын зураглалыг гаргаж ажиллахаар тохиролцов.

Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Франц Улсын Европ болон Гадаад хэргийн яам хоорондын 6 дугаар зөвлөлдөх уулзалтыг Улаанбаатар хотноо 1 дүгээр сард зохион байгуулав. Зөвлөлдөх уулзалтыг манай талаас ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, францын талаас Францын Европ болон Гадаад хэргийн яамны Ази, Номхон далайн газрын Ерөнхий захирал Тиери Мату нар тэргүүлж, хоёр талын харилцааг иж бүрэн түншлэлийн түвшинд хүргэх, улс төр, батлан хамгаалах, эдийн

засаг, худалдаа, шинжлэх ухаан, соёл, боловсрол, олон талт хамтын

ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх боломжийн талаар санал солилцов.



Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Франц Улсын Европ болон Гадаад хэргийн яам хоорондын 6 дугаар зөвлөлдөх уулзалт (ГХЯ, 2018.01.12-ны өдөр)

Бүгд Найрамдах Франц Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Филипп Мэрлин Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад Итгэмжлэх жуух бичгээ 10 дугаар сард барив.

ажиллагааны тухай Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Геологи, уул уурхайн судалгаа, шинжилгээний товчооны хооронд хамтран ажиллах тухай санамж бичигт талууд тус тус гарын үсэг зурав.



*Франц Улсын Элчин сайд Филипп Мэрлин Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад Итгэмжлэх жуух бичгээ гардуулав.
(Төрийн ордон, 2018.10.11-ний өдөр)*

Хоёр орны Батлан хамгаалах яамдын зөвлөлдөх уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулав. Сансрын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Сансар судлалын Үндэсний төвийн хооронд харилцан ойлголцлын санамж бичиг, Дэлхий судлалын салбарт хэрэгжүүлэх шинжлэх ухаан, техникийн хамтын

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга С.Амарсайхан тэргүүтэй төлөөлөгчид 10 дугаар сард Франц Улсад айлчилж, Ил-Дө Франс мужийн Орон нутгийн зөвлөлийн нэгдүгээр орлогч дарга Жером Шартье, Парис хотын Гадаад харилцаа хариуцсан орлогч дарга Патрик Клүгман нартай тус тус уулзаж Улаанбаатар, Парис хотуудын харилцаа, хамтран хэрэгжүүлж болох төсөл, хот төлөвлөлт, агаарын бохирдлыг бууруулах, замын ачааллыг багасгах зэрэг хамтын ажиллагааны асуудлуудаар санал солилцов.

Хоёр орны худалдааны нийт эргэлт 44,5 сая ам.доллар, үүнээс экспорт 5,4 сая ам.доллар, импорт 39,1 сая ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад экспорт 6 хувиар буурч, импорт 20 хувиар өссөн байна.

МОНГОЛ УЛС-ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛС

нар тус тус Монгол Улсад айлчилж, хоёр талын харилцааны өргөн хүрээтэй асуудлуудаар санал солилцов. Мөн Монгол, Британийн ээлжит дугуй ширээний уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулав. Энэхүү дугуй ширээний уулзалт нь Монгол, Британийн Засгийн газар хоорондын яриа хэлэлцээний гол механизм бөгөөд 1987 оноос хойш хоёр тал Улаанбаатар, Лондон хотуудад ээлжлэн зохион байгуулж, хоёр талын улс төр, эдийн засаг, худалдаа, соёл, боловсрол, шинжлэх ухаан, бүс нутгийн болон олон улсын тулгамдсан асуудлуудаар санал солилцож ирсэн уламжлалтай.



Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Британийн Гадаад хэрэг, хамтын нөхөрлөлийн яамны Ази, Номхон далайн орнуудын асуудал эрхэлсэн Төрийн сайд Марк Фийлд, 2018.07.20, Улаанбаатар хот

Британийн Ерөнхий сайд Тереза Мэй Парламентын гишүүн Жулиан Найтыг Монгол Улстай харилцах Худалдааны элчээр 1 дүгээр сард томилсон бөгөөд тэрээр 4, 9 дүгээр саруудад Монгол

Улсад ажиллаж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Гадаад харилцааны сайд, Эрчим хүчний сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн дэд сайд, Зам тээврийн хөгжлийн дэд сайд нартай тус тус уулзаж, хоёр талын хамтын ажиллагааны талаар санал солилцов.



Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Британийн Монгол Улстай харилцах Худалдааны элч Ж.Найт

Монгол Улс болон Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойг талууд /1 дүгээр сарын 23/ тэмдэглэн өнгөрөөв. Ойн хүрээнд 10 дугаар сарын 22-ны өдөр Монгол, Британий БХЯ-дын Морин пологийн багуудын уламжлалт нөхөрсөг тоглолтыг Хэнтийн Хөдөө аралд зохион байгуулав.



Морин пологийн нөхөрсөг тоглолт, 2018.10.22, Хэнтий аймаг

Гадаад харилцааны яамны дипломат ажилтнуудын хэлмэрчлэх ур чадварыг дээшлүүлэх 7 хоногийн сургалтыг Улаанбаатар дахь Британий Элчин сайдын яамтай хамтран 2, 12 дугаар саруудад Шотландын Хериот-Уатт Их

сургуульд зохион байгуулсан болно.

Хоёр орны худалдааны нийт эргэлт 205 сая ам.доллар, үүнээс экспорт 173 сая ам.доллар, импорт 32 сая ам.доллар байна.



Сургалтад хамрагдсан албан хаагчид, 2018.12.10, Эдинбург хот

МОНГОЛ УЛС-ТУРК

Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд 3 дугаар сард БНТУ-д албан ёсоор айлчилж, БНТУ-ын Үндэсний Их Хурлын дарга Исмайл Кахрамантай хэлэлцээ хийж, Ерөнхийлөгч Р.Т.Эрдоанд бараалхаж, Анкара хотын дарга Мустафа Тунатай уулзав. Айлчлалын үеэр Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт талууд гарын үсэг зурав. Энэхүү айлчлал нь хоёр улсын хоорондын дээд, өндөр хэмжээний уулзалт, яриа хэлэлцээг сэргээх, хоёр талын хууль тогтоох дээд байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, худалдаа, эдийн засгийн харилцааг идэвхжүүлэхэд чухал ач холбогдолтой болов.



Монгол Улсын Их Хурлын даргын Бүгд Найрамдах Турк Улсад хийсэн айлчлал. Анкара хот. 2018 оны 3 дугаар сарын 8.

Улсын Их Хурлын дарга М.Энхболд, Бүгд Найрамдах Турк Улсын Үндэсний Их Хурлын дарга Исмайл Кахраман нар.

Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхий сайд Бинали Йылдырым Монгол Улсад 4 дүгээр сард албан ёсоор айлчилж Ерөнхий сайд У.Хүрэлсүхтэй хэлэлцээ хийж, Ерөнхийлөгч Х.Баттулга, УИХ-ын дарга М.Энхболд нарт бараалхав.



Ерөнхий сайд У.Хүрэлсүх, БНТУ-ын Ерөнхий сайд Бинали Йылдырым нар. Улаанбаатар хот. 2018 оны 4 дүгээр сарын 6.




Турк Улсын Ерөнхий сайд Бинали Йылдырым Ерөнхийлөгч Х.Бхттулгад бараалхав. 2018.04.06

Айлчлалын үеэр талууд хөдөө аж ахуй, тээвэр, харилцаа, онцгой байдлын салбарт хамтран ажиллах тухай зэрэг чиглэлүүдээр Санамж бичиг байгуулав.

Энэхүү айлчлал нь Монгол, Туркийн дээд, өндөр түвшний улс төрийн харилцан ойлголцлыг бэхжүүлэх, хоёр талын харилцаа, хамтын ажиллагаанд түлхэц үзүүлэх ач холбогдолтой болов.

Эдийн засаг, худалдааны Монгол, Туркийн Засгийн газар хоорондын хамтарсан хорооны наймдугаар хуралдааныг Улаанбаатар хотноо 3 дугаар сард зохион байгуулсан бөгөөд хуралдааныг монголын талаас УИХ-ын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, туркийн талаас Шадар сайд

Хакан Чавушолу нар тус тус даргалж, хоёр талын харилцааны шийдэл хүлээж байгаа асуудлуудаар санал солилцож, цаашдын хамтын ажиллагааны чиглэл, хоёр орны эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын харилцааны нөөц бололцоог бүрэн ашиглах, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зэрэг чиглэлээр санал солилцож холбогдох протоколд талууд үсэг зурав.



Монгол, Туркийн Засгийн газар хоорондын эдийн засаг, худалдааны хамтарсан хорооны 8 дугаар хуралдааны үеэр.

Тус хуралдааны мөрөөр мал аж ахуй, мах, махан бүтээгдэхүүн, арьс шир боловсруулах салбарт Туркийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх, экспортын чиг баримжаатай хамтарсан компани байгуулах асуудлыг судлах, чөлөөт бүсийн чиглэлээр мэргэжилтэн сургах, туршлага судлах зэрэг чиглэлээр хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхээр ажиллаж байна.

Хоёр орны худалдааны эргэлт 43,6 сая ам. доллар, үүнээс экспорт 4,5 сая ам.доллар, импорт 39,1 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 27 хувиар өсөв.

МОНГОЛ УЛС-ЧЕХ

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Чехийн Засгийн газар хоорондын комиссын (ЗГХК) 7 дугаар хуралдааныг 2018 оны 4 дүгээр сард Прага хотноо зохион байгуулав. Эрүүл

мэндийн сайд, ЗГХК-ын монголын хэсгийн дарга Д.Сарангэрэл, Бүгд Найрамдах Чех Улсын Үйлдвэр, худалдааны дэд сайд, ЗГХК-ын чехийн хэсгийн дарга Э.Муржицкий нар тус тусын төлөөлөгчдийг тэргүүлж оролцов.



Монгол, Чехийн ЗГХК-ын хуралдаан 2018 оны 4 дүгээр сарын 10, Прага хот

Хуралдаанаар талууд ЗГХК-ын өмнөх хуралдааны мөрөөр хэрэгжүүлсэн ажлуудын хэрэгжилтийг дүгнэж, эдийн засаг, худалдаа, хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчин, зам тээвэр, уул уурхай, барилга болон эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх талаар санал солилцов. Хуралдааны үеэр тахийг Монгол оронд эргэн нутагшуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа Прага хотын амьтны хүрээлэнтэй “Нэн ховор зүйл амьтдыг хамгаалах тухай хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулав. Энэхүү санамж бичгийг байгуулснаар Монголын бөхөн болон хавтгай хамгаалах, тоо толгойг нь нэмэгдүүлэхэд чехийн талтай хамтран ажиллах боломж бүрдэв.



БОАЖЯ-ны ТНБД Ц.Цэнгэл, Прага хотын Амьтны хүрээлэнгийн захирал М.Бобек

Монгол Улс 2018 онд 273 мянган ам.долларын бараа Чех Улсад экспортолж, 9.4 сая ам.долларын бараа импортолсон бөгөөд өмнөх онтой харьцуулахад экспорт 18 хувиар өсч, импорт 13 хувиар буурсан байна.

МОНГОЛ УЛС-УНГАР

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Унгарын Засгийн газар хоорондын комиссын (ЗГХК) 6 дугаар хуралдааныг 11 дүгээр сард Будапешт хотноо зохион байгуулав. Хуралдааныг монголын талаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд Ж.Сауле, унгарын талаас Гадаад хэрэг, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Чаба Балог нар тэргүүлэв.



Монгол, Унгарын ЗГХК-ын хуралдаан 2018 оны 11 дүгээр сарын 20, Будапешт хот

Хуралдааны үеэр худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуй, усны менежмент, геологи, эрдэс баялаг, цаг уурын өөрчлөлт, боловсрол, соёл, аялал жуулчлал, эрүүл мэнд, цахим паспортын асуудал, зам тээвэр зэрэг чиглэлээр ажлын хэсгүүдийг тус тус хуралдуулж салбар тус бүрийн хамтын ажиллагааны асуудлаар мэдээлэл солилцож, цаашдын хамтын ажиллагааны асуудлуудаар санал солилцсон болно. Хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтын өнөөгийн хэмжээ бодит боломжоос доогуур байгаад талууд анхаарч, цаашид хоёр талын худалдааг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг харилцан дэмжиж ажиллахаар тохиров.

Монгол Улс Унгар Улсад 2018 онд 502 мянган ам.долларын бараа экспортолж, 12 сая ам.долларын бараа импортолсон бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад экспорт 74 хувиар өсч, импорт 0.8 хувиар буурсан байна.

МОНГОЛ УЛС-ПОЛЬШ

Бүгд Найрамдах Польш Улсын Парламентын доод танхим - Сеймийн Польш, Монголын парламентын бүлгийн дарга Марек Жонса тэргүүтэй төлөөлөгчид 5 дугаар сард манай улсад айлчилж хоёр орны парламент хоорондын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.



Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг, Польшийн Сеймийн танхим дахь Польш, Монголын парламентын бүлгийн дарга Марек Жонса тэргүүтэй төлөөлөгчид (ГХЯ, 2018.05.21-ний өдөр)

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 73 дугаар чуулганы үеэр Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Бүгд Найрамдах Польш Улсын Гадаад хэргийн сайд Яцэк Чапутовичтой уулзаж, мөн Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг Польш Улсад 5 дугаар сард ажлын айлчлал хийсэн нь байнгын яриа хэлэлцээний давтамжийг хадгалах, хоёр орны хамтын ажиллагааны асуудлаар санал солилцох чухал ач холбогдолтой байв.

Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг Варшав хотноо ажиллах үеэрээ Польшийн Гадаад хэргийн дэд сайд Пиотр Вавжыктай уулзав. Хоёр орны Гадаад хэргийн дэд сайд нар Монгол, Польшийн харилцаа идэвхтэй өргөжин хөгжиж буйд сэтгэл ханамжтай буйгаа тэмдэглэж, хоёр орны эдийн засаг, худалдаа, соёл, боловсрол, батлан хамгаалахын салбарын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд анхаарч ажиллахаа харилцан илэрхийлэв.



Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг, Польшийн Гадаад хэргийн дэд сайд Пиотр Вавжык нар
(Варшав хот, 2018.05.25-ны өдөр)

УИХ-ын гишүүн, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг Польш Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн бодлогын сайд Элжбиета

Рафалсагийн урилгаар 1 дүгээр сард айлчилсан бөгөөд айлчлалын үеэр талууд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улс хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурав. Энэхүү хэлэлцээр байгуулснаар Польш Улсад ажиллаж, амьдарч буй монгол иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийн харилцааг зохицуулах хууль эрх зүйн үндсийг бүрдүүлэв.



УИХ-ын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Польшийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн бодлогын сайд Элжбиета Рафалса нар
(Варшав хот, 2018.01.24-ний өдөр)

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын 50 сая еврогийн нөхцөлт зээлийн хэлэлцээрийн хүрээнд дэд бүтэц, хөдөө аж ахуй, иргэний хамгаалал, байгаль орчныг хамгаалах, эрүүл мэнд зэрэг салбарт 6 төсөл хэрэгжүүлэхээр польшийн талтай тохирч, тэдгээрээс онцгой байдлын салбарт хэрэгжүүлэх 2 төслийн сонгон шалгаруулалтыг хийж, холбогдох гэрээ байгуулав.

Монгол Улс Польш Улсад 2018 онд 268 мянган ам.долларын бараа экспортолж, 58 сая ам.долларын бараа импортолсон бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад экспорт, импорт тус бүр 20 орчим хувиар өссөн үзүүлэлттэй гарч байна.

МОНГОЛ УЛС-АВСТРИ

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд “Тайшир Алтай ус хангамж” төслийг 14 сая еврогийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр Австрийн Засгийн газар шийдвэрлэсэний дагуу талууд Санхүүжилтийн гэрээнд 5 дугаар сард Вена хотноо гарын үсэг зурж, төслийг хэрэгжүүлж эхлэв.

Монгол, Австрийн хооронд дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойг талууд тэмдэглэн өнгөрөөв. Ойн хүрээнд манай орны урлаг, соёл, зан заншлыг сурталчилсан цуврал арга хэмжээ, түүний дотор Австрийн Дэлхийн түүхийн музейд ёслолын хүлээн авалт, ардын урлагийн тоглолтууд, Монгол кино өдөрлөг, австри, монгол уран бүтээлчдийн “5+5: Уламжлал болон орчин үе” уран бүтээлийн үзэсгэлэн

гаргах зэрэг арга хэмжээ зохион байгуулсан болно.

Монгол, Австрийн худалдаа 2018 онд 23.79 сая ам. доллар, үүнээс экспорт 4.36 сая ам.доллар, импорт 19.43 сая ам.доллар болж, өмнөх оныхоос өсөв.



Тайшир-Алтай ус хангамж төслийн санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурах ажиллагаа, Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суугаа Элчин сайд Г.Баттунгалаг, Австрийн ЮниКредит банкны захирал Г.Карнер нар, Вена хот, 2018 оны 5 дугаар сарын 9-ний өдөр



Монгол Улс Бүгд Найрамдах Австри Улстай дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан Монгол Улсаас Австри Улсад суугаа Элчин сайдын яамнаас Вена хотын “Дэлхийн музей”-д зохион байгуулсан хүндэтгэлийн хүлээн авалт, Вена хот, 2018 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

МОНГОЛ УЛС-ЛЮКСЕМБУРГ

Люксембургийн Их Гүнт Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Марк Хубш Монгол Улсын

Ерөнхийлөгч Х.Баттулгад Итгэмжлэх жуух бичгээ 4 дүгээр сарын 4-нд барьж үүрэгт ажилдаа оров.




Люксембургийн Их Гүнт Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Итгэмжлэх жуух бичгээ барих үеэр. Төрийн ордон, Улаанбаатар хот. 2018 оны 4 дүгээр сарын 4.

Зүүн гар талаас: Люксембургийн Их Гүнт Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөө Бүрэн эрхт Элчин сайд Марк Хубш, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга нар.

МОНГОЛ УЛС-СКАНДИНАВЫН ОРНУУД

Шведийн Хаант Улсын Парламентын гишүүн, Гадаад хэргийн сайдын зөвлөх Кент Харштэд 4 дүгээр сард Монгол Улсад ажиллав. Тэрээр Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхаж, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, УИХ дахь Монгол, Шведийн Парламентын бүлгийн дэд дарга Н.Учрал нартай уулзаж, хоёр талын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.



УИХ-ын гишүүн Н.Учрал, Шведийн Вант Улсын Парламентын гишүүн, Гадаад хэргийн сайдын зөвлөх Кент Харштэд, 2018.04.04, Улаанбаатар хот

Монгол Улс Швед Улсад 130 мянган ам.долларын бараа экспортолж, 39 сая ам.долларын бараа импортолсон байна.

Эдийн засаг, шинжлэх ухаан,

техникийн хамтын ажиллагааны Монгол, Финландын Засгийн газар хоорондын хамтарсан комиссын ээлжит хуралдааныг 9 дүгээр сард Хельсинки хотноо зохион байгуулж, хуралдааны дүнгээр хамтарсан Протокол байгуулав.



Монгол, Финландын Засгийн газар хоорондын хамтарсан комиссын 13 дугаар хуралдаан, 2018.09.07, Хельсинки хот

Монгол Улс Финланд Улсад 160 мянган ам.долларын бараа экспортолж, 18 сая ам.долларын бараа импортолсон байна.

Монгол Улс, Норвегийн Хаант Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг талууд тэмдэглэн өнгөрөөв. Энэ хүрээнд Осло хотноо 1 дүгээр сард Монгол Улсаас Норвегийн Хаант Улсад хавсран суугаа ЭСЯ, Норвеги дахь Өргөмжит консулын газартай хамтран Осло хотын төв кино театрт “Чингисийн хүүхдүүд” монголын уран сайхны киноны нээлтийг зохион байгуулж, үзэгчдийн хүртээл болгов.

Монгол Улс Норвеги Улсад 510 мянган ам.долларын бараа экспортолж, 1 сая ам.долларын бараа импортолсон байна.

Монгол Улс Норвеги Улсад 510 мянган ам.долларын бараа экспортолж, 1 сая ам.долларын бараа импортолсон байна.

Данийн Үндэсний музей, Аархус хотын Угсаатны зүйн “Моосгард” музей хамтран зохион байгуулсан “Чингис хааны тал нутаг-Монголын нүүдэлчид” тусгай үзэсгэлэн 6 дугаар сарын 18-ны өдөр нээв. Уг үзэсгэлэнд Данийн аялагч, угсаатан судлаач Хэнинг Хаслунд Кристенсен 1920-30-аад онуудад хийсэн судалгаа, угсаатны эд өлгийн цуглуулгын дээж болох 1240 орчим үзмэр, Монголын Үндэсний музей, ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн 13 дугаар зууны эд хэрэгсэл, түүхэн олдворуудыг багтааж, орчин үеийн дижитал технологийг ашиглан олон нийтэд сонирхолтой

байдлаар Монголын нүүдэлчдийн соёл иргэншил, Чингис хааны дэлхийг эзэлсэн түүхэн үйл явдлыг дэлгэн харуулсан.

Монгол Улс Дани Улсад 31 мянган ам.долларын бараа экспортолж, 20 сая ам.долларын бараа импортолсон байна.



“Чингис Хааны тал нутаг-Монголын нүүдэлчид” тусгай үзэсгэлэнгийн постер

МОНГОЛ УЛС-ИРЛАНД

Монгол, Ирландын хооронд дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойн хүрээнд Ирланд Улсын Парламентын доод танхимын дарга Шон О’Фарел тэргүүтэй төлөөлөгчид 4 дүгээр сарын 29-нөөс 5 дугаар сарын 1-ний өдрүүдэд Монгол Улсад албан ёсоор айлчлав.



УИХ-ын дарга М.Энхболд, Ирланд Улсын Парламентын доод танхимын дарга Шон О’Фарел, 2018.04.30, Улаанбаатар хот

Айлчлалын хүрээнд Ирланд Улсын Парламентын доод танхимын дарга Шон О’Фарел Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхаж, УИХ-ын дарга М.Энхболдтой хэлэлцээ хийж, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд

Б.Батзориг нартай тус тус уулзаж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов. УИХ-ын дарга М.Энхболд, Ирландын Парламентын доод танхимын дарга Шон О’Фарел нар Монгол Улсын Их Хурал, Ирландын Парламентын доод танхим хоорондын хамтын ажиллагааны санамж бичигт гарын үзэг зурав. Мөн хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Ирландын Хөдөө аж ахуй, хүнс, тэнгисийн асуудал эрхэлсэн яам хооронд хамтран ажиллахаар тохиролцов.

Монгол Улс Ирланд Улсад 13 мянган ам.долларын бараа экспортолж, 8.8 сая ам.долларын бараа импортолсон байна.

МОНГОЛ УЛС-МОНАКО



Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Монакогийн Хант Улсын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны яамны Ерөнхий захирал бөгөөд дэд сайд Изабель Розабрунетто нар (ГХЯ, 2018.07.06-ны өдөр)


Монгол Улс, Монакогийн Хант Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 10 жилийн ойг тохиолдуулан Монакогийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны яамны Ерөнхий захирал бөгөөд дэд сайд Изабель Розабрунетто Монгол Улсад 7 дугаар сард айлчлав.

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар дэд сайд И.Розабрунеттог хүлээн авч уулзаж, боловсрол, эрүүл мэнд, соёлын өвийг хамгаалах, археологи, хүмүүнлэг зэрэг салбаруудад хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийн талаар талууд санал солилцов.


Монакогийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны дэд сайд Монакогийн хөгжлийн тусламжийн хүрээнд 2008 оноос хойш Монгол Улсад соёлын өвийг хадгалж хамгаалах, эрүүл мэнд, боловсрол, хүмүүнлэгийн салбарт хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн үр дүнтэй танилцахаар Архангай аймагт ажиллав. Мөн тэрээр ХХААХҮЯ, БСШУСЯ, ЭМЯ, ХНХЯ-ны удирдлагуудтай тус тус уулзаж хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон болно.

МОНГОЛ УЛС-БЕЛАРУСЬ

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар 6 дугаар сард Бүгд Найрамдах Беларусь Улсад албан ёсоор айлчилж хоёр орны хооронд тогтсон харилцан итгэлцэл, хамтын ажиллагааг эдийн засгийн агуулгаар баяжуулах, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл, уул уурхай, зам тээвэр зэрэг салбарт хамтын ажиллагааг идэвхжүүлэх, соёл, боловсрол, хүмүүнлэгийн чиглэлийн солилцоог нэмэгдүүлэхээр хүчин чармайлт тавьж хамтарч ажиллахаар тохирсон болно.




Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Беларусийн Гадаад хэргийн сайд В.В.Макей нар (Минск хот, 2018.06.04-ний өдөр)



Айлчлалын үеэр УИХ-ын гишүүн, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Бүгд Найрамдах Беларусь Улсын Ерөнхий сайд А.Кобяков, Үндэсний хурлын Төлөөлөгчдийн танхимын дарга В.Андрейченко нарт тус тус бараалхаж, хоёр орны найрсаг харилцааг бүхий л талаар хөгжүүлэх, түүний дотор парламент хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд

ЗГХК-ын хуралдаанаар тохирсон хамтын ажиллагааны зүйлсийг ажил хэрэг болгоход анхаарч, Монгол Улсад хөдөө аж ахуйн агропарк, сүүний үйлдвэрлэлийн кластер, Беларусийн машин, техникийн сэлбэгийн үйлдвэрлэл, үйлчилгээний төвүүдийг байгуулах, хөдөө аж ахуй, уул уурхай, зам тээвэр, барилга зэрэг олон салбарт мэргэжилтэн бэлтгэх зэрэг чиглэлээр хамтарч ажиллахаар тохиров.



*Ерөнхий сайд А.Кобяковтой хийсэн уулзалт
(Минск хот, 2018.06.04-ний өдөр)*




*Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Бүгд
Найрамдах Беларусь Улсын Үндэсний хурлын
Төлөөлөгчдийн танхимын дарга В.Андрейченко нар
(Минск хот, 2018.06.04-ний өдөр)*

УИХ-ын гишүүн, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Хууль зүйн сайд О.Л.Слижевский нар Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах

Беларусь Улсын Засгийн газар хооронд Иргэний болон аж ахуйн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай, Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх

тухай болон Гэмт этгээдийг шилжүүлэх тухай гэрээнүүдэд тус тус гарын үсэг зурав.

Хоёр орны худалдааны эргэлт 21 сая ам.долларт хүрснээс манай импорт 20 сая гаруй ам.доллар, экспорт 222 мянган ам.доллар байна.



Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Беларусийн Хууль зүйн сайд О.Л.Слижевский нар (2018.06.04-ний өдөр)

МОНГОЛ УЛС-СЛОВАК

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар 4 дүгээр сарын 20-ны өдөр Бүгд Найрамдах Словак Улсад ажлын айлчлал хийсэн бөгөөд энэ нь 1993 онд тусгаар тогтнолоо зарласан Словак Улсад хийсэн Монгол Улсын Гадаад харилцааны сайдын анхны айлчлал байлаа.



Сайд Д.Цогтбаатар Словак Улсын Шадар сайд Р.Раши, Эдийн засгийн сайд П.Жига

Айлчлалын хүрээнд Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Словак Улсын Ерөнхий сайд Петер Пеллегринид бараалхаж, Шадар сайд Рихард Раши, Эдийн засгийн сайд Петер Жига нартай хэлэлцээ хийж, худалдаа, эдийн засаг, хөдөө аж ахуй, боловсрол, цахим засаглалын салбарт хамтран ажиллах,

мал эмнэлэг, хөдөө аж ахуйн менежмент болон мэдээллийн технологийн нарийн мэргэжлээр оюутан Словак Улсын Засгийн газрын тэтгэлгээр сургах зэрэг чиглэлээр санал солилцов.



Сайд Д.Цогтбаатар Словак Улсын Шадар сайд Р.Раши, Эдийн засгийн сайд П.Жига, 2018 оны 4 дүгээр сарын 20, Братислав хот


Сайд Д.Цогтбаатар Словак Улсын Гадаад болон Европын хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Лукаш Паризектай уулзаж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа, бүс нутгийн болон олон улсын асуудлаар мөн санал солилцов.

Монгол Улс Словак Улсад 14 мянган ам.долларын бараа экспортолж, 2.9 сая ам.долларын бараа импортолсон байна.

МОНГОЛ УЛС-АЗЕРБАЙЖАН

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 9 дүгээр сард Бүгд Найрамдах Азербайжан Улсад ажлын айлчлал хийв. Энэхүү айлчлал нь хоёр орон 1992 онд дипломат харилцаа тогтоосноос хойш хэрэгжүүлсэн дээд хэмжээний анхны айлчлал байлаа. Айлчлалын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Бүгд Найрамдах Азербайжан Улсын Ерөнхийлөгч Илхам Алиевтэй ганцаарчилсан уулзалт хийхийн сацуу хоёр талын өргөтгөсөн хэлэлцээ хийж хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчид хооронд шууд харилцааг хөгжүүлэх, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, боловсрол, спорт, тээврийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар санал солилцов.

Түүнчлэн Ерөнхийлөгч Х.Баттулга Азербайжаны Газрын тосны сан, Технологийн паркард тус тус зочилж, үйл ажиллагаатай нь танилцав.



Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, Бүгд Найрамдах Азербайжан Улсын Ерөнхийлөгч Илхам Алиев нар (Баку хот, 2018.09.24-ний өдөр)



Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, Бүгд Найрамдах Азербайжан Улсын Газрын тосны санд зочлов (Баку хот, 2018.09.25-ны өдөр)

Дээрх айлчлалын мөрөөр Азербайжаны Эдийн засгийн дэд сайд Ниязи Сафаров тэргүүтэй бизнесийн төлөөлөгчид Монгол Улсад 10 дугаар сард айлчлах үеэрээ Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхаж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нартай

тус тус уулзаж хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсоны сацуу Гадаад харилцааны яам, Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим болон Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо хамтран Монгол, Азербайжаны бизнес уулзалтыг анх удаа зохион байгуулсан болно. Хоёр талын бизнес

уулзалтыг монголын талаас Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг, азербайжаны талаас Эдийн засгийн дэд сайд Ниязи Сафаров нар тэргүүлж оролцов. Бизнесийн уулзалтад Азербайжаны талаас мэдээллийн технологи, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, уул

уурхай, хиймэл дагуул зэрэг салбарын 30 орчим төлөөлөгчид оролцож, хоёр орны бизнес эрхлэгчдийг холбох, худалдаа, эдийн засгийн харилцааны суурийг бэхжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн асуудлуудаар санал солилцов.




Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг, Азербайжаны Эдийн засгийн дэд сайд Ниязи Сафаров нар Монгол, Азербайжаны бизнес форумыг нээв (ГХЯ, 2018.10.15-ны өдөр)

УИХ-ын гишүүн, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Баку хотноо 3 дугаар сард зохион байгуулсан ЕАБХАБ-ын Парламентын Ассамблей дахь Торгоны замыг дэмжих бүлгийн олон улсын анхдугаар бага хуралд оролцож, энэ үеэр Азербайжаны Гадаад хэргийн сайд Эльмар Мамедарьявтай уулзаж,

Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Азербайжан Улсын Гадаад хэргийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.



Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Азербайжаны Гадаад хэргийн сайд Эльмар Мамедарьяв нар (Баку хот, 2018.03.12)



Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Азербайжаны Гадаад хэргийн сайд Эльмар Мамедарьяв нар Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Азербайжан Улсын Гадаад хэргийн яам хоорондын хамтын ажиллагааны тухай харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав. Баку хот, 2018.03.12-ны өдөр.

Гадаад харилцааны сайд Азербайжаны СВС телевизийн сувагт ярилцлага өгч, Монгол, Азербайжаны харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх боломж, торгоны замыг сэргээн хөгжүүлэх санаачлагын ач холбогдолын талаар санал бодлоо хуваалцав.



Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Азербайжаны СВС телевизийн сувагт ярилцлага өгөв Баку хот, 2018.03.14-ний өдөр

Монгол Улсын Их Хурал дахь Монгол, Азербайжаны парламентын бүлэг 4 дүгээр сард байгуулагдаж хоёр орны парламентын бүлгийн Монголын талын даргаар УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр томилогдов.

Дипломат, албан/сервис паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Азербайжан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт хоёр улсын Гадаад харилцааны сайд нар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 73 дугаар чуулганы үеэр Нью-Йорк хотноо гарын үсэг зурав. Энэхүү хэлэлцээрийн дагуу хоёр улсын дипломат, албан/сервис паспорт эзэмшигч иргэд 90 хоногийн хугацаанд харилцан визгүй зорчих боломж бүрдсэн бөгөөд уг хэлэлцээр 2019 оны 2 дугаар сарын 7-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлэв.

Монгол Улсаас Бүгд Найрамдах Азербайжан Улсад хавсран суугаа Элчин сайд Р.Болд, Азербайжан Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Р.Теймуров нар хоёр орны Төрийн тэргүүн нарт Итгэмжлэх жуух бичгээ барьж тус тус үүрэгт ажилдаа оров.

МОНГОЛ УЛС БА АМЕРИК, ОЙРХ ДОРНОД, АФРИКИЙН ОРНУУД

МОНГОЛ УЛС БА АНУ

*Монгол Улсын Ерөнхий сайд
АНУ-д албан ёсны айлчлал хийв.*

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 9 дүгээр сард АНУ-д албан ёсны айлчлал хийж, Ерөнхийлөгч Д.Трамп, Дэд ерөнхийлөгч М.Пэнс, Төрийн нарийн бичгийн дарга М.Помпео болон албаны бусад хүмүүстэй уулзаж, Монгол, Америкийн харилцаа, хамтын ажиллагааны өргөн хүрээтэй асуудлаар санал солилцов.



*Ерөнхий сайд У.Хүрэлсүх АНУ-ын дэд ерөнхийлөгч
М.Пэнс нар. Вашингтон хот. 2018.09.20*

*Монгол, Америкийн харилцаа
Өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн
түвшинд хүрэв.*



*Ерөнхий сайд У.Хүрэлсүх дэд ерөнхийлөгч М.Пэнс
нарын албаны ёсны уулзалт. Вашингтон хот.*

Айлчлалын дүнгээр хоёр тал Хамтарсан албан мэдэгдэл гаргаж, Монгол, Америкийн харилцаа Өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн түвшинд хүрснийг зарлав. Ийнхүү Монгол Улсын чухал гуравдагч хөршүүдийн нэг АНУ-тай стратегийн түншлэлийн харилцаа тогтоох зорилтыг шат ахиулав. Мөн хоёр талын харилцааг эдийн засгийн агуулгаар баяжуулан хөгжүүлэхэд улс төрийн дэмжлэг үзүүлж ажиллахаа талууд харилцан нотолж, энэ хүрээнд “Монгол, Америкийн эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх тухай замын зураглал”-ыг тохиролцов.



*Ерөнхий сайд У.Хүрэлсүх АНУ-ын Төрийн нарийн
бичгийн дарга нар МСК-ийн хоёр дахь компакт
гэрээг баталгаажуулах тунхаглал гарын үсэг зурав.
Вашингтон хот. 2018.09.20*

Улмаар Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Мянганы сорилтын корпорац/МСК/-ийн хоорондын хоёрдахь Компакт гэрээг баталгаажуулсан Хамтарсан тунхаглалд гарын үсэг зурав. АНУ-ын Засгийн газраас олгож буй 350 сая ам.долларын энэхүү буцалтгүй тусламжийг Улаанбаатар хотын усан хангамжийг нэмэгдүүлэх дэд бүтцийн

хөтөлбөрт зарцуулахаар хоёр тал тохиролцов.

Гадаад харилцааны сайд АНУ-д албан ёсны айлчлал хийв.

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар 5 дугаар сард АНУ-д албан ёсны айлчлал хийж, Төрийн нарийн бичгийн дарга М.Помпео, Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдлын зөвлөх Жон Болтон, АНУ-ын Конгресс дахь Монголын бүлгийг хамтран даргалагч, Конгрессын гишүүн Дон Янг болон Төрийн департаментын өндөр албан тушаалтнууд, Мянганы сорилтын корпорац (МСК)-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Жонатан Нэш нартай тус тус уулзаж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон. Сайд Д.Цогтбаатар АНУ-ын МСК-тай хоёр дахь компакт гэрээ байгуулах албан ёсны хэлэлцээг дүгнэх хэлэлцээний төгсгөлийн шатны уулзалт, Монгол Улс, АНУ-ын Эдийн засгийн бодлогын II зөвлөлдөх уулзалт, бизнесийн дугуй ширээний уулзалт зэрэгт тус

тус оролцож, Хадсоны судалгааны хүрээлэнгийн Ерөнхийлөгч Кэн Вэйнштайн, Азийн нийгэмлэгийн Дэд ерөнхийлөгч бөгөөд Вашингтон хот дахь салбарын үйл ажиллагаа хариуцсан захирал Венди Катлертай тус тус уулзаж, Жонс Хопкинсийн Их сургуулийн Олон улсын харилцааны сургуульд зочилж, “Өөрчлөгдөж буй дэлхий: Жижиг орнуудын гүйцэтгэх үүрэг” сэдвээр лекц уншив.



Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга М.Помпео нар. Вашингтон хот.

Монгол Улсын ГХЯ, АНУ-ын Төрийн департамент хоорондын XII зөвлөлдөх уулзалтыг 1 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулж 2018 онд хоёр талын харилцаанд хэрэгжүүлэх арга



ГХЯ, АНУ-ын Төрийн Департамент хоорондын XII зөвлөлдөх уулзалт. Улаанбаатар хот. 2018.01.21

хэмжээ, цаашдын чиг шугамын талаар санал солилцохын сацуу Монгол, Америкийн хооронд стратегийн түншлэл тогтоох зорилтыг урагшлуулах, хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, МСК-ийн хоёрдугаар Компакт гэрээний бэлтгэл ажлыг сайтар хангах зэрэг асуудлыг хэлэлцэв. Зөвлөлдөх уулзалтад оролцсон монголын талын төлөөлөгчдийг ГХЯ-ны ТНБД Д.Даваасүрэн, америкийн талын төлөөлөгчдийг Төрийн департаментын Зүүн Ази, Номхон далайн асуудал эрхэлсэн Туслах ТНБД-ын үүрэг гүйцэтгэгч С.Торнтон нар тэргүүлэв. Энэ удаагийн зөвлөлдөх уулзалтад америкийн талаас 5 байгууллагын 20 гаруй, монголын талаас 11 байгууллагын 30 гаруй төлөөлөгч оролцсон болно.



АНУ-ын Конгрессын төлөөлөгчдийн тэргүүн ноён Т.Ёохо Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхав.

АНУ-ын Конгрессын Төлөөлөгчдийн танхимын Гадаад бодлогын байнгын хорооны Ази, Номхон далайн асуудал эрхэлсэн дэд хорооны дарга, Төлөөлөгчдийн танхимын гишүүн Т.Ёохо тэргүүтэй төлөөлөгчид 9 дүгээр сард Монгол Улсад айлчилж, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, УИХ-ын дарга М.Энхболдод тус тус бараалхав. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар төлөөлөгчдийг хүлээн авч уулзаж, УИХ дахь Монгол, Америкийн найрамдлын бүлгээс Конгрессын гишүүдэд зоог

барив. Конгрессын гишүүн Т.Ёохо тэргүүтэй АНУ-ын Конгрессын 10 гишүүн Монголын ноос, ноолууран болон оёмол сүлжмэл бүтээгдэхүүнийг АНУ-ын зах зээлд татваргүй нийлүүлэх тухай “Гуравдагч хөршийн худалдааг дэмжих тухай хууль”-ийн төслийг АНУ-ын Конгресст өргөн барьсан бөгөөд монголын тал хуулийг батлуулах чиглэлээр америкийн талтай ажиллаж байна. АНУ-ын Конгрессын гишүүд хамгийн сүүлд 2016 онд Монгол Улсад айлчилсан бөгөөд ийнхүү Т.Ёохо тэргүүтэй төлөөлөгчид айлчилсан нь хоёр талын улс төрийн яриа хэлцээг тогтмолжуулах, уламжлалт парламент хоорондын хамтын ажиллагааг үргэлжлүүлэхэд чухал ач холбогдолтой болов.

Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын МСК-ийн хоорондын хоёр дахь Компакт гэрээг эцэслэн тохирч, улмаар Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар 7 дугаар сарын 27-нд уг гэрээнд Вашингтон хотноо гарын үсэг зурсан бөгөөд Монгол Улсын Их Хурал уг гэрээг 2019 оны 1 дүгээр сарын 31-нд соёрхон батлав.

Монгол Улсаас АНУ-д суугаа Элчин сайд Ё.Отгонбаяр 3 дугаар сард АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трампад, АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд М.Клечески 2019 оны 2 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад ИЖБ-ээ тус тус барьж үүрэгт ажилдаа оров.

*Монгол Улсын Засгийн газар,
АНУ-ын МСК-ийн хоёр дахь Компакт
гэрээ байгуулав.*

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Төрийн нарийн бичгийн дарга М.Помпеогийн урилгаар 7 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд Вашингтон хотноо зохион байгуулсан Шашны эрх чөлөөг дэмжих тухай олон улсын Сайд нарын анхдугаар Бага хуралд оролцов. Монголын тал ГХЯ-нд Шашны эрх чөлөөний асуудал хариуцсан Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд томилсныг америкийн талд мэдэгдэв.

Монгол Улсын иргэд АНУ-д визгүй зорчих алсын зорилтын хүрээнд талууд “Хариуцлагатай аялцгаа” аяны хоёр дахь шатны кампанит ажлыг эхлүүлсэн бөгөөд БНСУ-ын тал энэхүү арга хэмжээнд нэгдэв. Монгол Улс 2018 оны 1 дүгээр сарын 19-нөөс АНУ-ын “Н2” визийн хөтөлбөрт хамрагдахаар америкийн талтай тохиролцов.

Монгол Улс АНУ-ын “Н2” визийн хөтөлбөрт хамрагдав.

АНУ-ын Төрийн департаментын Зүүн Ази, Номхон далайн асуудал эрхэлсэн Туслах ТНБД-ын үүрэг гүйцэтгэгч П.Мерфи 10 дугаар сард Монгол Улсад айлчилж, Ерөнхийлөгч Х.Баттулга, Шадар сайд Ө.Энхтүвшин нарт бараалхаж, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, ГХЯ-ны ТНБД Д.Даваасүрэн нартай уулзаж, Ерөнхий сайдын АНУ-д хийсэн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажил болон Солонгосын хойгийн асуудлаар санал солилцов. Мөн ТНБД Д.Даваасүрэн 8 дугаар сард Сингапурт зохион байгуулсан АРФ-ын хурлын үеэр АНУ-ын ТНБД М.Помпеотой уулзаж харилцааны асуудлаар санал солилцов.

Монгол, АНУ, Японы ээлжит гурван талын уулзалтыг талууд 4 дүгээр сард Токио хотноо, Монгол, Америкийн БХЯ-

дын XV зөвлөлдөх уулзалтыг 12 дугаар сард Улаанбаатар хотноо тус тус зохион байгуулав.

Мөн АНУ-ын Хөдөлмөрийн яамны Уурхайн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Туслах ТНБД-ын орлогч У.Палмер Монгол Улсад айлчилснаас гадна Төрийн департаментын Олон улсын шашны эрх чөлөөний эмхэтгэлийг гаргадаг албаны төлөөлөгчид, Хүний наймаатай тэмцэх хэлтсийн төлөөлөгчид, Дүрвэгсэд, шилжин суурьшигчдын асуудал эрхэлсэн товчооны төлөөлөгчид тус тус Монгол Улсад ажиллаж, ГХЯ, ХЗДХЯ болон бусад байгууллагын албаны хүмүүстэй уулзаж санал солилцсон.

Хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд 2016-2018 онд хэрэгжүүлсэн 2,5 сая ам.долларын өртөг бүхий “LEAD Mongolia” хөтөлбөрийг үргэлжлүүлэхээр талууд тохирч америкийн тал 2018-2021 онд 3 сая ам.долларын санхүүжилт олгохоор тохиров. Түүнчлэн АНУ-ын Энхтайвны корпус манай улсад илгээж буй сайн дурын ажилтнуудынхаа тоог 10 хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэв. АНУ-ын Орбис нүдний нисдэг эмнэлэг 8 дугаар сарын 12-30-ны өдрүүдэд Монгол Улсад найм дахь удаагаа ажиллаж, иргэдэд үнэ төлбөргүй үзлэг, эмчилгээ хийв.

Талууд 2019 оныг “Монгол, Америкийн залуучуудын жил” болгон зарлахаар тохиролцсон болно.

МОНГОЛ УЛС-КАНАД

Монгол-Канадын хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ойг талууд хоёр талдаа тэмдэглэн өнгөрөөв. Монгол Улсаас Канад Улсад суугаа Элчин сайд Я.Ариунболд 11 дүгээр сарын 13-нд Канадын Амбан захирагч эрхэмсэг хатагтай Жюли Паетад ИЖБ барьж үүрэгт ажилдаа оров.

Монгол-Канадын хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ойг талууд тэмдэглэв.



Монгол-Канадын дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ой. 2018.02.01

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Минск хотноо 10 дугаар сард зохион байгуулсан Мюнхений аюулгүй байдлын форумын Үндсэн чуулганы үеэр Канадын сенатор Райнел Андрейчуктай уулзаж хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцов. Торонтогийн Уул уурхайн олон улсын чуулга уулзалт (PDAC)-ад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар тэргүүтэй төлөөлөгчид оролцож Канадын Олон улсын худалдааны Парламентын нарийн бичгийн дарга Памела Голдсмит Жонес, Байгалийн баялгийн Парламентын нарийн бичгийн дарга Ким Рудд,

Торонтогийн Хөрөнгийн биржийн удирдлагууд, Канадын Экспортыг дэмжих байгууллагын Олборлох салбарын хөрөнгө оруулалтын газрын дарга Фрэнк Келли нартай уулзаж хамтын ажиллагааны талаар санал солилцохын сацуу “Mongolia@PDAC-2018” форум зохион байгуулж Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн төлөв байдлын талаар танилцуулав.

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батласан “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-ын дагуу Торонтогийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй байгууллага Монголын Хөрөнгийн биржид бүртгүүлж, үнэт цаасаа арилжаалах боломж бүрдэв. Ийнхүү Канад Улсад бүртгэлтэй “Эрдэнэ Ресурс Девелопмент” ХК нь энгийн хувьцааг Монгол Улсад давхар бүртгүүлэн 5 дугаар сарын 31-нд олон нийтэд танилцуулж, нийт 4 сая ширхэг энгийн хувьцааг \$0.34 кан.доллараар (640 төгрөг) үнэлэн давхар бүртгэлийн захиалгаа 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрөөр дуусгаж хөрөнгө босгов.

Канадын Засгийн газрын Хөгжлийн тусламжийн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад нийт 34 сая канад долларын өртөгтэй 6 төслийг 2016 оноос хэрэгжүүлж байгаа бөгөөд Төрийн албаны зөвлөл НҮБ-ын Хүний хөгжлийн сантай хамтран “Монгол Улсад мэргэжсэн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийг 2 дугаар

сараас хэрэгжүүлж эхлэв. ГХЯ-наас Хөгжлийн тусламжийн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад хэрэгжиж буй төслүүдийг хэрэгжүүлэгч, оролцогч

болон яамд, агентлагийн төлөөлөл оролцсон нэгдсэн уулзалтыг 10 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулав.

МОНГОЛ УЛС-ЛАТИН АМЕРИКИЙН ОРНУУД

Монгол, Кубын боловсрол, шинжлэх ухааны салбарын харилцаа хоёр орны нөөц боломжид тулгуурлан хэвийн хөгжиж байна. Кубын Засгийн газраас 2018-2019 оны хичээлийн жилд Монгол Улсаас 3 оюутныг тэтгэлгээр сургахаар шийдвэрлэв. МУИС-ын захирал Я.Төмөрбаатар Хавана хотноо 2 дугаар сард зохион байгуулсан Олон улсын дээд боловсролын Конгресст оролцож, энэ үеэр МУИС болон Хаванагийн Их сургуулийн хамтын ажиллагааны талаар санал солилцож, МУИС-д испани хэл, орон судлалыг хөгжүүлэх, багш, оюутан солилцох, хамтарсан судалгаа хийх, хамтарсан оюутны зуны сургалт болон эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулах, судалгааны ном бүтээл, нийтлэл харилцан солилцох, испани хэлний багш авч ажиллуулах зэрэг чиглэлээр хамтарч ажиллахаар тохиролцов. Түүнчлэн МУИС Кубын Генетикийн инженерчлэл, биотехнологийн төвтэй хамтарч ажиллахаар тохирсон болно. Монгол Улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн захирал С.Чулуун 10 дугаар сард Хаванагийн Их сургуулийн салбар “Сан Херонимо” сургуулийн багш, оюутнуудад “Монголын археологи: одоо ба ирээдүй” сэдвээр лекц уншихын сацуу Кубын Антропологийн хүрээлэнгийн удирдлага болон тэргүүлэх эрдэмтэдтэй уулзаж, хоёр орны хооронд түүх-археологи, нийгмийн ухааны салбарт

хамтарч ажиллахаар тохирсон болно.

Монгол, Кубын эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагаанд тодорхой ахиц гарав. ЭМЯ чихрийн шижин өвчний хөлний шархлааны үе шатыг эмчилдэг “Хэбэрпрот-П” тариаг Монгол Улсад ашиглах зөвшөөрлийг “ЭмИмпекс” компанид олгож, улмаар чихрийн шижин өвчнийг эмчлэх мэргэжилтэн Клиникийн III эмнэлэгт, Кубын Генетикийн инженерчлэл, биотехнологийн төвийн мэргэжилтэн “Сонгдо” эмнэлэгт тус тус сургалт зохион байгуулснаар Монголын эмч нар “Хэбэрпрот-П” тариагаар чихрийн шижин өвчний хөлний шархлааг Монголд эмчлэх боломжтой болов. Түүнчлэн 3 дугаар сараас Кубын эмч нар “Интермед” эмнэлэгт 2 жилийн хугацаатай гэрээгээр ажиллаж байна.

МОНЦАМЭ агентлаг Кубын “Пренса Латина” агентлагтай хамтарч ажиллах тухай Санамж бичиг 2 дугаар сард байгуулав. Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч Г.Эрдэнэбат 3 дугаар сард Хавана хотноо зохион байгуулсан “Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан- 2018” олон улсын бага хуралд оролцсон. Монголын хөгжмийн удирдаач Б.Лхагвасүрэн Кубын үндэсний симфони найрал хөгжмийг удирдан 2 дугаар сард Хаванад тоглолт хийсэн бол МУГЖ, Соёлын элч Д.Алтанхуяг, МУГЖ О.Анужин нар “Хаванагийн Олон улсын балетийн

фестиваль”-д 11 дүгээр сард оролцов.

Кубын Биеийн тамир, спорт, амралт чөлөөт цагийн үндэсний хүрээлэнгийн Ерөнхийлөгч Антонио Гарридо 4 дүгээр сард Монгол Улсад айлчилж, хоёр талын спортын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөний биелэлтийн талаар санал солилцохын сацуу 2020 оны Зуны Олимпын наадмын бэлтгэлийг хамтарч хийхээр тохиролцов.

Уругвайн Гадаад хэргийн дэд сайд Ариел Бергамино тэргүүтэй төлөөлөгчид 4 дүгээр сард Монгол Улсад айлчилж Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэгтэй хэлэлцээ хийж, улс төр, эдийн засаг, хөдөө аж ахуй, сэргээгдэх эрчим хүч, спорт, аялал жуулчлал, олон талт хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажиллах асуудлаар санал солилцов.

Уругвай Улстай бүх төрлийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас харилцан чөлөөлөх тухай хэлэлцээр байгуулав.



Айлчлалын үеэр талууд ГХЯ-дын улс төрийн зөвлөлдөх механизм байгуулах тухай харилцан ойлголцлын санамж бичиг, Бүх төрлийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас

харилцан чөлөөлөх тухай хэлэлцээрт тус тус үсэг зурав. Түүнчлэн Уругвайн Жанжин штабын дарга, генерал Марсело Монтанер тэргүүтэй төлөөлөгчид манай улсад 5 дугаар сард айлчилж, БХЯ болон Жанжин штабын удирдлагуудтай уулзав.

Монгол Улсын Засгийн газар, **Мексикийн Нэгдсэн Улсын** Засгийн газар хоорондын боловсрол, урлаг, соёл, залуус, биеийн тамир, спортын салбарт 2017-2020 онд хамтран ажиллах хөтөлбөрийн хүрээнд 2018-2019 оны хичээлийн жилд магистр, докторын зэргийн болон тусгай сэдвийн хүрээнд хийх судалгааны ажлын чиглэлээр мексикийн талд 2 тэтгэлэг олгохоор шийдвэрлэж, биет бус соёлын өвийг хамгаалах чиглэлээр туршлага солилцож, хамтарч ажиллахаар тохиролцсон.

УИХ-ын дарга М.Энхболд **Чилийн** Үндэсний Конгрессын Төлөөлөгчдийн танхимын дарга Фидел Эспинозатай Ханой хотноо 1 дүгээр сард зохион байгуулсан Ази, Номхон далайн орнуудын Парламентын чуулганы XXVI уулзалтын үеэр уулзаж хоёр орны парламентын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов. Түүнчлэн Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 73 дугаар чуулганы үеэр Бүгд Найрамдах Чили Улсын Гадаад хэргийн сайд Роберто Ампуеротой уулзаж эдийн засаг, уул уурхайн салбарын хамтын ажиллагаагаа цаашид идэвхжүүлж, уул уурхайн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Бүгд Найрамдах Чили Улсын Уул уурхайн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг

байгуулан хамтарч ажиллахаар тохиролцож, Энгийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас харилцан чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Чили Улсын Засгийн газар хоорондын ноот бичиг солилцов. Ийнхүү 2018 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс хоёр улсын иргэд 90 хоногийн хугацаанд харилцан визгүй зорчих нөхцөл бүрдэв.

Чили Улстай энгийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас харилцан чөлөөлөхөөр тохиров.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргалаар ахлуулсан УИХ-ын гишүүн С.Бямбацогт, А.Сүхбат, Л.Энхболд, УУХУЯ, АМГТГ, Монголбанк, Үнэт металлын сорьцын хяналтын газар, Баянхонгор аймгийн Засаг дарга, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооны төлөөлөл болон Швейцарын хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төслийн ажилтнуудаас бүрдсэн төлөөлөгчид Швейцарын хөгжлийн агентлагийн шугамаар Колумби, Эквадорт 5 дугаар сард ажиллаж Колумби, Эквадорын алтны худалдааны эрх зүйн орчин, алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулах зэрэг чиглэлээр туршлага судлав.

Монгол Улс, **Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын** Гадаад хэргийн яамд хоорондын улс төрийн V зөвлөлдөх уулзалтыг 9 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулав. Улсын Дээд шүүхийн шүүгч М.Батсуурь Бразилийн Дээд шүүхийн шүүгч, Дэлхийн Байгаль орчныг хамгаалах эрх зүйн комиссын дарга Антонио Эрман Бенжамини

урилгаар 3 дугаар сард Дэлхийн усны VIII форумд оролцсон.



Монгол-Бразилийн Гадаад Хэргийн Яамдын Зөвлөлдөх уулзалт. Улаанбаатар хот

Аргентины Хөдөө аж ахуйн технологийн хүрээлэн болон Хүнсний аюулгүй байдал, чанарын албаны 3 мэргэжилтэн малын эрүүл мэнд, гоц халдварт шүлхий өвчний чиглэлээр техникийн туслалцаа үзүүлэх, цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлох зорилгоор 6 дугаар сарын 25-29-нд Монголд ажиллав. Үүнтэй холбогдуулан Аргентины Засгийн газраас Өмнөд-Өмнөд хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлдэг техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрт Монгол Улсыг хамруулах, Техникийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар хооронд хэлэлцээр байгуулах зэрэг чиглэлээр ажиллаж байна.

Монгол Улсын Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 73 дугаар чуулганы үеэр **Бүгд Найрамдах Эквадор Улсын** Гадаад хэргийн сайд Хосе Валенсиатай уулзаж, хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцохын сацуу талууд "Бүх төрлийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах

Эквадор Улсын Засгийн газар хоорондын ноот бичиг” солилцов. Уг тохиролцооны дагуу хоёр улсын иргэд 90 хоногийн хугацаанд харилцан визгүй зорчих нөхцөл бүрдэв.

Эквадор Улстай бүх төрлийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас харилцан чөлөөлөхөөр тохиров.

Монгол Улсын төлөөлөгчид Вьентян хотноо 11 дүгээр сард зохион байгуулсан Зүүн Ази, Латин Америкийн хамтын ажиллагааны чуулга уулзалт (ФЕАЛАК)-ын Ахлах албан тушаалтнуудын XIX уулзалтад оролцов. ФЕАЛАК-ын хамтын ажиллагааны хүрээнд Аргентинд 2, Японд 1, Колумбид 8 оюутан тус тус сургалтад хамрагдав.

МОНГОЛ УЛС-ОЙРХ ДОРНОД, БУЛАНГИЙН ОРНУУД

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар 2018 оны 12 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд Катар Улс, Кувейт Улсад албан ёсны айлчлал хийж, мөн үеэр Катарт зохион байгуулагдсан 18 дахь удаагийн “Дохагийн форум”-д оролцов.




Дохагийн форум. Катар улс

Айлчлалын үеэр сайд Д.Цогтбаатарыг **Кувейт Улсын** Эмир Шейх Сабах Аль-Ахмед Аль-Жабер Аль-Сабах; Ерөнхий сайд Шейх Жабер Аль-Мубарак Аль-Хамад Аль-Сабах; Катар Улсын Ерөнхий сайд Шейх Абдулла бин Насер Аль-Тани нар тус тус хүлээн авч уулзаж, хоёр талын хамтын ажиллагааны болон олон улсын харилцааны харилцан сонирхсон

асуудлаар ярилцав. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Катарын Шадар сайд бөгөөд Гадаад хэргийн сайд Шейх Мохаммед бин Абдулрахман Аль-Тани, Кувейтийн Шадар сайд бөгөөд Гадаад хэргийн сайд Шейх Сабах Аль-Халид Аль-Сабах нартай тус тус албан ёсны хэлэлцээ хийв.

Албан ёсны уулзалт ярианы үеэр манай тал улс орныхоо улс төр, нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, гадаад бодлогын зорилтууд, гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих эрх зүйн орчны талаар мэдээлэл хийж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх талаар санал солилцов. Яриа хэлэлцээний үр дүнд Монгол, Кувейтийн Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдаан, Гадаад хэргийн яамд хоорондын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах, Монгол Улсын Ерөнхий сайдыг Катар, Кувейт улсуудад айлчлуулах зэрэг асуудлаар ярилцаж тохиролцов.



Сайд Д.Цогтбаатар Катарын Гадаад хэргийн сайд нар.
Доха хот.



Сайд Д.Цогтбаатар Кувейтийн
Эмит бараалхав.

Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд 6 дугаар сард Москва хотноо зохион байгуулсан Парламентаризмыг хөгжүүлэх олон улсын чуулга уулзалтад оролцох үеэр Катарын Зөвлөлдөх Зөвлөл (Парламент)-ийн дарга Ахмед Бин Абдулла Бин Зайед Аль Махмудтай уулзаж хоёр орны харилцаа болон парламент хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлаар санал солилцсон. **Катар Улсын** Гадаад хэргийн төрийн сайд Солтан бин Саад Аль-Мурайхи 7 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хуралд оролцож, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхаж, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатартай уулзаж харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэх талаар санал солилцож, Катарын тал Монгол Улсад хүүхдийн 35 цэцэрлэг барихаар шийдвэрлэв.

Батлан хамгаалахын сайд Н.Энхболд Катарын Батлан хамгаалахын сайдын урилгаар 3 дугаар сард Катар Улсад айлчилж, Доха хотноо зохион байгуулсан олон улсын батлан хамгаалахын үзэсгэлэн, бага хуралд

оролцсон бөгөөд Катарын Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Ганим Бин Шахийн Аль-Ганим 6 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан Олон үндэстний энхтайвныг дэмжих үйл ажиллагааны “Хааны эрэлд-2018” хээрийн сургуульд оролцов.

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Катар Улсын Гадаад хэргийн сайд Мохамед Бин Абдулрахман Аль-Тани-тай Давосын Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын үеэр уулзаж хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар мөн санал солилцов. Катарын Олимпийн хорооны дарга Шейх Жоан бин Хамад Аль-Тани 8 дугаар сард Монгол Улсад хувийн айлчлал хийв.

Элчин сайд З.Чинтүшиг 7 дугаар сард Катар Улсын Дэд Эмир Шейх Абдулла бин Хамад Аль-Танид ИЖБ-ээ барьж, үүрэгт ажилдаа орсон.


Кувейт Улс 3.5 сая ам.долларыг Өндөрхааны нисэх онгоцны буудлын шинэчлэлтийн төсөлд зориулан олгохоор шийдвэрлэсэн бөгөөд түүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн

газар, Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сан хоорондын хэлэлцээрт Монгол Улсаас Кувейт Улсад суугаа Элчин сайд З.Чинтүшиг, Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангийн Ерөнхий захирлын орлогч Ганим Сулейман Аль-Ганиман нар 7 дугаар сарын 18-ны өдөр гарын үсэг зурав. Кувейт Улсын Засгийн газраас олгосон 8 сая ам.долларын буцалтгүй тусламжаар Түлэнхийн төвийн барилгыг барьж байгаа билээ.

Монгол Улсын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчид 3 дугаар сард Кувейт Улсад, Кувейтийн Хэвлэл мэдээллийн яамны Ази, Африк, Австралийн мэдээний газрын захирал Мазен Али Аль-Ансари 10 дугаар сард Монгол Улсад тус тус ажиллаж харилцан туршлага судласан бөгөөд 6 дугаар сард Улаанбаатар

хотноо зохион байгуулсан “Алтан хальс” кино наадамд Кувейтийн Соёл, урлаг, утга зохиолын үндэсний зөвлөлийн удирдах ажилтнууд мөн оролцов.

Арабын Нэгдсэн Эмират Улсын Гадаад хэрэг, олон улсын хамтын ажиллагааны яамны Төрийн сайд Рийм бинт Ибрахим Аль-Хашими манай улсад айлчилж, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхаж, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Ерөнхий сайдын гадаад бодлогын зөвлөх Б.Мөнхжин нар боловсрол, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн салбарын албаны хүмүүстэй уулзаж, хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, хөтөлбөрүүдийн талаар санал солилцож, Улаанбаатар хотноо нийт 2500 орчим хүүхэд хичээллэх 3 сургууль барихаар шийдвэрлэв.



Арабын Нэгдсэн Эмират Улсын Гадаад хэргийн төрийн сайд Рийм бинт Ибрахим, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар нарын уулзалт. Улаанбаатар хот.

Монгол Улс Арабын Нэгдсэн Эмират Улсад ЭСЯ нээх асуудлыг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор 11 дүгээр сарын 7-ны өдөр хэлэлцэж дэмжсэн шийдвэр гаргав.

АНЭУ-ын Дубайн ханлигийн Хунтайж Шейх Хамдан бин Мохаммад Аль-Мактуум, Ерөнхийлөгчийн зөвлөх Шейх Султан бин Халифа Аль-Нахьян нар Монгол Улсад хувийн айлчлал хийсэн.

Монгол, **Израилийн** ГХЯ-д хоорондын V зөвлөлдөх уулзалтыг 7 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулж талууд хөдөө аж ахуй, хууль сахиулах, аюулгүй байдал, иргэний хамгаалалт зэрэг чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон.



Монгол, Израилийн зөвлөлдөх уулзалт.
Улаанбаатар хот. 2018.07.10

Элчин сайд Р.Болд Израилийн Ерөнхийлөгчид 11 дүгээр сарын 8-ны өдөр ИЖБ-ээ барьж үүрэгт ажилдаа оров. Мөн Израилийн Элчин сайд Ц.Хэйфэц Монгол Улсын Жудогийн холбоонд 20 мянган ам.долларын буцалтгүй тусламж өгөв.

Израилийн хөдөө аж ахуйн чиглэлийн “АгроСтадийс” агентлагийн шугамаар ХААИС-ийн 21 оюутан 11 сарын хугацаатайгаар үйлдвэрлэлийн дадлага хийв. Мөн Израилийн ГХЯ-ны тэтгэлгээр ГХЯ-ны 4 залуу дипломат 2018 оны 6 дугаар сарын 4-8-ний өдрүүдэд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан бол Израилийн Засгийн газрын тэтгэлгээр анх удаа манай 1 төрийн албан хаагч тус улсад магистрын сургалтад хамрагдаж байна.

МОНГОЛ УЛС-АФРИКИЙН ОРНУУД

Монгол-**Египетийн** Гадаад хэргийн яамд хоорондын Улс төрийн V зөвлөлдөх уулзалтыг 2 дугаар сарын 4-ний өдөр Каир хотноо зохион байгуулсан бөгөөд манай төлөөлөгчдийг ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн тэргүүлэв. Зөвлөлдөх уулзалтын үеэр талууд худалдаа, эдийн засаг, соёл, боловсрол, аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын эрх зүйн орчинг сайжруулах, бизнесийн хэлхээ холбоог нэмэгдүүлэх, харилцан хөрөнгө оруулалт татах чиглэлээрх хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх боломжийн талаар санал солилцов. Энэ үеэр Монгол, Египетийн хооронд дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын

Ерөнхийлөгчийн зарлигаар Хөгжлийн төлөөх Египетийн түншлэлийн Агентлагийг “Найрамдал” медалиар шагнасныг албан ёсоор гардуулав. Египетийн тал араб хэлний сургалтанд 3, цагдаагийн сургалтад 1 төрийн албан хаагч хамруулсан бөгөөд хөдөө аж ахуйн 5 мэргэжилтнийг сургалтад хамруулахаар шийдвэрлэсэн.

Монгол Улсаас **Бүгд Найрамдах Жибути Улстай** дипломат харилцаа тогтоосон тухай УИХ-ын тогтоол 2018 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан. Монгол Улсаас **Эсватинийн Хаант Улстай** дипломат харилцаа тогтоох тухай Хамтарсан албан мэдэгдэлд талууд Нью-Йорк хотноо 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр гарын үсэг зурав.

ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн 2 дугаар сард **Этиоп Улсад** ажиллаж, Гадаад хэргийн яамны улс төрийн асуудал эрхэлсэн төрийн сайд, хатагтай Хирут Зементэй уулзаж харилцааны асуудал, түүний дотор Улаанбаатар хотноо төвтэй ДГХБО-ын ОУСТ-ийн хүрээнд хамтарч ажиллахаар тохиролцов. Мөн тэрээр Кени Улсад зохион байгуулсан хөрөнгө оруулалтын загвар хэлэлцээрийн төслийн асуудлаарх олон улсын форумд оролцов.



Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, Этиопын Гадаад харилцааны дэд сайд Хирут Земен нар. Аддис Абаба хот

Буркина Фасо Улс Бүгд Найрамдах Кот д'Ивуар Улс, Бүгд Найрамдах Мали, **Бүгд Найрамдах Гана Улс**, Холбооны Бүгд Найрамдах Нигери Улс, Бүгд Найрамдах Нижер Улсын Элчин сайд нар Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад Итгэмжлэх жуух бичгээ барьж, үүрэгт ажилдаа оров.

Буркина Фасо, Замби, Этиопийн төлөөлөгчид Улаанбаатар хотноо 2018 оны 5 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулсан Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төвийн Захирлуудын зөвлөлийн хуралд оролцов.

3

ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА

МОНГОЛ УЛС БА НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 2018 оны 9 дүгээр сарын 24-28-ны өдрүүдэд Нью-Йорк хотноо НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 73 дугаар чуулганд оролцов. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Ерөнхий Ассамблейн 73 дугаар чуулганы Ерөнхий санал шүүмжлэлд үг хэлж, Монгол Улсын гадаад бодлогын зорилт, Засгийн газраас улс орны нийгэм, эдийн засгийн салбарт хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааг танилцуулж, олон улсын харилцааны тулгамдсан асуудлуудаар байр сууриа илэрхийлэв.



Ерөнхий сайд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганд оролцох үеэрээ

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга А.Гутеррестэй уулзаж, Монгол-НҮБ-ын харилцаа, хамтын ажиллагааны хэтийн төлөв, “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн хүрээнд НҮБ-тай хамтран ажиллах боломжийн талаар санал солилцохын сацуу НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн захирагч А.Штайнертай уулзаж, хамтын ажиллагааны асуудлаар ярилцав.



Ерөнхий сайд У.Хүрэлсүх, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга А.Гутеррес нар. Нью Йорк хот.

Түүнчлэн Ерөнхий сайд У.Хүрэлсүх “Мансууруулах бодисын асуудалтай тэмцэх дэлхийн уриалга”-д нэгдэх Өндөр түвшний арга хэмжээнд оролцож, АНУ-ын Ерөнхийлөгч

Д.Трампа-тай уулзаж, Монгол Улс уг уриалгад нэгдэж буйг нотлов. АНУ, Аргентин, Афганистан, БНХАУ, Колумби, Мали, ОХУ зэрэг нийт 28 улсын эхлүүлсэн энэхүү хамтарсан уриалгад Монгол Улс 128 орны хамт албан ёсоор нэгдэв. Ерөнхий сайд Социалист Интернационал байгууллагын гишүүн улс орнуудын төр, засгийн тэргүүн нарын ээлжит уулзалтад оролцож, үг хэлэв.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 73 дугаар чуулганы үндсэн хэсэг 2018 оны 9 дүгээр сарын 18-наас 12 дугаар сарын 22-ны өдрүүдэд хуралдаж, олон улсын энх тайван, аюулгүй байдал, зэвсэг хураах, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа, хүний эрх, сайн засаглал, олон улсын эрх зүй, тогтвортой эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжил, байгаль

хамгаалал, нийгмийн хөгжил, НҮБ-аас үзүүлэх хүмүүнлэгийн туслалцаа, олон улсын гэмт хэрэг, терроризм, НҮБ-ын төсөв зэрэг дэлхийн улс түмний өмнө чухлаар тавигдаж буй 178 багц асуудлыг хэлэлцэж, 281 тогтоол батлав. Манай төлөөлөгчид чуулганаар хэлэлцүүлсэн 10 гаруй асуудлаар байр сууриа илэрхийлж үг хэлэхийн сацуу “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсгээс ангид статус”, “Бичиг үсгийн боловсролын тухай”, “Ардчиллын боловсролын тухай”, “Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төвийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейд Ажиглагчийн статустай болгох тухай”, “Цөмийн зэвсэггүй бүс байгуулах тухай гэрээнд оролцогч талууд болон Монгол Улсын 4 дүгээр бага хурлын тухай” зэрэг тогтоолыг тус тус санаачлан батлуулав.

НҮБ-ЫН ШИНЭЧЛЭЛ

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шинэчлэлийн үйл явцыг эрчимжүүлэх үүднээс Засгийн газар хоорондын хэлэлцээг 2009 оны хоёрдугаар сард эхлүүлсэн. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шинэчлэлийн асуудлаарх Засгийн газар хоорондын хэлэлцээнд манай төлөөлөгчид оролцож, байр сууриа илэрхийлж ажиллав. Монгол Улс нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийг тэгш, шударга үндсэн дээр өргөтгөх, чингэхдээ байнгын болон байнгын

бус гишүүдийн тоог нэмж, хөгжиж буй болон хөгжингүй орнуудын төлөөллийг зохих ёсоор хангах, үйл ажиллагааг нь илүү нээлттэй, ил тод болгох, ажлын арга барилыг нь ардчилах, хориг тавих эрхийг хянан үзэх, хязгаарлах, яваандаа халах ёстой гэсэн зарчмын байр суурь баримталж, шинэчлэлийн дүнд Аюулгүйн Зөвлөлийн шийдвэр нь үр дүнтэй, НҮБ-ын гишүүн орнуудын өргөн төлөөллийг илэрхийлж чадахуйц байх ёстой гэж үзэж байна.

ЗЭВСЭГ ХУРААХ

Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээ (ЦЗҮДГ)-ний хэрэгжилтийг хянан хэлэлцэх 2020 оны бага хурлын бэлтгэл хорооны хоёрдугаар хуралдааныг Женев хотноо 4 дүгээр сарын 23-наас 5 дугаар сарын 3-нд зохион байгуулсан бөгөөд уг хуралдааны тайланд Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусын талаарх заалт тусгуулав. Түүнчлэн уг хуралдааны бэлтгэл ажилтай холбогдуулан Жакарта хотноо 3 дугаар сарын 21-22-нд зохион байгуулсан Ази, Номхон далайн бүс нутгийн уулзалтад манай төлөөлөгчид оролцож байр сууриа илэрхийлсэн болно.

Монгол Улс Парис хотноо 5 дугаар сард зохион байгуулсан Үл дэлгэрүүлэх аюулгүй байдлын санаачлага (Proliferation Security Initiative)-ын өндөр түвшний улс төрийн уулзалтад оролцож, уг уулзалтын үеэр баталсан Эрчимтэй санаачлага гаргах явдлыг хангах тухай, Стратегийн харилцаа холбоог өргөжүүлэх тухай, Үндэсний байгууллагуудын үйл ажиллагааг бэхжүүлэх тухай, Таслан зогсоох чадавхи, туршлагыг бэхжүүлэх тухай зэрэг нийт 4 хамтарсан мэдэгдэлд нэгдэв.

“Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсгээс ангид статус” A/Res/73/44 тогтоолыг 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар нийтийн зөвшилцлөөр батлуулав. Энэ удаагийн тогтоолд Австрали, Австри, АНУ, БНХАУ, Британи, Вьетнам, Индонез, Ирланд, Казахстан, Киргиз, Мальта, Марокко, Мексик, Франц, Филиппин, Хаити, Узбекистан зэрэг улс хамтран

зохиогчоор оров. Энэхүү тогтоолд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдал, бие даасан гадаад бодлого, эдийн засгийн аюулгүй байдал, экологийн тэнцвэрт байдал болон цөмийн зэвсгээс ангид статусыг бататган бэхжүүлэхэд Монгол Улстай хамтарч ажиллахыг НҮБ-ын гишүүн улсуудад уриалсан.

Энэ дашрамд тэмдэглэхэд Монгол Улс цөмийн зэвсгээс ангид статустай болж буйгаа 1992 онд НҮБ-ын индрээс анх зарласан бөгөөд НҮБ-ын Ерөнхий Ассамблей манай статусыг сайшаан дэмжиж, 1998 оноос хойш 2 жил тутамд тогтоол баталж ирсэн юм.

Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид статус нь цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх, зэвсэг хураах чиглэлээрх олон улсын хамтын нийгэмлэгийн хүч чармайлтад ихээхэн ач холбогдолтой алхам юм. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррес 2017 онд тохиосон Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид статусын 25 жилийн ойн хүрээнд ирүүлсэн илгээлтдээ манай статусыг “онцгой статус” хэмээн тэмдэглэж, цөмийн зэвсэг хураах, үл дэлгэрүүлэх талбарт гаргаж буй Монгол Улсын Засгийн газар, ард түмний ололт амжилтыг НҮБ ихэд сайшаан тэмдэглэж байгааг цохон тэмдэглэсэн билээ. Түүнчлэн 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдөр Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсгээс ангид статусын асуудлаар НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын A/73/202 тоот илтгэл гаргав.

2020 онд болох Цөмийн зэвсэггүй бүс байгуулах тухай гэрээнд оролцогч талууд болон Монгол Улсын ээлжит 4 дүгээр бага хурлын зохицуулагчаар манай улс ажиллахаар болсныг НҮБ-ын Ерөнхий Ассамблей A/Res/73/71 тогтоолдоо талархан тэмдэглэсэн болно.

Манай төлөөлөгчид 2018 оны 6 дугаар сарын 26-28-нд Гаг хотноо зохион байгуулсан Химийн зэвсгийг хориглох конвенци (ХЗХК)-д оролцогч улсуудын 4 дүгээр тусгай хуралдаан, 6 дугаар сарын 18-29-нд Нью-Йорк хотноо зохион байгуулсан Бага оврын болон хөнгөн зэвсгийн хориотой наймааны

бүх аспектаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, таслан зогсоох үйл ажиллагааны НҮБ-ын хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан хэлэлцэх НҮБ-ын гуравдугаар Бага хурал, 11 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгуулсан Химийн зэвсгийг хориглох конвенци (ХЗХК)-д оролцогч улсуудын Бүгд хурлын 23 дугаар хуралдаан, 11 дүгээр сарын 21-30-ны өдрүүдэд зохион байгуулсан Конвенцийн хэрэгжилтийг хянан хэлэлцэх 4 дүгээр хуралдаан зэрэг олон улсын аюулгүй байдал, зэвсэг хураах асуудлаарх томоохон хурал, чуулганд оролцов.

МОНГОЛ УЛС БА ЭНХИЙГ САХИУЛАХ АЖИЛЛАГАА



Монгол Улсын Зэвсэгт хүчин дэлхийн улс орнуудын энх тайван, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт тууштай оролцож, НҮБ-д цэрэг хандивлагч 124 орноос 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 26 дугаарт жагсав.

Өмнөд Судан, Баруун Сахар, Конго, Суданы Дарфур муж, Суданы Абией муж зэрэг НҮБ-ын Энхийг сахиулах 5 ажиллагаанд 900 орчим Монгол Улсын цэргийн албан хаагч үүрэг гүйцэтгэж байна.



Монгол Улсын энгийн иргэн, иргэний цагдаагийн байгууллагын албан хаагчид тус ажиллагаанд 2016 оноос бие даан оролцож байгаа бөгөөд эдүгээ нийт 14 цагдаагийн албан хаагч НҮБ-ын ЭСА-нд үүрэг гүйцэтгээд байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчин НҮБ-ын Энхийг сахиулах үйл ажиллагаанд өөрийн оролцоогоо бэхжүүлэх бодлого баримталж, манай энгийн иргэн, иргэний цагдаагийн байгууллагын албан хаагчдыг энэхүү үйл ажиллагаанд бие даан оролцоход Зэвсэгт хүчний зүгээс дэмжих, тус ажиллагаанд инженерийн рот оролцуулах бэлтгэл хангах, Таван толгой дахь Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвийг Бүсийн сургалтын төв болгон өргөжүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

“НҮБ-ын 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийн зорилтуудыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарч холбогдох яриа хэлэлцээнд ядуурал, ажилгүйдэл, боловсрол, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтол, усны нөөц, байгаль орчны бохирдол, ногоон хөгжил,

далайд гарцгүй орнуудад тулгамдаж буй асуудлууд зэрэгт тэргүүлэх ач холбогдол өгч, эдгээр асуудлаар хөгжиж буй орнуудын 77-гийн бүлэг, Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын бүлгээс баримтлах байр суурьт өөрийн орны байр суурийг нийцүүлэн ажиллаж байна.



“НҮБ-ын 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Үндэсний сайн дурын илтгэлээ 2019 онд зохион байгуулах Тогтвортой хөгжлийн асуудлаарх улс төрийн өндөр түвшний уулзалтын үеэр танилцуулах хүсэлтээ 2018 оны 3 дугаар сарын 28-ны өдөр НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын

газарт уламжилж, тайланг хэлэлцүүлэх орнуудын жагсаалтад оруулав. Түүнчлэн, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 165 дугаар захирамжаар баталсан “2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийн үндэсний сайн дурын илтгэл боловсруулах ажлын хэсэгт ГХЯ-ны төлөөлөл ажиллаж

байна. Манай улс үндэсний сайн дурын илтгэлээ танилцуулснаар тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн өнөөгийн явцыг дүгнэж, бусад орны туршлагаас суралцаж, хэрэгжилтийг сайжруулах, түргэсгэх ач холбогдолтой юм.

ГХЯ нь дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр ЗГХЭГ, СЯ, БОАЖЯ, ҮХГ-тай хамтран “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилт” сэдвээр үндэсний хэлэлцүүлэг 2018 оны 6 дугаар сард, “Тогтвортой хөгжлийн зорилтуудын талаарх Зүүн Хойд Азийн олон талт чуулга уулзалт”-ыг 2018 оны 9 дүгээр сард, “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн сайн дурын илтгэлийг боловсруулах асуудлыг хэлэлцэх үндэсний хэлэлцүүлэг”-ийг 2018 оны 10 дугаар сард тус тус Улаанбаатар хотноо зохион байгуулав.

Монгол Улс Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх зорилгоор уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар

олон улсын түвшинд өрнөж буй яриа хэлэлцээнд тогтмол оролцож, өөрийн хувь нэмрээ оруулж байна.

Польшийн Катовиц хотноо 12 дугаар сард зохион байгуулсан УАӨНҮБСК-ийн талуудын бага хурлын 24 дүгээр чуулганд Байгаль орчин аялал жуулчлалын яам, Гадаад харилцааны яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Нийслэлийн байгаль орчны газар, Байгаль орчин, уур амьсгалын сан зэрэг албаны төлөөлөгчид үндсэн хуралдаан болон Таланоа хэлэлцээрт оролцсоноос гадна чуулганы үеэр зохион байгуулсан 30 гаруй арга хэмжээнд оролцож, 12 арга хэмжээнд илтгэл тавьж, танилцуулга хийв. 24 дүгээр чуулганаар Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Дүрмийн номыг баталснаар 2020 оноос Парисын хэлэлцээр хэрэгжиж эхлэхээр болж, улс орнууд “хүрэн” эдийн засгийг үе шаттайгаар халж, хүлэмжийн хийн ялгарлаа тооцон тайлагнаж, 2030-2050 онд хүлэмжийн хийн ялгаралгүй, цэвэр технологид суурилсан, тогтвортой хөгжлийг цогцлоох үүрэг хүлээв.

МОНГОЛ УЛС - ЮНЕСКО

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар 10 дугаар сард Парис хотноо ЮНЕСКО-гийн дэд захирал Син Цюйтай уулзаж, тус байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төслүүдийн явц, үр дүн, цаашид хамтран ажиллах салбарууд, ЮНЕСКО-д ажиллаж буй монгол ажилтны тоог нэмэгдүүлэх зэрэг асуудлаар санал солилцов. Уулзалтын үеэр сайд Д.Цогтбаатар ЮНЕСКО-гийн Ерөнхий захирлын санаачлан хэрэгжүүлж буй бодлого болон бүтцийн шинэчлэлийг Монгол Улс дэмжиж ажиллахаа илэрхийлэв.

Манай төлөөлөгчид Бахрейн Улсын нийслэл Манама хотноо хуралдсан Дэлхийн өвийн хорооны ээлжит 42 дугаар чуулган, Маврики Улсын Порт Луис хотноо чуулсан ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах Засгийн газар хоорондын хорооны 13 дугаар хуралдаан, Парис хотноо хуралдсан Соёлын биет бус өвийг

хамгаалах тухай 2003 оны конвенцийн оролцогчталуудын Ерөнхий Ассамблейн 7 дугаар чуулган, ЮНЕСКО-гийн соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай 2005 оны конвенцийн Засгийн газар хоорондын хорооны 12 дугаар ээлжит чуулган зэрэг арга хэмжээнд оролцов.

ЮНЕСКО-гийн Холбоот сургуулиудын захирлуудын уулзалтыг 1 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан бөгөөд энэ үеэр ЮНЕСКО-гийн Холбоот сургуулиудын сүлжээнд Сүхбаатар дүүргийн Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль албан ёсоор нэгдэв. Мөн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Хөхүүрийн айраг эсгэх уламжлал, холбогдох зан үйл” өвийг хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад бүртгүүлэхээр нэр дэвшүүлэв.

МОНГОЛ УЛС - ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛ

Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл/ХЭЗ/-д 2015 онд гишүүнээр сонгогдон 2016-2018 онд ажиллав. Монгол Улс ХЭЗ-ийн гишүүнээр ажиллах хугацаандаа тус Зөвлөлийн 31 дүгээр чуулганы өндөр түвшний хуралдаанд Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн, 34 дүгээр чуулганы өндөр түвшний хуралдаанд Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, 37 дугаар чуулганы Өндөр түвшний хуралдаанд Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг нар тус тус оролцож,

Зөвлөлийн үйл ажиллагаан дахь Монгол Улсын оролцоог хангаж, Засгийн газраас хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих чиглэлээр дотооддоо болон олон улсын түвшинд хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн шинэчлэлийн талаар танилцуулж ажилласнаас гадна манай төлөөлөгчид Зөвлөлийн 31-39 дүгээр ээлжит чуулганууд, 25-28 дугаар тусгай чуулгануудын үйл ажиллагаанд оролцож, холбогдох сэдэвчилсэн хэлэлцүүлэгүүдэд улсынхаа байр

суурийг илэрхийлж байв. Түүнчлэн Бенин, Бельги, Коста Рика, Франц, Мексик, Молдова, Швейцарь зэрэг үндсэн бүлгийн орны хамтаар “Цаазаар авах ял оноож гүйцэтгэхийг хориглох тухай” тогтоолын төсөл санаачлан хэлэлцүүлж батлуулсан нь тэргүүлэх чиглэлээ бататгасан чухал ач холбогдолтой үйл явдал боллоо.

Мөн ХЭЗ-ийн ээлжит 39 дүгээр чуулганы үеэр НҮБ-ын Хүний эрхийн дээд Комиссарын албатай хамтран “Дэлхийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх орон нутгийн шийдэл: Хүний эрх ба хөгжлийг урагшлуулахад иргэдийн оруулах хувь нэмэр, оролцоо” арга хэмжээг зохион байгуулж “Жорлонгоо

өөрчилъе” санаачилгыг хэрэгжүүлж буй “Нутгийн шийдэл” ТББ-ын тэргүүн Ц.Оюунгэрэлийг оролцуулж манай улс дахь ариун цэврийн байгууламжийн тулгамдсан асуудлаар илтгэл тавиулж хэлэлцүүлэв.

Манай улсын хувьд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд сонгогдон ажилласан явдал олон улсын тавцанд нэр хүндээ бэхжүүлэх, НҮБ болон олон улсын бусад байгууллагын үйл ажиллагаан дахь Монгол Улсын бодит оролцоог нэмэгдүүлэх, олон талт хамтын ажиллагааны хүрээнд бусад улс оронтой хамтран ажиллах, харилцан дэмжлэг авч ажиллахад чухал ач холбогдолтой боллоо.

МОНГОЛ УЛС-АНДЭЗНК

/НҮБ-ЫН АЗИ, НОМХОН ДАЛАЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН КОМИСС/

Монгол Улс НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс /НҮБ-ын АНДЭЗНК/-ын гишүүнээр 1961 онд элссэнээс хойш худалдаа, хөрөнгө оруулалт, байгаль орчин, статистик, ядуурлыг бууруулах, эрчим хүч, гамшгийн эрсдлийг бууруулах, дамжин өнгөрөх тээвэр, далайд гарцгүй хөгжиж буй орнуудын эрх ашгийг хамгаалах зэрэг чиглэлээр хамтын ажиллагаа хөгжүүлж байна.

Комиссын эрх барих дээд байгууллага болох АНДЭЗНК-ын 74 дүгээр чуулган “Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөрийн эрин дэх тэгш бус байдал” сэдвээр Бангкок хотноо 5 дугаар сард хуралдсан бөгөөд уг чуулганд манай төлөөлөгчдийг Монгол Улсаас АНДЭЗНК-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч бөгөөд Элчин сайд Т.Төгсбилгүүн тэргүүлж оролцов.

Чуулганы хүрээнд ДГХБО-ын ОУСТ-тэй хамтран Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын бүс нутгийн интеграцчлалыг эргэн харах” сэдвээр тусгай арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд энэхүү арга хэмжээ нь Улаанбаатарт төвтэй ДГХБО-ын ОУСТ-ийг байнгын үйл ажиллагаатай олон улсын байгууллага болгох, үйл ажиллагааг нь сурталчлахад ач холбогдолтой болов.

Чуулганаар “Ази, Номхон далайн бүс нутгийн замын аюулгүй байдлыг сайжруулах тухай”, “Олон улсын хуурай боомтуудын төлөвлөлт, загвар, хөгжил, үйл ажиллагааны олон улсын ач холбогдлын тухай бүс нутгийн тогтолцоог дэмжих”, “Ази, Номхон далайн эрчим хүчний хоёрдугаар форумын дүнг хэрэгжүүлэх”, мөн “Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөрийн

эрин дэх тэгш бус байдал” сэдвээр болж буй үндсэн тогтоол болох “Ази, Номхон далайн бүс нутаг дахь бүх хэлбэрийн тэгш бус байдалтай тэмцэх бүс нутгийн хамтын ажиллагааны бэхжүүлэх” зэрэг манай ашиг сонирхолд нийцсэн тогтоолуудад манай улс хамтран зохиогчоор оролцов.

Гамшгийн эрсдлийн асуудлаарх Сайд нарын хоёрдугаар Бага хурлыг 2018 оны 7 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулахад бага хурлын бэлтгэл ажлын мэдээллийг гишүүн орнуудад түгээх, төлөөлөгчдийг өндөр түвшинд оролцуулах болон бусад техникийн туслалцааг АНДЭЗНК-оос авч ажиллах зэрэг ажлыг хийж гүйцэтгэв.

Азийн авто замын дагуу авто тээвэр

гүйцэтгэх тухай Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг манай улсын санаачилгаар 2016 онд байгуулсан бөгөөд хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд гурван улсын экспертүүдийн уулзалтыг Улаан-Үд хотноо АНДЭЗНК-ын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан.

Жил бүр манай 30 гаруй төрийн албан хаагч, судлаачдыг худалдаа, хөрөнгө оруулалт, байгаль орчин, статистик, эрчим хүч, ашигт малтмал, дамжин өнгөрөх тээврийн чиглэлээр АНДЭЗНК-ын шугамаар зохион байгуулж буй сургалт, семинарт хамруулж, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэхэд анхаарч ажиллаж байна.

ДАЛАЙД ГАРЦГҮЙ ХӨГЖИЖ БУЙ ОРНУУДЫН ОЛОН УЛСЫН СУДАЛГААНЫ ТӨВ



Монгол Улсын санаачилгаар Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Олон улсын судалгааны төв /ДГХБО-

ын ОУСТ/-ийг Улаанбаатар хотноо байгуулан ажиллаж байна. Энэхүү төвийн гол зорилго нь далайд

гарцгүй хөгжиж байгаа орнуудын эрх ашгийг хамгаалах, хөгжлийн бодлого боловсруулах, ДГХБО-ын талаарх Венийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гол тулгуур болох хамтын ажиллагааны судалгаа хийж хөгжилд хувь нэмэр оруулах явдал юм.

ДГХБО-уудын ОУСТ-ийг Улаанбаатар хотноо үүсгэн байгуулах тухай Олон талт хэлэлцээр хамгийн багадаа 10 орон нэгдэн орсноор хүчин төгөлдөр болох заалттай тул далайд гарцгүй орнуудаар соёрхон батлуулах ажил манай улсын хамгийн чухал үүрэг байлаа. 2017 оны 8 дугаар сарын байдлаар уг хэлэлцээрт 10 улс нэгдэн орсноор 2017 оны 10 дугаар сарын 6-наас уг хэлэлцээр хүчин төгөлдөр болсон билээ.

Хэлэлцээр хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан ДГХБО-ын ОУСТ-ийн Захирагчдын зөвлөлийг байгуулж, зөвлөлийн анхдугаар хурлыг ДГХБО-ын ОУСТ-тэй хамтран 5 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулав. Захирагчдын зөвлөлийн анхдугаар хурлаар ОУСТ-ийн Гүйцэтгэх захирлыг томилж, ОУСТ-ийн үйл ажиллагааны зарчим, дотоод журмын төсөл, хүлээн авагч оронтой байгуулах хэлэлцээрийн төслийг тус тус хэлэлцүүлж, холбогдох шийдвэр гаргав. Захирагчдын зөвлөлийн хуралд манай улс Дэд сайдын түвшинд оролцож, хурлыг даргалав. Түүнчлэн 2018 оны 6 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо ДГХБО-ын ОУСТ-ийн албан ёсны нээлтийн бага хурлыг зохион байгуулав.



*ДГХБО-ын ОУСТ-ийн албан ёсны нээлт.
Улаанбаатар хот.*

Хэлэлцээрт 2018 оны байдлаар Афганистан, Армян, Балба, Буркина Фасо, Бутан, Казахстан, Киргиз, Лаос, Монгол, Нигер, Парагвай, Тажикистан, Этиоп зэрэг далайд гарцгүй хөгжиж буй нийт 13 улс нэгдээд байна.

ДГХБО-ын ОУСТ нь Монгол Улсад төвтэй анхны Засгийн газар хоорондын олон улсын байгууллага төдийгүй далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хувьд ч анхны Засгийн газар хоорондын байгууллага юм.

МОНГОЛ УЛС-ЭҮНХ

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн (ЭҮНХ)-ий Ахлах албан тушаалтны уулзалт, Сайд нарын 18 дугаар бага хурал 4 дүгээр сард Азербайжан Улсын нийслэл Баку хотноо “Тогтвортой хөгжлийн төлөө олон улсын энхтайван, аюулгүй байдлыг хөхиүлэн дэмжих нь” сэдвээр зохион байгуулсан бөгөөд түүнд хөдөлгөөний гишүүн 120 улс, ажиглагч 17 улс, олон улсын 10 гаруй байгууллагын нийт 800 гаруй төлөөлөгч оролцож, Бакугийн тунхаглал, төгсгөлийн баримт бичгийг батлав. Уг төгсгөлийн баримт бичигт Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг олон улсын хэмжээнд

баталгаажуулах, Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын олон улсын судалгааны төвийг байгуулах Олон талт хэлэлцээр хүчин төгөлдөр болсонд баяр хүргэж, төвийн үйл ажиллагааг дэмжих, бүх нийтийн боловсролыг урагшлуулах, хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах болон Улаанбаатар хотноо 7 дугаар сард зохион байгуулсан Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлаарх Азийн сайд нарын хоёрдугаар бага хуралд холбогдох талуудыг идэвхтэй оролцохыг уриалсан заалтуудыг тус тус тусгуулж батлуулсан болно.



Сайд нарын бага хурлын Ерөнхий хэлэлцүүлэгт Гадаад харилцааны яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал О.Энхцэцэг үг хэлэв.

ЭҮНХ-ий Дээд хэмжээний XVIII уулзалт 2019 оны 10 дугаар сарын 25-26-нд Баку хотноо болох юм.

МОНГОЛ УЛС-АЗИ-ЕВРОПЫН УУЛЗАЛТ /АСЕМ/

Монгол Улс Ази-Европын уулзалт (АСЕМ)-ын Дээд түвшний 11 дүгээр уулзалтыг 2016 онд эх орондоо зохион байгуулснаас хойш тус яриа хэлэлцээний идэвхтэй түнш байж, 11 дүгээр уулзалтын төгсгөлийн баримт бичигт тусгагдсан асуудлуудыг ажил хэрэг болгох чиглэлээр ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 10 дугаар сарын 18-19-нд Брюссель хотноо зохион байгуулсан Ази-Европын уулзалт (АСЕМ)-ын Дээд түвшний 12 дугаар уулзалтад оролцов. Энэхүү уулзалт нь “Европ ба Ази: Дэлхийн нийтийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхийн төлөөх дэлхий нийтийн түншлэл” сэдвийн дор зохион байгуулагдсан бөгөөд “Ирээдүйг хамтран бүтээх нь: АСЕМ бол бүх нийтийг хамарсан өсөлт, тогтвортой уялдаа холбоог хангахад тэргүүлэх хүчин” сэдвээр болсон нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга үг хэлж, өнөөгийн олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд АСЕМ-ийн үүрэг өсөн нэмэгдэж байгааг тэмдэглэхийн сацуу Монгол Улсын хөгжлийн зорилтуудын хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж ирсэн АСЕМ-ын түнш орнуудтай хоёр болон олон талын худалдаа, эдийн засгийн төдийгүй нийгэм-соёлын идэвхтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлого баримталж байдгааг онцлон тэмдэглэж, манай улсын санаачилгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Зүүн хойд Азийн эрчим хүчний супер сүлжээ”-ний талаар дэлгэрэнгүй танилцуулав.



Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга АСЕМ-ын дээд түвшний уулзалт дээр. Брюссель хот.

Манай төлөөлөгчдийн тэргүүн тус Дээд түвшний уулзалтын үеэр ХБНГУ-ын Канцлер Ангела Меркел, БНСВУ-ын Ерөнхий сайд Нгуен Суан Фук, Ирланд Улсын Ерөнхий сайд Ан Таоиссэч Лео Варадкар, Унгар Улсын Ерөнхий сайд Виктор Орбан, Норвеги Улсын Ерөнхий сайд Эрна Солберг, Шведийн Вант Улсын Гадаад хэргийн сайд М.Уолсром нартай уулзаж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон болно.

АСЕМ-ын Дээд түвшний 13 дугаар уулзалтыг 2020 онд Камбож Улс хүлээн авч зохион байгуулахаар тохиролцсон.

АСЕМ-ын Дээд түвшний уулзалт хоорондын үйл ажиллагаа, түүний хүрээнд зохион байгуулдаг арга хэмжээнд идэвхтэй байр сууринаас оролцох, улмаар салбар дундын зохицуулалт хийхэд АСЕМ-ын Ахлах албан тушаалтнуудын уулзалтууд чухал үүрэг гүйцэтгэдэг. 2018 оны хувьд 4 дүгээр сард Вена, 9 дүгээр сард Токио, 10 дугаар сард Брюссель хотноо АСЕМ-ын ахлах албан тушаалтнуудын уулзалт зохион байгуулсан бөгөөд манай улс

Элчин сайд, Байнгын төлөөлөгч нарын түвшин тогтмол оролцож байлаа. Түүнчлэн АСЕМ-ын хүрээнд Софи хотноо зохион байгуулсан Соёлын сайд нарын 8 дугаар уулзалт, Нидерландын Лейден хотноо зохион байгуулсан Хүний эрхийн асуудлаарх цуврал семинар, БНСВУ-

ын Кан То хотноо зохион байгуулсан “Тогтвортой хөгжлийн зорилтын төлөөх уур амьсгалын үйл ажиллагаа, урагшлуулах арга зам” сэдэвт АСЕМ-ын Бага хуралд манай төлөөлөгчид мөн оролцов.

МОНГОЛ-ЕАБХАБ

Монгол Улс ЕАБХАБ-ын үйл ажиллагааны үндсэн гурван чиглэлийн /цэрэг, улс төр; эдийн засаг, байгаль орчин; хүний аюулгүй байдал/ хүрээнд түүний оролцогч орнуудтай хамтран ажиллаж, ялангуяа эдийн засаг, байгаль орчин, хүний аюулгүй байдлын асуудлуудад түлхүү анхаарч, эдгээр чиглэлээр тодорхой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхийг чухалчилж байна. Манай улс ЕАБХАБ-ын оролцогч буюу бүрэн эрхт гишүүний хувьд тус байгууллагын үйл ажиллагаатай нарийвчлан танилцаж, Сайд нарын зөвлөлийн болон Байнгын зөвлөлийн хуралдаан, Эдийн засгийн чуулга уулзалт, хүний эрхийн хэмжигдэхүүний хэрэгжилтийн талаарх уулзалт зэрэг гол арга хэмжээнд идэвхтэй оролцохын сацуу хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, үр бүтээлтэй, нягт хамтран ажиллахад анхаарч байна.

“Торгоны замын эдийн засгийн бүс дэх хамтын ажиллагаа, соёлын харилцааг бэхжүүлэхэд парламентын гишүүдийн гүйцэтгэх үүрэг” сэдвийн дор ЕАБХАБ-ын Парламентын Ассамблей дахь “Торгоны замыг дэмжих бүлэг”-ийн Олон улсын анхдугаар бага хурлыг Бүгд Найрамдах Азербайжан Улсын Баку хотноо 2018 оны 3 дугаар сарын 13-14-нд зохион байгуулсан бөгөөд

түүнд ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн Торгоны замыг дэмжих бүлгийн 22 гишүүн улсын 80 гаруй төлөөлөгч оролцож, Торгоны замын бүсэд харилцан ашигтай эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, худалдааны хэмжээг нэмэгдүүлэх, тээвэр, логистикийг хялбаршуулах, бүс нутагт итгэлцлийг бэхжүүлж, соёлын харилцааг хөгжүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэв. Уг бага хуралд УИХ-ын гишүүн, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр нар оролцов.

ЕАБХАБ-ын Үндэстэн дамнасан аюул, заналхийлэлтэй тэмцэх газар (ҮДАЗТГ)-ын дарга Раса Остраускайте 9 дүгээр сард манай улсад ажлын айлчлал хийж, ЕАБХАБ-ын ҮДАЗТГ-аас 2016 оноос эхлэн хилийн аюулгүй байдлын асуудал хариуцсан байгууллагуудад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх механизмыг бүрдүүлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан төслийн хүрээнд хилийн аюулгүй байдлын асуудал хариуцсан байгууллагуудын удирдлагуудтай уулзаж, байгууллагын үйл ажиллагаанд жендэрийн тэгш оролцоог хангах чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний талаар санал солилцов.

ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн алба (АИХЭА)-ны Хүний эрхийн газрын дэд захирал Женнифер Крофт тэргүүтэй төлөөлөгчид 9 дүгээр сард манай улсад ажлын айлчлал хийв. Энэхүү айлчлал нь манай улсын хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдал, ололт амжилт, сорилт бэрхшээлийг тогтоож, улмаар манай Засгийн газарт санал зөвлөмж өгөх, мөрөөр хамтран ажиллах боломжийг тодруулахад чиглэсэн бөгөөд айлчлалын төгсгөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг хамруулж,

хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын талаар дугуй ширээний уулзалт зохион байгуулав.

ЕАБХАБ-ын Сайд нарын зөвлөлийн 25 дугаар уулзалт Милан хотноо 12 дугаар сард зохион байгуулсан бөгөөд түүнд Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн тэргүүтэй төлөөлөгчид оролцож, ЕАБХАБ-ын үйл ажиллагааны хүрээнд манай улсын хийж гүйцэтгэсэн ажлын талаар танилцуулж, хоёр талын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

МОНГОЛ УЛС-ЗҮҮН ХОЙД АЗИ

Зүүн хойд Азид өрнөж буй үйл явц нь манай улсын аюулгүй байдал, тогтвортой хөгжилд шууд нөлөөлдөг тул энэ бүс нутагт оршиж буй улс орнуудтай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, ялангуяа бүс нутгийн олон талт үйл явц, яриа хэлэлцээ, интеграцийн өрнөлд оновчтой оролцох нь манай улсын гадаад бодлогын чухал зорилтын нэг юм. Бүс нутгийн бүх улс орнуудтай найрсаг харилцаатай орны хувьд Монгол Улс нь энэ бүс нутгийн аливаа маргаантай асуудлыг яриа хэлэлцээний замаар шийдвэрлэх үйл явц, ялангуяа Солонгосын хойгт үүсээд байгаа хурцадмал байдлыг намжаах, бүс нутгийн тогтвортой байдалд ахиц гаргах чиглэлд өөрийн хувь нэмрээ оруулах боломжтой гэж үздэг.

Монгол Улс 1980-аад оноос ЗХА-ийн яриа хэлэлцээний механизмыг бий болгох санал дэвшүүлж ирсэн бөгөөд 2013 онд Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх Улаанбаатарын

яриа хэлэлцээг (Ulaanbaatar Dialogue Initiative on Northeast Asian Security) эхлүүлэх санаачлага дэвшүүлж ажил хэрэг болгох чиглэлээр багагүй хүчин чармайлт тавьж ирсэн юм. Энэ хүрээнд Монгол Улс ЗХА-ийн эмэгтэй Парламентчдын чуулга уулзалт (2013), ЗХА-ийн хотуудын дарга нарын уулзалт (2014, 2015, 2018), Залуучуудын уулзалт (2015), ЗХА-ийн орнуудын шинжээчдийн түвшний “Эрчим хүчний хэлхээ холбоо” уулзалт (2015, 2016, 2018), ЗХА-ийн аюулгүй байдлын асуудлаарх олон улсын Бага хурал (2014, 2015, 2016, 2017, 2018)-ыг тус тус зохион байгуулсан.



Улаанбаатарын яриа хэлэлцээний гол зарчмууд нь аль нэг улс, нэг талын эрх ашгийг давуу тавихгүй, оролцогч талуудын саналыг хүндэтгэн, хэлэлцэх сэдэв, хамтран ажиллах арга зам, албан болон албан бус уулзалтыг бүх шатанд хийж, дүнг хэлэлцэж байх, бүс нутагт энх тайван, тогтвортой байдлыг хангах урт хугацааны зорилт дэвшүүлэн өргөн хүрээнд итгэлцлийг бүрдүүлэх, эхний ээлжинд хоёр талын яриа хэлэлцээг эхлүүлэх суурийг тавьж, улмаар гурван талт, олон талт яриа хэлэлцээнд чиглүүлэх явдал юм.

ЗХА-ийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачилга нь бүс нутагт үйлчилж байгаа байгаа бусад яриа хэлэлцээний

механизмуудаас хэлбэр, хөндөх сэдэв, оролцогчдын хувьд дараах байдлаар ялгарна. Нэгдүгээрт, яриа хэлэлцээ албан ёсны 1 дүгээр суваг болон академик түвшний 2 дугаар суваг хослуулан 1.5 гэсэн хэлбэрээр явагдаж байна. Чингэснээр яриа хэлэлцээг мухардмал байдалд орохоос сэргийлж, албан бус нөхцөлд илэн далангүй санал бодлоо илэрхийлэх боломж бүрдэж байна. Хоёрдугаарт, 6 талт яриа хэлэлцээ Солонгосын цөмийн хөтөлбөрийг хэлэлцдэг бол Улаанбаатарын яриа хэлэлцээ бүс нутгийн аюулгүй байдлын асуудлууд болон эрчим хүч, дэд бүтэц, байгаль орчны хамтын ажиллагаа, бүс нутгийн интеграц, уламжлалт бус аюул заналын асуудлыг хамруулдаг.



Өнгөрсөн хугацаанд зохион байгуулсан арга хэмжээнд ЗХА-ийн бүх орон оролцож ирсэн бөгөөд цаашид эдүгээ хэрэгжиж буй хоёр талын зөвлөлдөх

уулзалтуудыг 3 талт болгон өргөжүүлэх, түвшинг ахиулах, тогтмолжуулахыг зорьж байна.

4


МОНГОЛ УЛСЫН ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ХАРИЛЦАА

ГАДААД ХУДАЛДАА

Монгол улс 2018 онд дэлхийн 159 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 12,9 тэрбум ам.долларт хүрэв. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад 2,35 тэрбум ам.доллар буюу 22.3%-иар өссөн үзүүлэлт юм. Үүнээс экспорт 7 тэрбум ам.доллар, импорт 5,9 тэрбум

ам.доллар хүрч, гадаад худалдааны тэнцэл 1,1 тэрбум ам.долларын ашигтай гарав. Гадаад худалдааны нийт эргэлт 12,9 тэрбум ам.долларт хүрч түүхэн дээд амжилт тогтооход экспортын хэмжээ 13%, импортын хэмжээ 35% өссөн нь нөлөөлөв.

График 1. Гадаад худалдааны гүйцэтгэл,
тэрбум ам.доллар (2014-2018)



ЭКСПОРТ

Монгол улс дэлхийн 77 оронд бараа экспортолсноос БНХАУ-д 92.8%, ИБУИНХУ-д 2.5%, ОХУ-д 1.2% тус тус ногдож, нийт экспортын 96.5%-ийг

дээрх орнууд эзэлж байна. Экспортын өсөлтийг БТКУС-ийн барааны хэсгээр авч үзвэл эрдэс бүтээгдэхүүний экспорт 1136.6 сая ам.доллар буюу 23.0

хувиар, нэхмэлийн материал болон нэхмэл эдлэлийн экспорт 74.3 сая ам.доллар буюу 22.2 хувиар, хүнсний бэлэн бүтээгдэхүүний экспорт 68.4

сая ам.доллараар, амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүний экспорт 34.7 сая ам.доллар буюу 51.5 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл, сая ам.доллар (2013-2018)

Төрөл	2014	2015	2016	2017	2018	2018/2017
Эргэлт	11,011	8,467	8,274	10,536	12,886	22,3%
Экспорт	5,774	4,669	4,916	6,201	7,011	13%
Импорт	5,236	3,798	3,358	4,335	5,875	35,5%
Тэнцэл	539	872	1,558	1,865	1,136	-39%

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Үүнээс чулуун нүүрсний экспорт 2,8 сая тонноор, үнийн дүн нь 529,5 сая ам.доллараар, хилийн дундаж үнэ 9,5 ам.доллараар тус тус өсч, 2018 онд нийт 2,78 тэрбум ам.долларын 35.75 сая тонн чулуун нүүрс экспортолсон байна. Зэсийн баяжмалын экспорт 10,5 мянган тонноор буурсан ч хилийн дундаж үнэ нь 285.9 ам.доллараар, үнийн дүн нь

399.1 сая ам.доллараар тус тус өсч, 2018 онд нийт 2 тэрбум ам.долларын 1,43 сая тонн зэсийн баяжмал экспортолсон. Түүнчлэн төмрийн хүдрийн экспорт 7,4 сая тонн буюу 342,1 сая ам.доллар, боловсруулаагүй нефть 6189,8 мянган баррель буюу 392 сая ам.долларт тус тус хүрэв.

УУЛ УУРХАЙН БУС БҮТЭЭГДЭХҮҮН

Нэхмэл материал болон нэхмэл эдлэлийн экспортын 98.6 хувийг мал амьтны ноос, хивс, сүлжмэл, оёмол эдлэлийн экспорт эзэлж байна. Түүнчлэн самнасан ноолуурын экспорт 49.1 тонноор өсч, ямааны угаасан ноолуурын экспорт 123.0 тонноор буурсан байна. Өмнөх онтой харьцуулахад сүлжмэл эдлэлийн экспорт 2.7 сая ам.доллараар, оёмол эдлэлийн экспорт 2.1 сая ам.доллараар тус тус өслөө.

Монгол Улс 2018 онд нийт 162,8 сая ам.долларын өртөг бүхий 70,318 тонн мах, махан бүтээгдэхүүн экспортолсон нь 2017 онтой харьцуулахад даруй 2,5 дахин өссөн үзүүлэлт юм. Үүнээс 41096 тн түүхий мах (адуу 32,202тн, үхэр -1120 тн, хонь - 4602тн, ямаа - 1512тн, дайвар

мах - 1660тн)-ыг 48 аж ахуйн нэгж экспортод гаргасан байна. 11041 тн махыг боловсруулж, лаазалсан махан бүтээгдэхүүн хэлбэрээр экспортлов. Экспортын махыг Азербайжан, Катар, Арабын Нэгдсэн Эмират улс руу Буян-Ухаа боомтоор онгоцоор, Вьетнам, Иран, Казахстан, Киргизстан, БНХАУ зэрэг орнуудад Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур, Боршоо, Арцсуурь боомтуудаар автомашинаар, Малайз, Вьетнам, Гонконг руу Замын-Үүд, Сэлэнгэ боомтуудаар төмөр замаар тус тус гаргасан. Харин хонь, ямааны 18181,1 тн махыг дулааны аргаар боловсруулж, нийт 17 аж ахуйн нэгж зөвхөн БНХАУ-д Замын-Үүд, Хавирга, Булган, Шивээхүрэн боомтуудаар дамжуулан экспортолсон болно.

ИМПОРТ

Монгол Улс дэлхийн 157 орноос гарал үүсэлтэй бараа импортолсноос ОХУ-аас 29.1%, БНХАУ-аас 33.5%, АНУ-аас 3.6%, Японоос 9.5%, БНСУ-аас 4.5%, ХБНГУ-аас 2.9%-тай тэнцэх бараа бүтээгдэхүүнийг тус тус импортлов.

Импортын барааны нийт дүнд машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 1285.9 сая ам.доллар буюу 21.9 хувь, эрдэс бүтээгдэхүүн 1325.7 сая ам.доллар буюу 22.6 хувь, түүний дотор нефтийн бүтээгдэхүүн 1112.3 сая ам.доллар буюу 83.9 хувь, мал амьтан,

ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл 673.5 сая ам.доллар буюу 11.5 хувь, авто болон агаарын тээврийн хэрэгсэл тэдгээрийн эд анги 896.8 сая ам.доллар буюу 15.3 хувь, хуванцар болон хуванцар эдлэл, каучук болон каучукан эдлэл 226.8 сая ам.доллар буюу 3.9 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 540.3 сая ам.доллар буюу 9.2 хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн 372.2 сая ам.доллар буюу 6.3 хувийг тус тус эзэлж, эдгээр нь нийт дүнгийн 90.7 хувь ногдож байна.

Хүснэгт 2. Худалдааны гол түнш орнууд, мян.ам доллар (2018)


Улс	Экспорт	Импорт	Тэнцэл	Нийт эргэлт	Эзлэх хувь
БНХАУ	6,505,528.3	1,969,050.2	4,536,478.1	8,474,578.4	65,76%
ОХУ	85,937.4	1,710,347.3	-1,624,410.0	1,796,284.7	13,94%
Япон	26,468.5	561,042.6	-534,574.1	587,511.1	4,56%
БНСУ	21,200.4	262,365.9	-241,165.5	283,566.4	2,2%
Америкийн Нэгдсэн Улс	7,603.3	211,463.8	-203,860.4	219,067.1	1,70%
Их британи	172,856.0	31,944.5	140,911.5	204,800.5	1,59%
ХБНГУ	12,280.7	168,735.8	-156,455.2	181,016.5	1,4%
Итали	54,078.1	54,726.6	-648.5	108,804.7	0,84%
Вьетнам	9,648.3	48,951.0	-39,302.7	58,599.3	0,45%
Польш	332.2	58,027.1	-57,694.9	58,359.3	0,45%
Сингапур	30,008.4	27,629.4	2,379.0	57,637.8	0,45%
Энэтхэг	995.1	51,751.6	-50,756.5	52,746.7	0,41%
Малайз	1,658.0	50,303.0	-48,645.0	51,961.0	0,4%
Австрали	1,273.9	49,912.9	-48,639.0	51,186.8	0,4%
Франц	5,396.6	39,145.3	-33,748.7	44,541.8	0,35%
Турк Улс	4,474.8	39,155.0	-34,680.2	43,629.9	0,34%
Канад	2,313.4	38,989.2	-36,675.8	41,302.7	0,32%
Швед	130.3	39,084.7	-38,954.5	39,215.0	0,3%
Тайвань	25,471.5	13,354.2	12,117.3	38,825.7	0,3%
Украин	59.9	38,555.8	-38,495.9	38,615.8	0,3%
Казахстан	3,527.1	32,186.0	-28,659.0	35,713.1	0,28%
Тайланд	708.1	34,440.0	-33,731.8	35,148.1	0,27%
НИЙТ					97,02%

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монгол Улсад 2018 онд нийт 2,47 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж, энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад 382,9 сая ам.доллар буюу 18%-иар өссөн үзүүлэлт юм. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлтөд Канадын шууд хөрөнгө оруулалт 2018 онд 1,52 тэрбум ам.долларт хүрч хоёр

дахин, Японы хөрөнгө оруулалт 235,8 сая ам.доллар хүрч 2,5 дахин өссөн нь голлон нөлөөлөв. Хөрөнгө оруулалтын хэмжээ 2017 онтой харьцуулахад БНХАУ, Люксембург, Хонконг, Сингапур, ХБНГУ-ын хөрөнгө оруулалт харьцангуй буурсан үзүүлэлттэй байна.

График 2. Нийт гадаадын шууд хөрөнгө оруулалт, тэрбум ам.доллар (2010-2018)



2018 оны гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг салбар тус бүрээр авч үзвэл уул уурхайн салбарт 1.75 тэрбум ам.доллар (70,9%), санхүүгийн болон даатгалын салбарт 272,7 сая ам.доллар (11%), бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт 132,8 сая ам.доллар (5,4%),

үйлчилгээний бусад салбарт 76,6 сая ам.доллар (3,1%), үл хөдлөх хөрөнгийн салбарт 46,2 сая ам.доллар (1,9%), боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 40,87 сая ам.доллар (1,7%), барилгын салбарт 27,6 сая ам.доллар (1,1%) байна.

Хүснэгт 3. Монгол улсад орсон ГШХО-ын орох урсгал, улсаар

Улс	2017					2018 /сая ам.доллар/				
	I	II	III	IV	Нийт	I	II	III	IV	Нийт
Канад	28.9	122.6	228.5	386.2	766.3	396.4	335.9	316.1	476.4	1524.8
Япон	10.9	23.1	23.6	34.2	91.8	29.9	28.7	70.1	107.1	235.8
АНУ	18.0	40.2	25.2	55.4	138.9	17.4	41.3	15.4	55.0	129.2
Люксембург	14.6	60.3	155.4	16.8	247.0	39.3	47.2	21.8	0.0	108.3
БНХАУ	58.6	112.4	1.6	51.2	223.9	35.3	25.5	24.3	22.6	107.7
Хонг конг	24.8	55.4	5.8	15.9	101.9	31.7	12.2	24.5	0.0	68.4
Бельги	0.0	0.0	0.0	24.9	24.9	24.4	0.3	24.4	4.5	53.6

Улс	2017					2018 /сая ам.доллар/				
	I	II	III	IV	Нийт	I	II	III	IV	Нийт
Сингапур	33.6	52.4	0.0	49.0	135.1	0.0	1.2	0.0	44.9	46.1
Их Британи	4.9	4.9	15.3	0.0	25.1	4.2	7.8	14.4	13.4	39.8
Кайманы арлууд	0.9	6.1	1.9	2.1	10.9	17.5	18.4	0.2	0.0	36.1
ОХУ	2.4	12.2	15.6	0.0	30.3	5.3	3.5	5.9	12.4	27.1
БНСУ	3.0	0.5	2.9	3.7	10.2	11.2	2.7	2.0	7.6	23.5
Швейцарь	2.3	0.7	0.6	0.6	4.1	0.4	1.3	14.5	2.4	18.6
Австрали	0.6	3.7	38.9	0.0	43.1	2.9	2.0	4.4	1.9	11.2
Нидерланд		7.1	5.6	55.7	68.3	0.0	0.2	0.0	9.5	9.7
Герман	35.5	28.5	19.1	26.1	109.2	3.4	0.0	0.0	0.0	3.4
Франц	2.5	0.0	1.4	5.1	9.0	0.2	0.0	0.5	0.0	0.7
Турк	0.5	0.1	0.3	0.0	1.0	0.1	0.0	0.0	0.0	0.1
Бусад	12.0	6.0	8.4	18.9	45.4	6.4	534.3	1.7	10.8	25.1
Бүгд	254.0	536.2	549.9	746.1	2086.3	626.1	1062.5	540.3	768.5	2469.2

ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт худалдааны голлох түнш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, Монголын экспортын бараа бүтээгдэхүүний гадаад зах зээлийг өргөтгөх, худалдааг хөнгөвчлөх, чөлөөт худалдаа, эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн салбараас хамааралтай байдлыг бууруулах зорилтын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Монгол экспорт" хөтөлбөрийг боловсруулж 9 дүгээр сарын 5-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар

батлуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө гарган ажиллаж байна. Экспортын бодлого, зохицуулалтын салбар хоорондын уялдааг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах "Экспортыг дэмжих үндэсний зөвлөл" байгуулахаар шийдвэрлэв.

Гадаадын зах зээлд экспортлох боломжтой тэргүүлэх ач холбогдол бүхий бараа бүтээгдэхүүний судалгаа, маркетингийг төрөөс дэмжиж, "Монгол экспорт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх, нэн ялангуяа жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бизнесээ өргөжүүлэн хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд худалдааны голлох түнш орнуудын томоохон хотууд болох Бээжин, Владивосток, Токио зэрэгт Монгол Улсын Худалдааны төлөөлөгчийн газар нээж ажиллуулахаар шийдвэрлэв.

ОЛОН УЛС, БУС НУТГИЙН ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурлаас 10 дугаар сард Женев хотноо зохион байгуулсан “Дэлхийн хөрөнгө оруулалтын чуулга уулзалт”-д оролцож, Дэлхийн худалдааны байгууллага, Олон улсын худалдааны төв, НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурал, Дэлхийн оюуны өмчийн байгууллага, Олон улсын олимпын хороо болон Олон улсын зам тээврийн байгууллагуудын удирдлагуудтай уулзаж хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон явдал эдгээр байгууллагуудтай хөгжүүлж буй хамтын ажиллагааг урагшлуулахад чухал түлхэц үзүүлэв.

Дэлхийн Худалдааны Байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах Үндэсний хороо болон Дэд хороодын гишүүд болон хилийн хяналтын байгууллагуудад зориулсан “Итгэмжлэгдсэн оператор”, “Барааг урьдчилан тодорхойлох”, “Эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалтуудыг Дэлхийн банктай хамтран зохион байгуулав. Түүнчлэн худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах Үндэсний хорооноос “Худалдааг хөнгөвчлөх 2018-2022 Үндэсний хөтөч зураг”, мөн “Үндэсний хорооны стратеги төлөвлөгөө 2018-2022”-ийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Олон улсын худалдааны төвийн Гүйцэтгэх захирал хатагтай Аранча Гонзалез 10 дугаар сард Монгол Улсад айлчилж Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхаж, Гадаад

харилцааны дэд сайд Б.Батцэцэгтэй хэлэлцээ хийж, МҮХАҮТ-ын удирдлага болон хувийн хэвшлийн төлөөлөлтэй уулзаж санал солилцов. Олон улсын худалдааны төвийн дэмжлэгтэйгээр “Монгол Улсын худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураг”-ийг төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагуудын Үндэсний зөвлөлдөх уулзалтын дүнд боловсруулав. Олон улсын жишигт нийцсэн гадаад худалдаа, уул уурхайн бус экспортыг дэмжих худалдааны бодлого боловсруулах ажилд энэхүү замын зураг чухал ач холбогдолтой юм.

Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх “Монгол Улсын худалдааг дэмжих төсөл (Trade related assistance for Mongolia-TRAM)”-ийн хүрээнд Европын Холбооны орнуудад экспортлох боломж бүхий уул уурхайн бус салбарын экспортод төвлөрсөн үндэсний брэндийг бий болгох, зарим бүтээгдэхүүний кластер байгуулж хөгжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Түүнчлэн, төр болон хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих, экспортын боломжийг нэмэгдүүлэх, гадаад худалдааны чадавхийг бэхжүүлэхэд шаардлагатай сургалт, семинарыг төслийн зүгээс тогтмол зохион байгуулж, экспортлогч нарт тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлох, оновчтой шийдлийг олоход дэмжлэг үзүүлж ажиллав.

Евразийн эдийн засгийн холбоотой дэвшүүлсэн бөгөөд 2018 оны байдлаар Чөлөөт худалдааны хэлэлцээр EAЭЗХ-ны нийт 5 гишүүн орнуудаас байгуулах боломжийг судлах хамтарсан БНКазУ, БНКиру, БНБелУ дэмжиж судалгааны ажлыг эхлүүлэх саналыг байгаагаа EAЭК-т албан ёсоор Евразийн эдийн засгийн комисст илэрхийлсэн.

EAЭЗХ-той байгуулсан баримт бичгүүдийн жагсаалт

д/д	Баримт бичгийн нэр	Байгуулсан огноо, газар
1.	Монгол Улсын Засгийн газар болон Евразийн эдийн засгийн холбоо хоорондын хамтын ажиллагааны тухай санамж бичиг	2015.06.17 Москва хот
2.	Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон EAЭК хоорондын ажлын хэсгийн 2017-2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	2017.02.02 Улаанбаатар хот
3.	Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон Евразийн эдийн засгийн комисс хоорондын мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг	2017.10.04 Улаанбаатар хот
4.	Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар болон Евразийн эдийн засгийн комисс хоорондын техникийн зохицуулалт, итгэмжлэлийн салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг	2017.10.04 Улаанбаатар хот
5.	Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам болон EAЭК хоорондын 2017-2018 оны хамтын ажиллагааны төлөвлөгөө	2017.10.04 Улаанбаатар хот
6.	Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар болон Евразийн эдийн засгийн комисс хоорондын техникийн зохицуулалт, итгэмжлэлийн салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг болон Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон Евразийн эдийн засгийн комисс хоорондын мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын салбарт хамтран ажиллах тухай санамж бичгийг хэрэгжүүлэх 2018-2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө	2018.02.21

Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэхэд чиглэсэн үйл ажиллагааг үргэлжлүүлж холбогдох бэлтгэлийг хангасны үндсэн дээр хэлэлцээрт нэгдэн орох хуулийн төслийг импортын барааны Үндэсний хөнгөлөлтийн шинэчилсэн жагсаалт,

хэлэлцээрийн хавсралт болох барааны болон үйлчилгээний худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих хэлэлцээр, гарал үүслийн шалгуурын тухай нэмэлт өөрчлөлтийг шийдвэрлүүлэх бэлтгэлийг хангав.

Зүүн хойд Азийн бүс нутгийн хэмжээнд худалдаа, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх санаачлага болох “Их түмэн санаачилга”-ын гишүүн орнуудын Сайд нарын зөвлөлдөх хорооны уулзалтыг 6 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулав.

Дэлхийн банкны группын Олон улсын санхүүгийн корпорацийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын худалдаа, өрсөлдөх чадварт дэмжлэг үзүүлэх төслийг хэрэгжүүлэх тухай харилцан ойлголцлын санамж бичгийг 3 дугаар сард байгуулав. Энэхүү төслийн хүрээнд гадаад худалдааны нэгдсэн мэдээллийн портал байгуулахаар ажиллаж байна.

5

ГАДААД СУРТАЛЧИЛГАА, СОЁЛЫН ХАРИЛЦАА

Монгол Улсын түүх, соёл, ёс заншил, өв уламжлал, болон эдийн засаг, нийгмийн салбарын ололт амжилт, хөгжил дэвшлийг хилийн чанадад сурталчлах, гадаад орнуудтай соёлын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаад сурталчилгааны үндэсний нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх бодлого, зорилтуудын хэрэгжилтийг

хангах хүрээнд Монгол Улсын гадаад сурталчилгаа, соёлын гадаад бодлогыг тодорхойлох, стратеги төлөвлөгөөг төлөвлөх, үндсэн тулгуур баримт бичгүүдийг боловсруулах, нэгдсэн бодлого зохицуулалтаар хангахын сацуу салбар дундын хамтын ажиллагааг тогтмолжуулах чиглэлд анхаарч ажиллав.

ГАДААД СУРТАЛЧИЛГААНЫ БОДЛОГО, СТРАТЕГИ

“Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, түүнд хяналт тавьж ажиллах үүрэг бүхий Зөвлөлийг Гадаад харилцааны сайд тэргүүлэн ажиллаж байна. Энэхүү Зөвлөлийн бүрэлдэхүүнд БСШУСЯ, БОАЖЯ, УУЯ, СЯ, ЗТЯ, СУГ, МҮХАҮТ зэрэг байгууллагуудын удирдлагууд орсон. Түүнчлэн Зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, харилцан мэдээлэл солилцох үйл явцыг хялбаршуулах, улмаар хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийг дээрх Зөвлөлийн дэргэд байгуулав.

Тус яам гадаад сурталчилгаа, соёлын бодлогын хүрээнд:

- Монгол Улсын язгуур эрх ашгийг хамгаалах, нэр хүндийг өргөх, бэхжүүлэх, дипломат харилцааг өргөжүүлэхэд чиглэсэн зөөлөн хүчний үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах;
- Үндэсний түүх, соёл, урлаг, өв уламжлал, спорт, дэлгэцийн урлагаар дамжуулан Монгол Улсын гадаад бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг нэгдмэл байдлаар зохион байгуулах;

- Гадаад сурталчилгааны бодлого, агуулгыг төлөвлөх, нэгдсэн хэрэгжилтийг зохион байгуулах, хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- Гадаад сурталчилгааг хөгжүүлэх, зохицуулах хууль тогтоомжийн төсөл боловсруулах, олон улсын гэрээ байгуулах чиглэлээр санал боловсруулах үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах;
- Гадаадын улс орнуудын амжилттай хэрэгжүүлж буй зөөлөн хүчний бодлогыг эх орондоо нутагшуулах боломжийг судлах;
- Гадаадын улс орнуудад “Монголын соёлын төв” зэрэг байнгын үйл ажиллагаатай төлөөллийн газруудыг нээх замаар эх орноо сурталчлан таниулах үйл ажиллагааг өргөжүүлэх;
- Гадаадын улс орнуудад хадгалагдаж буй монголын түүх соёл, эд өлгийн зүйлсийг олж тогтоох, хэвлэн нийтлүүлэх, цахим хэлбэрт оруулах, хилийн чанад дахь монгол судлалыг хөгжүүлэх чиглэлд тус тус дэмжлэг үзүүлэх зэрэг асуудлуудыг тэргүүлэх зорилт болгон ажиллаж байна.

2018 оны хувьд тус Яам Монгол Улсын түүх, соёлын өв уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын ололт амжилт, хөгжил дэвшил, гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагааг дэлхий нийтэд сурталчлан таниулах, Монгол Улсыг сурталчилсан үзэсгэлэн, яармаг, кино, соёл, урлагийн тоглолт, өдрүүд, уулзалт, ярилцлага зохион байгуулах зэрэг нийт 86 арга хэмжээ гадаад болон

дотоодод зохион байгуулав.

“Монгол Улсын гадаад сурталчилгаа-Орчин үеийн урлаг” сэдэвт 8 дахь удаагийн хэлэлцүүлгийг 1 дүгээр сард, “Монгол Улсын гадаад сурталчилгаа-Дэлхийгээр тархсан монгол өв” сэдэвт 9 дэх удаагийн цуврал хэлэлцүүлгийг 6 дугаар сард тус тус зохион байгуулж холбогдох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, салбарын уранбүтээлчдийнтөлөөллийг оролцуулж тулгамдсан асуудлуудаар хэлэлцүүлэг өрнүүлж, харилцан мэдээлэл, туршлага солилцож, хэлэлцүүлгүүдийн мөрөөр Зөвлөмж гаргав.

“Соёлын бүтээлч үйлдвэрлэл 2018” хэлэлцүүлэгт “Монгол Улсын гадаад сурталчилгаа-Соёлын бүтээлч үйлдвэрлэл” сэдвээр, “Кино урлаг, хамтын ажиллагаа” хэлэлцүүлэгт “Монгол Улсын гадаад сурталчилгаа-Уран бүтээлчдийг дэмжсэн ажиллагаа” сэдвээр, Монголын эдийн засгийн форумын “Монгол Улсын брэндинг” салбар хуралдаанд “Монгол Улсын гадаад сурталчилгаа-Зөөлөн хүчний бодлого” сэдвээр, “Монгол судлалын өнөөгийн байдал, хэтийн төлөв, асуудал, шийдэл” хэлэлцүүлэгт Монгол судлалын асуудлаар, “Соёлын бодлого, түүний хэрэгжилт” сэдэвт семинарт оролцож, “Монгол Улсын гадаад сурталчилгааны үйл ажиллагаа, гадаад харилцааны нэгдмэл байдал” сэдвээр, “Монгол Улсын аялал жуулчлалын маркетинг” сэдэвт семинарт “Монгол Улсын гадаад сурталчилгаа-Аялал жуулчлал” сэдвээр тус тус танилцуулга хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Монголын түүх, соёл, урлагийг олон улсад сурталчлах, соёлын арга

хэмжээг хилийн чанадад өргөн цар хүрээтэй зохион байгуулах, уран бүтээлчдийг дэмжих, үндэсний брэнд бараа бүтээгдэхүүн, аялал жуулчлалыг сурталчлах зэрэг гадаад сурталчилгааны үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд “Монголын соёлын төв”-үүдийг хилийн чанадад нэмж байгуулах, эдүгээ ажиллаж буй төвүүдийн үйл ажиллагааг сайжруулах зорилт тавьж ажиллаж байна.

2018 онд гадаадын болон Монгол Улсын нэр хүнд бүхий 13 хүнийг Монгол Улсын Соёлын элчээр нэмж томилсноор эдүгээ нийт 43 Соёлын элч монгол судлал, соёлын өв, боловсрол, ардын язгуур урлаг, сонгодог урлаг, спорт зэрэг

чиглэлээр Монгол Улсыг сурталчлах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ хүрээнд “Монгол Улсын Соёлын элч нарын Анхдугаар чуулга уулзалт”-ыг 9 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан бөгөөд түүнд 50 гаруй төлөөлөгчид оролцсоноос Герман, Их Британи, Сингапур, Япон, Өмнөд Солонгос, Нидерланд, ОХУ, Казахстан, Индонез зэрэг улсад суугаа манай Соёлын Элч нар оролцов. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга чуулга уулзалтад оролцсон Соёлын элч нарыг хүлээн авч уулзав.

“Монгол Улсын Соёлын элчийн тухай журам”-ыг шинэчлэн батлав.

ТҮҮХ, СОЁЛЫН ӨВ

Монголын түүх, соёлын өв, дурсгалуудаар хилийн чанадад үзэсгэлэн гаргах, нэгдсэн бодлого, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах үүднээс түүх, соёлын өв, дурсгалуудаар гаргах үзэсгэлэнгийн жагсаалт, сэдэв агуулгыг боловсруулж, бэлтгэл ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий Зөвлөл байгуулж ажиллахаар шийдвэрлэв.

Тус яам БСШУСЯ, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнтэй хамтарч “Монгол: Тал нутгийн эзэнт гүрэн” сэдвээр 5-8 дугаар саруудад БНСУ-ын Үндэсний музейд үзэсгэлэн гаргав. Уг үзэсгэлэнд Монгол нутгаас илэрсэн хуучин чулуун зэвсгийн үеэс эхлэн шинэ чулуун зэвсгийн үеийн чулуун багаж зэвсэг, гоёл чимэглэлийн зүйлс, хүрэл

зэвсгийн үеийн хүрэл эдлэлүүд, төмөр зэвсгийн түрүү үеийн Пазырыкийн булшнаас илэрсэн хувцас хунар, зэр зэвсэг, Хүннүгийн дурсгалаас илэрсэн алт, мөнгөн чимэглэл, хүрэл сав суулга, шавар ваар, тэрэгний үлдэгдэл, Түрэгийн Билгэ хааны тахилын онгоны алтан эдлэлүүд, Монголын эзэнт гүрний үеийн Таван толгойн дурсгалаас илэрсэн ширэн гутал, төмөр сэлэм, хуяг, XVII зууны үеийн Занабазарын байгуулсан Сарьдагийн хийдийн малтлагаас илэрсэн шавар бурхад, XIX-XX зууны эхэн үеийн угсаатны эдлэл, хэрэглэл зэрэг 232 иж бүрдэл бүхий нийт 550 үзмэрийг дэлгэн танилцуулав. Мөн энэ үеэр “Монголын соёлын 7 хоног” арга хэмжээ зохион байгуулж, Монголын түүх, соёлын өвийг солонгосын олон нийтэд танилцуулав.

Цаашид ХБНГУ, БНТУ, ЕХ-ны гишүүн орнуудад “Тал нутгийн эзэнт гүрэн”, “Тал нутгийн эртний соёл: Чингис хаанаас өмнөх ба дараа үеийн тал нутгийн эзэд, эзэнт гүрнүүд” болон бусад төрлийн үзэсгэлэн зохион байгуулах чиглэлээр ажиллаж байна.

ОХУ-ын Эрмитажийн музей дэх монголын түүх, соёлын өв, дурсгалуудаар хоёр талын хамтарсан үзэсгэлэн гаргах, каталог хэвлүүлэх асуудлаар ШУА-тай хамтран ажиллав. Хамтарсан үзэсгэлэнг 2019 онд зохион байгуулах бэлтгэлийг хангаж байгаа

бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд гаргасан каталогийг яамны бэлгийн санд авч олон нийтэд сурталчилж байна.

Монгол орноос гаралтай археологи, палеонтологийн хилийн чанадад буй ховор олдворуудыг эх орондоо эгүүлэн авах чиглэлээр ажиллаж, Солонгос Улсад хууль бусаар гаргасан нь илэрсэн тарбозавр, протоцератопс, гадрозаврид, овирапторозавр, галлилим үлэг гүрвэлийн 11 ширхэг чулуужсан олдворыг манай тал албан ёсоор хүлээн авав.

МОНГОЛ СУДЛАЛ

Монгол Улсын засгийн газар монгол судлаачдыг дэмжих, тэдний залгамж халааг бэлтгэх чиглэлд анхаарч, монгол судлалыг дэлхийд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр Гадаад харилцааны яамны зүгээс Ерөнхий сайдын дэргэдэх Монгол судлалын үндэсний зөвлөл, Олон улсын монгол судлалын холбоотой нягт хамтран ажиллаж байна.

Их Британий Кэмбрижийн их сургуультай хамтарч “Кэмбриж Монгол” монгол судлалын семинарыг 12 дугаар сард зохион байгуулсан бөгөөд БНАСАУ-ын Пёнъяны Гадаад хэлний сургуульд Монгол хэл-соёлын анги нээв. Гадаадын монгол судлаачдыг дэмжих зорилтын хүрээнд монгол судлалаар суралцаж буй гадаадын оюутнуудад зориулж монгол хэл, соёлын сургалтыг 8 дугаар сард “Монгол судлалын үндэсний зөвлөл”-тэй хамтран зохион байгуулав.

Монголын түүхэн хүмүүс, газар нутаг, өв соёлын эд өлгийн нэрийг дотоод, гадаадад олон янзаар галиглаж, дуудаж байгааг цэгцлэх асуудлыг 2016 оноос эхлүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтарч холбогдох журам боловсруулж, нийтэд мөрдүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Зөвлөлийн дэргэд байгуулав. Ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд түүхэн нэр, нэршлийн жагсаалтыг гаргаж, тэдгээрийг НҮБ-ын таван хэлээр зөв галиглаж бичих журмыг боловсруулж олон нийтийн хүртээл болгов.

Тайванийн “Хааны ордон” музейд хадгалагдаж буй монголын түүх, соёлын өв дурсгалуудын талаар манай эрдэмтдийн хийсэн судалгааны дүнгээр 2 боть каталог хэвлэж олон нийтийн хүртээл болгов. Мөн Монгол, Ираны эрдэмтдийн хамтарсан Ил хаадын түүхийг судлах төслийн хоёрдугаар

шатны үйл ажиллагааг үргэлжлүүлж, Элчин сайд О.Дамбийням 4 дүгээр сард, Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг 9 дүгээр сард тус тус Иран Улсад ажиллаж, цаашид хамтран хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцов.

Гадаад харилцааны сайдын санаачлагаар түүхийн суурь мэдлэгтэй, олон улсын харилцааны чиглэлээр

суралцах сонирхолтой залуусыг дэмжих зорилгоор “Түүхийн Улсын Олимпиад”-ыг анх 2016 онд зохион байгуулсан бөгөөд 2018 онд “Түүхийн улсын хоёрдугаар олимпиад”-ыг зохион байгуулж тэргүүн байр эзлэсэн нэг сурагчийг МУИС-ийн Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургуульд Гадаад харилцааны яамны нэрээр суралцуулахаар шийдвэрлэв.

ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

2018 онд гадаадын 40 орчим баримтат киноны зураг авалтын багийг хүлээн авч, Монгол орон, монголчуудын ахуй амьдрал, зан заншил, байгаль экологийн талаар танин мэдэхүйн баримтат кино хийхэд нь дэмжлэг үзүүлсэн бөгөөд тэдгээрийн дотор дэлхийн томоохон хэвлэл, мэдээллийн агентлагууд болох Британий BBC агентлаг, АНУ-ын Discovery channel, Францын “Аугаа ертөнц” баримтат уран сайхны киноны баг, Японы NHK телевиз, Туркийн TRT зэргийн сурвалжлагчид, уран бүтээлчид Монгол Улсад зочилж манай орны түүх, соёл, зан заншлын талаар нэвтрүүлэг хийв. Энэ дашрамд тэмдэглэхэд “Монгол Улсад ажиллах гадаадын сэтгүүлчдийн журам”-ыг шинэчилж мөрдөж эхэлсэн бөгөөд энэ нь манай улсын зүгээс гадаадын хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллахад илүү таатай нөхцлийг бүрдүүлсэн болно.

2019 онд тохиох Халх голын дайны ялалтын түүхт 80 жилийн ойг тохиолдуулан Монгол-Японы хамтарсан “Дайчи” уран сайхны кино

бүтээхээр ажиллаж буй Монголын “Жюнь продакшн” кино баг, Монгол Улсад хүмүүжиж байсан БНАСАУ-ын 200 хүүхдүүдийн тухай “Мөнхийн цэцэг” кино бүтээх “Монгол фильм” кино баг, Монгол, Японы харилцааны сэдэвтэй “Наран улс Монголд” баримтат кино бүтээх “Нүүдэлчний домог” телестудийн баг, Германы сонгодог зураач Ф.Калмыкийн тухай баримтат цуврал нэвтрүүлэг бүтээх “Хүрээлэн” төслийн багтай тус тус хамтран ажиллаж байна.

Монгол Улсад байнга оршин сууж байгаа гадаадын сурвалжлагчдийн “Press club”-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа бөгөөд 2018 онд гадаадын нийт 300 гаруй сэтгүүлчдийг хүлээн авч үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлсэн.

МҮОНТВ-тэй хамтран “MNB World” сувгийн англи хэл дээрх нэвтрүүлгийг 12 дугаар сараас эхлүүлэв. Гадаад бодлого, харилцааны чиглэлээр мэдээ, мэдээлэл бэлтгэдэг дотоодын 20 байгууллагын редактор, сэтгүүлч, сурвалжлагч нарт Монгол Улсын гадаад бодлого, үйл ажиллагааны

талаар тогтмол танилцуулж, сургалт зохион байгуулснаас гадна манай 80 гаруй сэтгүүлчдийг БНХАУ, Энэтхэг,

БНСУ, Кувейт, Туркменистан зэрэг орнуудад богино хэмжээний сургалтад хамруулсан болно.

СУРТАЛЧИЛГАА БА ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ МОНГОЛ ИРГЭД

Монгол Улсын Засгийн газрын “Дэлхийн Монголчууд” хөтөлбөрийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг манай ДТГ-ууд болон хилийн чанад дахь Монголчуудын холбоодтой хамтран хэрэгжүүлэв.

Хилийн чанад дахь монгол хүн бүрийн санал, санаачилгыг сонсох, тэдэнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор 25 улсад үйл ажиллагаа явуулж буй Монголчуудын нийт 104 холбоо, нийгэмлэг, төрийн бус байгууллагуудыг нэгтгэсэн “Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл” ТББ-тай хамтран “Хилийн чанад дахь Монголчуудын холбоо, ТББ-уудын III чуулга уулзалт”-ыг Ерөнхий сайдын ивээл доор 9 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулав.

Чуулга уулзалтад төр, засгийн байгууллага болон дэлхийн 40 улсад үйл ажиллагаа явуулж буй 100 гаруй монголчуудын холбоод, ТББ-уудын төлөөлөл болон Монгол Улсын Соёлын элч нар нийт 160 гаруй төлөөлөгчид оролцож, хилийн чанад дахь монгол иргэдийн эрх ашиг, нийгмийн асуудал, гадаадад суралцаж буй болон төгссөн монгол оюутнуудын хөдөлмөр эрхлэлт, хилийн чанад дахь монгол хэл, соёлын төвүүдийн үйл ажиллагаа зэрэг асуудлуудаар санал солилцож, “Эх орондоо хөдөлмөр эрхэлцгээе” үзэсгэлэн, яармаг зохион байгуулав.

Хилийн чанадад ажиллаж, суралцаж буй иргэдийнхээ эх орондоо оруулах хувь нэмрийг нь дэмжихэд чиглэсэн “Монгол орны хөгжилд” 14 дүгээр чуулга уулзалтыг “Боловсрол-Мэдлэг солилцоо” сэдвээр 4 дүгээр сарын 26-29-нд Берлин хотноо, “Хилийн чанад дахь монгол оюутан залуучуудын чуулга уулзалт – Москва 2018” арга хэмжээг 5 дугаар сарын 7-8-нд Москва хотноо, “Ази, Номхон далайн бүсийн монгол оюутан залуучуудын чуулга уулзалт”-ыг 5 дугаар сарын 25-28-нд Токио хотноо тус тус зохион байгуулав. Эдгээр арга хэмжээний хүрээнд гадаадад ажиллаж амьдарч буй иргэдэд тулгарч буй асуудлууд, шийдвэрлэх арга замуудын талаар мөн санал солилцож, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх ажлыг сайжруулах асуудлыг хэлэлцэв.

“Гадаадад төгсөгчдийн анхдугаар чуулга уулзалт”-ыг 6 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулж түүний хүрээнд “Ажлын байрны өдөрлөг” зохион байгуулж, худалдаа, эдийн засаг, хүний нөөц, маркетинг, брендинг, мэдээллийн технологийн чиглэлээр 90 орчим нээлттэй ажлын байр зарласан бөгөөд цаашид ажлын байрыг нэмэгдүүлэх, чухал шаардлагатай мэргэжлийн талаарх мэдээллийг иргэдэд хүргэх, ирээдүйн мэргэжлээ зөв сонгоход нь залуучуудад туслах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байхаар төлөвлөж байна.

Хилийн чанад дахь монгол иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн эх орондоо оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, эргэн ирж суурьшихад нь дэмжлэг үзүүлэх үүднээс “Хилийн чанадад амьдарч, суралцаж буй монгол иргэдийг дэмжих лобби бүлэг”-ийг 11 дүгээр сард УИХ-ын дэргэд байгуулав. Энэхүү лобби бүлэг нь орон тооны бус зөвлөлийг дэргэдээ байгуулсан бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд хилийн чанад дахь Монголчуудын холбоод, Гадаад улсад төгсөгчдийн нэгдсэн холбоо болон эрдэмтэн, судлаачдын төлөөлөл орсон болно.

Нийслэлийн Засаг даргын тамгын газрын санаачилгаар Хилийн чанад дахь монгол туургатнуудтай харилцаа,

хамтын ажиллагааг хөгжүүлэх, хэл, соёл, өв уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол туургатны “Мөнх тэнгэр” соёл, урлагийн их наадмыг Улаанбаатар хотноо 7 дугаар сарын 6–8-нд зохион байгуулав. Энэхүү арга хэмжээний үеэр монгол туургатны соёл, урлагийн талаарх эрдэм шинжилгээний хурал, соёлын бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, уран бүтээгчдийн нэгдсэн тоглолт, монгол их хаадын монгол уран бичвэр, зургийн үзэсгэлэн зэрэг арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд энэхүү арга хэмжээнд БНХАУ-ын ӨМӨЗО, Шиньжан Уйгурын Өөртөө засах орон, Хөх нуур муж, ОХУ-ын Буриад, Тува, Халимаг, Алтай, Саха улсаас нийт 200 гаруй төлөөлөгчид оролцов.

6

ЭРХ ЗҮЙ БА КОНСУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр, дипломатын аргаар хангах, түүнчлэн Монгол Улс олон улсын эрх зүйг хүндэтгэн сахиж, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх ажлын хүрээнд манай улс 2018 онд олон талт 6 гэрээнд нэгдэн орж (Хавсралт 1), Засгийн газар хоорондын 22 гэрээ байгуулж, өмнө нь байгуулсан 9 гэрээг хүчин төгөлдөр болгож (Хавсралт 2), байгууллага хоорондын 65 гэрээ байгуулж, бүртгэв. (Хавсралт 3)

Олон талт гэрээнд нэгдэн орох чиглэлээр: НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн олон улсын гэрээг 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдөр, Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-ийг 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдөр, Олон улсын маргааныг энхийн замаар шийдвэрлэх тухай 1907 оны конвенцийг 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн УИХ-ын чуулганаар тус

тус соёрхон батлав.

Хоёр талт гэрээний хүрээнд: Монгол, Оросын стратегийн түншлэлийн харилцааг бэхжүүлэх, хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх эрх зүйн үндсийг бэхжүүлэх зорилтын хүрээнд “Төмөр замаар ачаа дамжуулан тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т талууд гарын үсэг зурж, улмаар 2018 оны 9 дүгээр сарын 7-ны өдрөөс уг хэлэлцээр хүчин төгөлдөр болов.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 4 дүгээр сарын 8-12-нд БНХАУ-д айлчлах үеэр Монгол, Хятадын Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, улс төр, эдийн засаг, худалдаа, хүмүүнлэг зэрэг салбарын харилцан ашигтай хамтын ажиллагааг урагшлуулах хүрээнд Засгийн газар, байгууллага хоорондын нийт 13 баримт бичигт үсэг зурсан нь хоёр улсын эдийн засаг, нийгэм, соёл, аж ахуйн нэгж хоорондын харилцаа

хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулав.

Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хооронд 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай хэлэлцээр”-ийг талууд батламжилснаар 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдрөөс энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болов.

Хилийн чанадад зорчиж буй монгол иргэдийн эрх ашигийг хамгаалах, гадаад улсад амьдарч, ажиллаж буй иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, зорчих нөхцлийг сайжруулах чиглэлд хэд хэдэн чухал хэлэлцээр байгуулав. Үүнд: Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдөр, Эрүүгийн, иргэний болон аж ахуйн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээг 2018 оны 6 дугаар сарын 4-ний өдөр тус тус байгуулсан бөгөөд мөн “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улс хоорондын хэлэлцээр”-т талууд Варшав хотноо 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр гарын үсэг зурж, уг хэлэлцээрийг УИХ 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр соёрхон батлав. Түүнчлэн иргэд зорчих нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр Армян, Уругвай, Чили, Эквадор, Азербайжан, Швейцар зэрэг улстай Засгийн газар хоорондын гэрээ байгуулав.

Хилийн боомтын чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын Үйлажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, экспортын бараа бүтээгдэхүүнийг өсөлтийг хангах, зорчигч, тээврийн хэрэгслийг улсын хилээр саадгүй түргэн, шуурхай нэвтрүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх асуудлаар БНХАУ-тай яриа хэлэлцээ явуулж Монгол, Хятадын хилийн Хавирга-Архашаат, Баянхошуу-Өвдөг, Сүмбэр-Рашаан, Бургастай-Лаомяо боомтуудыг хуваарийн бус үеэр нээн ажиллуулж манай улсын экспортыг нэмэгдүүлэх, хил дамнасан тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг сайжруулав. Зөвхөн Монгол, Хятадын хилийн Бургастай боомтыг дулааны улиралд хуваарийн бус үеэр нээн ажиллуулснаар 2018 оны 10 дугаар сарын байдлаар “Алтайн хүдэр” ХХК нь 2.1 сая тонн төмрийн хүдэр экспортолж улсын төсөвт 1.9 тэрбум төгрөг, “АМНАТ” ХХК 7.2 тэрбум төгрөг нийт 9.3 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.

Монгол Улс, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын 2014 онд тохиролцсоны дагуу улсын хилийн нэр бүхий зарим боомтод төмөр замын боомт байгуулах, улмаар хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан “Хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай 2004 оны хэлэлцээр”-т тухайн асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулах боломжийг бүрдүүлэв. Өөрөөр хэлбэл, Монгол, Хятадын хилийн Шивээхүрэн-Сэхэ, Гашуунсухайт-Ганцмод, Бичигт-Зүүнхатавч боомтод төмөр замын боомтын төрөл нэмж байгаа нь манай улсыг эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, ойрын ирээдүйд эдгээр боомтоор дамжин далайд гарах шинэ боломжийг нээсэн бодит алхам болов.

Хүний эрхийн чиглэлээр: Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн дунд хугацааны тайланг хэлэлцэх Засгийн газар, төрийн бус байгууллагын зөвлөлдөх уулзалт, орон нутагт зохион байгуулсан хэлэлцүүлэгт тус яам идэвхтэй оролцож, ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ГХЯ-тай холбоотой заалтуудын хэрэгжилтийг гаргаж, Гадаад харилцааны сайдын тушаалаар Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан Дэд зөвлөлийг байгуулж, ажлын төлөвлөгөө гаргаж батлуулав. Дэд зөвлөлийн хурлыг 6, 11 дүгээр саруудад хуралдуулснаар Эмэгтэйчүүд, аюулгүй байдлын асуудлаарх НҮБ-ын АЗ-ын 1325 тогтоолыг хэрэгжүүлэх, мөн НҮБ-ын Бизнес, хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх ҮҮАТ боловсруулах, хүн худалдаалах гэмт хэргийн шинэ хэлбэртэй тэмцэх чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх зэрэг зөвлөмжийг хэрэгжүүлэхэд тодорхой ахиц гарав.

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх үндэсний 8, 9 дүгээр нэгтгэсэн тайлан, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх үндэсний хоёрдугаар тайлан, Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенцын хэрэгжилтийн анхдугаар тайлан, мөн Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтийн

тухай үндэсний 23-24 дүгээр тайланг боловсруулах, орчуулгыг хянах ажилд оролцож, НҮБ-ын гэрээний хороонд хүргүүлэв.

Монгол Улс, Европын Холбооны Хүний эрхийн асуудлаарх хоёр дахь удаагийн хэлэлцээг 4 дүгээр сарын 20-нд Брюссель хотноо зохион байгуулж, хүний эрхийг хамгаалах, хангах, ялангуяа, хүүхдийн эрхийг хамгаалах, сэтгүүлчдийг хүний эрхийн сэдвээр давтан сургах, бизнес хүний эрхийн чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон.

НҮБ-ын Цэвэр ундны ус, цэвэрлэх байгууламжаар хангагдах эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч Лео Хэллер 4 дүгээр сарын 9-20-нд Монгол Улсад айлчилж ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмж хот, хөдөө, орон сууц, гэр хорооллын иргэдийн хувьд тэгш бус, ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжаар хангагдах нь хүний эрхийн асуудал болох талаар мэдлэг ойлголт хангалтгүй, эрх зүйн орчин бүрдээгүй гэсэн дүгнэлт хийснийг холбогдох байгууллагуудад уламжилж уг нөхцөл байдлыг засах талаар бусад улс болон НҮБ-тай хамтран ажиллах үйл ажиллагааг эхлүүлэв.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал эрхэлсэн Шведийн ТҮГЭС н.Пер-Андерс Сунэссон Монгол Улсын Гадаад харилцааны сайдын урилгаар 5 дугаар сарын 28-наас 6 дугаар сарын 1-нд Монгол Улсад айлчилж иргэд консулын чиглэлээр хамтран ажиллах, байнгын зөвлөлдөх механизм байгуулах боломжийг судлах, хохирогч илрүүлэх, хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хил хамгаалах чиглэлээр

хамтран ажиллах боломжийг хэлэлцэж, хоёр улсын цагдаагийн байгууллагууд шууд хамтран ажиллах эрх зүйн үндсийг тодорхойлох, цагдаагийн байгууллагын боловсон хүчин сургах, чадавхжуулах, биеэ үнэлэхтэй тэмцэх тухай Шведийн хуулийн загварыг судалж үзэх зэрэг асуудлыг хөндөж санал солилцов. Биеэ үнэлэхтэй тэмцэх Шведийн бодлого, холбогдох хуулийн талаарх мэдээллийг УИХ-ын Хүний эрхийн Дэд хороо болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд хүргүүлэв.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр ажиллаж Ази Номхон далайн

бүсийн байгууллага (APG)-аас Монгол Улсад өгсөн зөвлөмжийн дагуу НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн Үй олноор хөнөөх зэвсгийн хоригтой холбоотой манай улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар Австралийн Засгийн газраас 150.000 ам.долларын дэмжлэг, мөн АХБ-аас 1 жилийн хугацаатай манай улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг боловсронгуй болгох талаар 150.000 ам.долларын дэмжлэг авахаар тохиров. Мөн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон үй олноор хөнөөх зэвсэгтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгоход хандивлагчдыг зохицуулах бүлэгт хамруулж ажиллав.

**МОНГОЛ УЛС 2018 ОНД НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН
ОЛОН ТАЛТ ГЭРЭЭНИЙ ЖАГСААЛТ**

№	Олон талт гэрээний нэр	УИХ-аар соёрхон баталсан огноо
1.	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн олон улсын гэрээг	2018 оны 05 сарын 10-ны өдөр
2.	“Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”	2018 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр
3.	“Олон улсын хөрөнгө оруулалтын банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээр болон дүрэмд өөрчлөлт оруулах тухай 2014 оны протокол”	2017 оны 12 дугаар сарын 7 өдөр
4.	Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банк үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааны тухай 1963 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хэлэлцээр болон Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банкны дүрэм (1970 оны 12 дугаар сарын 18, 1977 оны 11 дүгээр сарын 23 болон 1990 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн протоколын дагуу нэмэлт, өөрчлөлт оруулснаар)-д өөрчлөлт оруулах тухай 2014 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн протокол	2017 оны 12 дугаар сарын 7 өдөр
5.	Швейцарын Холбооны Улсын Женев хотод 1979 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”	2018 оны 10 сарын 12 өдөр
6.	Олон улсын маргааныг энхийн замаар шийдвэрлэх тухай 1907 оны конвенц	2018 оны 10 сарын 11 өдөр

**МОНГОЛ УЛС 2018 ОНД БАЙГУУЛСАН БОЛОН ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛСОН
ХОЁР ТАЛТ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ЖАГСААЛТ**

1. Шинээр байгуулсан гэрээ			
№	Хоёр талт гэрээний нэр	Байгуулсан огноо	Баталсан, соёрхон баталсан огноо
1	Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангаас 2017-2019 онд авах зээлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээр	2018.01.16	2018.04.19
2	“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улс хоорондын хэлэлцээр”	2018.01.24	2018.10.26 соёрхон баталсан.
3	“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улс хоорондын хэлэлцээр”	2018.03.05	2018.11.05 Соёрхон баталсан.
4	Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр	2018.03.26	
5	Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын гэрээ	2018.03.29	
6	Дипломат, албан болон энгийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улс, Дорнын Бүгд Найрамдах Уругвай Улс хоорондын хэлэлцээрт	2018.04.02	2018.06.10
7	Дипломат болон албан/сервис паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Швейцарын Холбооны Улсын Засгийн газар хооронд хэлэлцээрт	2018.04.05	2018.06.16
8	Хууль бусаар оршин суугаа иргэдийг буцаан шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Швейцарын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон Хууль бусаар оршин суугаа иргэдийг буцаан шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Швейцарын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Швейцарын Холбооны Улсын Засгийн газар хоорондын протокол	2018.04.05	Баталсан
9	Үйлдвэрлэлийн чадавхи, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг бэхжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээр	2018.04.09	Баталсан

10	Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр	2018.04.09	-
11	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг	2018.04.09	-
12	Иргэний болон аж ахуйн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ	2018.06.04	-
13	Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ	2018.06.04	-
14	Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ	2018.06.04	-
15	“Төмөр замаар ачаа дамжуулан тээвэрлэх нөхцлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”	2018.06.08	2018.06.27
16	Энгийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Чили Улсын Засгийн газар хооронд солилцсон ноот бичиг	2018.09.27	2018.10.24
17	Бүх төрлийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Эквадор Улсын Засгийн газар хооронд солилцсон ноот бичиг	2018.09.24	
18	Дипломат болон албан/сервис паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Азербайжан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	2018.09.27	2018.10.24
19	Дипломат болон албан паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Армян Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	2018.09.28	2018.10.24
20	“Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын гэрээ”	2018.10.16	Соёрхон батална
21	“Хоёр талт гэрээний үйлчлэлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Румын Улсын Засгийн газар хоорондын протокол”	2018.11.28	Засгийн газар батална
22	“Авто замаар олон улсын зорчигч болон ачаа тээвэрлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Унгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”	2018.11.21	Засгийн газар батална

2. Өмнө байгуулсан гэрээг хүчин төгөлдөр болгосон байдал			
№	Хоёр талт гэрээний нэр	Байгуулсан огноо	Баталсан огноо
1	Дипломат болон албан паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Мальта Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт	2016.07.14	2018.02.08
2	“Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Мальта Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”	2016.07.14	2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн Засгийн газрын 84 дүгээр тогтоол
3	Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын Эрчим хүчний үр ашиг хөтөлбөрийн Санхүүгийн хамтын ажиллагааны тухай 2016-2017 оны хэлэлцээр болон Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хот дахь Сэргээн босголтын зээлийн банк хоорондын Нэмэлт зээлийн болон төслийн 2 дахь гэрээ	2017.06.27	2018 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр соёрхон баталсан.
4	Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хоорондын “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.	2017 оны 12 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан	2018 оны 2 дугаар сарын 02-ны өдөр соёрхон баталсан.
5	“Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”	2017 оны 5 дугаар сарын 25-ны өдөр	2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн Засгийн газрын 85 дугаар тогтоол
6	“Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”	2017 оны 6 дугаар сарын 1-ний өдөр	2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн Засгийн газрын 83 дугаар тогтоол
7	Дипломат, албан болон энгийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Аргентин Улс хоорондын хэлэлцээр	2017.08.31	2018.02.19
8	“Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”	2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр	2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын 151 дүгээр тогтоол
9	Дипломат болон албан паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Литва Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	2017.09.18	2018.04.29

**МОНГОЛ УЛС 2018 ОНД БАЙГУУЛСАН, САНАЛ ӨГСӨН, БҮРТГЭСЭН
БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН ГЭРЭЭНИЙ ЖАГСААЛТ**

№	Байгууллага хоорондын гэрээний нэр	Байгуулсан огноо	Бүртэгсэн огноо
Бүртгэсэн гэрээ			
1	“Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны дагуу ажилтан илгээх болон хүлээн авах тухай Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.01.16	2018.01.25
2	“Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хоорондын санамж бичиг”	2018.01.16	2018.01.25
3	“Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Их Хурал болон Бүгд Найрамдах Социалист тнам Улсын Үндэсний Ассамблей хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.01.22	2018.01.31
4	“Монгол Улсын Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, БНСВУ-ын Хоа Бинв мужийн ардын зөвлөлийн хооронд хамтын ажиллагааны харилцаа тогтоох тухай санамж бичиг”	2018.01.22	2018.01.31
5	“Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар болон Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Онцгой байдал, гамшгийн удирдлагын улсын хороо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.02.05	2018.02.13
6	“Монгол Улсын Далайн захиргаа болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Далайн хэргий газар хоорондын далайн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.01.29	2018.03.09
7	“Монгол Улсад цөмийн шинжлэх ухаан, технологийн төв байгуулахад хамтран ажиллах тухай Монгол Улсын Цөмийн энергийн комисс, ОХУ-ын цөмийн энергийн “Росатом” улсын корпораци хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.02.28	2018.03.09
8	“Монгол Улсын Түүх археологийн хүрээлэн, Үндэсний музей, Богд хааны ордон музей Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний музей хоорондын гэрээ”	2018.03.13	2018.03.14
9	“Монгол Улсын Гадаад харилцааны яам болон Олон улсын санхүүгийн корпораци хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.03.13	2018.03.14

10	“Өрсөлдөөний бодлогын салбарт Хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар болон БНКаЗУ-ын Үндэсний эдийн засгийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.03.29	2018-04-09
11	Иргэний агаарын тээврийн хөлөг онгоцны ослын урьдчилан сэргийлэлт, шалгалтын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам, Бүгд Найрамдах Казахстан Улсын Хөрөнгө оруулалт, хөгжлийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.03.29	2018.04.09
12	“Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын Аялал жуулчлалын газар болон Оросын Холбооны Улсын Эрхүү мужийн Аялал жуулчлалын агентлаг хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.03.28	2018.04.18
13	Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Азербайжан Улсын Гадаад хэргийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг	2018.03.12	2018.04.18
14	“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Турк Улс хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тохиролцоо”	2018.03.07	2018.10.24
15	“Хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Бүгд Найрамдах Турк Улсын Хүнс, хөдөө аж ахуй, мал аж ахуйн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.04.06	2018.04.06
16	“Тээвэр, харилцааны технологийн салбарт хамтарсан судалгаа, хөгжүүлэлт хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам, Бүгд Найрамдах Турк Улсын Тээвэр, далайн асуудал, харилцаа холбооны яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.04.06	2018.04.06
17	“Онцгой байдлын удирдлагын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, Бүгд Найрамдах Турк Улсын Гамшиг, онцгой байдлын удирдлагын газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.04.06	2018.04.06
18	“Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Хууль зүй дотоод хэргийн яамны харьяа Гадаадын иргэн харьяатын газар, Бүгд Найрамдах Турк Улсын Дотоод хэргийн яамны харьяа Шилжилт хөдөлгөөний ерөнхий газар хоорондын хамтарсан мэдэгдэл”	2018.04.06	2018.04.06
19	“Монголын Улсын Удирдлагын академи, Бүгд Найрамдах Турк Улсын Хилийн чанад дахь турк иргэд, ах дүү нийгэмлэг хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.04.06	2018.04.06

20	“Монгол Улсын Үндэсний номын сан, Бүгд Найрамдах Турк Улсын Үндэсний номын сан хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.04.06	2018.04.06
21	“Монгол Улсын Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Бүгд Найрамдах Турк Улсын Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, дэмжих удирдах газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.04.06	2018.04.06
22	Хятадын талаас олгосон хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлэх “Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл” төслийн тухай Монгол Улсын Сангийн яам, Хятадын экспорт-импорт банк хоорондын тусгайлсан зээлийн хэлэлцээр	2018.04.09	2018.04.19
23	“Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих” төслийг урагшлуулах тухай Монгол Улсын Сангийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Худалдааны яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.04.09	2018.04.19
24	“Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Боловсролын яам хооронд 2018-2021 онд хэрэгжүүлэх боловсролын солилцоо, хамтын ажиллагааны төлөвлөгөө”	2018.04.09	2018.04.19
25	“Спортын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Спортын ерөнхий газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.04.09	2018.04.19
26	“Монгол Улсын Гаалийн ерөнхий газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газар хооронд хууль бусаар хил давуулан худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.04.09	2018.04.19
27	“Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, БНХАУ-ын Зах зээлийн хяналтын удирдах хороо хооронд бичил, жижиг, дунд үйлдвэрийн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.04.09	2018.04.19
28	“Монгол Улсын Үндэсний мэдээллийн Монцамэ агентлаг болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Синьхуа агентлаг хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр”	2018.04.09	2018.04.19
29	Монгол Улсад Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж барих, технологийн шинэчлэл хийх төслийн Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон БНХАУ-ын Машин механизм, аж үйлдвэрийн корпорац (Sinoconst) хоорондын арилжааны гэрээ	2018.04.09	2018.04.19

30	Монгол, Хятадын хилийн дагуух эдийн засгийн хамтын ажиллагааны зэргэлдээ бүсүүдийн бүтээн байгуулалтын хоёр талын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах хэлэлцээний явцыг түргэтгэх тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Худалдааны яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг	2018.04.09	2018.04.19
31	“Барилга хот байгуулалтын яам, Байгаль орчин аялал жуулчлалын яам, Эрчит хүчний зохицуулах хороо болон Олон улсын санхүүгийн корпораци хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.04.13	2018.04.20
32	Радио давтамжийн 890-915/935-960 МГц зурвасыг хил орчмын бус нутгийн хөдөлгөөнт өргөн зурвасын үйлчилгээнд ашиглах тухай гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах протокол	2018.04	2018.05.02
33	Радио давтамжийн 1710-1785/1805-1880 МГц зурвасыг хил орчмын бус нутгийн хөдөлгөөнт өргөн зурвасын үйлчилгээнд ашиглах тухай гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах протокол	2018.04	2018.05.02
34	Радио давтамжийн 2500-2690 МГц зурвасыг хил орчмын бус нутгийн хөдөлгөөнт өргөн зурвасын үйлчилгээнд ашиглах тухай гэрээ	2018.04	2018.05.02
35	Радио давтамжийн 2300-2400 МГц зурвасыг хил орчмын бус нутгийн хөдөлгөөнт өргөн зурвасын үйлчилгээнд ашиглах тухай гэрээ	2018.04	2018.05.02
36	“Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам, Дорнын Бүгд Найрамдах Уругвай Улсын Гадаад хэргийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.04.02	2018.04.02
37	Сансрын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газрын агентлаг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Сансар судлалын үндэсний төв хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг	2018.05.18	2018.05.23
38	Үндэсний хөгжлийн газар болон Олон улсын санхүүгийн корпораци хоорондын хамтын ажиллагааны гэрээ	2018.05.22	2018.05.28
39	“Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар, Бүгд Найрамдах Чех Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар хоорондын санамж бичиг”	2018.05.22	2018.05.30
40	“Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Хууль зүйн үндэсний хүрээлэн, Бүгд Найрамдах Турк Улсын Хууль зүйн академи хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.05.14	2018.05.25

41	“Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжин хотын Ардын Засгийн газар хооронд хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх тухай харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.05.14	2018.06.12
42	Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Санхүүгийн хяналт, шалгалтын байгууллага хоорондын “Хяналт, шалгалтын сургалтын хөтөлбөрийн тухай хэлэлцээр	2018.05.22	2018.08.01
43	“Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Фридрих-Эбертийн сан хоорондын хамтын ажиллагааны протокол”	2018.06.05	2018.06.10
44	Хоёр талт зөвлөлдөх уулзалтын механизм байгуулах тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам, Балба Улсын Гадаад хэргийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.06.12	2018.06.12
45	“Монгол Улсын Хууль сахиулахын их сургууль болон ОХУ-ын Дотоод явдлын яамны Воронежийн дээд сургууль хооронд боловсрол, шинжлэх ухааны үйл ажиллагааны салбарт хамтран ажиллах тухай протокол”	2018.06.12	2018.06.12
46	“Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон Оросын Холбооны Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх холбооны алба хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.07.28	2018.07.28
47	“Монгол Улсын Гадаадын иргэн, харьятын газрын “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал дахь газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагаачлал, шилжилт хөдөлгөөний албаны “Гимхэ” олон улсын нисэх онгоцны буудал дахь газар хооронд хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.07.30	2018.07.30
48	“Бүс нутгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Шилийн гол аймаг, Тунгляо, Улаанхад хот хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.07.30	2018.07.30
49	Эрүүл мэндийн салбарыг хамтран хөгжүүлэх тухай Монгол Улсын Увс аймаг, БНСУ-ын Дэжон хот хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг	2018.08.01	2018.08.15
50	Монгол Улсын Далайн захиргаа, Бүгд Найрамдах Солонгос Вьетнам Улсын Далайн захиргаа хооронд далайн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг	2018.08.08	2018.08.24

51	“Монгол, Хятадын хилд шинээр байгуулах “Цагаандэл уул-Өлзий” боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалтын асуудлыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Боомтын алба хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг	2018.08.31	2018.08.31
52	“Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридорыг хамтран урагшлуулах механизм байгуулах тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам, ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яам, БНХАУ-ын Хөгжил, шинэчлэлийн хороо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.09.10	2018.09.30
53	“Өрсөлдөөний хуулийн хэрэгжилтийн салбарын түншлэлийн тухай Монгол Улсын Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Гүрж Улсын Өрсөлдөөний байгууллага хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг”	2018.09.07	2018.09.25
54	“Вакцинжуулалт хийгдсэн, шүлхийгүй бүсэд тавигдах шаардлагын тухай Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.09.18	2018.10.01
55	“Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн яам хоорондын санамж бичиг”	2018.09.05	2018.09.18
56	“Хэмжил зүйн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газар болон БНХАУ-ын Зах зээлийн зохицуулалтын газар хооронды харилцан ойлголцлын санамж бичиг	2018.09.17	2018.09.30
57	“Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт 2018-2020 онд хамтран ажиллах тухай Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Унгар Улсын Хүний хүчин зүйлийн яам хоорондын хөтөлбөр”	2018.09.17	2018.09.17
58	Мөрөөдлийн ой байгуулах тухай Монгол Улсын Улаанбаатар хот, БНСУ-ын Инчон хот хоорондын гэрээ	2018.09.18	2018.09.30
59	“Олон улсын оюутны үнэлгээнд (PISA) оролцох тухай Монгол Улсын БСШУСЯ болон Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага хоорондын хэлэлцээр”	2018.09.07	2018.11.30
60	“Бодлогын зөвлөлдөх уулзалтын тухай Монгол Улсын Гадаад харилцаан яам, Бүгд Найрамдах Филиппин Улсын Гадаад хэргийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”	2018.10.01	2018.10.21
61	“Статистикийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Үндэсний статистикийн хороо болон Унгар Улсын Статистикийн төв газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг	2018.10.21	2018.11.04

62	Монгол-Тяньжины Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны монголын талын ажлын хэсэг, тяньжины талын ажлын хэсэг, Монгол Төмөр зам ТӨХК, Тяньжин порт групп хоорондын Монгол-Тяньжины Дунзян тээвэр, логистикийн төв төслийн хамтын ажиллагааны тухай ерөнхий хэлэлцээр	2018.10.23	2018.11.15
63	Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон ОХУ-ын Ял шийтгэл гүйцэтгэх холбооны алба хоорондын хамтын ажиллагааны хөтөлбөр 2018-2020 он	2018.10.11	2018.10.30
64	“Боловсрол, шинжлэх ухааны салбарт Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон ОХУ-ын Шинжлэх ухаан, дээд боловсролын яам хооронд 2018-2020 онд хамтран ажиллах хөтөлбөр”	2018.11.20	2018.12.01
65	Биеийн тамир, спортын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, ОХУ-ын Спортын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг	2018.11.20	2018.12.01
Төслийг нь хянаж, санал хүргүүлсэн гэрээ:			
1	“Харилцаа, хамтын ажиллагаа тогтоох тухай аХарМонгол Улсын Их Хурал, Бүгд Найрамдах Социалист Шри Ланк Улсын Парламент хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
2	“Виз олгох нөхцөлийг хөнгөвчлөх тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Хууль зүйн яам хооронд 2018 онд хамтран ажиллах төлөвлөгөө”		
3	“Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, Энэтхэг Улсын Төрийн албаны холбооны комисс хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
4	“Тусгай хэрэгцээт боловсролыг дэмжих төв байгуулах, үйл ажиллагааг нь дэмжих тухай Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Грин Тичерс ТББ хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
5	“Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Баян-Өлгий аймаг, Бүгд Найрамдах Казахстан Улсын Өскемен хот хоорондын баримт бичиг”		
6	“Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Увс аймаг, Бүгд Найрамдах Киргиз Улсын Иссык-Куль муж хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
7	“Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Бүгд Найрамдах Куба Улсын Шинжлэх ухаан, технологи, байгаль орчны яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		

8	“Дээд боловсрол, судалгаа, шинжилгээний салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Бүгд Найрамдах Кипр Улсын Боловсрол, соёлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
9	“Монгол Улсын Архивын ерөнхий газар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Иргэний бүртгэлийн албаны архивын агентлаг хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
10	“Монгол Улсын Архивын ерөнхий газар, Япон Улсын Үндэсний архивын газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
11	“Боловсрол, шинжлэх ухааны салбарт болон залуучуудын асуудлаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам болон Бүгд Найрамдах Чех Улсын Боловсрол, залуучууд, спортын яам хоорондын хэлэлцээр”		
12	“Шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Бүгд Найрамдах Беларусь Улсын Шүүхийн шинжилгээний улсын хороо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
13	“Улс төрийн зөвлөлдөх уулзалт зохион байгуулах тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бахрейны Вант Улсын Гадаад хэргийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
14	“Монгол Улсын Архивын ерөнхий газар, Мексикийн Үндэсний архив хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
15	“Монгол Улсын Баян-Өлгий аймгийн Өлгий хотын Засаг даргын тамгын газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Дорнод Казахстан муж хоорондын баримт бичиг”		
16	“Өрсөлдөөний бодлогын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Шударга өрсөлдөөнийг хамгаалах зүй ёсны хороо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
17	“Эрүүл мэнд, анагаах ухааны салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Япон Улсын Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн халамжийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
18	“Соёлын хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Бүгд Найрамдах Чех Улсын Соёлын яам хоорондын тохиролцоо”		

19	“Хоёр талт зөвлөлдөх уулзалтын тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам, Оманы Султан Улсын Гадаад хэргийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
20	“Үзмэр түрээслүүлэх тухай Монголын Үндэсний музей, Шинжлэх ухааны академийн Түүх, археологийн хүрээлэн болон Данийн Вант Улсын Үндэсний музей хоорондын гэрээ”		
21	“Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Хөвсгөл аймаг, Бүгд Найрамдах Кыргыз Улсын Баткен муж хоорондын баримт бичиг”		
22	“Нийтлэг ашиг сонирхол бүхий асуудлаарх хоёр талт зөвлөлдөх уулзалтын тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам, Катар Улсын Гадаад хэргийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
23	“Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Азийн хөгжлийн банк хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
24	“Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Баянхонгор аймаг, Бүгд Найрамдах Болгар Улсын Русе муж хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
25	“Монгол Улсын Засгийн газар, Харвардын их сургууль хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
26	“Байгалийн шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлэх шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Геологи, уул уурхайн судалгаа, шинжилгээний товчоо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
27	“Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Хэрэглэгчийн агентлаг хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
28	“Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Үндэсний хөгжлийн газар, ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
29	Дэлхий судлалын салбарт хэрэгжүүлэх шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны газар болон Франц Улсын БРГМ (Геологи, уул уурхайн судалгаа, шинжилгээний товчоо)-ийн хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
30	“Монгол Улсын Их Сургууль, ХБНГУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		

31	Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Эрчим хүчний яам, Бүгд Найрамдах Азербайжан Улсын Эрчим хүчний яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг		
32	“Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Чола мужийн захиргааны байгууллага хоорондын баримт бичиг”		
33	“Спортын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Канад Улсын Спорт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
34	“Нөхөн сэргээх мэс засал, мэдээгүйжүүлэлт, эрүүл мэндийн холбогдох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Австрали Улсын Интерпласт ТББ хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
35	Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Үндэсний номын сан, Азийн сонгодог зохиолыг каталогт оруулах төслийн байгууллага хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
36	“Тэтгэлгийн тухай Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон Япон Улсын Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын олон улсын их сургууль хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-		
37	Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Дархан-Уул аймаг, Бүгд Найрамдах Солонгос Улсын Чангвон хот хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг		
38	Биеийн тамир, спортын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Соёл, спортын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг		
39	“Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Батлан хамгаалах яам, Филиппин Улсын Үндэсний батлан хамгаалахын газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
40	“Онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, Бүгд Найрамдах Тажикистан Улсын Засгийн газрын дэргэдэх Онцгой комисс хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
41	Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага хоорондын “Олон Улсын сурагчийн үнэлгээний хөтөлбөрт оролцох гэрээ”		

42	“Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Арабын Нэгдсэн Эмират Улсын Дотоод хэргийн яам хооронд аюулгүй байдал, терроризмтой тэмцэх чиглэлээр хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг”		
43	“Монгол Улсын Батлан хамгаалахын яам, Бүгд Найрамдах Турк Улсын Батлан хамгаалах яам хооронд цэргийн түүх, архив, музей судлал, хэвлэл мэдээллийн чиглэлээр хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг”		
44	“Монгол Улсын Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Бүгд Найрамдах Турк Улсын Батлан хамгаалахын их сургууль хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
45	“Цэргийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штаб, Бүгд Найрамдах Киргиз Улсын Зэвсэгт хүчний Жанжин штаб хоорондын хэлэлцээр”		
46	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон Бүгд Найрамдах Филиппин Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хоорондын хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг”		
47	“Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Батлан хамгаалах яам, Филиппин Улсын Үндэсний батлан хамгаалахын газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
48	Байгаль орчны салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Япон Улсын Байгаль орчны яам		
49	“Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Азийн хөгжлийн банк хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”		
50	Гадаад харилцааны яам, Олон улсын санхүүгийн корпорацитай байгуулах санамж бичиг;		
51	Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Аж үйлдвэр, худалдааны яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг;		
52	Барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрчим хүчний яам болон Олон улсын санхүүгийн корпораци хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг;		
53	Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн яам хоорондын санамж бичиг;		

54	Статистикийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндэсний эдийн засгийн яамны Статистикийн хороо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг;		
55	Монгол Улсын Их Хурал, Ирланд Улсын парламентийн Төлөөлөгчдийн танхим хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг;		
56	Монгол Улсын Эрүүл мэндийн яам болон Австрали, Шинэ Зеланд Улсын Интерпласт байгууллага хооронд байгуулахаар төлөвлөж буй харилцан ойлголцлын санамж бичиг;		
57	Статистикийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндэсний эдийн засгийн яамны Статистикийн хороо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг;		
58	Хяналт, шалгалтын сургалтын хөтөлбөрийн тухай Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Санхүүгийн хяналт, шалгалтын байгууллага хоорондын хэлэлцээр;		
59	Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Фридрих-Эбертийн сан хоорондын хамтын ажиллагааны протокол;		
60	Үндэсний хөгжлийн газар болон Олон улсын санхүүгийн корпораци хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр;		
61	Ур чадварын дадлагажигчийн хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний хэлтэс болон Япон улсын Ур чадварын дадлагажигч бэлтгэх байгууллага хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг.		
62	"Өрсөлдөөний хуулийн хэрэгжилтийн салбарын түншлэлийн тухай Монгол Улсын Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Гүрж Улсын Өрсөлдөөний байгууллага хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг"-ийн төслийг хянан, хүргүүлэв.		
63	Үндэсний хөгжлийн газар Солонгосын худалдаа-хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагтай хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг		

КОНСУЛЫН ХАРИЛЦАА

Монгол, Туркийн консулын IV зөвлөлдөх уулзалтыг 2 дугаар сард Улаанбаатар хотноо, Монгол, Хятадын консулын XIX зөвлөлдөх уулзалтыг 6 дугаар сард Бээжин хотноо, Монгол, Чехийн консулын II зөвлөлдөх уулзалтыг 9 дүгээр сард Прага хотноо, Монгол, Оросын консулын XVI зөвлөлдөх уулзалтыг 12 дугаар сард Москва хотноо, Монгол, БНСУ-ын консулын X зөвлөлдөх уулзалтыг 12 дугаар сард Улаанбаатар хотноо тус тус зохион байгуулав. Түүнчлэн консулын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх,

мэдээлэл хуваалцах үүднээс Монгол Улсад суугаа ДТГ-уудын консулын ажилтнуудын уулзалтыг 6 дугаар сард Улаанбаатар хотноо мөн зохион байгуулав.

БНЧУ-ын ЭСЯ-ны Шенгений виз мэдүүлэх төв 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс Улаанбаатар хотноо үйл ажиллагаагаа эхлүүлэв.

Тус яамны санаачилгаар “Бүс ба Зам - зорчих нөхцөлийг хөнгөвчлөх” хүрээнд Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудалд тусгай гарц нээв.



Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар 2018 оны наймдугаар сарын 25-ны өдөр БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн гишүүн бөгөөд Гадаад хэргийн сайд Ван И-д Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын “Бүс ба Зам” тусгай гарцыг танилцуулав.

Монгол Улсын “Виз мэдүүлгийн төвийн үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага, зохицуулалтын


тухай журам”-ыг баталж мөрдөж эхэлснээс гадна “Монгол Улсын виз олгох журам”-ыг шинэчлэн баталж

Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбоо /IATA/-ны мэдээлэл түгээх төв /ТИМАТИК/-д холбогдох журмын дагуу хүргүүлэв.

2018 оны байдлаар гадаадын 44 оронд Монгол Улсын 60 өргөмжит консул

ажиллаж байгаа бөгөөд тэдгээрээс 15 өргөмжит консул Монгол Улсын виз олгох эрхтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Харин Монгол Улсад гадаад орныг төлөөлсөн 34 өргөмжит консул ажиллаж байна.

МОНГОЛ ИРГЭД ВИЗГҮЙ ЗОРЧИХ УЛС





КОНСУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Консулын үйлчилгээг шуурхай хүртээмжтэй болгох, цахимжуулах, мөн олон улсын стандартад нийцүүлэхээр ажиллаж ГХЯ-ны Консулын газрыг Төрийн мэдээлэл, солилцооны “ХУР” системд холбов. Чингэснээр гадаадад байгаа иргэдийн мэдээллийг баталгаажуулах, ар гэртэй нь холбох ажлыг шуурхай гүйцэтгэх, иргэний бүртгэлийн зарим лавлагааг ДТГ-уудаар дамжуулан ГХЯ-наас шууд олгож байх боломж нээгдэв. Түүнчлэн 2018 онд Үндэсний статистикийн хороотой хамтарч хилийн чанадад оршин суугаа иргэдийн цахим бүртгэлийн програмыг нэвтрүүлж, бүртгэлийг эхлүүлэв. Мөн

визийн үйлчилгээг цахимжуулах чиглэлээр ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Дипломат, албан паспортын олгох үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах зорилгоор “Монгол Улсын дипломат, албан паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ыг шинэчлэн батлуулж, мөрдөж эхлэв. Мөн Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийг шинэчлэн, “Үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-д Засгийн газрын 2018 оны 326 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулав.



ИРГЭДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын иргэдэд АНУ-д хөдөлмөр эрхлэх эрх бүхий H2 ангиллын виз олгох үйл ажиллагааг хоёр тал 2018 оны 4 дүгээр сараас эхлүүлсэн бөгөөд БНСУ-ын хувьд жилд 500 сая төгрөгөөс дээш татвар төлдөг аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан, зарим төрлийн мэргэжлийн хүмүүс, БНСУ-д

сурч байсан иргэдэд олон удаагийн визийг 2018 оны 10 дугаар сараас эхлэн олгож байхаар тохиролцсон болно.

ГХЯ АНУ-ын ЭСЯ-тай хамтран “Хариуцлагатай аялцгаая” аяны 2 дугаар ээлжийг эхлүүлж, 2018 оноос тус аяныг өргөжүүлж БНСУ-ын ЭСЯ-тай хамтран ажиллахаар тохиролцов.



ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ ИРГЭДИЙН МЭДЭЭЛЭЛ



“Хилийн чанадад байгаа монгол иргэдэд туслах сан”-гийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулснаар эрх зүйн туслалцааны хүсэлтийн гадаад хэлээрх орчуулгын зардлыг Иргэдэд туслах сангаас гаргаж байх эрх зүйн

зохицуулалт бүрдүүлэв. 2018 онд Иргэдэд туслах сангаас нийт 224,0 сая төгрөгийн тусламж иргэдэд үзүүлсэн. Гадаадад байгаа иргэд гэмт хэрэгт холбогдох явдал өмнөх онтой харьцуулахад 14.6%-иар буурав.

КОНСУЛЫН АЛБАНЫ ЗҮГЭЭС ИРГЭДЭД ШУУД БОЛОН ШУУД БУСААР ҮЗҮҮЛСЭН ТУСЛАЛЦАА, ДЭМЖЛЭГ

- Эмнэлгийн төлбөр хөнгөлөх, чөлөөлүүлэх
- Торгуулийн хэмжээг бууруулах, чөлөөлүүлэх
- Эх орондоо буцах зардал


Дипломат төлөөлөгчийн газар **26**




322 Туслалцаа, дэмжлэг авсан иргэдийн тоо



Нийт үнийн дүн – 1,131,986 ам.доллар

ХАВСРАЛТУУД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 10

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлал, цэргийн номлол батлах, нийтлэх тухай” Улсын Их Хурлын 1994 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 56 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2011 оны
10 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

XXI зуун гарсаар дэлхий дахинд даяаршил улам бүр тэлж, шинжлэх ухаан, мэдээллийн технологи үсрэнгүй хөгжин, улс төр, эдийн засгийн интеграц өргөжиж, улс хоорондын харилцан хамаарал гүнзгийрч байна. Олон улсын харилцаа өнгөрсөн зууны сүүлийн хагасын хоёр туйлт үеийнхээс эрс өөрчлөгдлөө. Хөгжлийн шинэ томоохон төвүүд тодорч, олон улсын харилцаанд тэдгээрийн үзүүлэх нөлөө өсөх хандлагатай байна.

Нөгөөтэйгүүр, улс орнуудын хөгжлийн хурд, түвшин улам бүр ялгарч, буурай, эмзэг эдийн засагтай улсуудад ажилгүйдэл, ядуурал буурахгүй байна. Зарим улс, бүс нутагт цөмийн зэвсэгтэй болох оролдлого үргэлжилж, хурцадмал байдал намжихгүй байна. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол хийгээд олон улсын терроризм, хүний болон хар тамхины наймаа, гоц халдварт өвчний тархалт зэрэг аюул, сорилт нэмэгдэх болов.

Монгол Улс ардчилсан ёс, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, зах зээлийн эдийн засаг бүхий улс болж хөгжихийн хамт гадаад харилцаа, хамтын ажиллагаа улам бүр өргөжин тэлж, гадаадад ажиллаж, сурч байгаа иргэдийн тоо үлэмж нэмэгдэв.

Монгол Улс нөөц баялгаа ашиглан эдийн засгийн чадавхийг өсгөх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, хүн амын амьжиргааг дээшлүүлэх эрчимтэй хөгжлийн замд орж байна.

Дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд Монгол Улсын оруулж ирсэн хувь нэмрийг улам өсгөх, үндэсний хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд гадаад харилцааг өргөтгөн хөгжүүлж, түүний үр өгөөжийг улам нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Монгол Улсын гадаад бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодорхойлон заасан үндэсний ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд тус улсын гадаад, дотоод нөхцөл байдал нь гадаад бодлогын зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох үндэс болно.
2. Монгол Улсын гадаад бодлогын зорилго нь дэлхийн улсуудтай найрсаг харилцаатай байж, улс төр, эдийн засгийн болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх, хөгжил дэвшлийг хурдасгах замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах явдал мөн.

3. Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн.
4. Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулна.
5. Гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангаж, залгамж чанарыг хадгална. Гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангах, төрийн захиргааны төв болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад харилцааг уялдуулан зохицуулах, хяналт тавих үүргийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ.
6. Монгол Улс бусад улстай харилцахдаа бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдал, өөртөө засан тогтнох бүрэн эрхийг харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох, маргаантай асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, эрх тэгш, харилцан ашигтай хамтран ажиллах зэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэмд тодорхойлж, нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ, түүнчлэн хоёр талын харилцааны үндсэн баримт бичгүүдэд заасан бусад зарчмыг удирдлага болгоно.
7. Дэлхий, бүс нутагт нөлөө бүхий улсуудтай харилцаа, хамтын ажиллагааг түлхүү хөгжүүлэхийг зорихын хамт аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжилнэ.
8. Олон улсын харилцааны хөгжил, дэлхийн болон бүс нутгийн улс төрийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад бодлогын чиглэл, зорилтыг уян хатан тогтооно.
9. Монгол Улсын гадаад бодлого нь улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, соёл, хүмүүнлэгийн гадаад бодлого, гадаадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах, гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлого гэсэн харилцан уялдаа бүхий үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Улс төрийн гадаад харилцааны бодлого тодорхойлогч шинжтэй байна.

ХОЁР. УЛС ТӨРИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

10. Монгол Улсын улс төрийн гадаад харилцааны бодлогын зорилго нь тус улсын аюулгүй байдал, хөгжил дэвшлийг хангах таатай гадаад орчин бүрдүүлэх, дипломат болон консулын харилцаа хөгжүүлэх, нөлөө бүхий улсуудтай харилцааныхаа түвшинг дээшлүүлэх, олон улсын байгууллага дахь үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахад оршино.
11. Монгол Улсад гадны цэргийн аюул занал учраагүй нөхцөлд цэргийн аливаа холбоонд нэгдэхгүй, нутаг дэвсгэр, агаар мандлаа аль нэг улсын эсрэг ашиглуулахгүй байх, гадаадын цэргийн хүчнийг өөрийн нутаг дэвсгэрт

нэвтрүүлэхгүй, байрлуулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй байх чиг шугам баримтална.

12. Монгол Улс олон улсын эрх зүйг хүндэтгэн сахиж, гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлнэ.
 13. Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд бүс нутгийн болон дэлхийн чанартай тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бүх нийтийн үйл хэрэгт хувь нэмэр оруулахыг чармайна. Тухайлбал:
 - ардчиллыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж, идэвхтэй оролцох;
 - цөмийн болон үй олноор хөнөөх бусад зэвсэг үл дэлгэрүүлэх, зэвсэг хураах, олон улсын терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, НҮБ-ын болон олон улсын бусад энхийг дэмжих, сахиулах, сэргээн босгох үйл ажиллагаанд оролцох;
 - уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сөрөг үр дагаврыг багасгах, байгаль орчныг доройтлоос хамгаалах, гоц халдварт өвчний тархалтаас сэргийлэхэд чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн хүч чармайлтыг дэмжин оролцох.
 14. Монгол Улс улс төрийн гадаад харилцааны бодлого хэрэгжүүлэхдээ дараахь чиглэлийг баримтална:
 - 14.1. ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзах;
 - 14.2. АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;
 - 14.3. Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцох;
 - 14.4. Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд болон олон улсын санхүү, худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхтэй үргэлжлүүлэх, дэлхийн засаглал дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллах;
 - 14.5. Хөгжиж байгаа улсуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа
-

хөгжүүлэхийн зэрэгцээ Нэгдсэн Үндэстний Байгууллага, “77”-гийн бүлэг, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэг олон талын хүрээнд хамтран ажиллах.

15. Улс төрийн гадаад харилцааны бодлогын чиглэлүүдийг харгалзан тус улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын байршлыг тогтоож, гадаад бодлогыг хэрэгжүүлэх нөхцөлийг сайжруулна.
16. Хөгжлийн эрэлт хэрэгцээ, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилтод нийцсэн гадаад бодлогын судалгаа, шинжилгээ, гадаад харилцааны мэргэшсэн хүний нөөцийн бэлтгэл, сургалтын тогтолцоо бүрдүүлнэ.
17. Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газарт дипломат алба, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, технологийн талаар өндөр мэдлэг, боловсролтой, мэргэшсэн ажилтанг оролцуулан томилж, сэлгэн ажиллуулах бодлого баримтална.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

18. Үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн аюулгүй байдлыг баталгаажуулах, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд гадаад харилцааны үр нөлөөг нэмэгдүүлэх нь эдийн засгийн гадаад харилцааны бодлогын зорилго мөн.
19. Эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэхдээ эрх тэгш, харилцан ашигтай байх зэрэг нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг чанд мөрдөнө. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтыг үндэс болгон эдийн засгийн аюулгүй байдлыг бүх талаар хангахыг эрмэлзэж, аль нэг улсаас хэт хараат байдалд орохоос сэрэмжилнэ.
20. Эдийн засаг, худалдааны чөлөөт бүс, хамтарсан буюу гадаадын дагнасан хөрөнгө оруулалттай аж ахуйн томоохон нэгж байгуулах, концесс олгох, дэд бүтэц шинээр бий болгох зэрэг эдийн засгийн хөгжилд үлэмж нөлөө үзүүлэх төсөл, арга хэмжээг үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгод нийцүүлэн хэрэгжүүлнэ.
21. Эдийн засгийн гадаад харилцааны бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 21.1. эдийн засгийн салбаруудад тэргүүний технологи, менежмент нэвтрүүлж, ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар, стандартыг олон улсын жишиг, түвшинд ойртуулан нийцүүлэх замаар өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, экспортын хэмжээг өсгөхийг дэмжих;
 - 21.2. уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эдийг бүрэн боловсруулж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн гаргах, импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байр нэмэгдүүлэх, түүнчлэн мэдлэгт суурилсан үйлдвэрлэл хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

- 21.3. түлш, эрчим хүч, зам, тээвэр, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн салбарыг хөгжүүлэхэд дөхөм үзүүлэх;
- 21.4. олон улс, бүс нутгийн эдийн засгийн интеграц болон дэд бүтцийн сүлжээнд нэгдэхийг эрмэлзэх, далайн боомт хүрэх, дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- 21.5. монгол орны байгаль, түүх, соёлын өв санд түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх, үйлчилгээг нь олон улсын түвшинд хүргэх, олон улсын сүлжээнд хамрагдах, соёлын бүтээгдэхүүнийг гадаадад борлуулахад дэмжлэг үзүүлэх;
- 21.6. гадаад худалдааг эдийн засгийн өсөлт, хүн амын эрэлт хэрэгцээг хангахад чиглүүлж, үр ашгийг нь дээшлүүлэх, гадаад худалдааны тааламжтай нөхцлүүдийг олох замаар өөрийн бараа, үйлчилгээний зах зээлийг тэлэх нөхцөл бүрдүүлэх;
- 21.7. бизнесийн таатай орчин бүрдүүлж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг тэнцвэртэй нэмэгдүүлэхийн зэрэгцээ үндэсний аж ахуйн нэгж гадаадад хөрөнгө оруулах, дэлхийн санхүү, хөрөнгийн зах зээлд нэвтрэх нөхцөл бүрдүүлэхийг эрмэлзэх;
- 21.8. “Ногоон”, “Цэнхэр” эдийн засгийг хөгжүүлэх, уул уурхайн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгахад дэмжлэг үзүүлэх;
- 21.9. экологийн аюулгүй байдлыг хангах, тэнцвэрийг хадгалах, байгаль орчныг хамгаалах, ялангуяа цөлжилттэй тэмцэх чиглэлээр хоёр талын болон олон талын хүрээнд хамтын ажиллагаа хөгжүүлэх, гадаад улс, олон улсын байгууллагаас буцалтгүй тусламж авах талаар идэвхтэй ажиллах;
- 21.10. далайд гарцгүй хөгжиж байгаа улсуудын эрх ашгийг Нэгдсэн Үндэстний Байгууллага болон олон улсын бусад байгууллагын хүрээнд хамгаалах ажилд ахиц гаргах, их далайн нөөцөөс ашиглах боломжийг эрэлхийлэх.

ДӨРӨВ. ШИНЖЛЭХ УХААН-ТЕХНОЛОГИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

22. Орчин үеийн шинжлэх ухаан-технологийн үндэсний чадавхийг сайжруулах, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгахад дөхөм үзүүлэх нь шинжлэх ухаан-технологийн гадаад харилцааны бодлогын зорилго мөн.
 23. Шинжлэх ухаан-технологийн гадаад харилцааны бодлогыг дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:
 - 23.1. эрдэс болон хөдөө аж ахуйн түүхий эдийг гүнзгий боловсруулах, дэвшилтэт арга технологийг сонгон нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
-

- 23.2. эдийн засаг, нийгмийн салбарт инновац нэвтрүүлэх, цөмийн технологийг энхийн зорилгоор ашиглах чиглэлээр хамтын ажиллагааг идэвхжүүлэх, сэргээгдэх эрчим хүч ашиглах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тус тус дэмжлэг үзүүлэх;
- 23.3. мэдээллийн технологийн салбарт гадаадын хөрөнгө оруулалт, орчин үеийн ололтыг нэвтрүүлэх, шинжлэх ухаан-технологийн үндэсний мэдээллийн сүлжээг өргөтгөн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- 23.4. эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлээр туршилт, сорилт явуулах бааз суурийг бэхжүүлэх, мэргэшсэн судлаач бэлтгэхэд гадаадын тусламж, дэмжлэгийг нэмэгдүүлэхийг эрмэлзэх;
- 23.5. олон улсад Монгол судлал өргөжин хөгжихийг дэмжиж, гадаадад Монгол судлалын төв байгуулахад туслалцаа үзүүлэх;
- 23.6. шинжлэх ухаан-технологич, оюуны өмчийн салбарт хоёр талын болон олон талын үндсэн дээр хамтын ажиллагаа хөгжүүлэх.

ТАВ.СОЁЛ, ХҮМҮҮНЛЭГИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

- 24. Соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны бодлогын зорилго нь үндэсний соёл иргэншил, өвөрмөц өв уламжлалаа дэлхийн соёлын нийтлэг ололттой хослуулан хөгжүүлэх, түүх, соёлын үнэт зүйлээ хамгаалах, сэргээх, түүхэн шалтгаанаар гадаадад гарсан эд өлгийн зүйлийг сурвалжлан олоход чиглэсэн хамтын ажиллагаа хөгжүүлэх, нийгэм, хүмүүнлэгийн салбарын шууд харилцаанд тус дөхөм үзүүлэх явдал мөн.
- 25. Соёл, хүмүүнлэгийн салбарын гадаад бодлогыг дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:
 - 25.1. Түүх, соёлын дурсгалт болон үнэт зүйл, байгалийн өвийг хамгаалах, сэргээх талаар гадаад улс, ЮНЕСКО, олон улсын холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллаж, дэлхийн соёлын болон байгалийн өв сангийн бүртгэлд өөрийн биет, биет бус өвийг хамруулахыг зорих;
 - 25.2. Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг олон улсын жишиг, шаардлагад ойртуулан сайжруулах, энэ талаар ахиц дэвшилд хүрсэн улсуудын туршлагыг судалж хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлэх;
 - 25.3. Үндэсний хөгжилд нэн шаардлагатай мэргэжилтнүүдийг хөгжингүй улсуудад бэлтгэх, гадаадын өндөр мэргэшлийн багш, эрдэмтдийг ирүүлж ажиллуулах нөхцөл бүрдүүлэх, сургууль, судалгааны байгууллага байгуулах зэрэг боловсролын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
 - 25.4. Боловсрол, соёл, урлаг, спорт, олон нийт, мэдээллийн олон улсын байгууллагатай идэвхтэй харилцах, шаардлагатай гэрээнд нэгдэн орох, ижил төрлийн байгууллагуудын хооронд шууд харилцаа, солилцоо

хөгжүүлэх, соёл, урлаг, спортын олон улсын арга хэмжээнд оролцох, ийм төрлийн арга хэмжээг эх орондоо зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

- 25.5. Бусад улс дахь монгол туургатнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хэл, соёл, уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

ЗУРГАА.ГАДААДАД БАЙГАА ИРГЭДИЙНХЭЭ ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ БОДЛОГО

26. Гадаадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах бодлогын зорилго нь хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, эрх ашгийг хамгаалахад оршино.
27. Гадаадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:
- 27.1. Монгол Улсаас гадаад улсад суугаа бүрэн эрхт төлөөлөгчийн газар өөрийн иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны эрх ашгийг үндэсний болон тухайн улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний хүрээнд хамгаалах;
- 27.2. Монгол Улсаас гадаад улсад суугаа бүрэн эрхт төлөөлөгчийн газар өөрийн суугаа болон хавсран суугаа улсад амьдарч, ажиллаж, суралцаж байгаа иргэдийнхээ бүртгэл, судалгааг хөтөлж, тэдэнд шаардлагатай үед туслалцаа, дэмжлэг үзүүлэх;
- 27.3. иргэд гадаадад зорчих эрх зүйн таатай нөхцөл бүрдүүлэхийг эрмэлзэхийн зэрэгцээ тэд эх орондоо эргэн ирж, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахыг дэмжсэн бодлого хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлэх;
- 27.4. гадаадад гэрээгээр ажиллаж байгаа иргэдийнхээ нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр тухайн улстай хамтран ажиллах;
- 27.5. гадаадад байгаа иргэн гэнэтийн осол, халдлага, аюул, албадлагад өртөх, хүнд өвчин тусах, нас барах зэрэг тохиолдолд Монгол Улсаас тухайн улсад суугаа бүрэн эрхт төлөөлөгчийн газар бололцоотой туслалцаа, дэмжлэг шуурхай үзүүлэх;
- 27.6. гадаадад зорчиж байгаа иргэдийг хар тамхи, хүний наймаа зэрэг ноцтой гэмт хэрэгт өртөхөөс сэрэмжлүүлэх, ийм төрлийн хэрэгт холбогдож хохирогсдын эрхийг хамгаалах чиглэлээр тухайн улсын болон олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллах;
- 27.7. гадаадад байгаа иргэддээ тэдний хууль ёсны эрх, эрх чөлөө, үүрэг, хариуцлагын талаархи болон шаардлагатай бусад мэдээлэл, зөвлөлгөө өгч байх;
-

- 27.8. гадаадад буй иргэдийн үүсгэл санаачилгын байгууллага, холбоодын үйл ажиллагааг дэмжиж ажиллах.

ДОЛОО.ГАДААД СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ БОДЛОГО

28. Гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлого нь Монгол Улсын дотоод, гадаад бодлого, ардчилал, шинэчлэлийн үйл явцыг улс түмэнд сурталчлан таниулах, тэдэнд улс орныхоо талаар эерэг ойлголт, сэтгэгдэл төрүүлэх, найрсгаар хандан талархагчдын хүрээг өргөтгөх, иргэд хоорондын харилцаа, харилцан зорчих явдлыг нэмэгдүүлэхэд оршино.
29. Гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлогыг дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:
- 29.1. Монгол Улсын түүх, соёлын уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын ололт амжилтыг гадаадад сурталчлах үйл ажиллагааг идэвхжүүлэх, гадаад сурталчилгааны бүтэц бий болгохыг дэмжих;
- 29.2. монголын түүх, байгаль, зан заншил, ахуй амьдрал, хөгжил дэвшлийг харуулсан сурталчилгааны ном, товхимол, нэвтрүүлэг, кино, цомог зэргийг бэлтгэн бусад улс түмэнд түгээх, сурталчлах;
- 29.3. хоёр талын харилцааны хүрээнд гадаадад Монгол Улсыг сурталчилсан өдрүүд зохион байгуулах, үзэсгэлэн, яармаг гаргах, кино, урлагийн тоглолт үзүүлэх, уулзалт, ярилцлага зохион байгуулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- 29.4. гадаад сурталчилгааг сайжруулахын тулд бусад улс, олон улсын байгууллагын нэр хүндтэй хүмүүс, улс төр, нийгэм, соёлын зүтгэлтэн, сэтгүүлч болон хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;
- 29.5. Монгол Улсын талаар гадаадын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарч байгаа мэдээ, мэдээллийг судалж байх;
- 29.6. Монгол Улсын гадаад бодлого, гадаад харилцааны талаар олон нийт, хэвлэл, мэдээллийн байгууллагуудыг бодит мэдээллээр хангах, тэдний хүч бололцоог бусад улстай харилцаа, хамтын ажиллагаа хэвийн хөгжүүлэхэд чиглүүлэх;
- 29.7. гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлогыг хэрэгжүүлэхэд ардын болон соёлын дипломатын арга хэлбэрийг хэрэглэх;
- 29.8. энх тайван, найрамдлын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих.

ӨРГӨТГӨСӨН ИЖ БҮРЭН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛС, АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүхийн Америкийн Нэгдсэн Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр энэхүү Хамтарсан мэдэгдлийг гаргав.

Монгол Улс, АНУ нь хоёр улс дипломат харилцаа тогтоосноос хойших гуч гаруй жилийн хугацаанд гаргасан тууштай хүч чармайлтын үр дүнд Монгол Улс, АНУ-ын улс төр, эдийн засаг, боловсрол, соёл, иргэд хоорондын харилцаа холбоо гүнзгийрэн хөгжиж ирснийг тэмдэглэж, хоёр талын харилцаа Өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн шинэ түвшинд хүрснийг зарлан тунхаглав.

Монгол Улс, АНУ-ын ойр дотно хамтын ажиллагааны зарчмуудын тухай 2007 оны Тунхаглалд тусгалаа олж, улмаар 2004, 2005 оны Монгол Улс, АНУ-ын Хамтарсан мэдэгдлүүдээр баталгаажсан үндсэн зарчмууд нь хамтын үнэт зүйлс болон стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан харилцааг хөгжүүлэх үндэс суурийг тавьсныг талууд харилцан нотлов. Улмаар талууд хоёр орны харилцааг өргөжүүлэн бэхжүүлэхийн төлөө ажиллахдаа эдгээр зарчмыг тууштай дагахаа нотлон илэрхийлэв.

АНУ нь Монгол Улсын чөлөөт, ардчилсан нийгэм рүү хийсэн шилжилтийг сайшааж, хоёр орны найрамдал нөхөрлөлийг бататган, Энэтхэг-Номхон далайн бүс нутаг дахь чухал түншийн хувьд Монголын үүрэг, хувь нэмэр чухал болохыг нотлов. АНУ нь Монгол Улсын ардчилсан тогтолцоо руу шилжих үйл явцыг тууштай дэмжиж, зах зээлийн эдийн засгийг бэхжүүлэх, улмаар засаглалын чадварлаг институтүүдийг бий болгох, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах үйл явцад үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлж, түншилж ирсэнд монголын тал талархал илэрхийлэв. Манай тал АНУ нь Монгол Улсын чухал гуравдагч хөрш, дотнын анд, чухал түнш орон гэдгийг нотлов.

Бүс нутгийн болон олон улсын аюулгүй байдал

Америкийн тал Монголын зэвсэгт хүчин Афганистан дахь албаа урт хугацаанд нэр хүндтэй гүйцэтгэж байгаад баяр хүргэж, Шийдвэртэй дэмжлэг ажиллагаанд 2018 оноос хойш үргэлжлүүлэн оролцоно хэмээн хүлээж байгаагаа илэрхийлэв. Мөн олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд оруулж буй Монгол Улсын хувь нэмрийг үнэлж, Хааны

эрэлд хээрийн сургуулиар дамжуулан бусад орны энхийг сахиулах чадавхийг сайжруулахын төлөө хүч чармайлт гаргаж байгаад талархал илэрхийлэв. Монголын тал АНУ-ын зүгээс эдгээр сургалт болон Монголын Зэвсэгт хүчний чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж ирсэнд талархал илэрхийлэв. Хоёр тал тусгаар тогтносон, бүрэн эрхтэй улс орнуудаас бүрэлдэн бий болсон аюулгүй, тогтвортой, хөгжин цэцэглэсэн дэлхий ертөнцийг цогцлоохын төлөөх зорилгодоо хамтдаа байж, харилцан биенээ дэмжиж ажиллахаа нотлов.

БНАСАУ-ыг цөмийн зэвсгээс бүрмөсөн ангижруулах нь бүс нутгийн болон олон улсын аюулгүй байдалд чухал ач холбогдолтойг талууд харилцан нотолж, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолуудыг бүрэн хэрэгжүүлэх зорилгоор мэдээлэл солилцож, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхээр тогтов. Монгол Улс дээрх зорилтын хүрээнд дэмжлэг үзүүлж ирсэнд америкийн тал талархал илэрхийлж, олон улсын хамтын нийгэмлэгийн эрмэлзлийг үргэлжлүүлэн дэмжиж ажиллахыг хүсэв.

Эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх тухай

Монгол Улс, АНУ хоёр нь шинэ Өргөтгөсөн иж бүрэн түншлэлийнхээ хүрээнд эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаагаа хоёр орны ард түмний тусын тулд бэхжүүлэх эрмэлзэлтэй байгаагаа нотлов. Энэ хүрээнд хоёр тал “Монгол Улс, АНУ-ын хоорондын эдийн засгийн өргөтгөсөн түншлэлийн тухай замын зураглал”-ыг баталж, эдийн засгийн харилцааг өргөжүүлэхийн төлөө эерэг, үр бүтээлтэй арга хэмжээ авч ажиллахаа харилцан илэрхийлэв.

Мянганы сорилтын корпорацитай байгуулсан Монгол Улсад хэрэгжүүлэх Хоёр дахь Компакт гэрээ нь хоёр талын харилцааны томоохон үйл явдал болохыг талууд сайшаан тэмдэглэв. Компактын хүрээнд Улаанбаатар хотын усны хангамжийг хангах дэд бүтцийг сайжруулж, урт хугацааны тогтвортой хөгжлийг бодлогын шинэчлэл хийх замаар баталгаажуулахыг зорьж байна. Компакт гэрээ байгуулагдсан явдал нь АНУ-ын зүгээс Монгол Улс төдийгүй бүс нутагт эрх чөлөө, нээлттэй, тусгаар тогтносон болон ил тод байдлын зарчмуудыг сахин хамгаалах, түгээх хүсэлтийн илэрхийлэл гэдгийг америкийн тал онцлов. Энэхүү Компакт гэрээ нь Монгол, Америкийн ард түмний удаан жилийн нөхөрлөлийн бэлгэ тэмдэг бөгөөд Монгол Улсын эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулна гэдгийг монголын тал тэмдэглэв.

Хөрөнгө оруулалтын болон санхүүгийн тогтвортой орчин нь Монгол, Америкийн эдийн засгийн харилцааг гүнзгийрүүлэх чухал хүчин зүйл

гэдгийг тэмдэглэж, Монгол Улсыг санхүүгийн гэмт хэргээс хамгаалах, ил тод байдал болон макро-эдийн засгийн тогтвортой байдлыг нь хангах, бэхжүүлэхийн чухлыг талууд онцлов. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг Монгол Улсын чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааг дэмжихээ монголын тал илэрхийлж, Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн хүрээнд хүлээсэн үүргээ чанд биелүүлэхээ нотлов.

Нийтлэг үнэт зүйлс болон иргэд хоорондын солилцоо

Талууд эрх чөлөө, ардчилал, хүний эрхийн төлөөх хоёр улсын хамтын эрмэлзэл нь хоёр талын харилцааны үндэс суурь болж байгааг тэмдэглэв. Монголын тал Шашны эрх чөлөөний асуудлаарх Сайд нарын анхдугаар бага хурлыг зохион байгуулсанд америкийн талд талархал илэрхийлж, Ази, Номхон далайн бүс нутаг төдийгүй дэлхий дахинд шашны эрх чөлөөг дэмжих Монгол Улсын эрмэлзлийг илэрхийлэв. Өнгөрсөн 7 дугаар сард болсон Шашны эрх чөлөөний асуудлаарх Сайд нарын анхдугаар бага хурлын үеэр Монгол Улсын зүгээс Шашны эрх чөлөө хариуцсан Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд томилохоо зарласныг америкийн тал сайшаан тэмдэглэв. Монгол Улс нь бүс нутагтаа эл асуудлаар тэргүүлэгч орны хувьд шашны эрх чөлөөг дэмжихтэй холбоотой хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх арга замыг хамтран эрэлхийлж ажиллахаа талууд нотлов.

Талууд соёлын болон боловсролын хамтын ажиллагааны чухлыг онцлохын сацуу боловсролын хөтөлбөр, хамтын ажиллагааг төр-хувийн хэвшлийн түншлэл, солилцоог нэмэгдүүлэх, ашгийн төлөө болон ашгийн бус соёлын солилцоог дэмжих, Монгол Улс дахь Энхтайвны корпусын сайн дурын ажилтнуудын тоог нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь англи хэлний сургалтын хөтөлбөрөөр өргөжүүлэх хэлбэрээр хүмүүнлэгийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийн төлөө байгаагаа мөн нотлов. Энэхүү харилцааг өргөжүүлэх зорилгоор Монгол Улс болон АНУ нь 2019 оныг “Монгол, Америкийн залуучуудын жил” болгон зарлахаар тохиролцов.

Түүнчлэн талууд дээд, өндөр түвшний яриа хэлцээний давтамжийг хадгалж, ГХЯ- д хоорондын улс төрийн зөвлөлдөх уулзалт, батлан хамгаалахын зөвлөлдөх уулзалт, Эдийн засгийн бодлогын яриа хэлцээ, Худалдаа, хөрөнгө оруулалтын Ерөнхий хэлэлцээрийн уулзалт, Эрчим хүчний хамтын ажиллагааны яриа хэлцээ зэрэг механизмаар дамжуулан хоёр талын харилцааны тэргүүлэх асуудлууд, олон улсын

энхтайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх хүч чармайлтаа урагшлуулахын чухлыг тэмдэглэв.

Монгол Улс, АНУ нь ойр дотно түншлэлийнхээ хүрээнд ардчиллын зарчмыг сахих, сайн засаглал, хүнийг эрхийг дээдлэх, бүс нутагтаа болон олон улсад энхтайван, тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтийг авчрах чин эрмэлзэлтэй байгаагаа бататган нотлов.

Вашингтон хот

2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр

<http://www.mfa.gov.mn/?p=47816>

JOINT STATEMENT ON THE EXPANDED COMPREHENSIVE PARTNERSHIP BETWEEN MONGOLIA AND THE UNITED STATES

The text of the following statement was released by the Governments of the United States of America and Mongolia on the occasion of the official visit of Mongolian Prime Minister Khurelsukh to the United States of America:

The United States and Mongolia, recognizing that persistent efforts by both sides across thirty-one years of diplomatic relations have deepened political, economic, educational, cultural and people-to-people ties between the two countries, declared that their bilateral relationship had reached a new level of expanded comprehensive partnership.

The two sides recognized that the basic principles set forth in the 2007 Declaration of Principles for Closer Cooperation, and supported by the 2004 and 2005 U.S-Mongolia Joint Statements, have provided a solid foundation for the development of a relationship based on shared values and common strategic interests. Both countries reaffirmed their commitment to these principles as they pursue avenues to further broaden and deepen their bilateral relationship.

The United States hailed Mongolia's transformation into a free and democratic society, reaffirming both the friendship between the two countries and Mongolia's role as an important Indo-Pacific partner. Mongolia expressed appreciation both for the unwavering support of the United States during Mongolia's transition to democracy and for continued U.S. partnership as Mongolia works to strengthen its market economy, build strong governance institutions, and foster sustainable economic development. Mongolia reaffirmed the role of the United States as a significant third neighbor, a close friend, and an important partner.

Regional and Global Security

The United States commended Mongolia for the long and distinguished service of Mongolian forces serving in Afghanistan and expressed anticipation for its contribution to the Resolute Support Mission beyond 2018. The United States also expressed appreciation for Mongolia's contributions to global peacekeeping, including its efforts to enhance the peacekeeping ability of other nations through the Khaan Quest exercises. Mongolia thanked the United States for its support of the exercises and of

capacity building within the Mongolian armed forces. Both sides pledged to continue to provide mutual support in their shared pursuit of a secure, stable, prosperous world of independent and sovereign countries.

Both sides also reaffirmed the essential importance to regional and global security of the final, fully verified denuclearization of the DPRK, and pledged to continue cooperation and information sharing to ensure the full implementation of all UN Security Council resolutions. The United States thanked Mongolia for its assistance in this regard and urged continued support for the efforts of the international community.

Strengthening Economic Cooperation

Under the new expanded comprehensive Partnership, Mongolia and the United States expressed their intent to strengthen their shared economic, trade, and investment relationship for the benefit of both peoples. To that end, both sides noted with approval the completion of the “Roadmap for Expanded Economic Partnership between the United States of America and Mongolia” and expressed their desire to take positive and effective measures to expand economic relations.

Both sides welcomed the signing of Mongolia’s second Millennium Challenge Corporation Compact, which will support vital improvements to infrastructure supplying water to Ulaanbaatar, and will secure the long-term sustainability of that infrastructure through policy reforms. The United States observed that the Compact is representative of the U.S. desire to protect and promote the principles of freedom, openness, sovereignty, and transparency in Mongolia and across the region. Mongolia highlighted that the Compact is a symbol of the lasting friendship between the Mongolian and American peoples; and it has an important contribution to the economic development of Mongolia.

Recognizing that a stable investment and financial environment is an essential component of deepened U.S.-Mongolia economic relations, both sides acknowledged the importance of strengthening Mongolia’s defenses against financial crimes, improving transparency, and securing macroeconomic stability. Mongolia expressed support for further cooperation on developing its anti-money laundering and countering the financing of terrorism regimes, and reiterated the country’s commitment to fulfilling its commitments as part of its IMF program.

Shared Values and People-to-People Exchange

The United States and Mongolia affirmed that the two countries' shared commitment to freedom, democracy, and human rights represented a cornerstone of their bilateral relationship. Mongolia thanked the United States for hosting the Ministerial to Advance Religious Freedom, and expressed Mongolia's desire to promote religious freedom in the Asia-Pacific region and around the world. The United States welcomed Mongolia's announcement at July's Ministerial to Advance Religious Freedom of its appointment of an Ambassador at Large for Religious Freedom. Both sides committed to explore avenues through which to deepen cooperation in securing and expanding religious freedom, with Mongolia as a leader on this issue in the region.

Underscoring the importance of cultural and educational cooperation, the two countries reaffirmed their commitment to broadening educational programs through public-private partnerships, increasing direct exchanges, promoting both commercial and non-commercial cultural exchanges, and enhancing collaboration through an increase of Peace Corps volunteers and their activities in Mongolia, including, but not limited to, expanded English language teaching programs. With the view of deepening these ties, Mongolia and the United States agreed to announce 2019 as the "U.S.-Mongolia Youth Year."

The two sides also noted the importance of maintaining the frequency of high-level dialogues and bilateral mechanisms, including the Annual Bilateral Consultations, defense talks, the Economic Policy Dialogue, TIFA talks, and the Energy Cooperation Dialogue to discuss and collaborate on efforts to advance bilateral priorities and international peace and prosperity.

Mongolia and the United States reaffirmed their shared commitment to the principles of democracy, good governance, respect for human rights, and promotion of peace, stability, and prosperity in the region and beyond in the spirit of true partnership.

Washington, DC

September 20, 2018

МОНГОЛ УЛС, АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС ХООРОНДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨРГӨТГӨСӨН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ЗАМЫН ЗУРАГЛАЛ

Вашингтон хот, 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр

Монгол, Америкийн ард түмний тусын тулд энэхүү Замын зураглалыг дараах байдлаар хэрэгжүүлэхээр Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс харилцан тохиров:

Олон улсын худалдаа

Монгол Улс болон Америкийн Нэгдсэн Улс нь Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн төлөө тууштай байж, талууд ДХБ-ын хүрээнд зах зээлийг нээхэд үр дүн гаргах талаар хамтран ажиллах үүрэг хүлээснээ дахин нотлов.

Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа

Талууд өөрсдийн оролцоог илүүтэй хангасан, хөгжин цэцэглэсэн, зах зээлд суурилсан, эдийн засгийн сөргөлдөөнөөс ангид бүс нутгийн төлөөх нийтлэг үнэт зүйлс, ашиг сонирхлоо дахин нотлохын сацуу бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны тавцанд зохих мэдээлэл солилцох, хамтарч ажиллах замаар харилцан дэмжлэг үзүүлэх эрмэлзлэлээ илэрхийлэв.

Хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалт

Хоёр тал Монгол Улс, АНУ хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаарх Ил тод байдлын хэлэлцээрээр хүлээсэн тус тусын үүргээ бүрэн хэрэгжүүлэх замаар хоёр талын худалдааны харилцаагаа гүнзгийрүүлэх эрмэлзлэлээ дахин нотлов.

Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудалтай холбоотой авилгын асуудал нь эдийн засгийн эрүүл өсөлт хөгжил, дэвшилд саад тотгор болж буйг талууд хүлээн зөвшөөрч, түүнээс урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг хөхиүлэн дэмжиж, оюуны өмчийн эрхийг хамгаалан ажиллах хамтын эрмэлзлэлээ харилцан илэрхийлэв.

ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хоёр талын механизм байгуулахыг дэмжих зорилтын хүрээнд хандивлагч орнуудын зүгээс үзүүлж буй чадавхийг бэхжүүлэх, техникийн туслалцааны нөөц бололцоог ашиглах талаар хамтран ажиллахыг эрмэлзэнэ.

Талуудын хооронд чөлөөтэй, шударга, харилцан ашигтай худалдааг нэмэгдүүлэх, дэд бүтцийн хөгжилд АНУ-ын ЭКСИМ банк, Хилийн чанад дахь хөрөнгө оруулалтын корпораци (ОПИК)-ийн оролцоог хөшүүрэг болгон ашиглах замаар хоёр талын худалдаанд шинэ орон зай, салбар бий болгохыг хөхиүлэн дэмжих шинэ боломжийг эрэлхийлнэ.

Яриа хэлцээ болон механизм

Монгол Улс болон АНУ нь хоёр талын эдийн засаг, худалдааны чиглэлээр явуулж буй дараах яриа хэлцээ, механизмыг улам бүр бэхжүүлэхээ нотлов. Үүнд:

- Эдийн засгийн бодлогын зөвлөлдөх уулзалт;
- Монгол Улсын Засгийн газар болон Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын харилцааг хөгжүүлэхтэй холбоотой хэлэлцээрээр тохирсон уулзалт;
- Эрчим хүчний бодлогын зөвлөлдөх уулзалт;
- Монгол руу чиглэсэн худалдааны итгэмжлэгдсэн төлөөлөгчид болон бусад худалдааны төлөөлөгчид хоорондын бизнесийн уулзалт;
- АНУ-ын Худалдааны яамны Худалдааны хуулийн техникийн туслалцааны хөтөлбөр болон АНУ-ын Сангийн яамны Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд туслалцаа үзүүлэх зэрэг чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр;
- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, АНУ-ын Худалдааны танхимын Монгол Улс дахь салбар болон бусад байгууллагуудын бизнес форум, дугуй ширээний уулзалт зэрэг бизнесийн арга хэмжээ.

Байгалийн нөөц

Байгалийн нөөц ихтэй хоёр улсын хувьд Монгол Улс болон Америкийн Нэгдсэн Улс нь эдгээр байгалийн нөөцийг хоёр орны ард түмний баялаг болгоход шаардлагатай бүхий л нөхцлийг бүрдүүлэхийн төлөө дараах салбарт ойр хамтран ажиллаж, хүчин зүтгэл гаргахыг зорино. Үүнд:

Хөдөө аж ахуй

Хөдөө аж ахуйн салбар нь Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд шаардлагатай чухал хүчин зүйл болохыг онцлохын сацуу талууд хоёр орны хэрэглээ болон экспортын хувьд эрүүл бөгөөд хангалттай хүнсний хангамжийг тогтвортой үйлдвэрлэхэд чиглэсэн хөдөө аж ахуйн хамтарсан судалгаа хийх болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх замаар хөгжлийг дэмжихийг эрмэлзэнэ;

Ус

Усны хангамжийн тогтвортой эх үүсвэрийн дутагдал нь хувийн хэвшилд түшиглэсэн эдийн засгийн өсөлтийг дэмжих Монгол Улсын чадавхийг хязгаарлаж болохыг анхааралдаа авч, талууд Мянганы сорилтын корпорацийн 2 дахь компакт гэрээ, ялангуяа Улаанбаатар хотын усан хангамжийг урт хугацаанд тогтвортой хангахад чиглэсэн бодлогын шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэхийг зорино;

Эрчим хүч болон сэргээгдэх эрчим хүч

Монгол Улсын эрчим хүчний салбар нь эдийн засгийн өсөлтийн эх үүсвэр болох бололцоотойг харгалзан, Монгол Улсыг эрчим хүчээр тогтвортой хангах дотоодын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор талууд эрчим хүчний хамтын ажиллагааг хоёр тал, бүс нутаг, олон талт өнөөгийн хамтын ажиллагааны бүтэц, тэр дундаа Эрчим хүчний бодлогын зөвлөлдөх уулзалтын хүрээнд үргэлжлүүлэхийг зорино;

Уул уурхай

Уул уурхайн салбар нь эдийн засгийн өсөлтөд чухал хувь нэмэр оруулдгийг онцолж, Монгол Улс болон АНУ нь уг салбарт дэвшилтэт туршлага, дэд бүтэцтэй орнуудын хувьд хамтын ажиллагааны шинэ чиглэл, боломжийг хөхиүлэн дэмжиж, туршлага, дэвшилтэт технологи, шилдэг арга барилыг харилцан солилцох замаар хамтын ажиллагааг үргэлжлүүлэхийг зорино.

Санхүүгийн үйлчилгээ

Монгол Улс болон АНУ нь авилга, мөнгө угаахтай тэмцэх зорилгодоо нэгдмэл хэвээр байна. Талууд олон улсын санхүүгийн салбарыг чадавхтай байлгахыг дэмжиж ажиллана.

Дэд бүтэц

Талууд хоёр улсын эдийн засгийн өсөлтийг сайжруулж, эрчимжүүлэх

зорилгоор чанартай дэд бүтэц, түүний дотор цахим дэд бүтцийг өргөжүүлэхийг дэмжиж ажиллахыг эрмэлзэнэ;

Монгол Улс болон Америкийн Нэгдсэн Улс нь тээврийн салбарыг хөгжүүлэхийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, тус тусын холбогдох тээврийн салбарын нээлттэй зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулахыг зорино.

Хөгжлийн хамтын ажиллагаа

Талууд Мянганы сорилтын корпорацийн хоёр дахь компакт гэрээний усны хангамж, усыг дахин ашиглах, усны салбарын тогтвортой байдлыг хангах хөрөнгө оруулалтыг үр дүнтэйгээр бэлтгэх, гүйцэтгэх, хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.

Түүнчлэн Мянганы сорилтын корпорацийн анхны компакт гэрээний үр дүн нь ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангахад үзүүлсэн урт хугацааны нөлөөг бүрэн үнэлэх зорилгын үүднээс хяналт, үнэлгээ, тайланг үргэлжлүүлнэ.

Монгол Улсын жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийг төрөл бүрийн хөтөлбөр, төслөөр дамжуулан дэмжих хамтын ажиллагааг үргэлжлүүлнэ.

Хувийн хэвшлийг дэмжих

ЖДҮ эрхлэгчид болон хувийн хэвшил нь хоёр орны эдийн засгийн тогтвортой өсөлтийн гол хөдөлгүүр болохыг харилцан тэмдэглэж, Монгол Улс болон АНУ нь тэдгээрийн өсөлтийг тэтгэсэн орчныг бий болгохыг хөхиүлэн дэмжихийг эрмэлзэнэ.

Хамтын ажиллагааны шинэ чиглэл

Талууд хоёр улсын байгаль орчныг хамгаалахын сацуу эдийн засгийг бэхжүүлж, төрөлжүүлэх зорилгоор эрүүл мэндийн үйлчилгээний дэд бүтэц, бичил эрчим хүч зэрэг эдийн засгийн хамтын ажиллагааны шинэ чиглэл, салбарыг үргэлжлүүлэн дэмжихийг зорино.

<http://www.mfa.gov.mn/?p=47821>

A ROADMAP FOR EXPANDED ECONOMIC PARTNERSHIP BETWEEN MONGOLIA AND THE UNITED STATES OF AMERICA

Washington, DC September 20, 2018

Mongolia and the United States have committed to pursue and implement this roadmap for the benefit of the peoples of Mongolia and the United States in the following ways:

Global trade

Mongolia and the United States remain committed to implementing their obligations under the WTO Agreement on Trade Facilitation, and the two sides re-affirmed their commitment to cooperate in seeking market-opening outcomes in the WTO.

Regional economic cooperation

The two sides, re-confirming their shared values and interests in a more inclusive, prosperous, and market-oriented region free from economic coercion, announced their intent to provide mutual support, through information sharing and cooperation, as appropriate, in regional economic platforms.

Bilateral trade and investment

Mongolia and the United States re-affirmed their intent to deepen their bilateral commercial relationship through full implementation of their obligations under the United States-Mongolia Transparency Agreement;

The two sides expressed a shared desire to further promote transparency, protect intellectual property rights, and prevent corruption in matters related to international trade and investment, recognizing them as stumbling blocks to achieving healthy economic growth and development;

With a view to encouraging the establishment of a bilateral dialogue to foster the robust and full implementation of the WTO Trade Facilitation Agreement, both sides shared their intent to work towards identifying sources of capacity building and technical assistance available by donors; and

The two sides intend to seek new opportunities to increase mutually beneficial bilateral trade that is free, fair, and reciprocal, and to promote the

introduction of new sectors and areas of bilateral trade, including by leveraging U.S. EXIM Bank and the Overseas Private Investment Corporation for infrastructure development, as appropriate.

Dialogues and mechanisms

Mongolia and the United States welcome and commit to strengthening the existing bilateral dialogues and mechanisms for economic and trade engagement, which include:

- The Economic Policy Dialogue;
- Meetings of the U.S.-Mongolia Trade and Investment Framework Agreement, under the Agreement Between the Government of the United States of America and the Government of Mongolia Concerning the Development of Trade and Investment Relations;
- The Energy Cooperation Dialogue;
- The exchange of businesses through U.S. Department of Commerce trade missions to Mongolia and other trade events;
- Capacity building programs, including the U.S. Department of Commerce's Commercial Law Technical Assistance Program and the U.S. Treasury's assistance in improving Mongolia's anti-money laundering and countering the financing of terrorism system; and
- Business events, such as business forums and roundtables, by the Mongolian National Chamber of Commerce and Industry, the American Chamber of Commerce, and other organizations.

Natural resources

As countries abundant in natural resources, Mongolia and the United States intend to endeavor to create all the necessary conditions towards converting natural resources into wealth for the peoples of the both countries, including through close cooperation in the areas of:

Agriculture

Convinced that the agricultural sector is a significant factor in the necessary diversification of Mongolia's economy, the two countries intend to support its development by seeking opportunities for collaborative agricultural research and other activities aimed at sustainable production of a safe and abundant food supply for consumption and export;

Water

Recognizing that a lack of sustainable sources of water supply constrain Mongolia's ability to support private-sector led economic growth, the two countries intend to maintain support for the Millennium Challenge Corporation's Second Compact, including its infrastructure development and policy reforms that enhance the long-term sustainability of Ulaanbaatar's bulk water supply;

Energy

Aware of the potential of Mongolia's energy sector to become a source of economic growth, and with the view to expanding Mongolia's domestic sources of sustainable energy, the two countries desire to continue energy collaboration through existing bilateral, regional, and multilateral engagement structures, including the Energy Cooperation Dialogue; and

Mining

Welcoming the mining sector as a strong contributor to economic growth, Mongolia and the United States, as two countries with advanced experience and infrastructure in this sector, intend to continue their cooperation by encouraging newer areas and opportunities for cooperation and through exchanges of experiences and advanced technologies, as well as best practices.

Financial services

Mongolia and the United States remain aligned on the goals of combating corruption and money laundering. Both countries affirm their support for a resilient international financial sector.

Infrastructure

The two countries seek to support the expansion of quality infrastructure, including digital, in order to facilitate and improve economic growth in both countries; and

Mongolia and the United States recognize the importance of transport development and aim to improve the competitiveness of their respective transportation sectors in more open markets.

Development cooperation

Both countries decided to faithfully prepare, execute, and implement the second Millennium Challenge Corporation Compact, involving investments in water infrastructure, including supply and wastewater recycling, as well as water sector sustainability;

Recognized that continued monitoring and reporting of results from the first Millennium Challenge Corporation Compact may be necessary to develop a full understanding of its long-term impacts on poverty and economic growth; and

Committed to continue to collaborate in supporting Mongolian small- and medium-sized enterprises (SMEs) through various programs and projects.

Supporting private businesses

Mongolia and the United States seek to promote enabling environments for the growth of SMEs and the private sector, as they mutually note that these are the engines of steady economic growth in both countries.

New areas of cooperation

Both countries intend to continue encouraging newer areas and fields of economic cooperation, such as healthcare infrastructure and micro power, aimed at strengthening and diversifying their economies while protecting the environment.

<http://www.mfa.gov.mn/?p=47824&lang=en>

МОНГОЛ, ЯПОНЫ ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

Япон Улсын Ерөнхий сайдын урилгаар тус улсад албан ёсны айлчлал хийж буй Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүх, Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэ нар 2018 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Токио хотноо албан ёсны хэлэлцээ хийж, хэлэлцээний дүнгээр дараах Хамтарсан мэдэгдлийг гаргав.

1. Хоёр улсын Ерөнхий сайд нар Монгол, Японы Стратегийн түншлэлийн харилцааг цаашид улам бэхжүүлэхээр тохиролцов. Ерөнхий сайд Ш.Абэ эрх чөлөө, ардчилал, хүний эрх, эрх зүйт төр зэрэг нийтлэг үнэт зүйлс бүхий Монгол Улс нь Япон Улсын бүс нутаг дахь чухал түнш болохыг тэмдэглэж, хоёр улсын өргөн хүрээтэй, олон талт хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хөгжүүлэхийн сацуу бүс нутаг болон олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө тулгамдсан асуудлуудаар харилцан уялдаа холбоотой ажиллах эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлэв. Ерөнхий сайд У.Хүрэлсүх Монгол Улсын “гуравдагч хөрш” улсууд дотроос нэн тэргүүнд “Стратегийн түншлэл”-ийн харилцаа тогтоосон чухал түнш Япон Улстай харилцаа, хамтын ажиллагаагаа улам бүр гүнзгийрүүлэн хөгжүүлэх эрмэлзлээ нотлов.

Ерөнхий сайд У.Хүрэлсүх Япон Улсын зүгээс өнөөг хүртэл Монгол Улсад үзүүлж ирсэн өргөн хүрээтэй дэмжлэг туслалцаа нь Монгол орны орчин үеийн хөгжлийн суурийг тавихад чухал ач холбогдолтой болсныг тэмдэглэж, Япон Улсын Засгийн газар, ард түмэнд гүн талархал илэрхийлэв.

Мөн Ерөнхий сайд Ш.Абэ Япон Улсад энэ онд учирсан байгалийн гамшигтай холбогдуулан Монгол Улсын төр, засаг болон ард түмний зүгээс халуун дотно илгээлт ирүүлж, дэмжлэг үзүүрсэнд талархал илэрхийлэв.

2. Хоёр улсын Ерөнхий сайд нар 2017 оны 3 дугаар сард байгуулсан “Монгол, Японы Стратегийн түншлэлийг хөгжүүлэх Дунд хугацааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, улс төр, аюулгүй байдал, батлан хамгаалах, бүс нутаг, олон улсын тавцан дахь хамтын ажиллагаа, худалдаа, эдийн засаг, соёл, олон нийтийн солилцоо зэрэг өргөн хүрээнд харилцаа бэхжиж буйд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлэв. Хоёр улсын Засгийн газар “Стратегийн түншлэлийн Дунд хугацааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн талаарх танилцуулгыг олон нийтэд зориулан гаргав. Цаашид хоёр улсын харилцааг энэхүү Дунд

хугацааны хөтөлбөрт тулгуурлан үргэлжлүүлэн хөгжүүлэх эрмэлзлээ хоёр тал нотлов.

3. Ерөнхий сайд У.Хүрэлсүх Япон Улсын Батлан хамгаалах яамнаас Монгол Улсын Зэвсэгт хүчний чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэмжлэгийг сүүлийн зургаан жилийн турш үзүүлж, хоёр улсын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхийн сацуу бүс нутаг, олон улсын энх тайван, тогтвортой байдлыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулж буйг өндрөөр үнэлэв. Ерөнхий сайд Ш.Абэ Монгол Улсын Зэвсэгт хүчний чадавхийг нэмэгдүүлэх чиглэлд үргэлжлүүлэн хамтран ажиллахын сацуу Монгол Улс болон АНУ-ын хамтран зохион байгуулж буй "Хааны эрэлд" олон улсын хамтарсан сургуулилтад Япон Улс үргэлжлүүлэн идэвхтэй оролцох эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлэв.

4. Хоёр улсын Ерөнхий сайд нар энэ оны 12 дугаар сарын 12-ны өдөр Япон, Монголын төр, хувийн хэвшлийн хамтарсан IX зөвлөлдөх уулзалт амжилттай зохион байгуулагдсаныг сайшаахын сацуу энэхүү зөвлөлдөх уулзалтын механизмд тулгуурлан хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцааг улам бүр бэхжүүлэх чиглэлд хамтын ажиллагаагаа эрчимжүүлэн хөгжүүлнэ гэдэгт санал нэгдэв.

Мөн хоёр улсын Ерөнхий сайд нар Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар нь гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс нээж, үйл ажиллагааг нь эхлүүлэхээр болсныг сайшааж, тус төвөөр дамжуулж Монгол дахь Японы хөрөнгө оруулалтыг тэлэх чиглэлд дэмжлэг үзүүлж ажиллахаа нотлов.

Түүнчлэн хоёр улсын Ерөнхий сайд нар Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн Хамтын ажиллагааны дэд хороо 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдөр анхдугаар хуралдаанаа амжилттай зохион байгуулсныг сайшааж, хэлэлцээрийн хүрээн дэх хамтын ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор тус дэд хороог тогтмол хуралдуулж байхаар санал нэгдэв.

Мөн хоёр улсын Ерөнхий сайд нар Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Японы Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллага (ЖЕТРО)-аас энэ сарын 13-ны өдөр Токио хотноо хамтран зохион байгуулсан бизнес форум нь хоёр улсын худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжилд хувь нэмэр оруулсныг үнэлж, баяр хүргэв.

5. ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Япон Улсын Засгийн газраас Монгол Улсад олгож буй “Төсөв, нийгэм болон эдийн засгийн шинэчлэлийн хөгжлийн бодлогын зээл” нь Монгол Улсын макро эдийн засгийн тогтвортой удирдлага, нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст үзүүлэх тусламжийг дэмжих, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болсныг Ерөнхий сайд У.Хүрэлсүх тэмдэглэв.

6. Хоёр улсын Ерөнхий сайд нар Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал нь Монгол, Японы хамтын ажиллагааны шинэ бэлгэ тэмдэг болж, аялал жуулчлалыг хөгжүүлэх, иргэдийн солилцоог өргөжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт найдаж буйгаа илэрхийлэв.

Монгол Улсын Засгийн газар болон Японы консорциум хоорондын яриа хэлэлцээ бодитоор урагшилж, ойрын хугацаанд тохиролцоонд хүрэхэд хоёр улсын Засгийн газар үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэхээ нотлов. Монгол Улсын Засгийн газар 2019 оны 1 дүгээр сард багтааж Концессын гэрээг эцэслэн тохиролцох, түүнчлэн олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг ирэх онд багтааж шуурхай ашиглалтад оруулах чиглэлээр ажиллаж буйгаа мэдэгдэж, Япон Улсын Засгийн газар Монгол Улсын Засгийн газрын баримталж буй чиглэлийг хүндэтгэн дэмжиж, нисэх онгоцны буудлын аюулгүй үйл ажиллагааны менежментийг хангах нөхцөлтэйгээр аль болохуйц богино хугацаанд ашиглалтад оруулах чиглэлд Японы консорциумын үйл ажиллагааг үргэлжлүүлэн дэмжиж ажиллах эрмэлзэл илэрхийлэв.

Монгол Улсын Засгийн газар шинэ нисэх онгоцны буудлыг саадгүй ашиглалтад оруулахад гэрээний дагуу бэлтгэл ажлыг эрчимжүүлж, Монгол Улсын Засгийн газар хариуцаж буй холбогдох байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгаж,

үйл ажиллагааны менежментийн бүрэлдэхүүнийг байгуулж, олон улсын болон дотоодын бүхий л арилжааны нислэгийг нүүлгэн шилжүүлэх болоод шинэ нисэх онгоцны буудлын үйл ажиллагааны менежментэд шаардлагатай холбогдох яам, агентлаг, байгууллагыг нүүлгэх ажлыг нээлтээс өмнө бүрэн дуусгахаа нотлов.

Мөн хоёр улсын Ерөнхий сайд нар тус нисэх онгоцны буудалд түшиглэн хоёр улсын агаарын тээврийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, Монгол Улсын цаашдын хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлд яриа хэлэлцээг үргэлжлүүлэхээр тохиролцов.

7. Хоёр улсын Ерөнхий сайд нар Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх үлэмж нөөц бололцоо байгааг тэмдэглэж, аялал жуулчлалын салбар дахь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлэхээ илэрхийлэв.

Түүнчлэн хоёр улсын Ерөнхий сайд нар Япон Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр ноолуурын чиглэлд үйл ажиллагаа эрхэлдэг хоёр талын байгууллагууд хамтран ажиллаж, Монголын ноолуурын үйлдвэрлэлийн чадавхийг бэхжүүлж Япон дахь экспортыг дэмжихэд чиглэсэн техникийн хамтын ажиллагаа болон Японы зах зээл дэх сурталчилгааг идэвхжүүлж буйг сайшаав.

8. Хоёр улсын Ерөнхий сайд нар сургалтын эмнэлгийн барилгын ажил урагшилж буйг сайшааж, тус эмнэлэгт зохистой менежментийг нэвтрүүлж, Монгол Улсын эрүүл мэндийн салбарын хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлд хоёр тал хамтран ажиллахаа нотлов.

9. Ерөнхий сайд Ш.Абэ Хамтарсан кредит олгох механизм (ХКОМ)-ыг Япон Улстай Монгол Улс хамгийн анх байгуулж хэрэгжүүлсэн болохыг дурдаж, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хоёр улсын хамтын ажиллагааг улам хөгжүүлэх эрмэлзэлтэй байгааг талууд нотлов.

Хоёр улсын Ерөнхий сайд нар Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Япон Улсын Байгаль орчны яам хооронд “Байгаль орчны салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг” энэ өдөр байгуулсныг сайшаав.

Хоёр улсын Ерөнхий сайд нар энэ оны 11 дүгээр сард болсон Хамтарсан кредит олгох механизмын Хамтарсан хорооны 6 дугаар хуралдааны үр дүн болон энэ онд зохион байгуулагдах хоёр улсын Байгаль орчны яам хоорондын Бодлогын 12 дугаар зөвлөлдөх уулзалтын механизмаар дамжуулан глобаль түншүүдийн хувьд уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчны салбар дахь бусад холбогдох асуудлаар хоёр талын хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэхээр тогтов.

10. Хоёр улсын Ерөнхий сайд нар Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд хөдөө аж ахуйн салбарыг улам бүр хөгжүүлэхийн чухлыг онцолж, энэхүү салбарт хамтын ажиллагаагаа эрчимжүүлэхээр тогтов. Энэ хүрээнд монголын талаас санал болгосон “Хөдөө аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэх замаар нэмүү өртгийн сүлжээг бий болгох мастер төлөвлөгөө” төслийг хэрэгжүүлэхээр албан ёсоор шийдвэрлэснийг

талууд сайшаан хүлээн авав.

11. Хоёр улсын Ерөнхий сайд нар 2020 оны Токиогийн Олимп, Паралимпийн наадмыг угтаж Япон Улсын 16 орон нутгийн захиргааны нэгж Монгол Улсын “Хүлээн авагч хот”-оор бүртгүүлээд байгаа нь хоёр улсын ард иргэд хоорондын солилцоо нэн өндөр түвшинд хүрснийг илтгэн харуулж байгааг тэмдэглэн сайшаав. Хоёр улсын Ерөнхий сайд нар 2020 оны Олимп, Паралимпийн наадамд оролцох баг тамирчиддаа амжилт хүсэхийн сацуу тус наадмыг биеийн тамир, спорт, иргэд хоорондын солилцоог улам бүр гүнзгийрүүлэх талбар болгоно гэдэгт санал нэгдэв.

12. Ерөнхий сайд нар бүс нутаг болон олон улсын тавцан дахь хуулийн засаглал, энх тайван, тогтвортой байдал, хамтын ажиллагаа болон хөгжил цэцэглэлтийг хангахад НҮБ-ын дүрэм, олон улсын хууль журмын суурь зарчим болон төрт улсын тусгаар тогтнол ба бүрэн эрхт байдлыг хүндэтгэх явдалд суурилсан чөлөөт, нээлттэй олон улсын дэг журмыг чанд мөрдлөг болгохын ач холбогдлыг онцлов.

13. Японы тал “Чөлөөт, нээлттэй Энэтхэг, Номхон далай”-г цогцлоох чиглэлд гаргаж буй хүч чармайлтынхаа талаар мэдээлж, Монгол Улстай хөгжүүлж болохуйц хамтын ажиллагааны талаар цаашид хоёр улсын зөвлөлдөх уулзалт, Монгол Улс, АНУ, Япон Улсын гурван талт уулзалт болон бусад механизмаар дамжуулан үргэлжлүүлэн санал солилцох эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлэв. Монголын тал Ази, Номхон далайн бүс нутгийн интеграцчлалд идэвхтэй оролцох сонирхолтой байдгаа нотолж, Япон Улсын “Чөлөөт, нээлттэй Энэтхэг, Номхон далай” үзэл санаа нь тус бүс нутгийн улс орнуудыг хамарсан, интеграцчлалыг дэмжсэн, нээлттэй хөгжил, хамтын ажиллагааны санаачилга хэмээн ойлгож байгаагаа тэмдэглэв. Хоёр улсын Ерөнхий сайд нар “Чөлөөт, нээлттэй Энэтхэг, Номхон далай”-г цогцлоох чиглэлд хамтран ажиллахаар санал нэгдэв.

14. Хоёр улсын Засгийн газар олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах хүрээнд хамтын ажиллагаагаа бэхжүүлэхийн хамт НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шинэчлэлийн асуудлаарх Засгийн газар хоорондын яриа хэлэлцээг эрчимжүүлж, уг шинэчлэлийг ойрын хугацаанд хэрэгжүүлэх чиглэлд хамтран ажиллана. Япон Улс НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн болохыг Монгол Улсын Засгийн газар цаашид ч тууштай дэмжинэ.

15. Хоёр улсын Ерөнхий сайд нар НҮБ-ын Далайн эрх зүйн тухай

конвенц (UNCLOS)-д тусгагдсан зүйлсийг хамруулсан олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд нийцүүлж, хуульд суурилсан эрх чөлөөт, нээлттэй далайн дэг журмыг дэмжих амлалтаа нотлов.

Хоёр улсын Ерөнхий сайд нар усан болон агаарын хөлөг онгоцоор чөлөөтэй зорчих, худалдааг саадгүй хийх, хүлээцтэй байх, эрх зүйн болон дипломат үйл явцыг бүрэн хүндэтгэж, олон улсын эрх зүйд суурилсан энхийн замаар маргааныг шийдвэрлэхийн чухлыг онцлов.

Мөн хоёр улсын Ерөнхий сайд нар өнөөгийн нөхцөл байдлыг өөрчлөх, хурцадмал байдлыг нэмэгдүүлэхээс урьдчилан сэргийлэх зарчмыг баримталж ажиллах нь чухал гэдэгт санал нэгдэв.

16. Хоёр улсын Ерөнхий сайд нар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын чадавхийг бэхжүүлэхэд үргэлжлүүлэн хамтран ажиллахаа нотлов.

17. Ерөнхий сайд Ш.Абэ Япон Улстай нэгдмэл үнэт зүйлстэй Монгол Улс нь бүс нутаг, олон улсын хамтын нийгэмлэгт улам бүр идэвхтэй үүрэг гүйцэтгэнэ гэдэгт найдаж буйгаа илэрхийлэв. Ерөнхий сайд Ш.Абэ Монгол Улсын Зүүн Азийн дээд түвшний уулзалтад нэгдэх эрмэлзлийг нааштай үнэлж, Япон Улс тус уулзалтад Монгол Улсыг нэгдэхийг дэмжиж байгаагаа илэрхийлэв.

18. Хоёр улсын Ерөнхий сайд нар Солонгосын хойгт сүүлийн үед өрнөж буй нааштай үйл явцууд, түүний дотор АНУ-БНАСАУ болон БНСУ-БНАСАУ-ын хооронд болсон дээд түвшний уулзалтууд нь маргаантай асуудлуудыг цогцоор шийдвэрлэхэд чиглэсэн алхам болсон хэмээн сайшаан тэмдэглэв.

Хоёр улсын Ерөнхий сайд нар БНАСАУ үй олноор хөнөөх бүхий л зэвсэг, бүхий л тусгалын баллистик пуужингаасаа бүрмөсөн, хяналттайгаар, эргэлт буцалтгүйгээр ангижрах асуудлыг баталгаажуулахын тулд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолуудыг НҮБ-ын нийт гишүүн улс орон бүрэн хэрэгжүүлэхийн чухлыг нотлов. Хоёр улсын Ерөнхий сайд нар маргаантай асуудлуудыг дипломат аргаар шийдвэрлэхийг дэмжиж байгаагаа мөн нотлов.

Монгол Улс эдгээр зорилтын хүрээнд “Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачилгыг дэвшүүлж, олон улсын бага хурлыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байгаа бөгөөд японы тал бүс нутгийн асуудлуудыг хэлэлцэх Зүүн хойд Азийн энх тайван, тогтвортой байдлыг

хангахад чиглэсэн “Улаанбаатарын яриа хэлэлцээ” зэрэг Монгол Улсын санаачилга, байр суурийг ойлгон хүлээн авч байгаагаа илэрхийлэв.

Ерөнхий сайд Ш.Абэгийн зүгээс хулгайлагдсан иргэдийн асуудлыг шийдвэрлэхийн ач холбогдлыг онцолж, Ерөнхий сайд У.Хүрэлсүх энэхүү асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн Япон Улсын байр суурийг дэмжихээ илэрхийлэв. Хоёр улсын Ерөнхий сайд нар хулгайлагдсан иргэдийн асуудлыг богино хугацаанд шийдвэрлэхийн төлөө үргэлжлүүлэн нягт хамтран ажиллана гэдэгт санал нэгдэв.

19. Ерөнхий сайд У.Хүрэлсүх Азийн Буддистуудын энх тайвны бага хурлын 50 жилийн ой тохиож буй 2019 онд Монгол Улсын Засгийн газрын санаачилгаар Улаанбаатар хотноо Олон улсын хурал зохион байгуулахаар төлөвлөж байгааг мэдэгдэв. Энэ мэт Монгол Улсын олон улсын хамтын нийгэмлэгийн энх тайван, тогтвортой байдалд хувь нэмэр оруулахад чиглэсэн эрмэлзлийг Ерөнхий сайд Ш.Абэ сайшаав.

Монгол Улсын Ерөнхий сайд Япон Улсын Ерөнхий сайд

Ухнаагийн Хүрэлсүх Абэ Шинзо

Япон Улс Токио хот

2018 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Х.БАТТУЛГА ДОРНЫН ЭДИЙН ЗАСГИЙН IV ЧУУЛГА УУЛЗАЛТЫН НЭЭЛТИЙН ҮЕЭР ХЭЛСЭН ҮГ

(Владивосток хот 2018 оны 9 дүгээр сарын 12)

ОХУ-ын Ерөнхийлөгч, Эрхэмсэг ноён Владимир Владимирович Путин,
БНХАУ-ын Дарга Эрхэмсэг ноён Си Жиньпин,

Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэ, БНСУ-ын Ерөнхий сайд ноён Ли Наг Ён,

Хатагтай, ноёд оо,

Дорнын эдийн засгийн чуулга уулзалтад дахин урьсан ОХУ-ын Ерөнхийлөгчид талархал илэрхийлье.

Жил бүр зохион байгуулагддаг Дорнын эдийн засгийн чуулга уулзалт нь Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын хамтын ажиллагааны цаашдын чиглэлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой яриа хэлэлцээний талбар болж байна. Чуулга уулзалтын хүрээ, оролцогчдын түвшин жил ирэх тутам өргөжиж байна. Хөрш орнууд болох ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, бүх талын хамтын ажиллагааг тогтвортой хөгжүүлэх, бүс нутгийн улс төр, эдийн засгийн интеграцид хамрагдах нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлүүд юм. Энэ оны 6 дугаар сард Хятадын Чиндао хотноо ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нартай хоёр болон гурван талын уулзалт хийж, хамтын ажиллагааг улам бүр гүнзгийрүүлэх эрмэлзлээ нотолсон.

Хатагтай, ноёд оо,

Энэ удаагийн чуулга уулзалт “Алс Дорнод: Боломжийн хязгаарыг тэлэх нь” сэдвийн дор зохиогдож байна. Чуулга уулзалтад оролцогч орнууд хоёр болон олон талын хамтын ажиллагааг хөгжүүлэх шинэ боломжийг эрэлхийлэх зорилготой гэж миний бие харж байна. ОХУ-ын Алс Дорнодын бүс нутаг нь Монгол Улсын хувьд бүс нутгийн орнуудтай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх, эдийн засгийн интеграцид хамрагдах нэг чухал гарц, боломж юм.

Монгол Улс хоёр хөрш орны нутаг дэвсгэрээр төмөр замаар дамжин тээвэрлэлт хийж, мөн хөрш орнуудынхаа далайн боомтыг ашиглан дэлхийн зах зээлд бүтээгдэхүүнээ гаргахаар төлөвлөсөн. Энэ зорилгоор Монгол Улсын Их Хурал 2010 онд Төмөр замын тээврийн талаар

баримтлах бодлогыг баталсан. Энэ бодлого амжилттай хэрэгжиж байна. Энэ оны зургадугаар сард ОХУ-тай “Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулсан нь том алхам боллоо. Үүнээс гадна манай улс “Монгол Улс, БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжин далайд гарах, буцах болон дамжин өнгөрөх тээвэр хийх тухай хэлэлцээр”, “Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай Монгол, Хятадын Засгийн газар хоорондын хэлэлцээр” зэрэг чухал баримт бичгийг БНХАУ-тай байгуулаад байна.

Эдгээр хэлэлцээрийг байгуулснаар хөрш орнуудын нутгаар дамжин өнгөрч, далайн боомтуудаар дамжуулан Зүүн Хойд Азийн болон бусад улсуудтай худалдаа хийх боломж нээгдлээ. Монгол Улсыг далайд гарах гарцыг нээсэн, олон улсын худалдаа эдийн засгийн интеграцид нэгдэх боломжийг олгосон чухал гэрээ хэлэлцээрийг байгуулж дэмжлэг үзүүлсэн ОХУ-ын Ерөнхийлөгч ноён В. В. Путин, БНХАУ-ын Дарга Си Жиньпин нарт талархал илэрхийлье.

Монгол Улс нь хөрш орнууд, бүс нутгийн орнуудтай улс төрийн харилцааны өндөр түвшинд хүрсэн, аливаа хурцадмал, маргаантай асуудалгүй орон билээ. Энэ ч үүднээс “Улаанбаатарын яриа хэлэлцээ” зэрэг бүс нутгийн орнуудын харилцан ойлголцлыг бэхжүүлэх, яриа хэлэлцээг гүнзгийрүүлэхэд чиглэсэн санаачилга дэвшүүлэн ажиллаж байна. Улс төрийн харилцааны өндөр түвшинг бататгахын зэрэгцээ бүс нутгийн орнуудтай хөгжлийн бодлогоо уялдуулж, томоохон төсөл хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэхийг зорьж байна. Тухайлбал, “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор” байгуулахаар ажиллаж байгаа. Хөтөлбөрийн хүрээнд тодорхой төслүүдийн хэрэгжилтийг эхлүүлэх талаар Чиндао хотод болсон уулзалтаар Путин Ерөнхийлөгч, Си Жиньпин дарга нартай ярилцсан.

ОХУ-аас БНХАУ руу барихаар төлөвлөж байгаа байгалийн хийн хоолойг Монгол Улсаар дамжуулан өнгөрүүлэх асуудлаар бид хамтран ажиллахад бэлэн байна. Монгол Улсын энэ хүсэлтийг дэмжсэн ОХУ-ын Ерөнхийлөгч ноён Владимир Владимирович Путин танд талархаж байна. БНХАУ-ын Дарга Си Жиньпин дэмжинэ гэдэгт найдаж байна. Бид энэ асуудлаар баталгаатай эрх зүйн орчин бий болгоход бэлэн байна. Манай улс түүнчлэн худалдаа, хөрөнгө оруулалтын гол түнш орнуудтайгаа хамтын ажиллагааг улам өргөжүүлэх, хөрөнгө оруулалтын илүү таатай нөхцөл бүрдүүлэх үүднээс Япон улстай “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр”-ийг 2015 онд байгуулсан бол Бүгд Найрамдах

Солонгос Улстай мөн ийм хэлэлцээр байгуулах хамтарсан судалгааны ажлыг дуусгаад байна.

Мөн Евразийн эдийн засгийн холбоотой Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах үндэслэлийг хамтран судлахаар ярилцаж байна.

Хатагтай, ноёд оо,

Монгол Улсын эдийн засгийн уналт зогсож, өсөлт тогтворжиж байна. Дотоодын Нийт Бүтээгдэхүүний өсөлт 2017 онд 5.3, 2018 оны эхний хагаст 6.3 хувьд хүрсэн. Бид манай эдийн засгийн уул уурхайн салбараас хамааралтай эмзэг байдлыг бууруулахаар зорьж байна. Гол түнш орнуудтай худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, түүний дотор Монголоос гаргах уул уурхайн бус, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх бодлого баримталж байна.

Монгол Улс бүс нутгийн орнуудтай олон талын болон хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлэх бодлого баримтлахыг энэ индрээс нотлохыг хүсч байна. Эдийн засгийн үр ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэхийн тулд тодорхой санал дэвшүүлье. Зүүн хойд Азийн орнуудыг цахилгаан эрчим хүчээр хангах, оргил цагийн ачаалал хуваалцсан, нөөц ашиглалтын оновчтой шийдэл болох “Зүүн хойд Азийн эрчим хүчний супер сүлжээ” төслийн ажлыг хамтран, цаг алдалгүй, шуурхай эхлүүлэхийг уриалж байна.

Бид энэхүү супер сүлжээний бодит эхлэл болгож, Монгол Улс-Хятад улс хамтарсан эрчим хүчний цогцолбор болон үлэмж өндөр хүчдэлийн шугамын төсөл эхлүүлж байгааг мэдэгдэхэд таатай байна. Энэхүү цогцолбор нь нар, салхи, нүүрсний эхүүсвэрээс нийт таван мянга гурван зуун тавин (5350) МВт-ын суурилагдсан хүчин чадалтай станцуудаас бүрдэх юм. Мөн Монгол Улсаас Хятад улс руу 1500 км үлэмж өндөр хүчдэл бүхий цахилгаан дамжуулах тогтмол гүйдлийн шугам татна.

Цогцолборын судалгааны ажил, ТЭЗҮ бэлтгэгдэж дууссан бөгөөд удахгүй бүтээн байгуулалтын ажил эхлэх болно.

Ер нь Монгол Улс уудам нутагтай учир нар, салхины эх үүсвэрийн цахилгаан үйлдвэрлэл нь улирлын болон цагийн бүсийн зөрүүнээс үүдэн Япон, Солонгос улсуудын оргил цагийн ачааллыг хөнгөвчлөх, түүнээс гадна хураагуурын үүрэг гүйцэтгэх боломжтой. Сэргээгдэх эрчим хүч хэрэглэх нь аль ч улсын хэрэглэгчдэд таалагдах биз ээ. Энэхүү сүлжээ нь Зүүн хойд Азийн бүс нутгийг хамарсан эрчим хүчний интеграц болох бөгөөд Азийн супер сүлжээний эхний шат гэж харж

байна.

Зүүн хойд Азийн супер сүлжээ нь бүс нутгийн улс орнуудын хамтын ажиллагаа, хөгжлийн шинэ боломжийг нээхийн зэрэгцээ бүс нутгийн бүх орнуудын итгэлцлийг бэхжүүлэх чухал хүчин зүйл болно гэж үзэж байна.

Чуулга уулзалтын үйл ажиллагаанд өндөр амжилт хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЗИ-ЕВРОПЫН УУЛЗАЛТЫН ДЭЭД ТҮВШНИЙ
12 ДУГААР УУЛЗАЛТАД МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Х.БАТТУЛГЫН ХЭЛСЭН ҮГ**

Нэгдүгээр бүгд хуралдаан: “Ирээдүйг хамтран бүтээх нь: АСЕМ бол бүх нийтийг хамарсан өсөлт болон тогтвортой уялдаа холбоог хангахад тэргүүлэх хүчин”

Брюссель хот, 2018 оны 10 дугаар сарын 19

Эрхэм хүндэт төр, засгийн тэргүүн нар аа,

Хүндэт төлөөлөгчид өө,

Ноёд хатагтай нар аа,

Даяаршил, өндөр технологийн хөгжил, нөөцийн хомсдол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг орчны хувьсал өөрчлөлтөөс үүдэж энэ зуунд дэлхий нийтийн өмнө олон сорилт бэрхшээл тулгараад байгаа билээ. Тиймээс олон улсын хамтын нийгэмлэгээс Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр, Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Парисын хэлэлцээр зэрэг түүхэн баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж эхлээд даруй гурван жил өнгөрч байна.

Өнөөдөр энд чуулж байгаа Ази, Европын уулзалт бол бидний үндэсний болон бүс нутаг, олон улсын түвшний хөгжлийн алсын хараа, бодлого, хөтөлбөрөө хэрэгжүүлэх нэгэн чухал арга механизм гэдэгтэй бүгд санал нийлэх биз ээ.

Түүний дотор 2016 онд болсон Дээд түвшний 11 дүгээр уулзалтын Улаанбаатарын тунхаглалд заасны дагуу АСЕМ-ын орнууд Тогтвортой хөгжлийн төлөөх түншлэлээ бэхжүүлэх, уялдаа холбоог бүхий л хүрээнд хөгжүүлэх чиглэлээр өнгөрсөн хоёр жилд идэвхтэй хамтран ажиллалаа.

Хүндэт төлөөлөгчид өө,

Монгол Улсын хувьд нэг талаас АСЕМ-ын үйл ажиллагаа, хөгжилд хувь нэмрээ оруулах, нөгөө талаас манай улсын хөгжлийн тэргүүлэх зорилтуудын хэрэгжилтэд чухал хувь нэмэр оруулж байгаа АСЕМ-ын хүрээнд хамтын ажиллагаагаа эрчимжүүлэхийг эрмэлздэг.

Үнэхээр ч Монгол Улсын улс төр, эдийн засаг, соёлын хамгийн том түншүүд бол АСЕМ-ын орнууд байдаг. Тиймээс эх газрын хатуу уур амьсгал, далайд гарцгүй байрлал, сүүлийн жилүүдийн эдийн

засгийн хүндрэл зэрэг өөрийн орны өмнө тулгарч буй олон сорилт, бэрхшээлийг даван туулахад АСЕМ-ын түншүүд, хөрш улсуудаа түшиж тулан, олонталын болон хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлэх бодлого баримталж байна.

Бид сүүлийн арав гаруй жил, түүний дотор 2016 оноос хойш Монгол-Орос-Хятад гурван улсын дэд бүтцийн холбоосууд, эдийн засгийн коридорыг байгуулах чиглэлээр идэвхтэй ажиллаж тодорхой хэлэлцээрүүдийг байгуулснаар хөрш орнуудын нутгаар дамжин өнгөрч, далайн боомтуудаар дамжуулан Зүүн Хойд Азийн болон бусад улстай худалдаа хийх боломж өсөн нэмэгдлээ. “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрийн хүрээнд төслүүдхэрэгжүүлж эхлэх, ОХУ-аас БНХАУ руу барихаар төлөвлөж байгаа байгалийн хийн хоолойг Монгол Улсаар дамжуулан өнгөрүүлэх болон Евразийн эдийн засгийн холбоотой Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлын үндэслэлийг хамтран судлах зэрэг олон ажлыг ойрын хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Түүнчлэн Монгол Улс АСЕМ-ын эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн сүлжээ байгуулахыг дэмждэг ба манай улсын санаачилгаар байгуулагдсан Улаанбаатарт төвтэй “Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төв”-өөр дамжуулан тус сүлжээний үйл ажиллагаанд хувь нэмэр оруулахыг зорьж байна.

Хүндэт төлөөлөгчид өө,

Зүүн Хойд Азийн бүс нутаг төдийгүй дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг бататган бэхжүүлэхэд Солонгосын хойгийн тогтвортой байдлыг хангах явдал нэн чухал юм. Тиймээс бид бүс нутгийн аюулгүй байдал, тогтвортой байдлын асуудлаарх яриа хэлэлцээний механизмыг хөгжүүлэхийг зорьж Улаанбаатарын яриа хэлэлцээ зэрэг хурал, арга хэмжээг санаачлан тууштай хөгжүүлж ирсэн.

Монгол Улс сүүлийн үед Солонгосын хойгт гарч буй нааштай өөрчлөлтүүдийг талархан сайшааж байгаа бөгөөд талуудын яриа хэлэлцээ, хүчин чармайлт нь бүс нутаг, дэлхий дахины аюулгүй байдалд эерэгээр нөлөөлнө хэмээн итгэж байна.

Бид Зүүн Хойд Азийн хамтын ажиллагааг улс төр, аюулгүй байдлын төдийгүй эдийн засаг, соёлын зэрэг бусад хүрээнд өргөжүүлэх санал санаачилга дэвшүүлэх, бүс нутгийн орнуудын энэ чиглэлийн санаачилгыг дэмжих, нэгдэх чиглэлээр ажиллаж байна.

Миний бие өнгөрсөн сард Владивосток хотноо болсон Дорны эдийн засгийн форумын үеэр цахилгаан эрчим хүчээр хангах, оргил цагийн ачаалал хуваалцсан, нөөц ашиглалтын оновчтой шийдэл болох “Зүүн Хойд Азийн эрчим хүчний супер сүлжээ” төслийн ажлыг хамтран, цаг алдалгүй, шуурхай эхлүүлэхийг уриалсан.

Хүндэт төлөөлөгчид өө,

АСЕМ бол цаашид бидний хамтран тодорхойлсон хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдэд суурилсан ажил хэрэгч механизм байх ёстой. АСЕМ-ын үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхийн тулд олон улсын тавцан дахь өнөөгийн тулгамдаж буй асуудлуудад АСЕМ-ын орнууд нэгдсэн байр суурьтай хандах нь чухал гэсэн түнш орнуудын саналыг бид бүрэн хуваалцаж, дэмжиж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХ НҮБ-ЫН ЕРӨНХИЙ
АССАМБЛЕЙН 73 ДУГААР ЧУУЛГАНЫ ЕРӨНХИЙ САНАЛ
ШҮҮМЖЛЭЛД ХЭЛСЭН ҮГ**

(Нью-Йорк хот, 2018 оны 9 дүгээр сарын 29)

Чуулганы дарга аа,
Ноён Ерөнхий нарийн бичгийн дарга аа,
Эрхэм Хатагтай, ноёд оо,
Хүндэт төлөөлөгчид өө,

Юуны өмнө Ерөнхий Ассамблейн 73 дугаар чуулганы даргаар гишүүн орнуудын дэмжлэгийг авч сонгогдсон хатагтай Гарсес танд чин сэтгэлийн баяр хүргэж байгааг минь хүлээн авна уу.

Таныг энэхүү хариуцлагатай, чухал үүрэг даалгавраа гүйцэтгэхэд манай төлөөлөгчид бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг чармайн ажиллах болно.

Чуулганы дарга аа,

Өнөөдөр бид хавтгай, глобалчлагдсан, харилцан хамаарал бүхий дэлхий дээр амьдарч байна. Бидний амьдрал улам бүр цахимжиж, технологийн дэвшил амьдралын хэв маягийг тодорхойлж эхэллээ. Нэг талаас дэлхий ертөнц ийнхүү хөгжиж байгаа хэдий ч зөрчил тэмцэл, өлсгөлөн ядуурал, тэгш бус байдал зэрэг тулгамдсан асуудал, зовлон бэрхшээл тулгарсаар байна.

Тиймээс НҮБ-ын үйл ажиллагааг хүн бүрт хүргэх, илүү тогтвортой, амар амгалан, эрх тэгш дэлхий ертөнцийг бий болгох талаар хэлэлцэж буй энэ удаагийн Ерөнхий санал шүүмжлэлд Монгол Улсын Засгийн газрын тэргүүний хувиар оролцож байгаадаа таатай байна.

НҮБ өнгөрсөн 73 жилийн хугацаанд даян дэлхийн ойлголцол, шударга ёс, энхийн төлөөх үйлсээрээ гишүүн орон бүртээ хүрч чадсан. Цаашид тус байгууллага Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд дэлхийн хүн бүрт бодлого, үйл ажиллагаагаа хүргэх зорилго тавьсан нь цаг үеэ олсон, НҮБ-ын суурь зарчимд нийцсэн хандлага гэж Монгол Улс үзэж байна.

Хөгжил цэцэглэлтийн гадна хэнийг ч үл орхихын төлөө ажиллах бидний хамтын үйлсийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррес өөрийн шинэчлэлийн бодлогоороо манлайлж байгаад

Монгол Улс талархалтай байна.

Ялангуяа НҮБ-ын энх тайван, аюулгүй байдлын бүтцийн шинэчлэлийн хүрээнд урьдчилан сэргийлэх болон эвлэрүүлэн зуучлах чадавхийг нэмэгдүүлэх, энхийг сахиулах ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, хөгжлийн системийн шинэчлэлийн хүрээнд уялдаа холбоо, үр дүн, хариуцлага, ил тод байдлыг дээшлүүлэх талаар гаргаж буй бүтээлч санаачлага, үйл ажиллагааг сайшаан дэмжиж байна.

Чуулганы дарга аа,

Өнгөрсөн 2017 онд дэлхий дахины цэрэг зэвсгийн зардал 1.7 их наяд ам.долларт хүрсэн нь өмнөх оноос өссөн төдийгүй хүйтэн дайн дууссанаас хойших хамгийн өндөр дүн болохыг Стокгольмын Энх тайвны судалгааны хүрээлэнгээс гаргасан судалгаанд дурджээ. Дэлхий дахинд зэвсэглэлээр хөөцөлдөх явдал буурахгүй, зарим бүс нутагт зөрчил тэмцэл гүнзгийрч, тогтворгүй байдлыг өдөөх, ялангуяа зэвсэгт мөргөлдөөнд техник, технологийн үсрэнгүй дэвшлийг ашиглаж байгаа нь байдлыг улам аюултай болгож байна.

Монгол Улс аливаа зөрчил тэмцлийг хүчээр бус, тайван замаар, яриа хэлэлцээний аргаар шийдвэрлэх ёстой гэсэн зарчмын байр суурийг үргэлж баримталж ирсэн билээ.

Бид Монголчуудын харилцаа, сэтгэлгээний соёл, шашин шүтлэг нэвт шингэсэн энхийг эрхэмлэх үзэл санаандаа тулгуурлан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулган болон бусад хурал, зөвлөгөөнд оролцохдоо энх тайван, аюулгүй байдлын төлөөх бусад улс орнуудын санал санаачлага, үйл ажиллагааг тууштай дэмжиж, энэ байгууллагын хариуцлагатай гишүүн орон байхыг ямагт чармайж ирсэн.

Монголчууд бид энх тайван, амар амгалан байдал үгүйлэгдэж, гамшиг зовлон тохиолдсон улс орон, ард түмэнд ямагт туслахыг эрмэлздэг.

Тэртээ 1978 оноос жил бүрийн 10 дугаар сарын 24-30-нд дэлхий дахинаа тэмдэглэж ирсэн “Зэвсэг хураах долоо хоног”, 1984 онд баталсан “Улс түмний энх тайван орших эрхийн тухай тунхаглал” тогтоолуудыг санаачилж, 1992 оноос нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс хэмээн тунхаглаж, эл статусаа баталгаажуулсаар ирсэн нь бүс нутаг болон даян дэлхийн энх тайван, аюулгүй байдалд бидний оруулсан хувь нэмрийн нэгээхэн хэсэг билээ.

Тэнхлүүн явахад тэмээгээр тусалснаас тэвдэж явахад тэвнээр тусал

гэж монголчууд хэлцдэг. Монголчууд бид энх тайван, амар амгалан байдал үгүйлэгдэж, гамшиг зовлон тохиолдсон улс орон, ард түмэнд ямагт туслахыг эрмэлздэг.

Бид Солонгосын дайны үеэр БНАСАУ-ын өнчирч үлдсэн зуу зуун хүүхдийг авч, өсгөж өндийлгөж байсан бол сүүлийн хэдэн арван жилийн турш байгалийн гамшиг, террорист халдлагад өртсөн улс орнуудад өөрсдийн боломж, нөөцийн хэрээр тусалж, бүс нутгийн зарим улсад хөгжлийн тусламж үзүүлж, ардчилсан шилжилтийн туршлага, сургамжаа хуваалцаж ирсэн.

Энэ жил 70 жилийн ойгоо тэмдэглэж буй, дэлхийн энх тайван, аюулгүй байдалд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд Монголын цэргийн албан хаагчид 2002 оноос, цэргийн багууд 2006 оноос хойш үүрэг гүйцэтгэж байна. Өдгөө монголын энхийг сахиулагчид дэлхийн хамтын нийгэмлэгээс “гуйвшгүй, төвшин, чадвартай” гэсэн үнэлгээ авсанд бид бахархалтай байдаг.

НҮБ-д цэрэг хандивлагч эхний 30 улсын нэг, хүн амдаа харьцуулсан энхийг сахиулагчдын тоогоороо түүнээс ч илүү эрэмбэтэй Монгол Улс цаашид ч энхийг сахиулах ажиллагаанд оролцох оролцоогоо нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа бөгөөд Ерөнхий нарийн бичгийн даргын “Энхийг сахиулахын төлөөх үйл ажиллагаа” санаачилгыг сайшаан дэмжиж байна.

Чуулганы дарга аа,

Монгол Улсын аюулгүй байдал, хөгжил дэвшилтэй салшгүй холбоотой Зүүн Хойд Азийн асуудал нь манай гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг яах аргагүй мөн.

Энэ жил болж өнгөрсөн хоёр Солонгосын болон бусад дээд хэмжээний уулзалт, яриа хэлэлцээний үйл явцыг Монгол Улс туйлын анхааралтай ажиглан сайшааж, Зүүн Хойд Азид итгэлцэл, энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх чиглэлд нааштай өөрчлөлтүүд гарна хэмээн итгэж байна. Бид үйл явцыг зөвхөн ажиглаад зогсохгүй үүнд өөрийн хувь нэмрийг оруулахыг зорьж байна.

Монгол Улс 1980-аад оноос Зүүн Хойд Азийн яриа хэлэлцээний механизмыг бий болгох саналыг тууштай дэвшүүлж ирсэн. 2014 оноос Зүүн Хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээ” олон улсын бага хурлыг жил бүр зохион байгуулж ирлээ.

Өдгөө бага хурлын нэр хүнд өсөж, яриа хэлцлийн цар хүрээ өргөжин бүс нутгийн аюулгүй байдал, эрчим хүч, дэд бүтцийн сүлжээ, ногоон хөгжил, хүмүүнлэгийн хамтын ажиллагааны боломж зэрэг өргөн хүрээний асуудлыг хэлэлцдэг, дэд бүсийн бүх улсын оролцоог хангасан, албаны хүмүүс болон эрдэмтэн судлаачдын өргөн оролцоотой нээлттэй механизм болон төлөвшиж байна.

Нөгөө талаас Ази тив нь дэлхийн хамгийн гамшигт өртөмтгий бүсийн нэг юм. Бид болзошгүй гамшгийн аюулд өртөх эмзэг байдлаа арилгах, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр бүс нутгийн хамтын ажиллагааг дэмжиж идэвхтэй хамтран ажилладаг.

Энэ хүрээнд бид Зүүн Хойд Азийн гамшгийн эрсдэлийг бууруулах платформыг Монгол Улсад байгуулах санаачлагыг дэвшүүлж үүнийгээ “Улаанбаатарын яриа, хэлэлцээ” олон улсын удаа дараагийн бага хурлууд, мөн энэ оны 7 дугаар сард Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын II бага хурлын үеэр тус тус хэлэлцүүлснийг бүс нутгийн орнууд дэмжин хүлээж авч бодит ажил болгохын төлөө хамтран ажиллаж байна.

Саахалт айлын санаа нэг, айл хүний амь нэг гэж монголчууд хэлдэг. Монгол Улс хоёр хөрштэйгээ харилцаагаа стратегийн түвшинд хөгжүүлэх, тэдний зүгээс бүс нутгийн хэмжээнд гаргасан санаачилгыг анхааралтай ажиглаж, идэвхтэй оролцох байр суурь баримталдаг.

Манай улс “Бүс ба зам” санаачилгыг дэмжсэн зорчих нөхцлийг хөнгөвчлөх, мөн “Бүс ба зам” санаачилгад хамрагдаж буй улс орнуудын залуу дипломат, судлаачдын бүтээлийг дэмжих зорилго бүхий “Энх тайван, дэвшил, хөгжил цэцэглэлтийн төлөөх шагнал”-ыг бий болгох санаачлагыг тус тус дэвшүүлсэн.

Чуулганы дарга аа,

Өнөөдөр дэлхий дээрх цөөнгүй тооны зэвсэгт мөргөлдөөн, зөрчил тэмцэл, алан хядах ажиллагааны гол шалтгаан нь иргэншил, шашин хоорондын зөрчил байгаатай хэн ч маргахгүй биз ээ.

Монголын эзэнт гүрэн нь бүх шашныг хүлцэх, хүндлэх асар том бүс нутаг байсан нь өнөөгийн ертөнцөд маш сургамжтай.

Монгол бол хэдэн мянган жилийн түүхэндээ шашны болоод үндэстэн хоорондын дайн гаргаж байгаагүй цөөн улсын нэг юм. Тэртээ 812

жилийн өмнө байгуулагдсан Их Монгол улсад хуулийг бүхнээс дээр тавьж, шүтэж бишрэх эрх чөлөөг хөхиүлэн дэмждэг, христ, лал, күнз, буддын сургаалтнууд тэгш эрхтэй, үзэл суртлын дайнгүй зэрэгцэн оршдог байжээ.

Өөрөөр хэлбэл, Монголын эзэнт гүрэн нь бүх шашныг хүлцэх, хүндлэх асар том бүс нутаг байсан нь өнөөгийн ертөнцөд маш сургамжтай юм.

Хожмоо XX зууны “хүйтэн дайн”-ы үед ч монголчууд 1969 онд анх байгуулагдсан Азийн Буддистуудын энх тайвны бага хурлын хүрээнд даян дэлхийд энх тайвныг тогтооход олон улсын бурхны шашинтнуудын дуу хоолойг нэгтгэхийн төлөө, үзэл суртлын талцал хуваагдлын эсрэг идэвхтэй үйл ажиллагаа явуулж тодорхой үр дүнд хүрч байсан юм.

Эдүгээ Азийн Буддистуудын энх тайвны багахурал шиг яриа хэлэлцээний механизмын орон зай үгүйлэгдэж байна.

Тиймээс бид НҮБ-ын Эдийн засаг нийгмийн зөвлөлд зөвлөх статустай Азийн Буддистуудын энх тайвны бага хурлын үйл ажиллагааг бүс нутаг болон олон улсын түвшинд дахин идэвхжүүлэх, Зүүн Хойд Ази болон Төв Азийг холбож буй улсын хувьд Шашны эрх чөлөөний чуулганыг ирэх онд өөрийн эх орондоо зохион байгуулах санал, санаачилга гаргаж буйгаа НҮБ-ын индэр дээрээс мэдэгдэж байна.

Бидний санал, санаачилга өнөө цагийн энх тайвны соёл, бусдын шашныг хүлцэх, шашин шүтлэгийн эрх чөлөөний хөгжлийн шинэ өрнөлд бодит хувь нэмэр оруулна хэмээн итгэж байна.

Чуулганы дарга аа,

Манай улс бол үндэсний түвшний Тогтвортой хөгжлийн зорилтуудыг түүчээлж баталсан орны нэг юм. 2016 оны 2 дугаар сард баталсан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-д Монгол Улс 2030 он гэхэд ардчилсан засаглалаа бэхжүүлж, экологийн тэнцвэрт байдлыг ханган, ядуурлын бүх хэлбэрийг устгаж, дээд эрэмбийн дундаж орлоготой улс орны эгнээнд шилжих зорилт дэвшүүлсэн юм.

Бид Тогтвортой хөгжлийн зорилтуудыг үндэсний хөгжлийн бусад бодлого, баримт бичгүүдтэй уялдуулж, богино, дунд хугацааны төлөвлөгөө, хөтөлбөрт хуваан үе шаттай хэрэгжүүлж эхлээд байна.

Түүнчлэн хөгжлийн санхүүжилтыг баталгаажуулахын тулд Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн дагуу Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх, олон талыг хамарсан ажлын хэсгийн судалгаанд

үндэслэн Тогтвортой хөгжлийн зорилтуудынүндэсний түвшний шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлон батлах чиглэлээр ажиллаж байна.

Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засгийн өсөлт сэргэж, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт нэмэгдэж, төсвийн орлого давж биеллээ.

Эдийн засгийн өсөлт хүмүүсийн амьдралд шууд тусгалаа олохгүй байгаа нь манай Засгийн газрын өмнө тулгарч байгаа нэг сорилт.

Гэвч Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай, түүхий эдийн үнэ ханшийн өөрчлөлтөд мэдрэмтгий тул эдийн засгийн өсөлт урт хугацаанд тогтвортой бус, хэлбэлзэл ихтэй байгаа нь Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг тогтворгүй болгох, түүхий эдийн үнэ ханш буурсан жилүүдэд хөрөнгө оруулалт буурах зэрэг бодит эрсдэлүүдийг бий болгож байна.

Эдийн засгийн өсөлт хүмүүсийн амьдралд шууд тусгалаа олохгүй байгаа нь манай Засгийн газрын өмнө тулгарч байгаа нэг сорилт юм.

Тухайлбал, эдийн засгийн өсөлтийн дүнд ажилгүйдэл бага зэрэг буусан авч ядуурал буурахгүй байна. Тиймээс Засгийн газрын хөтөлбөрүүд, салбарын төлөвлөлт зэрэгт баян, ядуугийн ялгааг багасгах, ядуурлыг бууруулахтай холбоотой зорилтуудыг заавал тусгах, төр - хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих, орлого багатай өрхүүдийг цахим бүртгэл, судалгаанд бүрэн хамруулахыг зорьж байна. [Мөн асуудлыг цогцоор нь шийдвэрлэхийн тулд “Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах салбар дундын үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлага гарч байна.

Чуулганы дарга аа,

Энэ жил хүний эрхийн түүхэн дэх хамгийн чухал баримт бичиг болох Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 70 жилийн ой тохиож байна.

Манай улс эл тунхаглалын үзэл санаан доор хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр их хүчин чармайлт гаргаж амжилтад хүрсэн ба сүүлийн жилүүдэд жендэрийн тэгш байдлыг хангах, хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, хүний наймаа болон мансууруулах бодисын аюултай тэмцэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хөхиүлэн дэмжих зэрэг асуудалд

онцгой ач холбогдол өгч ирлээ.

Монгол Улс 2016-2018 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн гишүүнээр анх удаа сонгогдон ажиллаж, хүний эрхийг хамгаалах, бэхжүүлэх чиглэлээр олон улсын хамтын нийгэмлэгийн үйл хэрэгт өөрийн хувь нэмрээ оруулж байгаадаа сэтгэл хангалуун байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүн бүр эрх, эрх чөлөөг бүрэн эдэлж болохуйц нийгмийн болон олон улсын дэг журамд аж төрөх эрхтэйг заасан байдаг. Дүрвэгч, шилжин суурьшигчдын асуудлаарх 2016 оны Нью-Йоркын тунхаглалын мөрөөр гишүүн орнууд шилжин суурьшигчдын асуудлыг хоёр жилийн турш нухацтай хэлэлцсэн.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсан түүхт 70 жилийн ойн өдөр Марракеш хотноо батлагдах гэж буй Аюулгүй, дэг журамтай, хэвийн шилжин суурьшигчдын асуудлаарх дэлхий нийтийн гэрээ нь шилжин суурьшигчдын эрхийн хамгаалалд ахиц дэвшил авчрах чухал баримтбичиг болно гэж бид итгэж байна.

Дэлхий дээрх шилжин суурьшигчдын тоо сүүлийн хориод жилд эрс нэмэгдсэн ба энэ байдал цөөн хүн амтай, Зүүн Хойд Азийн өндөрлөг газарт оршдог манай улсыг ч тойрч гараагүй.

Ажилгүйдэл, ядуурал зэрэг шалтгаанаар дотоод, гадаадын шилжин суурьшилт нэмэгдэж байна.

Манай улсын хувьд 1990-ээд оноос хойш хөдөө, орон нутгаас хот, сууринг чиглэсэн шилжилт хөдөлгөөн эрс нэмэгдэж, 2017 оны байдлаар Улаанбаатар хотод нийт хүн амын 45 хувь нь оршин сууж, хүн амын цэвэр өсөлт 22.3 хувьд хүрлээ.

Нийслэл хотод ядуурал, ажилгүйдэл, эрүүл мэндийн үйлчилгээ, сургууль цэцэрлэгийн хүртээмж, агаарын бохирдол зэрэг нийгмийн асуудлууд бусад газраас илүү хуримтлагдаад байна.

Монгол Улсын иргэдийн боловсролын түвшин харьцангуй өндөр бөгөөд 2018 оны улсын төсвийн хоёрдахь том багц нь боловсролын салбарын төсөв байгаа нь төр засгаас хүний хөгжилд байнга тэргүүлэх ач холбогдол өгч ирсний илрэл юм.

Гэвч сургуулийн хүртээмж, чанар нь хүн амын өсөлт, хотжилтын хурд, орчин үеийн боловсролын жишиг, стандартыг тэр бүр гүйцэхгүй байна.

Хөдөөгийн хүн амын нягтрал буурч, сургууль, цэцэрлэгийн анги

дүүргэлт улам бүр багасч байхад, хотод байдал эсрэгээрээ байна. Өнгөрсөн жил Улаанбаатар хотод иргэдтэй хийсэн уулзалт дээр нэгэн иргэн өвөл Цельсийн хасах 20-25 хэмийн хүйтэнд 10 гаруйхан настай хүүхэд нь үдшийн 9 цагт гуравдугаар ээлжид орсон хичээлээ таран, сургуулийн автобус байхгүй учир харанхуй гудамжаар гэр рүүгээ явган алхаж ирдэг тухай ярьж байсныг би сэтгэл эмзэглэн санаж явдаг.

Нийслэлд цэцэрлэг хүрэлцэхгүй, захын дүүргийн олон сургууль гурван ээлжээр хичээллэж, өрхийн эмнэлгийн ачаалал хэтэрч, агаарын бохирдол хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, улсын хэмжээний нийт ажилгүй иргэдийн гуравны нэгээс илүү хувь нь Улаанбаатар хотод амьдарч байгаа зэрэг олон асуудлыг Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд 2030 он гэхэд үе шаттайгаар шийдвэрлэх ажлыг Засгийн газраас хэрэгжүүлж эхлээд байна.

Түүнчлэн манай улсын нийт хөдөлмөрийн насны иргэдийн 5 орчим хувь нь гадаад улсуудад ажиллаж, амьдарч байгаа бөгөөд тэдний эрүүл мэнд, нийгмийн даатгал, давхар иргэншил зэрэг асуудлыг цогцоор шийдвэрлэх, холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудал бидний өмнө тулгамдаж байна.

Чуулганы дарга аа,

Энх тайван, аюулгүй байдал, хөгжлийн асуудлын зэрэгцээ өнөөдөр хүн төрөлхтний өмнө тулгараад байгаа бас нэг том сорилт асуудал бол уур амьсгалын өөрчлөлт билээ.

Парисын гэрээг дэлхийн 179 орон соёрхон батлаад байна. Гэвч хэрэгжилт хангалтгүй, улс орнуудын хамтын үүрэг хариуцлага сул хэвээр байна. Иймд энэ асуудлыг хянан хэлэлцэх Дээд хэмжээний уулзалтыг 2019 оны 9 дүгээр сард зохион байгуулах Ерөнхий нарийн бичгийн даргын саналыг бид цагаа олсон арга хэмжээ гэж талархан дэмжиж байна.

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагавар нь дэлхийн бүх улс үндэстнүүд, түүний дотор нэн буурай хөгжилтэй, далайд гарцгүй хөгжиж буй болон арлын жижиг орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжилд илүү хурц мэдрэгдэж эхлээд байна.

Үүнтэй уялдуулан Монгол Улсын санаачилга, манлайллаар Улаанбаатар хотноо үүсгэн байгуулагдсан Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төв нь өнгөрсөн тавдугаар сард албан ёсны нээлтээ хийснийг цохон дурдахыг хүсч байна.

Далайд гарцгүй хөгжиж буй 32 орныг төлөөлсөн анхны Засгийн газар хоорондын байгууллага болох Олон улсын судалгааны төв нь эдгээр орны нийтлэг бэрхшээл, эрх ашиг, байр суурийг хамгаалах, олон улсын худалдаанаас хүртэх үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг бүхий бодлогын судалгаа, эрдэм шинжилгээ, төслийн ажлуудыг гүйцэтгэх бөгөөд та бүхнийг энэхүү төвийн үйл ажиллагааг дэмжиж, бидэнтэй урьдын адил хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Байгаль, цаг уурын эрс тэс нөхцөлтэй хөдөө аж ахуй, уул уурхайгаас ихээхэн хамааралтай эдийн засаг бүхий манай улсад газар хөдлөлт, цөлжилт, хөрсний доройтол, ой хээрийн түймэр зэрэг үзэгдлийн хамрах хүрээ, давтамж, түүний сөрөг үр дагавар нэмэгдэж байна.

НҮБ-ын Уур амьсгалын долоо хоногийн арга хэмжээний хүрээнд уур амьсгалын ийм өөрчлөлт Монгол Улсад хэрхэн нөлөөлж буйг, бусдад бас яаж нөлөөлж болохыг сэрэмжлүүлсэн “Цэнхэр алт” баримтат киноны нээлтийг зохион байгуулж байгааг та бүхэнд энэ дашрамд сонордуулахыг хүсч байна.

Эрхэм хүндэт төлөөлөгчид өө,

Дэлхийн улс үндэстнүүд бүгдээрээ нэг итгэлцэл дор нэгдмэл байж, одоо болон ирээдүйн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарлан ойлгож, хүн төрөлхтний энх тайван, аюулгүй байдал, эрх чөлөө, тогтвортой хөгжлийн төлөө дэлхий нийтээрээ хамтдаа хүчин зүтгэхийг НҮБ-ын эрхэм индэр дээрээс уриалж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**“ЗҮҮН ХОЙД АЗИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДЛААРХ
УЛААНБААТАРЫН ЯРИА ХЭЛЦЭЭ” ОЛОН УЛСЫН 5 ДУГААР БАГА
ХУРЛЫГ НЭЭЖ ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД Д.ЦОГТБААТАРЫН
ХЭЛСЭН ҮГ**

(Улаанбаатар хот, 2018 оны 6 дугаар сарын 14-15)

Ойрын өдрүүдэд өрнөж буй үйл явц дипломат үйл ажиллагааны онцгой ач холбогдлыг та бидэнд бэлэнээ харууллаа. Хоёрхон өдрийн өмнө АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трамп, БНАСАУ-ын удирдагч Ким Жөн Ын нар анх удаа нүүр тулан уулзаж, Солонгосын хойгт урт удаан хугацаанд бат бэх орших энхтайвныг цогцлоох, тус хойгийг цөмийн зэвсгээс бүрэн ангижруулах талаар тохиролцон хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурлаа. Монгол Улс энэхүү түүхэн уулзалтад баяр хүргэж байна.

Дипломат үйл хэргийг тод томруун харуулж буй нэгэн онцлог үйл явц бол Улаанбаатарын яриа хэлцээ мөн. Учир нь цөхрөл, хурцадмал байдал, зөрчилдөөн зэрэг хоолой даран ирсэн хүнд хэцүү цагт ч бид яриа хэлцээг ямагт үргэлжлүүлж ирсэн билээ. Тиймээс энэхүү үйл явцыг урагшлуулахын төлөө цуцалтгүй хүч чармайлт гаргаж ирсэн Улаанбаатарын яриа хэлцээний хамтран зүтгэгчид та бүхэндээ талархан баяр хүргэхийг хүсч байна.

Дөрөв, тавхан сарын өмнө АНУ, БНАСАУ-ын удирдагчид шууд яриа хэлцээ өрнүүлнэ гэж, түүнчлэн 4 дүгээр болон 5 дугаар сард болсон хоёр Солонгосын дээд түвшний уулзалтыг тохионо гэж төсөөлөх ч боломжгүй байлаа. Гэсэн хэдий ч аливаа бэрхшээлийг үл харгалзан яриа хэлцээ өрнөсөн юм. Энэ нь яриа хэлцээ өрнүүлэх, харилцаа холбоо тогтоох боломж ямагт байдгийг, итгэл найдвараа хэзээ ч орхиж болохгүйг харуулж байна. Энхийг тогтоохыг бид үнэхээр хүсч байвал боломжгүй зүйл гэж үгүй билээ. Энэ бол гучаад жилийн өмнө манай гаригийн бусад хэсэгт түүх болон улиран одсон ч манай энэ бүс нутагт өдгөө хүртэл оршсоор байгаа хүйтэн дайны төгсгөлийн эхлэл гэж бодож байна. Хүйтэн дайны тухай тэмдэглэх ялдамд энд чуулж буй эрдэмтэн судлаачид та бүхнийг хүйтэн дайны өртөг зардал, түүний уршгаар алдагдсан боломжийн талаар судалгаа хийхийг уриалж байна. Энэ нь хүйтэн дайн дахин гарахаас сэргийлэх, мөн ийм нөхцөл байдал хаалга дэлдэх аваас урьдчилан зогсоход та бидэнд тустай юм.

